

Улсын бүртгэлийн дугаар:

Нууцын зэрэглэл: Б

Аравтын бүрэн ангиллын код

Төсөл хэрэгжүүлэх гэрээний
дугаар SSA-020/2016

**БАТЛАН ХАМГААЛАХЫН
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН**

**МОНГОЛ ЦЭРГИЙН ТҮҮХ
Суурь судалгааны төслийн тайлан
(2016-2018)**

Төслийн удирдагч:

С.Ганболд. Түүхийн ухааны доктор,
профессор, БХЭШХ-ийн Цэргийн түүх
судлалын төвийн дарга, хурандаа.

Захиалагч байгууллага:

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын
яам

Санхүүжүүлэгч байгууллага:

Шинжлэх ухаан технологийн сан

Тайлан өмчлөгч:

Батлан Хамгаалахын Эрдэм Шинжилгээний
Хүрээлэн. 13300. Улаанбаатар, Баянзүрх
дүүрэг, 16-р хороо, Д.Нянтайсүрэнгийн
гудамж, Улаанхуаран. Утас 453942. И-мэйл
mids@mndu.gov.mn

Улаанбаатар хот. 2019 он

Улсын бүртгэлийн дугаар:

Нууцын зэрэглэл: Б

Аравтын бүрэн ангиллын код

Төсөл хэрэгжүүлэх гэрээний
дугаар SSA-020/2016

БАТЛАН ХАМГААЛАХЫН

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН

МОНГОЛ ЦЭРГИЙН ТҮҮХ

Суурь судалгааны төслийн тайлан

(2016-2018)

Төслийн удирдагч:

С.Ганболд. Түүхийн ухааны доктор,
профессор, БХЭШХ-ийн Цэргийн түүх
судлалын төвийн дарга, хурандаа.

Төслийн гүйцэтгэгч:

С.Ганболд, Х.Шагдар, Ж.Базарсүрэн,
Т.Эрдэнэхишиг, И.Чинбат, Л.Баяр,
Т.Сүхбаатар, Н.Хишигт, Б.Батсүрэн,
Г.Мягмарсамбуу, Ц.Цэрэндорж, Ц.Энхчимэг,
Д.Ундрах, Н.Даваадорж, И.Саруул, Ц.Минжин

Тайлан өмчлөгч:

Батлан Хамгаалахын Эрдэм Шинжилгээний
Хүрээлэн. 13300. Улаанбаатар, Баянзүрх
дүүрэг, 16-р хороо, Д.Нянтайсүрэнгийн
гудамж, Улаанхуаран. Утас 453942. И-мэйл
mids@mndu.gov.mn

ГҮЙЦЭТГЭГЧДИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

С.Ганболд, Х.Шагдар, Ж.Базарсүрэн, Т.Эрдэнэхишиг, И.Чинбат, Л.Баяр, Т.Сүхбаатар, Н.Хишигт, Б.Батсүрэн, Г.Мягмарсамбуу, Ц.Цэрэндорж, Ц.Энхчимэг, Д.Ундрах, Н.Даваадорж, И.Саруул, Ц.Минжин

С.Ганболд, Түүхийн ухааны доктор (Ph.D), профессор. БХЭШХ-ийн Цэргийн түүх судлалын төвийн дарга

Х.Шагдар. БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, цэргийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор.

Ж.Базарсүрэн. БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, түүхийн ухааны доктор (Ph.D), профессор.

Т.Эрдэнэхишиг. БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, түүхийн ухааны доктор (Ph.D), профессор.

И.Чинбат. ҮБХИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн тэнхимийн багш, доктор (Ph.D).

Л.Баяр. БХЭШХ-ийн Батлан хамгаалахын дүн шинжилгээний төвийн ЭША, доктор Ph.D).

Т.Сүхбаатар. БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор Ph.D).

Н.Хишигт. ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D), профессор.

Б.Батсүрэн. ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн Эртний түүхийн секторын ЭША, доктор (Ph.D),

Г.Мягмарсамбуу. ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн Бүс нутаг, орчин үеийн түүхийн салбарын эрхлэгч, доктор Ph.D), профессор.

Ц.Цэрэндорж . ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн Дундад зууны түүхийн салбарын эрхлэгч. доктор Ph.D), профессор.

Ц.Энхчимэг. ШУА-ийн Нийгмийн ухааны бага чуулганы эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D).

Д.Ундрах. МУИС-ийн багш, доктор (Ph.D).

Н.Даваадорж ХХЕГ-ийн харьяа Хилийн түүх судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D)

И.Саруул (Ph.D), профессор.

Ц.Минжин доктор (Ph.D)

ГАРЧИГ

РЕФЕРАТ	4
ҮР ДҮНГИЙН БАТАЛГААЖИЛТ	6
ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ	7
ОРШИЛ	8
НЭГ. МОНГОЛЫН ЭРТНИЙ УЛСУУДЫН ЦЭРЭГ	13
ХОЁР. ХАМАГ МОНГОЛ, ИХ МОНГОЛ УЛСЫН ЦЭРЭГ	27
ГУРАВ. ЮАН УЛСЫН ЦЭРЭГ	45
ДӨРӨВ. ЭЗЭНТ ГҮРНИЙ МОНГОЛ ЦЭРЭГ	58
ТАВ. ЭЗЭНТ ГҮРНИЙ ДАРААХ ҮЕИЙН МОНГОЛЫН ЦЭРЭГ (ХИҮ ЗУУНЫ II ХАГАС-ХҮИИ ЗУУНЫ II ХАГАС)	84
ЗУРГАА. МАНЖИЙН ЭРХШЭЭЛИЙН ҮЕИЙН МОНГОЛ БА ЗҮҮНГАРЫН ХАНТ УЛСЫН ЦЭРЭГ	94
ДОЛОО. МОНГОЛ УЛСЫН ЦЭРЭГ (1911-1921)	106
НАЙМ. МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ ЦЭРЭГ (1921-1945)	119
ЕС. МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧИН (1945 ОНООС ЭДҮГЭЭ)	138
ДҮГНЭЛТ	153
ЭШ ТАТСАН СУРВАЛЖ, СУДАЛГААНЫ ЗОХИОЛУУД	169
ХАВСРАЛТ	170

РЕФЕРАТ

Үндэслэл: Өнгөрсөн ХХ зууны ерээд оноос эхлэн түүхийн шинжлэх ухаанд түүхийг үзэх шинэ хандлага бий болж, үзэл сурталжсан, гуйвуулсан, хэт гоёчилсон, туйлширсан чиг хандлагаас зайлсхийж, түүхийг үнэн бодитоор судлах болсон билээ. Энэ чиг хандлагын хүрээнд монголын түүхчид түүхийн судалгааны шинэ онол, арга зүйг үндэслэн Монгол Улсын түүхийг олон талаас нь судлан шинжилсээр байна. Түүний дотор монгол цэргийн түүхийн судалгаа ерээд оноос эрчимтэй хөгжиж ирэв.

Ерээд оноос өмнөх цэргийн түүх бичлэгт монгол цэргийн түүхийг 1921 оноос эхтэй гэж үзсээр ирсэн бөгөөд энэ цаг үеэс хойших үеийн түүхийг судалсан судалгаа нэлээдгүй болжээ. Гэсэн ч тэрхүү судалгаа нь нөгөөх л үзэл суртлын нөлөөнөөс ангижраагүй, түүхийн “цагаан толбо” болсон олон асуудлыг тойрч иржээ. 1921 оноос өмнөх үе тухайлбал, Чингис хааны цэргийн түүхийг судлах нь нэн өрөөсгөл байв.

Монголын түүхчид Хүннүгээс эхлэн монголын түүхийн талаар чамгүй судалгаа хийсээр ирсэн ч тухайлан монгол цэргийн түүхийн талаар судалсан нь нэн ховор байв. Эдгээр нөхцөл байдлыг харгалзан монголын цэргийн түүхчид монгол цэргийн түүхийг Хүннүгийн үеэс эхлэн тусгайлан судлах зорилго тавьж үүний үр дүнд 1996 онд “Монгол цэргийн түүхийн товчоон” хэмээх монгол цэргийн хоёр мянга гаруй жилийн түүхийг товч тоймлосон 2 дэвтэр бүтээл туурвисан юм.

Эл бүтээл нь монгол цэргийн түүхийн судалгааг шинэ шатанд гаргаж, анх удаа монгол цэргийн түүхийг цогцоор нь судалсан судалгаа байлаа. Гэсэн ч тухайн цаг үеийн бололцоо, судлаачдын хэлний бэрхшээл зэргээс хамаарч эзэнт гүрний үеийн түүхийг бүрэн гүйцэт тусгаж чадаагүй байдаг юм. Сүүлийн үед түүхийн судалгаанд олон тооны бүтээл хэвлэгдэн гарах болсны зэрэгцээ гадаад хэл дээрх монгол цэргийн түүхтэй холбогдох олон тооны сурвалж судалгааны эргэлтэд орох болов.

Эдгээр нөхцөл байдалтай уялдан монгол цэргийн түүхийг шинжлэх ухааны өнөөгийн түвшинд дахин судлах, бага судлагдсан түүхийг лавшруулан судлах аятай боломж нээгдэж байгаа тул монгол цэргийн түүхийн өмнөх судалгааг гүнзгийрүүлж авч үзэх шаардлага зүй ёсоор тавигдах болсон нь энэхүү судалгааг хийх гол үндэслэл болж байна.

Зорилго: Монгол цэргийн түүхийг нэн эртнээс өнөөг хүртэлх үеийг хамруулж цогц судалгаа хийх явдал болно.

Судалгааны арга зүй: Түүхийн шинжлэх ухааны болон цэргийн шинжлэх ухааны онол, түүний дотор цэргийн байгуулалтын болон зэвсэгт хүчний байгуулалтын онол, арга зүй, цэргийн урлагийн зарчмуудыг удирдлага болгов.

Үр дүн: Төслийн ажлын үр дүнд монгол цэргийн түүхийг 9 боть болгон туурвиж номын эхийг бэлэн болгов.

Дүгнэлт: Бидний судалгааны ажлын үр дүнд монгол цэрэг он цагийн хувьд Хүннү улсын үеэс ч өмнө үүсч бий болсон гэдгийг археологийн судалгаа болон түүхэн сурвалжийн мэдээгээр нотлон харуулав. Өдгөөгөөс 5000 жилийн тэртээ монголын анхны төрт улс бий болж, өмнөд хөрш рүүгээ цэргийн хүчээр уулгалан довтолж, удаа дараа дайтаж байсан тухай сурвалжийн цөөнгүй мэдээ байдаг аж. Түүнчлэн хүрлийн үе болон түрүү төмрийн үед холбогдох археологийн олдворуудын дотор хүрэл болон төмөр зэвсгийн цөөнгүй олдвор олдсон зэргээс үзвэл монгол

цэргийн түүхийг 5000 гаруй жилийн тэртээгээс авч үзэх нь арга зүйн хувьд зүйтэй байна.

Монгол цэргийн түүхийн бусад үед холбогдох гадаад хэл дээрх олон тооны сурвалж, судалгааны бүтээлээс орчуулан судалгааны эргэлтэд анх удаа оруулснаар монгол цэргийн түүхийг гүнзгийрүүлэн судлах боломжийг нээж өгч байна.

Түлхүүр үг: Монгол цэрэг, цэргийн байгуулалт, зэвсэгт хүчний байгуулалт, цэргийн урлаг, тактик, цэргийн зэр зэвсэг, монгол цэргээс гадагшаа болон дотооддоо хийсэн аян дайн, байлдаан.

ҮР ДҮНГИЙН БАТАЛГААЖИЛТ

Олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл	16
Улсын болон салбарын хэмжээний эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл	22
Гадаад хэлээр хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл	2
Дотоодод хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл	25
Удирдаж хамгаалуулсан доктор	4

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АЦХЭЯ-Ардын цэргийн хэрэг эрхлэх яам
АДБНУ-Алс дорнодын Бүгд найрамдах улс
АЗГ-Ардын засгийн газар
АТЗГ- Ардын түр засгийн газар
АЖЦ-Ардын журамт цэрэг
БНМАУ-Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БНХАУ- Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БЦЖ-Бүх цэргийн жанжин
БЦЗ-Бүх цэргийн зөвлөл
БХЭШХ-Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн
БХЯ-Батлан хамгаалах яам
ДИУ-Дундад Иргэн Улс
ДЯЯ-Дотоод явдлын яам
ЗХУ-Зөвлөлт Холбоот Улс
ЗСБНХУ- Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс
ЗОУ- Зөвлөлт Орос Улс
ЗХЕШ-Зэвсэгт хүчний ерөнхий штаб
МАА-Монгол ардын арми
МАН- Монгол ардын нам
МАХН- Монгол ардын хувьсгалт нам
МАХЦ- Монгол ардын хувьсгалт цэрэг
НТ-Нийтийн тоолол
НТӨ- Нийтийн тооллын өмнөх
ОХУ-Оросын Холбооны Улс
ОК(б)Н- Оросын коммунист (большевик) нам
СнЗ-Сайд нарын зөвлөл
ҮБХИС-Үндэсний батлан хамгаалахын их сургууль
ХЦЗ-Хувьсгалт цэргийн зөвлөл
ЦЯЯ-Цэргийн явдлын яам

ОРШИЛ

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яамны захиалгатай, Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилттэй, Суурь судалгааны төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх 2016.03.31-ний өдөр баталсан SSA-020/2016 дугаартай гэрээний дагуу Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгээс “Монгол цэргийн түүх” нэртэй төслийн ажлыг гүйцэтгэв.

Эл төслийн ажлын гол үр дүн нь Монгол цэргийн түүхийг 9 ботиор бичиж, хэвлэлийн эхийг бэлдэх явдал болно.

Төслийн ажлын хүрээнд:

Монголын эртний улсуудын цэрэг.

Хамаг Монгол, Их Монгол улсын цэрэг.

Юан улсын цэрэг.

Эзэнт гүрний Монгол цэрэг.

Эзэнт гүрний дараах үеийн Монгол цэрэг (XIV зууны II хагас-XVII зууны II хагас).

Манжийн эрхшээлийн Монгол ба Зүүнгарын хант улсын цэрэг.

Монгол улсын цэрэг (1911-1921)

Монгол ардын хувьсгалт цэрэг (1921-1945)

Монгол Улсын зэвсэгт хүчин (1945 оноос эдүгээ) хэмээх 9 боть түүхийг бичиж бэлэн болгоод байна.

Судалгааны ажлын тайланг боловсруулах, бүтэц, судалгаа явуулах арга зүйн удирдамжаа БХЭШХ-гийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж зөвшөөрүүлсний үндсэн дээр судалгааны ажлыг гүйцэтгэж, тайланг боловсруулав.

Судлаач бид судалгааны ажлын агуулгаас судалгааны объект, судлах зүйл, судалгааны ажлын зорилго, зорилт зэргийг доорх байдлаар томъёоллоо:

Судалгааны ажлын зорилго нь: Монгол цэргийн түүхийг нэн эртнээс өнөөг хүртэлх үеийг хамруулж цогц судалгаа хийх.

Судалгааны ажлын объект нь: Монгол цэрэг.

Судлах зүйл нь: Монгол цэргийн байгуулалтын тогтолцоо, цэргийн урлаг, аян дайн, байлдаан, цэргийн зэр зэвсгийн хөгжилд шинжилгээ хийх.

Судалгааны ажлын зорилт нь:

- Монгол цэргийн түүхийг Хүннүгээс өмнөх үе, хүрэл зэвсгийн болон төмрийн түрүү үеэс судлах;
- Цэргийн түүхэнд урьд төдий л судлаагүй Алтан ордны улс, Цагадайн улс, Ил хант улсын цэргийн түүхийг судлан шинжлэх;
- Судалгааны ажилд Монголын болон гадаадын эрдэмтдийн бүтээлийг түлхүү хамруулах;
- Монгол цэргийн үе үеийн түүхэнд болсон дайн, байлдааны талаарх гадаадын зарим эрдэмтдийн санал дүгнэлтэд шүүмжлэлтэй хандах, няцаалт өгөх;
- Дэлхийн цэргийн хэргийн хөгжилд Монгол цэргийн оруулсан хувь нэмрийг тодорхойлох;

Судалгааны ажлын шинэлэг тал нь:

- Монгол цэргийн түүхэнд холбогдох сурвалжууд, судалгааны бүтээлийг өнөөгийн судалгааны төвшинд өргөнөөр хамруулснаараа эх түүхээ сонирхон судлагч хэн бүхэнд гарын авлага болно.
- Монгол цэргийн түүхийг анх удаа цогцоор нь судалсан.
- “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д заасан “эх түүхээ тээн хөгжүүлэгч байх үзлээр ард иргэдээ хүмүүжүүлэх” заалт хэрэгжихэд тус нэмэр болно.
- Түүх бичлэгт дурддаг зарим нэр томъёо, он цагуудыг залруулахыг оролдсон.
- Үе үеийн Монгол цэргүүд эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө ямагт тэргүүлэн оролцож байжээ гэдгийг түүхэн эх сурвалжуудаар нотлон харуулсан.

Энэхүү 9 боть бүтээлийг туурвихад БХЭШХ, ҮБХИС, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, МУИС-ийн эрдэмтэд оролцсон болно.

“Монголын эртний улсуудын цэрэг” хэмээх I ботийг БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Ph.D), профессор Ж.Базарсүрэн, БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D), профессор Т.Эрдэнэхишиг, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D) Б.Батсүрэн, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D) С. Өлзийбаяр нар бичив. Тус ботид хүрэл зэвсгийн болон түрүү төмрийн үеийн зэвсгийн судалгааг археологийн судалгаанд тулгуурлан гаргасны дээр Хүннү, Сяньби, Жужан, Хятан улсын төр-цэргийн байгуулалт, дайн байлдаан, цэргийн урлаг, зэр зэвсгийн хөгжлийн талаар дэлгэрэнгүй өгүүлсэн байна. Энэхүү боть нь нийтдээ 141 хуудас болно.

“Хамаг Монгол, Их Монгол улсын цэрэг” хэмээх II боть нь нийтдээ 393 хуудас бөгөөд БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор Х.Шагдар, БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Ph.D), профессор Ж.Базарсүрэн, доктор (Ph.D) Ц.Минжин нар бичиж гүйцэтгэв. Уг ботид Хамаг Монгол, Их Монгол улсын цэргээс дотооддоо болон гадагшаа хийсэн дайн байлдааны учир шалтгаан, үр дагаврыг нарийвчлан авч үзсэний дээр монгол цэргийн явуулсан дайн байлдааныг цэргийн урлагийн үүднээс задлан шинжилжээ.

“Юан улсын цэрэг” хэмээх III боть нь 159 хуудас болно. Уг ботийг БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Ph.D), профессор Ж.Базарсүрэн, БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор Т.Эрдэнэхишиг нар бичиж гүйцэтгэв. Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүн болох Юан улсын цэргийн байгуулалт, дайн байлдаан, зэр зэвсгийн хөгжил, түүний онцлогийг гадаад, дотоодын судлаачдын бүтээл, сурвалжийн мэдээнд түшиглэн дэлгэрэнгүй судалж, олон тооны баримтыг судалгааны эргэлтэд анх удаа оруулжээ.

“Эзэнт гүрний Монгол цэргийн түүх” хэмээх IV боть нь 260 хуудас болно. Уг ботийг БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Ph.D), профессор Ж.Базарсүрэн, БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D) Т.Сүхбаатар нар хамтран бичив. Эл ботид Алтан ордны улс, Цагаадайн улс, Ил хант улсын цэргийн түүхийг анх удаа судалгааны түвшинд авч үзсэнээрээ онцлог бөгөөд түүх бичлэгт эдгээр улсын цэргийн түүхийг нарийвчлан судалсан нь ховор юм. Зохиогчид дээрх улсуудын цэргийн байгуулалт, дайн байлдаан, зэр зэвсгийн хөгжил, түүний онцлогийг гадаад, дотоодын судлаачдын бүтээл, сурвалжийн

мэдээнд түшиглэн дэлгэрэнгүй судалж, олон тооны баримтыг судалгааны эргэлтэд анх удаа оруулжээ.

“Эзэнт гүрний дараах үеийн Монгол цэрэг (XIV зууны II хагас-XVII зууны II хагас)” хэмээх V боть нь 288 хуудас болно. ҮБХИС-ийн багш, доктор (Ph.D), дэд профессор И.Чинбат, МУИС-ийн багш, доктор (Ph.D), дэд профессор Д.Ундрах, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн Дундад зууны салбарын эрхлэгч, доктор (Ph.D), профессор Ц.Цэрэндорж нар энэ боть дээр ажиллав. Түүх бичлэгт “феодалын бутралын үе”, улмаар “улс төрийн бутралын үе” гэж хэд хэдэн янзаар нэрлэгддэг энэ цаг үеийг зохиогч нар дээрх байдлаар томъёолон нэрлэсэн нь түүхэн нэршлийн талаар шинэ санал болж байгаа юм. Эзэнт гүрэн задарсны дараа монголчууд өвөр хоорондоо байлдан тэмцэлдэхийн зэрэгцээ Мин улсын цэрэгтэй олонтаа байлдсаныг түүхэн сурвалжуудын мэдээнд түшиглэн дэлгэрэнгүй гаргажээ. Түүнчлэн энэ цаг үеийн монгол цэрэгтэй холбогдох эртний хятад хэлээр бичсэн олон тооны сурвалжийг орчуулан судалгааны эргэлтэд анх удаа оруулсан нь монгол цэргийн түүхэнд чухал ач холбогдолтой юм.

“Манжийн эрхшээлийн Монгол ба Зүүнгарын хант улсын цэрэг” хэмээх VI боть 182 хуудас болно. Тус ботийн зохиогчоор ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн Дундад зууны салбарын эрхлэгч, доктор (Ph.D), профессор Ц.Цэрэндорж, МУИС-ийн багш, доктор (Ph.D), профессор И.Саруул нар ажиллав. Зохиогчид Манж Чин гүрний зүгээс Монгол улсыг эзлэн авахын төлөө хийсэн дайн байлдаанууд, түүний эсрэг монгол цэрэг хэрхэн тэмцсэн, монгол цэргийн байгуулалт, зэр зэвсгийн байдлыг судлан шинжилжээ. Манжийн эрхшээлд орсон үед ч монгол цэрэг өөрийн өвөрмөц төрх, дайчин чанараа алдалгүй олон удаагийн дайн байлдаанд оролцож байсныг сурвалж бичгийн мэдээнд тулгуурлан нотлон харуулахыг эрмэлзсэн байна.

“Монгол улсын цэрэг (1911-1921)” хэмээх VII боть 105 хуудас бөгөөд зохиогчоор ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн салбарын эрхлэгч, доктор (Ph.D), профессор Г.Мягмарсамбуу ажиллав. Түүх бичлэгт “Олноо өргөгдсөн Монгол Улс”, “Богд хаант Монгол Улс” гэж нэрлэгдэж ирсэн энэ үеийн монгол цэргийн түүхийг зохиогч цэргийн байгуулалт, дайн байлдаан, зэр зэвсэг, цэргийн хууль цаазын хүрээнд авч үзжээ.

“Монгол ардын хувьсгалт цэрэг (1921-1945)” хэмээх VIII боть 258 хуудас бөгөөд түүнд XX зууны эхэн үеийн монгол цэргийн түүхийг цэргийн байгуулалтын хүрээнд авч үзсэн байна. ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D), профессор Н.Хишигт, БХЭШХ-ийн Цэргийн түүх судлалын төвийн дарга, доктор (Ph.D), профессор С.Ганболд нар ботийн зохиогчоор ажиллав. Уг ботид монгол цэргээс 1921 оны Ардын хувьсгал, 1939 оны Халхын голын дайн, 1945 оны Чөлөөлөх дайнд гүйцэтгэсэн үүргийг дэлгэрэнгүй авч үзэхийн хамт энэ он жилүүдэд цэргийн шинэчлэлийг анх хэрэгжүүлж эхэлснийг архивын баримтад түшиглэн харуулжээ.

“Монгол Улсын Зэвсэгт хүчин (1945 оноос эдүгээ)” хэмээх IX боть 271 хуудас болно. Ботийн зохиогчоор БХЭШХ-ийн Цэргийн түүх судлалын төвийн дарга, доктор (Ph.D), профессор С.Ганболд, БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D) Л.Баяр, ХХЕГ-ийн харьяа Хилийн түүх судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D) Н.Даваадорж нар ажиллав. ХХ зууны сүүлийн

хагас, шинэ зууны эхэн үеийн монгол цэргийн түүх нь ихэд онцлогтой тухайлбал, бараг бүрмөсөн татан буугдсан цэргийг цаг үеийн шаардлагаар дахин байгуулсан, энэ цаг үед хөгжлийнхээ урьд байгаагүй дээд түвшинд хүрсэн, олон улсын энхийг дэмжих ажиллагаанд оролцох болсноор монгол цэргийн нэр хүнд өсч улмаар Монгол Улсын нүүр царай болж хөгжсөнийг түүхэн хөгжлийнх нь явцтай холбон авч үзсэн байна.

Энэхүү 9 боть номын эхэд

Хавсаргасан зураг 295

Хүснэгт 51

График 10

Схем 19 байгаа болно.

Түүнчлэн гадаад, дотоодын эх сурвалж, судалгааны бүтээлээс 1571 ишлэл авчээ. Үүнийг тус бүрд нь авч үзвэл:

Боть I- 86

Боть II-144

Боть III-90

Боть IV-293

Боть V-228

Боть VI-77

Боть VII-180

Боть VIII-262

Боть IX-211 ишлэл тус тус авсан байна.

Төслийн гүйцэтгэгч нар энэ хугацаанд 60 гаруй илтгэл, өгүүлэл бичиж нийтлүүлснийг тайлангийн ард хавсралтаар үзүүлэв.

Төслийн багийнхантай энэ хугацаанд 2 удаа семинар зохион байгуулж төслийн ажлын явцын талаар мэдээлэл сонсов. Түүнчлэн төслийн гүйцэтгэгч нартай хэсэгчилсэн уулзалтыг цөөнгүй хийсэн болно.

БХЭШХ байгуулагдсаны 40 жил, Цэргийн түүх судлалын төв үүсэн байгуулагдсаны 60 жилийн ойд зориулсан “Цэргийн эрдэм судлал-60 жил” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, цэргийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор Х.Шагдар, БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, түүхийн ухааны доктор (Ph.D), профессор Ж.Базарсүрэн нар “Цэргийн түүх судлал 60 жил”, “Монгол цэргийн түүх 9 боть төсөл” илтгэл хэлэлцүүлээ.

Мөн энэ хугацаанд төслийн багийнхан 2017 онд Ховд аймагт томилолтоор ажиллаж 1912 оны Ховдыг чөлөөлсөн байлдааны дүр зургийг сэргээж, газар орны судалгаа хийж баримтжуулав. Эл хээрийн судалгаагаар Ховдыг чөлөөлөх байлдаанд монгол цэргийн хүч хуралдуулсан газар орон, байлдаанд хэрэглэсэн тактик нь цэргийн урлагийн үүднээс зөв байсныг батлав. Үүний хамт судалгааны эргэлтэд урьд орж байгаагүй хадны сүг зураг нэлээдийг олж илрүүлэн хэмжилт хийж баримтжуулав.

Түүнчлэн 2018 оны 5 дугаар сард Халхын голд дайн болсон газар орон дээр тандан судалгаа хийж, цэргийн археологийн судалгаа хийх боломжийг судлав. Эл судалгаагаар Халхын голын орчимд байлдааны талбарын археологийн судалгаа хийх бүрэн боломжтой нь тогтоогдсон ба харамсалтай нь тэсэрч дэлбэрээгүй сум,

мина их байх магадлалтай нь судалгаа явуулахад хүндрэл учруулах эрсдэлтэй байна.

Мөн онд Булган аймгийн Дашинчилэн сумын нутаг Лах уулын орчимд хээрийн тандан судалгааны ажил хийв. Энэ нутаг нь 1204 онд Чингис хааны цэрэг Найманы Таян хааны цэрэгтэй энэ газар оронд хүнд ширүүн байлдаан хийж, монгол цэргийн ялалтаар төгссөн түүхтэй газар юм. Уг газар орныг цэргийн урлагийн үүднээс тандан судалж монгол цэргийн баримталсан тактик зөв байжээ гэж нотлов.

НЭГДҮГЭЭР БОТЬ МОНГОЛЫН ЭРТНИЙ УЛСУУДЫН ЦЭРЭГ

Эртний улсуудыг цэрэг хэмээх нэгдүгээр боть нь удиртгал, дөрвөн бүлэг, төгсгөл, ном зүйгээс бүрдсэн нийт 155 хуудастай.

Удиртгалд Хүннү, Сяньби, Жужан, Кидан улсуудын төр, цэргийн түүхэнд холбогдох сурвалж, судалгааны зохиолын тоймыг тусгасан байна. Түүхэнд болж өнгөрсөн тодорхой дайн байлдаан, түүний өрнөл явц, цэрэг армийн шинжтэй үйл явдлыг судлахаас гадна цэргийн түүх нь дайн байлдаан, аливаа цэргийн хэргийн зорилго зорилт, учир шалтгаан, үр дүн ач холбогдолыг задлан шинжилсэний үндсэн дээр зэвсэгт хүчний байгуулалтын хөгжил, цэрэг арми бүрдүүлэх арга зарчим, түүний хангамж хангалт, төрлийн цэрэгт хуваах зарчим, цэргийн захирагч дарга нарын урлаг, цэргийн урлагийн сэтгэлгээний түүх, цэргийн үйл ажиллагааны хэлбэр тактикийн түүхийг мөшгөн судалдаг.

Цэргийн түүхийн шинжлэх ухааны сурвалж эх хэрэглэгдэхүүнийг дотор хоёр хуваана. Нэгд бичгийн дурсгал, сурвалжууд, хоёр дахь нь археологийн малтлага шинжилгээ, судалгааны явцад үүсэж бүрэлдэх эд өлгийн арвин хэрэглэгдэхүүн болно. Цэргийн түүхийн судалгааны нэг гол эх сурвалж болох эртний монголын нүүдэлчдийн цэрэг эрсийн хэрэглэж явсан зэр зэвсэг, хувцас хэрэглэл зэрэг эд өлгийн (биет соёлын өв) эх хэрэглэгдэхүүнийг археологийн судалгаагаар илрүүлж, малтаж, шинжсэний үндсэн дээр судалгааны эргэлтэнд оруулдаг нь мэдээж.

Үндсэндээ XIX зууны үед Н.Я.Бичурин, Э.Паркер, Де Грот нар нүүдэлчдийн түүхэнд холбогдох хятад сурвалжийн баримт мэдээг европ зүгийн хэлнүүдэд орчуулж судалгааны эргэлтэнд оруулсанаар Төв Азийн нүүдэлчдийн түүхийг өрнийн баримжаатай түүхийн шинжлэх ухааны арга зүйгээр судлах ажлын үндэс тавигджээ.

Судалгааны бүтээлийн хувьд анхдагчаар Францын түүхч Ж.Дегинь “Христийн мэндэлсний өмнө ба дараах үеийн Хүннү, Түрэг, Монгол болон дорнын бусад татарын түүх” хэмээх Төв Азийн нүүдэлчдийн бүрэн түүхийг нэрлэдэг.

Монголын эртний улсуудын цэргийн түүхэнд холбогдох гол гол мэдээ эртний хятадын сурвалжид байдаг. Байлдаант улсын үед (НТӨ V-III зуун) зохиогдсон “хятадын сонгодог” гэж нэрлэдэг сурвалжид “Хулсан номын тэмдэглэл” (Чжушу цзинянь), “Цзочжуань”, “Шүлэгт ном” (Шицзин), “Хавар намрын улс” (Чуньцю), “Улсын өгүүлэл” (Гоюй) зэрэг бичгийн дурсгал багтана. Эртний улсуудын түүхийг судлахад үед мөн “Байлдаант улсын бодлого”, “Шанхайцзин” буюу “Уул усны судар”, Сыма Цяний “Түүхэн тэмдэглэл”, Бань Гу-ийн “Хань улсын судар”, Фань Е-ийн “Хожуу Хань улсын судар”, Фан Сюаньлин нарын “Цзинь улсын түүх” зэрэг сурвалжийн мэдээ чухал.

Энэхүү ботид гадаад, дотоодын судлаачдын монгол, англи, орос, хятад, солонгос зэрэг орны хэлээр бичигдсэн олон арван ном зохиолоос эшлэл татсан байна.

Нэгдүгээр ботийн **“Хүннү гүрний төр, цэрэг”** хэмээх I бүлэг нь дотроо Хүннүгийн өмнөх үеийн (Төмрийн түрүү үе) цэргийн ажиллагаа, Хүннү гүрний төр, цэргийн байгуулал, Хүннү нарын дайн байлдааны түүхэн тойм, Хүннү улсын цэргийн зэр зэвсэг гэх дөрвөн зүйлтэй.

Манай судлаачид хүрэл зэвсгийн үеийг төлөөлөх археологийн соёлуудыг нээн илрүүлсээр байгаа бөгөөд өнөөгийн төвшинд түрүү (барагцаагаар НТӨ III мянганы эхнээс НТӨ 1800-аад он), хөгжингүй (НТӨ 1800-1200 аад он) болон хожуу (НТӨ 1200-600 аад он) шат гэж 3 хуваан үздэг билээ.

Хүрэл, төмрийн түрүү үеэс төмөрлөг боловсруулалт ихээхэн эрчимжих болсон ч үйлдвэрлэх аж ахуйн зэрэгцээ ан агнуур, түүвэрлэх аж ахуйн хэлбэр тодорхой төвшинд хадгалагдсаар байсныг монгол орны байгалийн харилцан өөр бүс нутгаар түрүү болон хөгжингүй хүрлийн үед тархсан афанасьев, хэмцэг, сагсай, түрүүлэг харуулсан булшны соёлууд болон хүрэл зэвсгийн сүүл үеийн хиргисүүр-буган хөшөө, дөрвөлжин булшны соёлын хэрэглэгдэхүүнээс харж болох байна. Энеолитын үед Өмнөд Сибирийн нутгаар төвлөн тархсан заримдаг газар тариалан, мал аж ахуй эрхлэгч афанасьевийн соёлыг үлдээгчдийн ул мөр манай орны нутгаас илэрч байгаа нь мөн үед монгол оронд үйлдвэрлэх аж ахуйд шилжсэн болохыг харуулах чухал хэрэглэгдэхүүн болох юм. Монгол нутгаас афанасьевийн дурсгалууд илэрч байгаа нь Монголын баруун хэсгээр түрүү хүрлийн үеэс үйлдвэрлэх аж ахуй эрхлэх болоод байсныг илтгэх юм.

Хөгжингүй хүрлийн үеэс манай нутгийн баруун хэсгээр ийнхүү харьцангуй өргөн хүрээг хамарсан угсаа, соёлын томоохон нэгдлүүд бүрэлдэх болжээ. Эдгээр нь хүн амын бүрэлдэхүүн төдийгүй аж ахуй эрхлэлт, амьдралын хэв маяг, итгэл үнэмшлийн хувьд ойролцоо ард түмэн бөгөөд хамрах хүрээ, үлдээсэн дурсгалын тоо хэмжээ зэргээр шалгуур болгон авч үзвэл сагсай буюу дөрвөн хөшөөт булшны соёлынхон гол цөм нь болж байв. Ийнхүү хүрэл төмрийн түрүү үед хиригсүүр буган чулуун хөшөө үлдээгчид, дөрвөлжин булшны соёлыг үлдээгчид мөн оршиж байв.

Ази-Европын тал нутгийн аймгуудын дунд нийгмийн ялгарал ихэд гүнзгийрэхийн хамт хүчирхэг холбоодууд бий болж, мал сүрэг, эд баялгийг хуртмтлуулах зорилгоор байлдааны тэрэгт морин цэрэг бүхий цэргийн хүчээр хөрш зэргэлдээ нутаг руу уулгалах болсон нь угсаа, соёлын хөдөлгөөний нэгэн шинэ давалгааг эхлүүлсэн юм. Үүний нөлөө тусах болсны илрэл нь тэрэгт дайчдын үлдээсэн хиргисүүр-буган хөшөөний соёл болно.

Ийнхүү хүрэл зэвсгийн дунд болон төгсгөл үеэс өнөөгийн монгол нутагт олон хүний хүч хөдөлмөрийг шаардсан сүрлэг чулуун байгууламжууд хийгдэх болсны зэрэгцээ түүнд олон зуун адуугаар тахилга өргөж байгаа нь нийгмийн ялгаа гүнзгийрэн, олон хүнийг хүчээр ажиллуулах механизм бий болсныг илтгэнэ. Нөгөө талаар олон зуун адууг тахилгын зан үйлд зориулан нядлаж байгаа нь бодит хэрэгцээнээс илүү гарсан хуримтлал гэж ойлгож болох төдийгүй түүний эх үүсвэр нь дан ганц дотоодын адуун сүргийн нөхөн үйлдвэрлэл бус цэргийн идэвхтэй үйл ажиллагааны үр дүн байж болно. Өөрөөр хэлбэл дээрмийн дайн тулаан хийж, олзлон авах замаар бий болгосон хуримтлал болох ажээ. Тиймээс хиргисүүр-буган хөшөө болон дөрвөлжин булштаны тогтмол хуримтлалын нэгэн эх үүсвэр болсон байлдааны урлаг, зэр зэвсгийн талаар дурдвал, Тэрэгт цэрэг, Морьт цэрэгтэй байсан бөгөөд Довтолгооны зэр зэвсэгт а/ харвуул зэвсэг б/ гардан тулааны зэвсэг в/Хамгаалалтын хэрэгсэл зэрэг багтаж байв.

Хүннүгийн төр улсын үүсэл хөгжил (товч тойм). НТӨ 350-300-аад он гэхэд Төв Ази, Монгол оронд хүннү нараас гадна нутгийн зүүн хэсгээр дунху нар, баруун,

баруун өмнөд хэсгээр юэчжи нарын харьяат энэтхэг-европ хэлний бүлэгт багтах хэлээр ярилцдаг малчин нүүдэлчид нутаглаж байлаа.

Энэ цаг үед, Их говийн өмнүүрх нутагт – Газал (Иньшань) уул, Ордосын Бор тохой, Сөнөд-Цахарын тал хээр, Улаанхадын өндөрлөгт линьху, лоуфань нарын нүүдэлчид, хагас нүүдэлчин шаньжун аймгийхан суурьшиж Байлдаант улсын үеийн (НТӨ 403-221 он) Цинь, Жао, Янь гэсэн гурван улстай хиллэж байв.

Монголын эрдэмтэд, эдгээр нүүдэлчдийн дунд аль хэдийн “төр улс” үүсээд, магадгүй бүр нэг-хоёр зууны нүүр ч үзсэн байж мэднэ хэмээн сүүлийн үед бичих болсон.¹

Төр, улс оршиж байгаагийн гол шинж 1) нутаг дэвсгэр=хил хязгаар (оудай/оуто), 2) төрийн тэргүүнээ нэрлэх цол (шаньюй/дарга), 3) мөн Янь улсын ванг Хүннүтэй холбоо тогтоо гэж түшмэл нь зөвлөж буй баримт, 4) бидний таамаглаж байгаагаар, Хүннү НТӨ 215, 214 онд Зүүн Ордос, Иньшань уулын ху (линьху, лоуфань) нарт цэргээр туслаад Цинь улсын цэрэгт түрэгдсэн зэрэг НТӨ 273-214 онд холбогдох эдгээр баримт Хүннү, Дунху, Юэчжи, Лоуфань, Линьху зэрэг нүүдэлчид эртнээс² төр улстай байсныг харуулж байна.

Хүннүд төр улс их эрт үүссэнийг хөрш нүүдэлчдийн түүхэн жишээнээс харж болно. Чингэхлээр хүннү нарт, ялгаагүй угсаа гарваль нэгтэй дунху нарт наад зах нь нтө V зууны дунд үеэс - НТӨ IV зууны дунд үе гэхэд хэдийнээ төр улс байжээ, хүннү нар гэнэт нтө 209 онд төр улстай болоогүй, төр ёсны хөгжлийн их эртний сурвалжтай нүүдэлчид болох нь дурдсан цөөн хэдэн баримтаас харагдаж байна.

Модун шаньюйгаас өмнө хүннүгийн төрд дараах зүйл нэгэнт уламжлал болон хэвшсэн байжээ. Үүнд, нэг, ахмад хүү шаньюйн угсаа залгамжилдаг ёс нэгэнт тогтсон байна. Хоёр, Хүннү улс нутаг дэвсгэр, хүн амаа ураг төрлийн харилцаанд суурилсан овог аймгаар биш харин газар нутгийн чанар давуулаг түмтүүдэд хувааж захирдаг болчихсон байв. Гурав, их хэмжээний цэрэг дайчилж гадагш хийдэг аян дайныг зөвхөн шаньюй толгойлж байна. Дөрөв, гадаад харилцааг шаньюй дангаар хариуцдаг болохыг гэрчлэх мэдээ байна. Энэ бүхнээс үзвэл Модун шаньюйгаас өмнө хүннүгийн төр ёсны хөгжил нэлээд цэгцэрсэн олон үе уламжилсан шинжтэй байжээ.

Хүннүгийн төр ёсны хөгжил дээрх мэт их эртний улбаатай ч НТӨ 209 онд хаан болсон Модун шаньюй Хүннүгийн төр ёсонд, зарим талаар бүр зарчмын чанартай шинэтгэл хийсэн гэж үздэг.

Модуны байгуулсан хүннү гүрэн нь аравтын тогтолцоонд үндэслэсэн төр, цэргийн нэгдсэн зохион байгуулалттай байжээ. Төр улсын тэргүүн болох шаньюй нь улс орны дотоод, гадаад бүхий л асуудлыг бие даан шийдвэрлэх эрхтэй боловч хүннүгийн язгууртнуудын их хурилдайгаар улс оронд холбоотой том том асуудлыг авч хэлэлцэн шийдвэр гаргадаг байсан байна. Хүннүгийн арми дан ганц морьт цэргээс бүрдэх ба хүүхдүүд нь бүр багаас намнаж харваж морь унаж сурдаг тул эрэлхэг дайчин эрс болон өсөж том болдог байв. хөдөлгөөнт морьт цэрэгтэй байсан учир байлдааны арга тактик маш их уян хатан цагийн байдлыг зөв үнэлж цөөн хүнээр олныг ялах бодлого баримталдаг байжээ. Байлдааны тактик зөв байсан тул гадагш хийсэн аян дайн бүхэн нь амжилт дагуулах нь олонтаа байв. Хүннү нар

¹ Монголын эртний түүх. Тэргүүн боть. Хүннү. УБ., 2017, т. 82-83

² Дээр өгүүлсэн таамгаар бол нтө 450-аас 350 оны хооронд төр улстай болсон байх.

хүчирхэгжин мандахас хавьгүй өмнө ч тэд хүчирхэг цэрэг, зэвсэгтэй байсан юм. Хятадын ханлигуудын хойгуур суух Жун, Ди, Линьху, Лоуфань зэрэг нүүдэлчин олон аймгууд тэдний урд хөрштэйгээ хийж байсан дайн байлдаанаас энэ бүгд харагдана. НТӨ 307 онд хятадын Жао ванлигийн эзэн У Лин ван өөрийн цэрэгт ху-гийн нэгэн адил хувцас өмсөж, морь унан, нум сумаар харваж сурахыг тушааж байв.

Түмэн шаньюй хэдэн онд Юэчжи улсыг довтолсныг тогтоох боломжгүй, НТӨ 209 оноос нэлээд олон жилийн өмнө л довтолсон байх гэж таамаглаж болох юм. Түмэн шаньюй НТӨ 215, 214 онд Цинь улсын Мэн Тянь жанжны эсрэг говь өмнөд рүү цэрэг илгээж Линьху, Лоуфаний вант улсуудыг өмгөөлж тулалдаад ялагдсан бол Юэчжи улсыг гэнэт довтолж амжилт олж байсан бололтой.

Түмэн шаньюйн хүү Модун шаньюй гарч ирээд НТӨ 209-202 оны хооронд нүүдэлчдийг нэгэн дээвэр доор нэгтгэжээ. Түүхийн тэмдэглэлд, Модун эцгээ харван алж Хүннүгийн шаньюй болсны дараа зүүн хөрш Дунхугийн эзэн³ түүнээс улсынхаа газар нутгаас тасдан өгөхийг шаардсан тухай өгүүлдэг. Үүнд хилэгнэсэн Модун шаньюй НТӨ 208 оны хавраас 207 оны намрын хооронд⁴ Дунхуг довтолж төрийг нь эвдэн, нутгийг нь эзэлж, хүн ардыг нь хураан авчээ. Хүннүгийн залуу хаан ингэж Дунхуг эзэлж хүчээ эрс зузаатгав. Тэрээр НТӨ 206-202 оны хооронд Юэчжи нарт анхны цохилт өгч, ялжээ.

Хүннүгийн баруун этгээдээр, одоогийн БНХАУ-ын Шинжаан муж, Тэнгэр уулын ард Алтайн уулс хүртэл нутагтай эртний зүүн иран болон эртний жинхэнэ түрэг хэлтэн аймгууд бол түүний бодлого төлөвлөгөөний эхний золиос болов. Энэ тухай, Сыма Цянь «Түүхийн тэмдэглэл»-дээ, Модун “後北服渾庾、屈射、丁零、鬲昆、薪犁之國 ... дараа нь умардад⁵ Хуньюй, Цюйшэ [*Skula/Скиф], Динлин [*Тэрэгтэн], Гэкунь [Киргиз], Синьли [*Серинда/Сеяньто] улсыг эзлэв”⁶ гэсэн маш товч мэдээ байдаг.

Модун НТӨ 200 онд ихэрхэг дээрэнгүй ханддаг урд хөрш Хан улсад довтлон эзэн хааныг нь Бээжингийн ойролцоох Байдан уулын дэргэд 7 хоног орчим бүслэн хааж, энх ургийн гэрээ хэлэлцээр байгуулан жил бүр Хүннүд их хэмжээний өргөл барьц өгч байя гэсэн болзолтойгоор хааныг суллан явуулж байв. Энэ удаагийн хэлэлцээрээр цагаан хэрэмнээс хойш нум сум агсагчид буюу хүннү нар оршин суух нутаг мөн гэдгийг хүлээн зөвшөөрүүлж чадсан байна.

Хүннү нар ийнхүү амжилттай дайн байлдаан хийхэд хүннү цэрэг, агт морьд шилдэг байснаас гадна байлдааны зэр зэвсэг их үүрэгтэй байв. Манай эрдэмтэд Хүннүгийн цэргийн зэвсэглэлийн төрлийг эртний хятадын түүхийн сурвалжийн мэдээ, эртний судлалын баримтад тулгуурлан судлаад 10 гаруй төрөл хэмээн тодорхойлсон байна. Нангиад түүхийн эртний чухал сурвалжийн нэг болох “Ши цзи”-д (Хүннүгийн) ”нум сум харваж чаддаг бүхэн нь хуягт морьт цэрэг болдог...Тэдний

³ Х.Пэрлээ, Дунхугийн эзнийг Гэхүтү (Гэуту) гэдэг гэж бичсэн.

⁴ Батсүрэн Б. Ухуань (Авар) ба Сяньби (Сэрби). УБ., 2016, т. 27

⁵ Түүхийн тэмдэглэлд уул нь «умардын» гэж зориуд цохсоныг үл анзааран Хүннүгийн умард дахь аймгууд гэж ойлгосоор ирсэн нь буруу үзэл баримтлал болно. Үнэн хэрэгтээ, ‘жинхэнэ’ эртний «Хятад» орноос умардад оршин суугч нарыг л зааж хэрэглэсэн үг билээ. Хаан нутаглаж байсныг нь тодорхой хэлээгүй гэсэн үг.

⁶ 史記(shi ji)。卷(juan)110, 匈奴(xiongnu), 第2893頁

урт зэвсэг нь нум сум, богино нь илд, жад”⁷, “Хүннү нар нум сумаа гайхамшигтай эзэмшсэн морьт цэрэгтэй” гэсэн байдаг.

Хүннүгийн зэр зэвсгийг эртний монгол уламжлалын дагуу ангилваас “Байлдах зэвсэг”, “Байлдааны хэрэгсэл” гэсэн үндсэн хоёр хэсэгт хувааж болно. Үүнд: “Байлдах зэвсэг” хэмээх тодорхойлолтод дайтан тулалдах явцад хүн, амьтан, байгаль орчинд шууд аюул хөнөөл учруулах үйлчлэл бүхий зүйлийг; “Байлдааны хэрэгсэл” хэмээх ухагдахуунд байлдааны явцад хүн, амьтанд хохирол учруулдаггүй авч тулалдаанд шууд нөлөөлдөг болон байлдах нөхцөлийг бүрдүүлэх үйлчлэл бүхий зүйлсийг хамруулна.

“Сяньби улсын төр-цэрэг” хэмээх II бүлэг. Хүннүгийн дараа төр улсаа байгуулан хүчирхэгжсэн монгол угсаат Сяньбичууд НТ 93 онд Хятадын цэрэг, Ухуань, Өмнөд хүннү нарын хамт Умард хүннүгийн эсрэг довтлон байлдсаны дараа сяньбичүүд умард хүннүгийн нутгийг эзлэн сууж, умард хүннүгийн үлдсэн 100 орчим мянган өрхийг өөрийн эрхшээлд оруулсан бололтой. Ийнхүү умард хүннүгийн хүн амыг эрхшээлдээ оруулсан нь сяньбичүүдийн цаашдын хүчирхэгжилтэнд ихээхэн түлхэц болсон нь гарцаагүй. Үүнээс хойш 60 гаруй жилийн дараа НТ II зууны тэргүүн хагас буюу 150-иад оны үед Сяньбийн нэгэн аймгийн толгойлогчийн хүү Таньшихуай Сяньбийн олон ханлиг улсыг нэгтгэн нэгдсэн улс байгуулжээ. Тэр өмнө зүг хил дагуу дээрэмдэж, хойшоо Динлин хүрч, зүүнтээ Фуюйг ухрааж, баруун зүгт Усунийг цохиж, хүннүгийн хуучин бүх нутгийг эзлэв.

Таньшихуай Сяньбийн нэгдсэн улс байгуулаад нутаг дэвсгэрээ өргөтгөн гаднаа аюулгүй болсны хойно Хүннүгийн уламжлалаар улсаа зүүн, баруун, төвийн гэсэн гурван хэсэгт хуваажээ.

Сяньби улс төр, цэргийн нэгдсэн зохион байгуулалттай, хаант засаглалтай байсан бөгөөд хүннүгийн цэрэг захиргааны аравтын зохион байгуулалтыг уламжлан авчээ. Тэдний улс төрийн эрхтэн дархтнууд Хүннү улсын нэгэн адил цөм их бага хэмжээний цэрэг захирч цэргийн эрхтний үүрэг гүйцэтгэж байв. Сяньбийн зүүн, баруун, төвийн ахлагч (их хүн) нар хаанд захирагдаж, түүний шийдвэрийг дагана. Сяньби улсын аймгийн толгойлогчид түмтийн ноёд байсан бололтой. Энэ талаар “Зинь улсын судар”-ын 108 дугаар бүлэг “Муюн Гүйн намтар”-т: Дунху нар “Хүннүтэй нэг зэрэг мандан гарсан бөгөөд нум сумт цэрэг хоёр зуу мянга гаруй буй. Зан заншил, түшмэдийн цол нь Хүннүтэй адил”⁸ гэжээ. Сяньбийн аймгийн ахлагч нарын гол үүрэг нь овог аймгийн нийт хүмүүсийн үйл ажиллагааг удирдан чиглүүлдэг ба хүмүүсийн хооронд гарсан маргаантай асуудлыг шийдвэрлэх эрхтэй байв.

Сяньбичууд хүннүгийн нэгэн адил нум сумт морьт цэрэгтэй байв. тэдний цэрэг зэвсгийн талар хятад сурвалжид “тэдний зэвсэг хулц, морь хурдан...хүннүгээс нэн хэтэрчээ” гэсэн мэдээ байдаг. Тэд гол зэвсэг болох нум сумаа даргар эвэрт үхрийн эврээр хийдэг байв. Сяньбичууд өмнөд хөрш рүүгээ байнга шахам уулгалан довтолдог байсан ба энэ байдал Таньшихуайг залгамжлагчдын үед ч багасаагүй байна.

Хан улс Ухуань, Өмнөд Хүннүгийн цэрэг зэвсгийн хүчийг авсан тохиолдолд сяньбиг ялах буюу ухраан няцааж байсан юм. Хүннү, сяньби зэрэг үндэс угсаа

⁷ *Nü là-ōyü. Øè öçè. хэбi бiа ièi āóí èр øè ñàí íáíü. 2879 àyüü dàè*

⁸ *Дэлгэржаргал П. Сяньби . Монголын эртний түүх дэд боть. УБ, 2017.т.33*

нэгтэй нүүдэлчдийн байлдах арга ухаан их ойролцоо бараг адилхан байсан нь ойлгомжтой. Сяньбичуудын байлдах арга ухааны талаар сурвалжид дурдсан зүйл бараг байхгүй. Хуй салхи мэт довтлон ирээд, бяц шидсэн ваар мэт таран оддог, хөнгөн гавшгай морьт цэрэг бүхий сяньбичуудтай тулалдахын тулд хятадууд 400 гаруй жилийн өмнө хэрэгжүүлж байсан бодлогоо үргэлжлүүлж морьт цэргийн анги олныг байгуулахаас өөр аргагүй болсон бололтой.

Сяньби нар байлдахдаа юуны өмнө хөнгөн морьт цэргийн тагнуул хийдэг байсан нь амжилт олох нэг нөхцөл болдог байжээ. Сяньбийн цэрэг нь хатуу нэгдсэн зохион байгуулалттай, дайсанд замбараагүй дайран ордоггүй, хэрхэн байлдах аргаа урьдаас боловсруулдаг ба заримдаа тулалдаанд орохдоо цэргээ 3 гар болгон дайтдаг байв.

Тухайн үед сяньбичууд эрэлхэг дайчин чанар, цэрэг зэвсгийн хүчээр бусдаас давамгайлан гарч, нэгэн үе хүчтэй удирдагчийн гарт зангидагдан хүчирхэг улс байгуулан, урьд хүннүгийн эзэмшиж байсан өргөн уудам нутгийг эзэмшсэн ба цэрэг, зэвсгийн талаар хүннүгээс ч илүү гарч байсан тул олон улс орныг эзлэн эрхшээж явжээ.

Хятадын Хан, Вэй зэрэг улсууд Сяньби улсыг оршин тогтнохоос эхлээд түүний хүчирхэгжихээс болгоомжлон сүмбийн язгууртнуудыг шан харамж, хэргэм зэргээр талдаа татаад ч, өмнөд хүннүг тэдний эсрэг удаа дараалан турхираад ч, өөрсдөө хэд хэдэн удаа цэрэглэн довтлоод ч амжилт олоогүй билээ.

Гэвч Сяньби нарын хүчирхэг нэгдмэл байдал дотоодын самууны улмаас алдагдаж сарнин бутарч салжээ. Сяньбийн дараа тогтсон Муюн, Тоба улсууд нэлээд хүчирхэгжиж байсан боловч мөн л дотоодын самуун болон хэт хятадчилагдсаны улмаас мөхжээ.

“Жужан улсын төр-цэрэг” хэмээх III бүлэг. Сяньбийн дараа Жужанчууд монгол нутгаар төвлөрөн төр улсаа байгуулжээ.

402 онд Жолошуй голын умард эрэгт хүрэлцэн ирсэн Жарун “анх удаа цэргийн цааз тогтоож, мянган хүнийг анги (цзюнь) болгож жанжин томилон харин зуун хүнийг туг (чуан) болгон даамал тавьжээ. Дайсанд түрүүлэн довтлон орогсод нь олзны хүн ба эд зүйлүүдээс түрүүлэн хүртэх, харин айн хулчийгч хэн бүхнийг чулуугаар толгойг нь хага цохих буюу гарт таарсан боломжтой зүйлээр цохиж хорооно. Бичиж тэмдэглэх бичиг үсэггүй байсан тул захирагч, ахлагч нар хонины хорголоор дайчдынхаа тоог багцаалдаг байсан бол яваандаа модон дээр хэрчлээс гаргаж тэмдэглэх аргад сайн суралцжээ⁹. Н.Я.Бичурин эдгээр албан тушаалтанг “удирдагч”, “тэргүүлэгч”-тэй дүйлгэсэн байдаг бөгөөд орчин цагийн генерал, цэргийн дарга нартай тэнцэж болох ба мэдээжийн хэрэг ийм зохицуулалт нь Жужаны цэргийн хүчийг мэдэгдэхүйц дээшлүүлсэн чухал алхам болсон юм¹⁰.

Энэ үйл явдлаар Жужан улсыг албан ёсоор байгуулагдсан хэмээн үздэг дотоод, гадаадын олон эрдэмтэд бий. Жарунд ийнхүү цэргээ засах, цааз тогтоох бодит шаардлага гарсан нь өмнөх үеэс хавьгүй хүчирхэг болж, цэргийн хүч зузаарсны илрэл болно. Мөн түүнийг дагасан улс иргэдийнхээ аюулгүй байдлыг

⁹ *Материалы по истории древних кочевых народов группы дунху. Введение, перевод и комментарии В.С.Таскина. М., 1984. стр.269*

¹⁰ *Крадин Н.Н. Общественный строй Жужаньского каганата // История и археология Дальнего Востока: к 70 летию Э.В.Шавкунова. Владивосток, 2000.с.80-94*

хамгаалах нь аливаа удирдагчийн үндсэн үүрэг болох тул хөрш зэргэлдээ нүүдэлчид, суурин иргэдийн довтолгоог сөрөн зогсох хүч чадалтай байх зайлшгүй шаардлагын улмаас дээрх шинэчлэлийг хийжээ.

Жаруны эл үйлдэл зөв байсныг батлах нэгэн үйл явдал болсон нь хөрш баян хүчирхэг хүннүгийн үлдэгдэл Жибаецы хүрээ довтолсон хэрэг юм. Энэ нь гэнэтийн санамсаргүй зүйл байгаагүй нь ойлгомжтой билээ. Магадгүй ийм өрсөлдөгч байсан учраас цаашид тулгарах олон тулаанд бэлдэж Жарун цэргээ зассан нь тодорхой юм. Жужаны эсрэг довтлон орсон нь урьдын Өндөр тэрэгтний Бэйхоули шиг Жаруны хүчийг дутуу үнэлсэнтэй адил санагдана. Хаяа хатган орж ирсэн шинэ өрсөлдөгч Жужанчуудыг бага дээр нь даран, дангаар ноёрхох санаархлын үүднээс дээрх халдлагыг сэдсэн нь илт. Сурвалжид “Жужаны баруун хойд талд хүннүгийн үлдэгдэл баян, хүчирхэг Жибаецзи хүрээ оршино. Тэр цэрэг хуралдуулан Жарунд довтлов. Эгэньхэ (Орхон) голын эрэг дээр Жарун зууралдсан тулаан хийж, хиартал цохин бүх газрыг нь хураан авчээ. Жарун улам хүчирхэгжиж, цэцэглэн мандав. Тэрээр мал аж ахуй эрхлэн ус, өвс хөөн нэгээс нөгөө нутагт сэлгэн нүүдэллэнэ”¹¹ хэмээн тэмдэглэсэн байдаг.

Бага буурай эзэмшлүүд Жаруны довтолгоон, сүр хүчээс бэргэж түүнд даган оржээ. Үүнтэй уялдаад Жарун өөртөө “Цюдоуфа хаан” цол олгожээ.

Жужанчууд хүчирхэгжимэгцээ хил хязгаарт уулгалах нь ширүүсэх, тогтмолжих хандлагатай болсон нь Вэй улсыг байнгын бэлтгэлтэй байлгах, хилийн орчимд сэргийлэх цэргийн хүчийг барьж байхад хүргэжээ.

Хятадууд умард хилийн хамгаалалтыг чангаруулан, бэлэн байдалд байлгахыг хичээдэг байсан нь сурвалжийн мэдээнээс тодорхой мэдэгддэг. Үүний нэгэн маш тод жишээ бол 423 онд Жужанчуудын довтолгооноос сэргийлэн [бэхлэлт хэрмийг] 2000 гаран мод газар (800 км гаран-С.Ө) сунган, байнгын харуул суулгасан¹² явдал болно.

Жужан ба Вэй улсын хооронд өрнөж байсан дайн тулааны дараагийн хэлбэр их төлөв Вэй улсын зүгээс эхлүүлдэг дайсны нутагт нь хүрч, өрсөн цохих байлдаан юм. Энэ төрлийн байлдаан Вэй улс умард хилээ сэргийлэн хамгаалах зорилгоор өрсөн цохих тактик хэрэглэж өдүүлдэгт онцлог нь оршино. “Жужанчууд улсын хязгаарт байнга л халддаг, иргэд түшмэдийг үргэлжид зовоодог. Иймд энэ зуны улиралд гэнэт довтлон тэдний улсыг сөнөөхгүй л бол тэд намар довтлон ер амгалан байлгахгүй” хэмээх цэргийн номлол тэднийг Жужаны эсрэг довтлон орох байлдааны үндэс болдог гэж хэлэхэд хилсдэхгүй. Тухайлбал, 391 оны Онгудай, Битүбат нарын, 394 оны Хэдохань, Жарун нарын Вэй улсын эсрэг өдөөсөн самууныг дарсан их Говийн орчимд болсон байлдаан, Жарун өөрийн холбоотон Хожуу Цзинь улсын харьяат Чуфу, Сугуянь хүрээг Вэй улсын цэрэг халдахад түүнийг өмгөөлөн цэрэг илгээсэн 402 оны байлдааныг энэ ангилалд оруулан тооцож болох бөгөөд сурвалжид Жужаныг ихээхэн хохирол үзсэн тухай мэдээ үлдээжээ. 406, 409 онуудад Жарун хилийн будлиан өдүүлсэн бол түүний дараа жил 410 онд Вэйн талаас цохилт өгөхөд зугтан явахдаа Жарун насан эцэслэсэн байна. Жужаны Ижин хаан 464 онд

¹¹ Материалы по истории древних кочевых народов группы дунху. Введение, перевод и комментарии В.С.Таскина. М., 1984. стр.269

¹² Хандсүрэн Ц. Жужаны хаант улстай холбогдох түүхийн сурвалж бичгүүд // Жужаны хаант улс ба түүхийн зарим судалгаа. УБ., 2005. т.71

хэрэм даван дайран довтолсны хариуд 470 онд гурван замын цэргээр гэнэдүүлэн цохиж, маш их хохируулжээ. Энэ тулаанаар түм гаран хүн олзлон, таван түм илүү хүн хороож, өдий төдий адуу мал, зэр зэвсэг хураажээ. Ер нь Жужан улсыг довтлоод түм, бумаар хүн хядаад мал олзлоод байсан мэдээ үндсэндээ хятад сударч түшмэдийн хэтрүүлэг биш байгаадаа гэх зүй ёсны бодол төрнө, үүнийг цаашид нягтлууштай, ер нь хятад сурваж бичигт бичсэн шиг түм, бумаар нь хүн малыг олзолж, устгаад байсан юм бол Жужанчууд малтайгаа аль хэдийн байхгүй болох байсан шүү дээ¹³ хэмээн Г.Сүхбаатар абугай эргэлзжээ. Энэ эргэлзээ үнэхээр ортой бөгөөд кунзийн сурталт хятад бичгийн түшмэд өөрийн улсыг бусдаас дээгүүрт үзэх, дэлхий ертөнцийн төв, эзэн хааныг “Тэнгэрийн хүү” хэмээн гүн бат итгэж, түүнийг сурталчилах тэдний үндсэн үүрэгт ажил нь тул ийнхүү баахан дэгсдүүлж, эртний кунз сурталт хятад түүх бичлэгийн уламжлалыг ягштал барин Вэй улсын олсон амжилтыг сүр дуулиантуулан бичдэг байснаас зайлахгүй бизээ.

Бүрэн бус боловч түүхэнд тэмдэглэгдсэн томхон 53 тулгаралт, байлдаан, болсноос нүүдэлчдийн талаас 23 удаа Вэй улсын хилд томоохон халдлага хийжээ. Харин Вэй улсаас 22 удаа довтолсон бол бусад 8 тохиолдол энэ хоёр улсын хооронд шууд бус буюу Түрэгийн хүрээтэй дайтсан, хэрэм нэмэн барьсан зэрэг мэдээ оржээ. Жужанаас Вэй улсад халдсан хамгийн их давтамжтай жилүүд нь 402-409 он (3), 423-428 он (5), 472-479 он (4), 485-487 он (3), 501-504 он (2), 536-540 он (2) болно. Харин Вэйн талаас 391 он (2), 410-418 он (4), 424-429 он (6), 448-449 он (2), 454-458 он (2), 470-472 он (2) байна. Эдгээрийг хооронд нь харгалдуулан үзвэл Умард Вэй улсын талаас эхлэн өдүүлж, түүний хариуг Жужаны тал өгсөн бол Вэй улсын зүгээс дахин уулгалах бодлогоо идэвхжүүлсэн тул Жужанчуудын хилийн дээрэм тонуул хийх үйлдэл ширүүсчээ. Вэй улсын зүгээс ч Жужаныг тамирдуулах, эзлэн авах түрэмгий бодлогоо хэвээр хадгалсан тул 423-429 онуудад 11 удаа ээлжлэн бие биенээ уулгалан довтолсон хоёр улсын харилцааны хамгийн халуухан жилүүд өнгөрчээ. Үүний дараа 20-иод жил хэсэг намжмал байснаа дахин Вэй улсын зүгээс уулгалан довтлох дээрмийн бодлогодоо шилжсэн байна. Хэдийгээр ингэж улайран зүтгэж байсан боловч Г.Сүхбаатарын оновчтой тайлбарласнаар “Вэй улс Жужан улсыг сөнөөх гэсэн гол зорилгодоо хүрч чадаагүйгээр барахгүй, өөрөө хүчин маш мөхөсдсөн”¹⁴ байна. Вэй улс үнэндээ сулран доройтож, дайн хийх чадамжаа 470-аад оны сүүлийн хагасаас үндсэндээ алдах болсон нь дээрх хүснэгтээс харагдаж буй бол харин ч Жужанчууд Вэйн хилд халдах, уулгалан довтлох бодлогоо үргэлжлүүлсээр байжээ.

Нирун улс бусад монгол туургатан овог аймгийн нэгэн адил дан морьт цэрэгтэй байв. Судлаачид Нируны морьт цэргийг дотроо хөнгөн морьт цэрэг, хүнд морьт цэрэг гэж хуваагддаг байсан хэмээжээ. Тэгэхдээ хөнгөн морьт цэргийн морь нь хуяггүй, цэрэг нь хуяг, дуулгатай байсан ба хүнд морьт цэргийн хүн, морь аль аль нь хуяг дуулгатай байсан гэж үздэг. Цэргийн гол зэвсэг нь нум сум, жад байжээ.

Нируны үеийн хуягт морьт цэргийн гол дурсгал бол Монгол улсын Ховд аймгийн төвөөс 60 км зайтай орших Эрдэнэбүрэн сумын нутагт Цамбагарав уулын “Хар хад” гэдэг хаданд сийлсэн хуягт морьт цэргийн зураг байдаг.

¹³ Сүхбаатар Г. Монгол Нирун улс (330-555) УБ., 1992 т. 34

¹⁴ Сүхбаатар Г. Монгол Нирун улс (330-555) УБ., 1992 т.37

Сурвалжийн мэдээгээр 402 онд Тоба улсын цэрэг Сугуянь, Чуфу хоёр аймгийг довтлоход Шэлүнь тэдгээрийг хамгаалан байлдаад, Вэй улсын цэрэгт цохигдон, хуягтай морь 2000 гаруйг олзлуулж байсан ажээ. Мөн 521 оны 1-р сард Вэй улсын хаан Нируны Амгайд мингуан нарийн хийцний хүний ба морины хуяг нэг хос, морины ба хүний хуяг зургаа, мөнгөн утсаар ороосон иштэй адууны цагаан хялгасан мончигтой жад зэрэг зүйл бэлэглэсэн /244-н 27, 126-н 280-280/ гэх зэрэг олон мэдээ тэмдэглэгдэн үлджээ. Бас Нирун улс зэр зэвсэг үйлдвэрлэхийн тулд түрэг овог аймгийнхнаас төмөр татварлан авдаг байсан гэх мэдээ ч бий.

“Хятан улсын төр-цэрэг” хэмээх IV бүлэг. Жужанаас хойш хүчирхэгжин гарч ирсэн монгол угсаат нүүдэлчид бол Хятанчууд юм.

Хятан нар нь НТӨ IV зууны үеэс эхлэн Нангиадын түүхийн сурвалж бичигт тэмдэглэгдсэн байх бөгөөд тэднийг Хүн-гийн Дорнод Ху-гийн удам, монголчуудтай нийтлэг нэг гаралтай гэж Хятаны судлаач ихэнх эрдэмтэн, мэргэжилтнүүд үздэг.

Эртнээс нааш цагаан хэрмийн умард дахь уугуул нутагтаа монгол туургатан овог аймгууд өрсөлдөн дараа дараалан ноёрхлоо тогтоож асаны дотор X зууны үед хятанууд түүхийн тавцнаа товойн гарч ирсэн билээ.

VII –IX зууны үед хятанууд 12 овог аймагт хуваагдаж байснаас X зуун гэхэд 2 нь тарж бутарсан ажээ. Харин X зууны үед /916/ Елюй овгийн Амбагян хан Дахэгийн ноёрхогч угсааныхныг бут цохин хятаны бүх овог аймгийг нэгтгэж, хатуу чанд захиргаа тогтоосноор хятанууд эсгий туургатны дунд ноёрхох хүчин бүрэлдэж эхэлжээ. Тийнхүү гучин жил өнгөрөхөд хятаны Ляо /буюу “Төмөр” / улс байгуулагдаж Амар мөрний сав нутгаас Тангудын цөл, Шар тэнгисээс Алтайн уулс хүртэлх өргөн уудам нутгийг эрхшээлдээ оруулсан байлаа.

Хятаны цэрэг-захиргааны байгуулалт нь эсгий туургатан хийгээд дорно дахины улс аймгийн уламжлалд тулгуурласан өвөрмөц тогтолцоотой байв. Хятаны үеийн цэрэг-захиргааны тогтолцоонд хааны “Орд” өвөрмөц үүрэг гүйцэтгэдэг байлаа. Судлаачид тэр үеийн хятаны “Орд” хэмээх томъёондоо “хааны өргөө ордон” –оос гадна хааны” бие хамгаалах шадар цэрэг”-ийг хамааруулдаг. Учир нь “Орд” нь шууд харьяаны цэргээс гадна албат иргэд, боолтой, тодорхой эзэмшил газартай, өөрөөр хэлбэл бие даасан цэрэг –захиргаа аж ахуйн нэгж байжээ.

Хятаны аймгийн тэргүүлэгчдийг гурван жил тутам сонгодог журмыг Амбагян өөрчилж, өөрийгөө Хятаны хаан болгож, хаан төрийн ширээг үе улиран залгамжлах болгожээ.

Амбагян эрх дархаа улам бэхжүүлэхээр цаг үе нь өнгөрөн байсан аймгийн байгууллагыг бүрмөсөн эвдэж, Киданы хуучин 8 аймгийн үндэс болгон Кидан улсыг байгуулав.

Амбагян улсаа Хятан хэмээн нэрлэж, цэрэг - засаг захиргааны байгууллыг Умард орд, Өмнөд орд болгож хоёр хуваасан бөгөөд умард ордонд Хятан тэргүүтэй нүүдэлчин аймгуудыг захирч байжээ. Өмнөд ордонд тэр үед Хятанд хараат байдлаар алба барьдаг суурьшмал хүн амыг захирдаг байлаа.

Хууль цаазны түүх судлаач И.Дашням бичихдээ: “...Засаг захиргааны дараагийн хуваарь нь нийслэл хот, чжоу, бэхлэлт хот, сянь болно. Хятанд нийслэл хот 5, чжоу 6, бэхлэлт хот 150, сянь /хошуу/ 200 байсныг өмнө дурьдсан билээ. Хятан гүрэнд үндсэн 55 аймаг байсны 16 нь өмнөд замын, 28 нь умард замын, 8 нь гадаад аймгууд байжээ. Аймгууд нь их аймаг, бага аймаг, хараат аймаг гэсэн гурван

төрөлд хуваагдана. Үүнээс их аймгууд нь Хятаны гол аймгууд юм. Засаг захиргааны хуваарь бүр нь оршин амьдрах газар нутаг, харьяалан захирах хүн ам, голлон эрхлэх аж ахуйгаасаа хамааран өөр өөрийн засаглах захиргаа, удирдлагын өөрт нь зохицсон нарийн бүтэцтэй байхад чиглэгдэж байснаараа онцлог бөлгөө...”¹⁵

“...Хятан гүрэнд төрийн удирдлагын өөрийн гэсэн бүтэц, зохион байгуулалт, тэдгээрт ажиллах түшмэдийн харьцангуй нарийн тогтолцоо, ёс горим бүрэлдэн бий болсон байна. Амбагян хаан 922 оны орчим төрийн түшмэлийн зэрэг дэв, улсын цэргийг ерөнхийлөн захирах тушаал бий болгон тогтоосон байна. Хааны шууд захиргаанд ажиллах илижин /элтегин эзэн/, юйвэй, тамажуй, сали цэрэг захиргааны том түшмэлийн тушаалууд ч гарч ирсэн байна. Мөн эрдмийн хэрэг эрхэлсэн лин я хэмээх эрдэмтэн түшмэл, улсын тэнгэрийн улирлыг үзэгч мэргэшсэн түшмэлтэй байжээ. Хятан гүрэн төрийн захиргааны байгууллага, ялангуяа соёл, боловсрол, урлагийн чиглэлээр урлагийн яам, эрдмийн хоёр хүрээлэн, мал эмнэлгийн газар зэргийг байгуулан ажиллуулж байсан ажээ.

Хятан гүрэнд аймгуудын гурван төрлийн захиргаа, тухайлбал Их аймгийн захиргаа, Бага аймгийн захиргаа, Хараат аймгийн захиргааг тус тус байгуулсан байна. Их аймаг бүрийг Илижин хэмээх тушаалтан толгойлж, дор нь зүүн зайсан, баруун зайсан, тайш, сыту зэрэг тушаалтнууд ажилладаг байжээ.

Хятаны цэргийн тогтолцоо нь цэрэг-иргэний хосолмол шинжтэй байжээ. 15-50 насны эрчүүдийг цэрэгт татдаг байжээ. Хятаны цэрэг нь үндэснээ эзэн хааны торгон шадар цэрэг (禁衛諸軍), нүүдэлчин аймгуудын цэрэг, харь угсаатны цэрэг гэсэн 3 хэсгээс бүрдэж байв.

Хааны торгон шадар цэрэг нь хааны шадар цэрэг (御帳親軍), ордны хамгаалалтын цэрэг (宮衛騎軍) гэсэн 2 хэсгээс бүрдэж байв. Эхнийх нь эзэн хааны гэр бүлийн шууд харьяаны, хамгийн шилдэг цэргүүдээс бүрдэлдэж байв. Энэхүү хааны шадар цэрэг (御帳親軍) нь дотроо хааны шууд харьяаны анги, хатны шууд харьяаны ангид хуваагддаг байв.

Хятаны цэргийн гол нэгж нь анги бөгөөд нэг анги нь 500-700 хүнтэй байжээ. 10 анги нийлж 1 зам (дао), 10 зам нийлж 1 лу болдог байжээ. Морьт цэрэг тус бүр 3 морь, төмөр хуяг 9, морины хуяг, нум 4, сум 400, урт богино жад, том жижиг сүх, төмөр муна ..., жижиг хиур, хэт цахиур гэх мэтийг биедээ авч явах ёстой. Эдгээр зэвсгийг хувийн зардлаар бэлтгэнэ.

Бас жинхэнэ цэрэг тус бүр 2 туслах цэрэгтэй байжээ. 1 туслах нь амуу будаа, агт морины өвс тэжээл бэлтгэх үүрэгтэй байв. Хятанчууд аян дайнд хурдан явахын тулд цэргийн хүнс амуу авч явдаггүй, харин тухайн газраасаа хүнсээ хангадаг байсан агаад дээр дурдсан туслахууд өдөр бүр ийш тийш мордож, хоол тэжээлийг дээрэмдэн тонох буюу ан гөрөө хийх, загасчлах гэх мэтээр цэргийн хүнсийг хангадаг байв.

Харин нөгөө 1 туслах нь агт морь болон зэвсэг багаж хэрэгслийг хариуцдаг байсан бололтой. Жинхэнэ цэргээ хуяг дуулга өмсөхөд нь туслах, морио хуяглахад нь тусламж хэрэгтэй байсан болов уу. Цэрэг тус бүрийн авч явдаг хэд хэдэн морийг тулалдааны үед хариуцдаг байсан гэж үздэг.

¹⁵ И.Дашням., 128 дахь тал.

Хятаны цэрэг аян дайнд мордохдоо үндсэн анги буюу хөсөг хамгаалах цэрэг (3 түмэн цэрэгтэй), манлай (3 мянган цэрэгтэй) гэсэн 2 хэсэгт хуваагддаг байжээ. Манлай анги нь дотроо тагнуулын хэсэг (100 хүнтэй) ба манлай, үндсэн ангитай холбоо барих ажил хариуцсан холбооны ангиас бүрдэнэ. Тагнуулын хэсэг нь хамгийн шилдэг цэргүүдээс бүрдэх бөгөөд 10-аад цэрэг нийлж нэг баг болно. Тэд үндсэн ангийн урд, хойно 20 ли зайтай явдаг байжээ. Харин шөнийн цагт нэлээд болгоомжтой 5-10 газар яваад мориноосоо бууж дайсны хүн, малын чимээ чагнадаг байв.

Пархэ (Бохай) улс нь мохэ болон когүрйөгийн үлдэгдэл ард иргэдээс бүрдсэн бөгөөд хамгийн их хүчирхэгжсэн үедээ буюу IX зууны эхээр тус улсын нутаг өнөөгийн Манжуурын зүүн хойт болон Солонгосын хойгийн хойт хэсэг, Оросын Алс Дорнодын Приморье хязгаарын нутаг дэвсгэрийг хамарч байжээ. Тэр үед Пархэ улсын нутаг баруун зүгт Лууха гол, хойт зүгт Сунгари мөрөн хүрч, Зүүн хойт Ази дахь хүчирхэг улсын нэг болсон байв.

Пархэ улс 698 онд байгуулагдсан цагаасаа эхлэн Хятантай нэлээд идэвхтэ Елюй Абаоцзи 907 онд Хятаны хаан сууринд сууснаар хөрш зэргэлдээ орнуудын эсрэг аян дайн хийж эхэлжээ. Тэрээр Нанхиад руу аян дайн хийхийн өмнө ар талын аюулгүй байдлаа хангах зорилгоор Пархэгийн эсрэг бодлого баримталж эхлэв. Ингэснээр Хятан-Пархэгийн хооронд түгшүүртэй харилцаа бий болжээ. Хятанчууд 903 оноос эхлэн Ляодунгийн хойгт нэвтэрсэн нь Пархэд аюул занал учруулсан боловч Пархэ тэр цагт дотоодын самуунтай байсан тул олигтой арга хэмжээ авч чадаагүй ажээ. Хятан улс хүчирхэгжихээс болгоомжилсон Пархэ нь 911 оны үед Шилла зэрэг улсуудад нууцаар элч илгээн далд холбоо тогтоохыг оролджээ¹⁶.

Гэвч 915 оны үеэс Шилла өмнө нь Пархэтэй тогтоосон нууц гэрээгээ огоорч, Хятантай харилцаа тогтоов. Үүний улмаас ганцаардсан Пархэ улс 918 онд Хятанд элч илгээн найрамдалд харилцаа тогтоох санал тавив. Гэвч удалгүй 918 онд хятанчууд Пархэгийн Ляоян хотыг гартаа оруулж, түүнд түшиглэн Пархэг довтлох бэлтгэл хийж эхэлсэн нь хоёр улсын харилцааг хурцатгажээ. 919 онд хятанчууд Ляоян хотыг засаж сэлбэн нанхиад, пархэчүүдийг дээрэмдэн талж, тэнд суулгажээ. Тиймээс 924 онд Пархэ улс Хятаны нутаг Ляочжоу-г довтолж захирагчийг нь хороогоод, тэнд нутаглаж байсан хүмүүсийг олзлон авснаас¹⁷ гадан зүрчид, уйгур, шивэй зэрэг аймгуудыг турхиран Хятаныг довтлуулжээ. Үүнээс шалтгаалан Хятан-Пархэгийн хооронд дайн дэгдэв. Энэ дайн эцэстээ хятанчууд Пархэг онцын эсэргүүцэлгүйгээр буулган авч, тус улсыг Зүүн Дань хэмээн нэрлээд, нийслэл Хухань хотын нэрийг Тяньфу хэмээн өөрчилжээ. Тэгээд хунтайж Бэй-г Жэньхуан ван өргөмжлөөд, Зүүн Дань улсын хаан болгожээ.

Корйө улс Пархэгийн өшийг авахын тулд Хожуу Цзинь улсад хандан Хятаныг хамтран довтлох хүсэлт тавьж байжээ. 980-аад оны үед нанхиад нутагт ноёрхохын төлөө тэмцэлдэж байсан Хятан, Сун улс хоёр хоёул Корйөд элч илгээн талдаа татахыг оролджээ. Сун улс 986 онд элч илгээн Корйөтэй цэргийн холбоотон болох санал тавьсанд Корйө улс аргагүйн эрхэнд хамтран довтлохоор амласан хэдий ч

¹⁶송기호, 「발해 멸망기의 대외관계 -거란-후삼국과의 관계를 중심으로-」, “한국사론” 17권, 서울대학교 국사학과, 1987, 83쪽.

¹⁷ Юү Дыггон, *Пархэгийн шинжлэл, орчуулсан Ц.Цэрэндорж, УБ., 2014, 50-р тал.*

амлалтаа биелүүлээгүй ажээ. Яг энэ үед Хятан улс Корйөд элч илгээж найрамдал тогтоохыг хүссэн боловч Корйө Хятаны саналд татгалзсан хариу өгчээ. Корйөгийн үйлдэл нь тус улс Хятанд дайсагнан хандаж байгааг харуулсан гэж үзээд Хятан улс 993 онд Корйөг довтолов. Гэвч хоёр тал эцсийн дүнд хэлэлцээр хийж, Корйөгийн тал найрамдах санал тавьсан тул тулалдахаа зогсоож, цэргээ эргүүлэн тат хэмээн Хятаны хаан зарлиг буулгажээ. Ийнхүү тулалдаанаа зогсоож, найрамдал тогтоов. Түүний үр дүнд Корйө нь Хятаныг “дээдлэхээр” болсон агаад үүний илрэл болгож Сун улсын оны цолыг хэрэглэхээ зогсоож, Хятаны оны цолыг хэрэглэхээр болжээ. Хятаны энэхүү довтолгооны зорилго нь Корйөтэй албан ёсны харилцаа тогтоож, алба бариулах зорилготой байв.

Хэдийгээр өнгөн дээрээ найрамдалт харилцаа тогтоосон боловч, Корйө улс Хятаны өрсөлдөгч Сун улстай харилцааар байв. Хятаны хаан болгон 1010 оны эцсээр 40 түмэн цэрэг авч өөрийн биеэр Корйөг довтолжээ. Самсүчхэ-гийн тулалдаанд Хятаны цэрэг ялж улмаар өмнө зүгт давшиж Квагжү хотыг эзлээд, 6 мянган цэрэг үлдээгээд, гол хүч нь өмнө зүгт давшилтаа үргэлжлүүлэв. 12-р сарын 8-нд Анъжү хотыг, мөн сарын 10-нд Сүгчхөнъ хотыг авав. Ийнхүү амархан автсан нь Кан Жо хамаг хүчээ фронтын тэргүүн шугамд хуримтлуулсны улмаас ар талыг хамгаалах цэрэг хангалтгүй болсонтой холбоотой гэж үздэг. 12-р сарын 10-нд хятаны цэргийн тэргүүн анги Сөгийөн-д хүрмэгц хотын хамгаалалтыг хариуцаж байсан жанжин Вөнъ Жөнсог бууж өгөхөөр шийджээ. Гэвч яг тэр өдөр зүүн хойт нутгаас Чи Чхэмүнъ, Тхаг Сажөн нарын удирдсан өмөг цэрэг хотод нэвтэрч бууж өгөх снал гаргачдыг дарангуйлж, Сөгийөн хотыг гартаа оруулжээ. Түүнээс гадна хэдэн удаагийн бэрхшээл сорилтыг туулсны эцэст Сөгийөн хотыг дайсанд алдсангүй. Ийнхүү Корйөгийн 2 дахь нийслэл болох стратегийн чухал ач холбогдол бүхий Сөгийөн хотыг хамгаалж чадсан нь энэ удаагийн дайны ялалт ялагдлыг шийдэх шийдвэрлэх хэрэг болсон билээ.

Сөгийөн-г довтолох үед тус хотоос дутаан гарсан Корйөгийн ван 12-р сарын 30-нд өнөөгийн Кйөнги мужийн Янжү-гээс Хятаны хаанд Ха Гонжинъ 하공진(河拱辰) нарыг элчээр илгээн “өөрийн биеэр бараалхах” нөхцөлтэйгээр найрамдах хүсэлт тавьжээ. Хятаны эзэн хаан элчийг барьцааны хүн болгож, Корйөгийн вангийн хүсэлтийг хүлээн зөвөөшрчээ.

Кэгийөн хотыг эзэлсэн хятан цэрэг хотод дээрэм тонуул үйлдэж, вангийн орд харш, тахилгын сүм, гол чухал барилга байшинг галдан шатаагаад, хотод 10 хоног болсны эцэст 1-р сарын 11-нд дайны олз омог, олзлогдогсдыг авч Кэгийөнгөөс цэргээ татаж эхэлжээ.

Хятаны 3-5 дахь удаагийн довтолгоон. Мөн Корйөгийн тал амласан ёсоор улсын ван нь Хятанд бараалхаагүй тул барьцааны хүнийг хороож, Корйөгийн ванг бараалхахыг шаардав. Гэвч Корйөгийн ван өвчтэй хэмээн шалтаглан бараалхаагүй тул Хятан улс 993 оны үед Корйөд найр тавин өгсөн газар нутгийг эргүүлэн өгөхийг шаарджээ. Гэвч Корйөгийн тал тэрхүү хүсэлтийг хүлээн зөвшөөрөөгүй учир хоёр орны харилцаа хурцадсаар 1014 онд Хятаны цэрэг дахин Корйөг довтолоход хүргэжээ. Энэ үеэс эхлэн 1017 оны 1-р сар хүртэл нийт 3 удаагийн довтолгоон болжээ. 1033, 1037 онд хил хязгаарт бага хэмжээний тулалдаан өрнөсөн ч урьдын адил томоохон дайн тулалдаан дахиж гараагүй ажээ. 1037 онд Хятан улс Корйөтэй

зөвшилцөлд хүрснээр 1039 оноос эхлэн хоёр улсын хооронд энхийн харилцаа тогтжээ. Энэхүү харилцаа 1125 онд Хятан улс мөхөх хүртэл үргэлжилжээ.

Зүрчидийн бослогын улмаас хүнд байдалд орсон Хятан улс 1114, 1115 онд Корйөгөөс цэргийн тусламж хүссэн хэдий ч¹⁸ Корйөгийн тал хариу өгөөгүй ажээ.

Хятаны цэргийн зэвсгийн иж бүрдэл нь тэр үеийн бусад эсгий туургатан овог аймгийн нэгэн адил уртын болон охор зэвсэг, хамгаалах хэрэгслээс бүрдэж байв. Хятаны гол зэвсэг нь нум сум, байлдааны гол хэрэгсэл нь агт морь байлаа.

Тэр үеийн хуулиар цэрэг хүн бүр “төмөр хуяг есөн зүйл, эмээл хазаартай морь, морины төмөр юмуу ширэн хуяг, нум, сум, урт богино жад, билүү, сүх, далбаа, алх, шөвөг, хэт цахиур, морины идүүр, морины аргамжаа 200 тохойг өөрсдөө бэлтгэж ирэх ёстой байлаа¹⁹.

Хятаны үед эсгий туургатны болон дэлхий дахины цэргийн хэрэг, зэр зэвсгийн үйлдвэрлэл, байлдааны технологид эрс шинэчлэлийн чанартай нэгэн нээлт гарсан нь галт буу зохион бүтээсэн явдал байлаа.

“Хятан улсын түүх”-нд өгүүлснийг үзвэл “Дай (Их) Ляо улсын цэргийн зохион байгуулалтын хууль”-д хятан цэрэг бүр энгийн болон хатанга хатуу 4 нумтай, 400 зэв сумтай байх ёстой” хэмээн заасан байжээ. Монгол Улс, Өвөр Байгал, Манжуурын нутгаас олдсон эртний судлалын олдвороос үзэхэд Хятаны зэв сум нь “төмөр” болон “ясан” зэв хэмээх хоёр төрөлд хамаарч байна.

Эртний улсууд нь цөм төрийн байгууламжийн хувьд нэгдмэл төвлөрсөн хэлбэрийн улсууд байсан бөгөөд цэрэг-захиргааны аравтын тогтолцоонд тулгуурласан төр, цэргийн нэгдмэл зохион байгуулалт, улсыг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваариар баруун, зүүн гар, төв хэмээн хуваасан “гурван гарын тогтолцоо” нь Монголын нутаг дэвсгэр, төр улсыг байгуулан оршин тогтнож байсан монгол угсаат дараагийн улсуудад уламжлагдан хэрэглэгдэж байжээ. Тийнхүү эртний Хиан улсын үеэс үүдэлтэй төрт ёс, цэргийн байгууламжийн тогтолцоо Хүннү, Сүмбэ, Нирун, Хятаны зэрэг улсын үед улам нарийн, боловсронгуй болсоор Их Монгол улсын үетэй золгожээ. Тухайлбал, эртний төрт улсууд болох Хүннү, Сяньби /буюу Сүмбэ/, Жужан /буюу Нирун/, Тоба Вэй, Муюн, Хятан /буюу Кидан/ нар нь дорно дахинаас үүдэлтэй цэрэг – захиргааны аравтын тогтолцоог уламжлан авч төгөлдөржүүлэн сайжруулсан нь хожимоо Их Монгол Улсад мянгатын тогтолцоог буй болгох үндэс суурь болж өгчээ.

Хүннү, Сүмбэ, Нирун, Хятан зэрэг монгол нутагт тогтож байсан эртний улсуудын гол дайсан нь ямагт Хятадын нутагт ээлж дараалан тогтож байсан нангиад удмын улсууд байсан бөгөөд нүүдэлчид цэрэг, зэвсгийн хүчээр хятад болон хөрш зэргэлдээх улс орнуудаас огтхон ч дутаж байгаагүйгээр барахгүй зарим талаар илүү гарч байсны баталгаа нь тэдгээр улсуудад ноёрхлоо тогтоож байсан явдал юм. Гэвч түүхийн тодорхой тодорхой үе цагт нүүдэлчин монголчуудыг бусдын өмнө хүчин мөхөсдөхөд хүргэж байсан гол шалтгаан нь гагцхүү дотоодын хямрал буюу баяжин хүчирхэгжсэн ноёд, язгууртнуудын эрх мэдэл, алдар нэр, эд баялгийн төлөөх тэмцлээс үүдсэн эв нэгдэлгүй байдалтай холбоотой байсныг бидний энэ судалгаа ч нотлон харуулж байна.

¹⁸ Корйөса, 13:35a6-b2, 14:3b4-9, 6a6

¹⁹ Мансан. Монгол үндэстний бүрэн түүх. Дөрөвдүгээр дэвтэр. ӨМӨЗО. 2004 он. 553 дахь тал

Мөн монгол угсаатныг нэгтгэж ирсэн эртний төрт улсуудын уламжлал нь хожим хойно нэгэн хэл, нэгэн зан заншил, хэв болон бичгийн хууль цааз, цэрэг-захиргааны нэгэн тогтолцоотой үндэстэн улс буй болгох урьдач нөхцөл болсон байна.

Тэдгээр улсуудын цэргийн бүтэц, зохион байгуулалт, зэр зэвсгийн хүчин чадал, байлдааны арга технологи нь тухайн цагтаа бусад ямар ч улс орноос дутахгүйгээр барахгүй, зарим зэвсэг, ялангуяа харвуул зэвсгээр тэргүүлэх хэмжээнд байсан нь тэдгээрийн дайн байлдааны ажиллагаа, ялалт амжилтаас тодорхой байна. Монголчууд түүхэндээ хоёр удаа “дэлхийг донсолгож” асаны эхнийх нь хүннүтэй холбоотой нь тэр үед цэрэг зэвсгийн хүчээр тэргүүлж байсны хөдөлшгүй нотолгоо бөгөөд бидний судалгаанд дурдагдсан хүннүгийн зэвсгийн төрөл хэлбэр, бүтэц хийц ч үүнийг илтгэн харуулж байна. Тиймээс Л.Н.Гумилевын өгүүлснээр чухамдаа “Хүннүчүүд л хятадын түрэмгийллээс тухайн үедээ дэлхий дахиныг авран хамгаалсан” агаад улмаар урт удаан хугацааны амь хайргүй тэмцлийнхээ үр дүнд гол дайсан болох хятадын Хан улсыг бутцохин мөхөөсөн байна. Түүгээр барахгүй хятадууд хүннү цэргийг дууриан “Хүннү маягийн морьт цэргийг үүсгэн, хүннүгийн гутал, хувцсыг хэрэглэж, нум сумаар харвах хийгээд байлдааны бусад арга тактикийг нь хуулбарлан дуурайж байсан” болон эмээл, дөрөө хэрэглэхээс эхлээд агт морио хуяглахыг хүртэл олон улс даяар таниулсан нь дэлхий дахины цэргийн хэрэгт өвөг дээдсийн маань оруулсан үнэтэй хувь нэмэр юм.

Монголын эртний төрт улсуудын цэрэг-захиргааны байгуулалт хийгээд төрийн тогтолцоо, дайн байлдаан, зэр зэвсгийн түүх нь тус бүрдээ биеэ даасан судалгааны асуудлууд бөгөөд энэ чиглэлээр түүх, археологи, угсаатны зүй, төр эрх зүйн түүх, цэргийн эрх зүй, цэргийн байгуулалт, антропологийн талаас нь нарийвчлан судлах шаардлага зүй ёсоор урган гарч буй нь судалгааны явцад харагдаж байна.

ХОЁРДУГААР БОТЬ ХАМАГ МОНГОЛ, ИХ МОНГОЛ УЛСЫН ЦЭРЭГ

Хоёрдугаар боть нь Хамаг Монгол, Их Монгол Улсын дайн, байлдаан; Хамаг Монгол, Их Монгол Улсын цэргийн урлаг; Хамаг Монгол, Их Монгол Улсын цэрэг, зэвсэгт хүчний байгуулалт, Их Монгол Улсын дайны үр дүн хэмээх 3 анги, 7 бүлэг,

31 зүйл, 69 тактикийн болон зэвсэг, хамгаалалтын хэрэгслийн зураг, төгсгөл, ном зүйгээс бүрдэнэ.

I ангийн Төв, зүүн Азийн фронт гэсэн бүлгийн 1.1 ба 1.2 зүйлд Чингис хаанаас Хамаг Монгол Улсаа төвхнүүлэн тогтоох болон Их Монгол Улсыг байгуулахын төлөө дотооддоо хийсэн байлдаануудын гарсан шалтгаан, явц, сөргөлдөгч талын ялагдсан, Чингис хааны цэргийн ялсан нөхцөл шалтгаан, үр дүнг шинжлэн боловсруулсан байна. Үүнд: Чингис хаанаас мэргэд, Жамуха, татар, жүрхэн, зүүн болон баруун найман, Гүр хан Жамуха, тайчууд, тэдгээрийн үлдэгдэл эвслүүд, хэрэйд, наймантай байлдан ялж, Их Монгол Улсаа байгуулсан байлдаануудын түүхийг авч үзсэн.

Эл судалгаагаар, Чингис хаан 1178-1206 оны завсарт хийсэн тэмцлийнхээ үр дүнд:

- Өөрийн шадар нөхөд, урт дурын хүмүүсээр цөм болсон Хамаг Монголын цэрэгтээ тулгуурлан татар, хэрэйд, найман мэргэд аймгуудыг байлдан мөхөөж "эсгий туургатан улсыг...нэгтгэн барах" стратегийн их зорилгоо хэрэгжүүлэн Их Монгол Улсыг засан тогтоов.

-Байлдаан, тулалдаанд хатуужсан дан хөнгөн морьт цэргийн хүчирхэг армийг байгуулав.

-Чингис хааны үеийн алдарт жанждын хойноос Зүч, Шихихутаг, Чимбай тэргүүтэй хойчийн их жанждын нэгэн үе өсч өндийв гэсэн дүгнэлт хийсэн болно.

1.2-оос 1.6 дүгээр зүйлд Тангуд, Кидан, Солонгос, Зүрчидийн Алтан улсад Чингис хаан довтолсон дайн, байлдааны учир шалтгаан, явц, үр дүнг авч үзсэн.

Зүрчидийн Алтан улстай дайтсан шалтгаан нь: Их Монгол Улсын тусгаар тогтнол аюулгүй байдалд Алтан улс илт заналхийлсэнээс үүдсэн бол Киданыг чөлөөлөх, Тангуд, Солонгосыг байлдан дагуулах явдал нь Алтан улсыг байлдан мөхөөх стратегийн бодлогын хүрээнд болж өнгөрсөнийг зохиогч нотлон харуулав.

Кидан, Солонгосыг Чингис хаан өөрийн холбоотон болгож чадсан нь түүний дипломат бодлогын том ялалт байв. Тангудын ялагдсан шалтгаан нь:

- Алтан улстай хүч хавсран эсэргүүцэхийн оронд хоорондоо дайтаж хүчээ тамирдуулав. Энэ хоёр орон хоорондоо дайтаж байхад монголчууд аль алины нь цэргийг дуртай цагтаа цохин доройтуулсаар байв.
- Тангудын эрх баригчид дотроо зөрчилтэй, хүч чадлаа нэгтгэн улсаа удирдахын оронд байн байн төрийн эргэлт гарган хаанаа огцруулж, эрх мэдэл булаацалдан улс орныхоо удирдлагын жолоог алдагдуулав.
- Сүүлийн хагас зуун жилд дайн дажингүй амар жимэр амьдрахдаа хүчирхэг гэгдэж байсан цэргийнхээ байлдах чадварыг хэвээр хадгалах талаар анхаарал тавиагүй аж. Бүр сүүлчийн мөчид тэд гол гол хотоо сахин суух гэнэн шийдвэр гаргав. Энэ үед монголчууд хот байлдах аргад суралцсан байсныг ер харгалзан үзсэнгүй.
- Стратегийн эрс шийдвэртэй нэгэн бодлого барьж, Монголын талд тууштай зогсохын оронд тэднийг хууран мэхэлж, хэдэн тийш урван няцаж, явуургүй аргыг давтан давтан хэрэглэсэн нь тус улсыг мөхөөх дайнд Чингис хааныг мордоход эрхгүй хүргэв. Ялагдах төдийгүй мөхөл амсав.
- Хөрш орнуудтайгаа харилцах гадаад бодлогодоо хэдийнээс болгоомжгүй хандсанаас аюулт мөчид тэдэнд туслах орон байсангүй.

- Чингис хааны дайсан - Алтан улстай сүлбээлдэх болсон нь аюул тарьж Алтан улсыг мөхөөх стратегийн бодлогын хүрээнд Тангуд улсыг шийдвэртэй мөхөөх нь Чингис хааны стратеги, тактикийн зайлшгүй алхам болж хэрэгжив.

Харин Алтан улсыг дайлах, “баруун гар”-ыг жинхэнэ ёсоор олж, Тангудын цэрэг-эдийн засгийн хүчийг ашиглах боломж нээгдсэн, Тангудыг мөхөөснөөр Түвдүүдийг сайн дураараа орж ирэх явдлыг араасаа дагуулсан нь Чингис хаанаас Тангудтай хийсэн дайны гол үр дүн байжээ.

1.6-аас 1.9 дүгээр зүйлд Зүрчидийн Алтан улсыг Өгэдэй хаан байлдан мөхөөсөн, Өмнөд Сүн улс, Дали, Төвд улсад Өгэдэй, Мөнх хаан дайтсан дайн байлдааны ажиллагаанд дүн шинжилгээ хийжээ.

Алтан улсыг байлдан мөхөөсөн судалгааны дүнгээр зохиогч дараах дүгнэлтүүдийг хийсэн байна. Үүнд:

Монголын ялалтын гол сурвалж: - 1211 онд Үнэгэн даваанд, 1213 онд Цавчаал боомтын ард, 1232 онд Саньфиншань ууланд Алтан улсын тус бүр 10-15 түмэн цэрэг бүхий бүлэглэлүүдийг бутцохисон нь зүүн фронтын цэрэг-улс төрийн байдалд эргэлтийн шинжтэй ялалт авчирав.

- Кидан, Тангуд, Солонгос, Сүн улстай цэрэг-улс төрийн холбоо байгуулж, хамтран тэмцэж чадав. Тухайлбал, Тангудыг “баруун гар” болгож ашиглах бодлого бүрэн биелэв.

Тангуд улс нь Чингис хааны шахалтаар 1211 оноос эхлэн Алтан улсад довтолж, энэ нь 1214-1224 оны 10 жилийн дайнд хүргэж, ингэснээр Алтан улсыг мөхөөх дайны туршид өнөөгийн Ганьсу мужийн Миньсянь хотоос Хөх хот хүртэлх 1000 шахам километрийн заагт Алтан улсын 5 түм орчим цэргийг татан байлдаж, Монголын цэргийн баруун жигүүр, ар талын аюулгүй байдлыг ханган “баруун гар” болох үүргээ дуртай ч дургүй ч гүйцэтгэсэн билээ.

-1216 он гэхэд Ляодуныг Алтан улсаас үндсэнд нь тусгаарлаж, 1219 оноос Солонгостой “ах дүү” болж цэрэг, эдийн засгийн хүчийг нь ашиглав.

Алтан улсын ялагдсан шалтгаан: - Нэгэн зууны турш оршин тогтнохдоо Алтан улсын төрийн гадаад бодлого нэн харгис байж, эргэн тойрны бүх улсынхаа заналт дайсан болж хувирсан нь түүний ялагдлын гол шалтгаан мөн. Хөрш орнуудтайгаа эвсэн нэгдэж чадсангүй, ямагт 2-4 фронтод ганцаар байлдав. Тариачид газрын эзэд хоорондоо алалцаж байсныг тооцвол Алтан улс гадаад дотоодын 5 фронтод байлдав. “Улаан алчууртныхан, газрын эздийн зарим нь монголын талд орж байв”⁷.

- Төв Азийн улс төрийн амьдралд эртнээс анхаарал тавьж, батлан хамгаалах арга хэмжээг эртнээс авч байсангүй. Нэгэнт эртнээс бэлтгэлгүй байсны учир Хатан голын дээд урсгал, Их цагаан хэрмээ ашиглан баруун хойт талдаа нэгдмэл удирдлагатай нэгдсэн фронт, хориглолтын шугам байгуулж эс чадан хот балгад тус тусдаа хэсэг бусгаар тэмцэн бутцохиулав. Хотууд бие биендээ туслах гэвч гавшгай морьт цэрэг дутмагаас ямагт хожимдож байв. Тиймээс Монголын анхны цохилт очиход Тангуд, Сүн, Солонгосын хилээс цэргээ татаж чадсангүй. Ляодунаас цэргээ татахын өмнө аль хэдийнэ монголын цэрэг оржээ. Ингэснээр Монголын цэрэгт хойд бэхлэлтүүдээ яах ийхийн зуургүй алдав.

⁷ БНМАУ-ын түүх.УБ., 1966.т.254

- Эзэн хаан нь Бээжинг орхин нийслэлээ Нанжинд шилжүүлсэн нь мөн чанартаа Хатан голоос хойшхи газар нутаг, хүн ам, эдийн засгийн нөөцөө монголчуудад тавьж өгөөд тэдний довтолгоог өмнө зүг урин дуудсан, Сүн улсын тэмцлийг улам гааруулж, зүүн өмнөд хилийнхээ аюул түгшүүрийг нэмэгдүүлсэн, зүүн хойт хятадын ард түмнээс улс төр, эдийн засгийн хэлхээ холбоогоо таслан зайлсан, олон улсын тавцанд Алтан улсын нэр хүндийг унагасан, өөрийн язгууртан, жанждын тэмцлийн зоригийг бөхөөсөн ноцтой хэрэг болж хувирав.

- Нийслэл шилжсэний дараа ч Хатан гол, Ханьшуй мөрний эрэгт бүх хүчээ төвлөрүүлэн нэгдмэл хориглолт байгуулж чадсангүй, урьдын адил нийслэлдээ бүх хүч, нөөцөө хураан бусад газар нутгаа тавьж өгөв.

- Монголын давшилт саарсан 1223-1229 онд гадаад харилцааны ноцтой алдаа эндлээсээ болоод дотоод байдал, батлан хамгаалах чадавхиа бэхжүүлж, сөрөг цохилт хийж чадсангүй.

- Хатан гол Тунгуань боомт, Циньлиний их уулс зэрэг байгалийн бартаа саадад итгэл тавихдаа өвлийн цагаар монголын морьт цэрэг саадгүй туулж чадахыг төдийлөн харгалзаж үзсэнгүй, монголын цэрэг Нанжины өмнө, хойноос зэрэг орж ирэхэд хоёр замын армийг нийлүүлэхгүй байх шийдвэртэй арга хамжээ авч чадсангүй, Өгэдэйн арми Хатан голыг чөлөөтэй гатлан, Тулуйн армитай нийлэв.

-Цэргийн нэгдсэн удирдлагын зарчим зэвсэгт хүчинд нь байсангүй.

-Агтаа найдваргүй гарт хадгалуулснаас дайны эхнээс явгарч маневрын гол хэрэглэл-морьт цэргийн нөөцөө барав.

-Дайны дунд үеэс даргалах боловсон хүчний болон эрэлхэг шударга жанжин, туршлага, сургалттай цэргийн нөөц нь дуусав.

Алтан улсыг мөхөөсний гол үр дүн: - Монгол улс Алтан улсын вассалаас чөлөөлөгдсөн төдийгүй, монголын тусгаар тогтнолын үе үеийн дайсан болсон түүнийг мөхөөн албат болгож Их Монгол Улсын төрийн аюулгүй байдлын баталгааг хангав.

- Монголын ард түмэнд айх аюулгүй энх амьдрах боломж нээгдэв.

- Их Монгол улсын зүүн хил Хатан гол, Вэйхэ голын заагт хүрч цэрэг, эдийн засгийн асар их баялагийг эзэмших болов.

- Ази, Европ, Африкийн худалдаа соёлын харилцааг шинэ шатанд гарган хөгжүүлэх түүхэн боломж нээгдэв.

- Мянгаад жилийн туршид монголчуудын өвөг дээдсийн хуримтлуулсан суурин орныг дайлах стратеги, тактикийн хөгжил дээд боловсрон төлөвшив.

- Чингис хааны суут оюун билиг, арга барилаар суралцсан төр, цэргийн зүтгэлтнүүдийн нэгэн үе өсч өндийв. Тэдний жолоодсон морьт цэргийн маневрын боломж XIII зууны дэлхийд хосгүйгээ харуулсан зэрэг ач холбогдлыг дурьдаж болох байна.

Өгэдэй, Мөнх хаад Өмнөд Сүн улстай дайтсан шалтгаан нь Сүн улс Их Монгол Улстай байгуулсан гэрээгээ зөрчин Их Монгол Улсын эзэмшилд халдан довтолсон, Хааны элчийг алж тэрсэлсэн зэргээс үүджээ. Өгэдэй хааны довтолгоон төдийлөн амжилттай болсонгүй бөгөөд Мөнх хааны довтолгоон амжилт олохын босгон дээр тэрбээр нас барсанаар дайныг зогсоожээ.

Дали, Төвд, Вьетнамд монголын цэрэг дайтсан нь Өмнөд Сүн улсыг далайд шахан бүслэх стратегийн бодлогын хүрээнд болжээ.

"БАНУУН ФРОНТ" хэмээх хоёрдугаар бүлэг нь Их Монгол Улсын хаадаас Дундад болон Бага Ази чиглэлд хийсэн дайны түүхийг хамарч байна.

Хар Кидан, Сартуулыг дайлсан шалтгаан нь тэдний зүгээс Их Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалд илт заналхийлсэн үйлдлүүдээс үүджээ. Хар Киданыг дипломат аргаар дагуулан авсан бол Сартуулыг зэвсгийн хүчээр дарахаас өөр аргагүй болсоныг зохиогч түүхэн баримтаар нотлон өгүүлжээ.

Сартуулын эзэд төр улсаа орхин цааш зугтсан нь тэднийг хөөн устгах үүргийг Чингис хаанд тулгаснаар тэрбээр цэргээ Өмнөд Ази, Хоросанд оруулан дайтах болон Зэв Сүбэдэйн Каспийн тэнгисийг тойрсон алдарт аялан байлдааныг өдөөн дагуулжээ.

Сартуулыг эрхшээлдээ оруулсан тухайд зохиогч дараах дүгнэлт хийж байна.Үүнд:

Сартуулын ялагдсан шалтгаан: - Шах Мухаммед лалчуудыг Хар Киданы дарлалаас аврах оролдлого хийгээгүйн дээр, Чингисийн элч лал худалдаачдыг бүрэлгэн ард иргэдийн дотор нэр сүрээ унагаж, тэдний дэмжлэгээс хагацав. Эзэн дээдэс, иргэд доодос, шах жанждын хооронд эвлэршгүй ан цав гарчээ.

- Жанжиддаа нэр хүндгүй, төрийн сайдынхаа албан тушаалыг устгасан Мухаммед газрын эзэд, шашныхан, ерөөс хүн амынхаа ганц анги, засаглалын системийн ганц ч элементэд тулгуурлаж чадсангүй.

- Зэвсгийн хүчээр дөнгөж дагуулаад байсан Хорезмын их гүрний Афганистан, Ираны мужууд нь хэрэг дээрээ толгой даасан шахуу, эе эв, нэгдмэл дэг журамгүй, эрээвэр хураавар олон үндэстэн угсаатны цуглуулга байв. Мухаммед Багдадын халифын хүчийг татан нэгдэж чадсангүй.

- Хоёр засаглал тогтсон хагарал нь Сартуулын эсэргүүцэх хүчийг сарниулжээ.

- Нэгэн удирдлага, нэгэн сахилгатай нэгдмэл арми байсангүй. Хэдэн түм цэргийг нэгэн сахилгад оруулан дайнд удирдах жанжин ч байсангүй.

- Отрар, Ходженд, нийслэлүүддээ тулалдсанаас үзэхэд "Сартуулын шахын цэргүүд эр зоригоор дутсангүй, гагцхүү удирдлага муу байжээ" гэсэн дүгнэлт хийж болох юм. Өөрийн армийг тусгаар цайз бэхлэлтүүдийг хамгаалуулахаар тараасан явдал нь түүнийг сүйрэлд хүргэжээ"⁸.

- Байгалийн агуу их гурван саад, Тэнгэр уул, Кызылкумын цөл, Сырдарья ба Амударья мөрнөө ашиглан хориглолтын нэгдмэл систем байгуулахын оронд монголчууд хотыг байлдаж чадахгүй хэмээн сэтгэж, хээр талд задгай байлдахаас зайлсхийн томоохон хотууддаа цэргээ хэсэг хэсгээр тараан суулгажээ. Гэтэл монголчууд хотыг байлдаж сурсан, хот нураах шинэ зэвсэг ачиж ирсэн байлаа. Найдаж байсан байгалийн саадууд нь Чингис хааны очих гүүр, нээлттэй хаалга болж хувираад, гол цохилтын чиглэлийг тосон хүлээж чадсангүй.

- Нийслэлээ орхин зугтацгаасан нь хүнд сорилтын үед засгийн эрх, цэргийн удирдлагыг гартаа чанга атгаж байх дайны зарчмыг алдагдуулжээ.

- Хорезмын их гүрнийг дайлах явцад, түүний эрхшээлд байсан Дундад ба Өмнөд Азийн асар олон үндэстэн хамрагдсаны дотроос өнөөгийн Казахстан, Узбек,

⁸ Рене Груссе...т.226

Туркмен, Киргиз, Таджики, Афганистан, Ираны нутгийг эзэлж, Пакистанд хүртэл Их Монгол Улсын нутгийг сунгажээ.

- Алтан улсыг дайлах арын аюулгүй байдал бүрэн хангагдав.

Сартуулын их эзэнт гүрнийг монголчууд мөхөөн гартаа оруулснаар өрнө, дорно, өмнө умрын худалдаа харилцааны зангилгааг эрхшээлдээ авав. Ингэж Сартуулын газар нутаг Монголчуудыг Бага Ази тийш морилох үүд хаалгыг нээжээ.

Бүхэлдээ Дундад Азид хийсэн дайн, Зэв Сүбэдэйн аялан байлдааны стратегийн холбооны үр дүнг Зохиогч шинээр харж дүгнэсэн нь:

-Зэв, Сүбэдэй нар Мухаммедыг бараг Персээс хөөн гаргаж, иргэдийн нь зориг зүрхийг үхүүлэн, ингэснээрээ Чингис хааны цэрэг Желал-ад-Динаг мөшгөн цохих явцад болон Өмнөд Ази, Хорасанд дайтахад баруун гарын аюулгүй байдлыг хангав.

- Сартуулын шах Мухаммед, түний эх Туракина нарыг мөрдөн хөөж устгах үүргээ, тэдэнд цэрэг цуглуулан тэмцэх зав чөлөө өгөхгүйгээр тасралтгүй довтолгосоор яв цав биелүүлэв.

- Их Монгол Улсын баруун хилд олон жил түгшүүр төрүүлж байсан хибчагуудыг бутцохин тараав.

- Кавказ дахь олон үндэстний шашин хоорондын зөрчлийг чадварлаг ашиглаж Гүрж-Армяны цэрэг, аланчуудыг бутцохив.

- Тэд явсан газар бүртээ өртөө байгуулж Кавказын хүзүүвчээр дайрсан тойруу бөгөөд аюултай шугамыг Ижил мөрний адаг-Урал-Каспийн тэнгисийн шил, тал дундуур Зүчийн нутгаар Казахстанд хүрэх шинэ шулуун замаар сольж, Чингис хаан буюу эх оронтойгоо найдвартай холбоо барих болгов.

- Зэв, Сүбэдэй нар гатлан гарсан гол мөрнүүдийнхээ байрлал, загас баялаг нуур цөөрөм, дайсны орд, мөнгөний уурхай гэх мэтийн байдал төрх, байршил зэргийг тэмдэглэж авдаг хятад, уйгур хүмүүстэй байжээ. Бичээчийн үүрэг гүйцэтгэж явсан олзны армян ламтны ярьснаар бол Кавказын чанад дахь газар орнуудад арав болон түүнээс дээш насны бүх эрэгтэйчүүдийн тооллого явж байжээ.

Ийнхүү тэд Кавказ, Европт асар их тагнан турших ажиллагаа хэрэгжүүлж, Венец, Генуэзийн худалдаачидтай холбоо тогтоов. Хориод жилийн дараа Сүбэдэй Европыг дайлахдаа энд тогтоосон холбоо сүлбээ, мэдлэг туршлагаа ашигласан юм.

- Чингис хааны цэрэг Дундад, Өмнөд Ази, Европт дайтаж Шах Мухаммед, хибчагийг мөрдөн явахдаа газарзүйн их нээлт хийж, дорныг өрнөтэй холбон, европчуудыг газарзүйн их нээлтийн аянд даллан босгов.

-Чингис хаан баруун, зүүн фронтын цагийн байдалд бодит шинжилгээ, дүгнэлт хийж Дундад Азиас цаг алдалгүй эргэсэн нь түүний жанжины авъяас мэдрэмжийн нэгэн тод жишээ юм гэж дүгнэжээ.

2.5 дугаар зүйлд Их Монгол Улсын цэрэг Бага Азид буюу эртний Армян, Гүрж, Азербайжан, Турк, Иран, Ирак, Сири, Палестинд дайтсан учир шалтгаан, явц, үр дүнд шинжилгээ хийсэн.

Монголын довтолгооны өмнөх Бага Азид бие даасан болон нэг нь нөгөөгийн вассал болсон нийт арван хэдэн төр улс оршин тогтнож байлаа. Каспийн тэнгисийн баруун өмнөд эргээр Арран, Ширван, түүнээс Хар тэнгис хүртэл Гүрж, түүний вассал Их Армян, Хар тэнгисийн зүүн өмнөд эргээр мөн гүржийн вассал Трапезунт, Хорасанаас Курдистан хүртэл Исмаилит (Перс; Иран) түүнээс цааш Доод месопотами-д Аббасид буюу Багдад (Ирак), Ираны өмнөд биед далайн эргээр

Багдадын вассал Керман, Хар тэнгисийн өмнөд эргээр Рум, түүний өмнөд хилд Газрын дундад тэнгисийн Киликийн хойг орчмоор Румын вассал Киликийн (бага) Армян, түүнээс өмнө зүгт Газрын дундад тэнгисийн зүүн дээд эргээр Антиохи, түүнээс өмнө тийш тэнгисийн зүүн эргээр Иерусалим, Багдадаас цааш Сири-Египетийг хамарсан Эюбид, Эгийн тэнгисийн эрэгт загалмайтан Никейн эзэнт улс тус тус нутаглан байжээ.

Бага Ази нь дундад зуун болон эдүгээ ч Европ, Ази, Африк гурван тивийн уулзвар, Меккад үүссэн лал, Палестинд үүссэн христос болон иудей хэмээх дэлхийн гурван шашны өлгий, ус, хуурай замын худалдаа харилцааны зангилаа болсон гоц онцлогтой, стратегийн чухал түшиц газар орон юм. Загалмайн шашинт орнуудын гол түшиг нь Армян, Гүрж байсан бөгөөд тэд Зэв, Сүбэдэйн цэрэгтэй байлдсанаар монголчуудын дайсанд тооцогджээ. Тиймээс хожимхон нь 1236-1245 онд Чурмаган, Цагаадай, Бачу нарын цэрэг дараалан довтолж Гүрж, Армяныг эрхшээлдээ авсан юм. Ингэснээр Монгол-Армян-Гүржийн загалмайн шашинтны эвсэл бүрэлдэж лалын шашинтны эсрэг дайтаж эхлэв.

Иранд монголчууд дайн зарласан нь:

1. Хорезмын үлдэгдлийг устгах;
2. Лалчуудын зэвүүцлийг төрүүлэн байдаг аллагын үүрийг “даран сөнөөж”⁹ лалын ертөнцөд байр сууриа бататгах;
3. Бага-Дундад Ази, Европ-Энэтхэгийн худалдааны замын аюулгүй байдлыг хангах зорилгоос урган гарчээ.

Багдадыг монгол цэрэг байлдах болсон шалтгаан: “Монголд халдахаар Ираны дундуур Багдадын халиф Мустасимийн цэрэг ч, Их сельжукийн өв залгамжлагч Румын туркменчууд ч, Сири, Месопотамын эмир, тэр ч байтугай Мисирийн мамлюкууд чөлөөтэй туулаад ирж болох байсан тул нутгийн хилээ Нуб, Сахаар хүртэл тэлэх шаардлагатай байжээ. Түүнчлэн Персийг дайлахад холбоотноор оролцох урилгыг тэд хүлээн авсангүй. Энэ нь нөхөрлөх бус дайсагнана л гэсэн үг билээ.

Бага Азид дайлсан дүн:

-Бага Азийн орнууд нэгдэн Каспийн эрэгт, улмаар Персийн өндөрлөгт, дараа нь Курдистаны нуруунд, удаад нь Тигр, Евфрат мөрний зааг дээр бүх хүчээ хуримтлуулан эсэргүүцэж чадсангүй нь тус тив шашны хагарал, мөргөлдөөний талбар байснаас болсон бөгөөд энэ нь түүний улс орнууд дараа дараагаар ялагдахын шалтгаан боллоо.

Монголын ялалтын шалтгаан нь:

- Бага Ази олон шашны тэмцлийн талбар болсон эмзэг байдлыг монголын жанжид овжин ашиглаж чадав. Лалын доторхи дайсан, ялагдашгүй гэгдсэн Ассассин (Исмаилит)-ын эсрэг дайн зарласан нь суннит лалынхныг баярлуулж, суннитын төв-Багдадыг унагасан нь Сирийн шийтүүдийг бахархуулж, тэдгээр нь зэвсэг хөдөлгөлгүйгээр дагаар орж байлаа.

- Шашны олонхийн дарлалд байгаа цөөнхийг талдаа татан, олонхий нь эсрэг тэмцэлд чадварлаг ашигласан зэрэгт оршино.

⁹ Марко Поло...т.45

Айн жалудын тулалдаан бол ертөнцийн түүхэнд эргэлтийн үе байлаа"¹⁰. Египет зөвхөн өөрийгөө хамгаалсан төдийгүй Ойрхи Дорнодод загалмайн шашныг сэргээх гэсэн Ази, Европын санаархалыг бүрмөсөн нурааж монголчууд болон түүний холбоотон загалмайтнуудын эсрэг лал-мамлюкуудын түрэлтийг эхэлж, эцэст загалмайн ойрхи дорнодыг лалчилж дуусгав гээд Зохиогч Айн жалудад монголчуудын ялагдсан шалтгааныг тодорхойлон сийрүүлсэн болно.

- Монголчууд 1208-1260 оны хооронд Ази, Европт дайтах явцдаа өөртэйгээ тэнцэх дайснаа Африк тивд хүргэж бэлдсэн нь XIII зууны хоёрдугаар хагаст Хибчаг боолчуудаар төрөө булаалгасан Египет, түүний мамлюкууд болжээ.

Дундад, Бага Азид хийсэн аян дайны дүнгээр Сартуул, Армян, Гүрж, Ширван, Арран, Азербайжан, Рум, Керман, Киликийн Армян, Аббасид, Эюбид, Трапезунд, Багдад зэрэг эртний төр улсыг байлдан дагуулж өнөөгийн Казахстан, Узбекистан, Туркмен, Таджик, Афганистан, Пакистан, Армян, Гүрж, Азербайжан, Турк, Иран, Ирак, Сири, Ливан, Изриал улсын нутгаар дайтан гарч Бага Азийг бүхлээр нь эзлэн Африк тивд тулж, Энэтхэгээс Сири, Арабын цөл, Арабын тэнгис, Персийн булангаас Кавказ, Каспийн тэнгис, Амударья хүртэлх Баруун өмнөд Азийн удам нутгийг хамарсан Эл хаант улс (1256-1360)-ыг байгуулсан нь 100 шахам жил оршиж тогтножээ.

"БАРУУН ХОЙД ФРОНТ" гэх гуравдугаар бүлгийн 3.1 дүгээр зүйлд Дорнод Европын аймаг, угсаатнуудыг төвшитгөсөн байлдааны явцыг авч үзсэн болно. Тухайн үед Дорнод Европт Харлуг (Печенег; Гуз; Огуз; Торк; Туркмен), Алан (Асы; Осетин, Ясы), Черкес (Касоги), Хибчаг (Половчууд, Куманчууд) зэрэг нүүдэлч болон хагас суурьмал аймгууд, Булгар, Башкир, Мордов, Буртасын улс оршиж Оросын зүүн хилийг халхлан байв. Эдгээрээс Хибчагууд нь Их Монгол Улсын баруун хойт хилийн аюулгүй байдалд мэргэд, найманы үлдэгдлүүдтэй эвсэн заналхийлж байсан юм. Бусад нь Зүчийн улсын баруун хилийн аюулгүй байдлыг холдуулах, нутгийг нь тэлэх, Орос руу гарах зам нээх стратегийн бодлогын хүрээнд монголын довтолгоонд хамрагджээ.

1223-1236 оны завсарт 1223, 1230, 1232, 1236 онд дөрвөн удаагийн довтолгооноор Ижилийн Булгарыг бүрэн мөхөөн дагуулжээ. Булгар үүнээс хойшхи 200 жил "Алтан орд" улсын хамгийн их цэцэглэн хөгжсөн мужийн нэгэн болжээ.

Башкир, Булгарын хамт Буртас, Саксин, Мордовчууд монголын гарт орсоноор 1223 оноос 1238 оны завсарт хибчаг, черкес, алан, гуз, харлуг, булгар, башкир, мордов, буртас, саксин зэрэг нүүдэлч ба суурин соёл иргэншилтэй 10 томоохон аймаг, угсаатныг монгол эрхшээлдээ оруулан авчээ. Хибчаг, Булгар, бусад үндэстнийг эзлэн авснаар монголын "Зүчийн улсын" баруун, баруун хойт хил Оростой залгалаа. Оросын "зүүн хойт хилийн жийргэвчүүд" цөм бутран унав.

3.2.1 болон 3.2.2 дугаар зүйлд Орос орныг дайлсан түүхийг авч үзсэн. Зохиогч Орос, Монголын дайныг:

а/ Калк голын тулалдаан (1223);

б/ Бат Сүбэдэй Орос орныг дайлсан нь (1237-1240) буюу:

1/ Зүүн хойт Оросыг дайлсан нь (1237-1238 оны өвөл, хавар)

2/ Өмнөд Оросыг дайлсан нь (1238-1240 он) хэмээн үечлэн боловсруулсан.

¹⁰ Саундерс.Ж.Ж....т.132

1937 онд Бат, Сүбэдэйн цэрэг Орост нэвтэрч Рязань хот улсаас эхлэн дайлж Зүүн хойт Оросыг ганц жилийн дотор буулган авчээ. Зүүн хойт Оросыг эрхшээлдээ оруулсанаар 1238-1239 оны зааг өвлөөр Киевийн Оросын хилийн хот-вант улс Переяславль руу Батын цэрэг довтолгон оржээ. Мөн нэг жилийн дотор Өмнөд Орос монголын эрхшээлд оров.

Бат, Сүбэдэйн ялалт нь “зэрлэг эр зориг, хүний олноор хийсэн зүйл огт биш бөгөөд түүний өвөг эцэг Чингисийн ялалт шиг цэрэг, зэвсгийн хосгүй зохион байгуулалт, стратеги тактикийн гарамгай бэлтгэл, эсрэг этгээдийн талаар бодитой судалж, байлдааны ажиллагааг сайтар боловсруулсны үр дүн байсан юм”¹¹.

Харин Сүбэдэй баатар Орос оронд түүхэндээ үзээгүй цохилт, мартагдашгүй сургамж өгсөн нь хожмын оросын армид хичээл сургууль болж үлдсэнийг шударгуу зохиогч, зохиолч нар дурсан бичсээр байдаг. Зөвлөлтийн нэрт түүхч В.В.Каргалов: “Цохилт гэнэтийн байдаг. Чингис хаан тэгж гэрээсэлсэн юм. Ядарч туйлдсан цэргийг шинэ хүчээр цохив. Чингис хаан тэгж гэрээсэлсэн. Морьт цэргийн шинэ хүчээр дайсанд амьсгал авах завдал өгөлгүй хөөн цохив. Ийнхүү оросууд Чингис хааны гурван гэрээслэлийг нэгэн зэрэг хэрэглэв”¹² хэмээсэн нь үнэн үнэлгээ юм.

3.3 дүгээр зүйлд Батын цэрэг Баруун Европт довтолсон дайны түүхийг авч үзсэн бөгөөд дайны жолоог тийш сунгасны гол хэрэгтэн нь Унгар байв.

Унгарт довтлох болсон шалтгаан:

Нээд: Католиг шашинд орох болзолтойгоор орогнуулахыг хүсч элч илгээн тохиролцсоны дагуу 1239 онд IY Бела ван монголын дайсан Хибчагийн хан Котяны 40 мянган хүн амыг хил дээрээ биеэр угтан аваад бүх хибчагуудыг Мажарын дотор тараан суулгах зарлигийг буулгасан.

Бат элчээ илгээж Котян хааны тэргүүлсэн 4 түмэн хибчагийг эгүүлж өгөхийг Унгарын IY Бела вангаас шаардаж, эс өгвөл өөрийг нь дайснаар үзэж дайлна гэдгээ санууллаа. IY Бела хариу өгсөнгүй нь зэвсгээ билүүдэж буйн гэрч болов.

Хоёрт: Ярославын дараагаар Киевийг эзэгнэсэн Черниговын ван Михаил Батын элч очиход тулалдахаар шийдсэн авч айхдаа 1239 онд Киевийг орхин Унгарт гарсан билээ. Улмаар тэр Польшид зугтан гараад Польшоос ирж Даниилтай уулзан монголын эсрэг хамтран тэмцэх гэрээ байгуулсан.

Гуравт: “Европ дахин монголыг зогсоохын тулд хамтран тэмцэх ажлыг зохион байгуулж байгаагүй нь монголчуудыг зоригжуулан урагш хөдлөхөд шавдуулжээ.

Өмнөд Оросын нутгаас Батын цэрэг Унгарын нийслэл Эстрегом руу 3 замаар хөдөлж замдаа Европын рыцаруудыг бутцохин урагшилсаар Эстергомыг 3 талаас нь зэрэг бүслэж 1241-1242 оны зааг өвлөөр түүнийг буулган авч, зугтсан Бела ванг мөрдөн хөөж устгах цэргийг Адриатын тэнгисийн эрэг газар руу мордуулжээ. Энэ үед Өгэдэй хаан таалал төгссөн мэдээ авч Батын цэрэг жолоо эргүүлжээ.

"ХАМАГ МОНГОЛ, ИХ МОНГОЛ УЛСЫН ЦЭРГИЙН УРЛАГ" хэмээх II АНГИ нь 2 бүлэг, 8 зүйл, 17 тактикийн зураг бүхий дараах бүтцээр бичигдсэн болно. Үүнд:

"Цэргийн урлаг" хэмээх шинжлэх ухааны нэр томъёонуудыг орчин үед янз янзаар тайлбарлан тодорхойлж байгаа тул аль онол, томъёоллыг баримталсан болохыг авч үзэв. Үүнд:

¹¹ *Иванин.М.Н.Тэмүжин, Төмөрийн цэрэг хэрэглэх арга.Хөх хот.,1987.т.194*

¹² *Полководцы.Х- XVI вв.М.,1989.с.120*

Дайны болон цэргийн урлагийн түүх нь цэргийн шинжлэх ухааны салшгүй холбоотой хоёр салбар юм.

Дайны түүх: “Аливаа дайны түүх нь тодорхой дайнуудыг он цагийн дараалалд нь судалж, тэдгээрийн онцлогийг нээж, цэргийн түүхийн шинжлэх ухааны үндэс болж байдаг.Тухайлбал; - тухайн дайны үүссэн нийгэм, эдийн засгийн нөхцөл шалтгаан; - оролцогч талуудын улс төрийн зорилго; - дайны шинж чанар; - байлдаануудын явцыг судалсаны үндсэн дээр тэр дайны улс төр, цэргийн үр дүн; - ялалт ба ялагдлын шалтгаан; - нийгмийн хөгжилд үзүүлсэн нөлөө; - дайнаас авах сургамж, дүгнэлтийг нээн тодорхойлж, ингэснээрээ орчин үеийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд баялаг материал болдог”¹³.

Шууд практикаас үүдэн тодорхой онол буюу зөвлөмж (зарчим) болоод эргэж практикт нөлөөлж байдаг нь цэргийн урлагийн нэгэн онцлог. Тиймээс өнгөрсөн дайн байлдаан дээр дүн шинжилгээ хийж, түүний туршлагаас суралцах нь жанжин төдийгүй цэрэг бүхэнд байдаг бөгөөд үүний тулд цэргийн урлагийн түүх гэдэг салбар шинжлэх ухааныг хүн төрөлхтөн хөгжүүлж иржээ.

Өнөөгийн ойлголтоор “Цэргийн урлагийн түүх” нь цэргийн түүхийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд өнгөрсөн дайны түүхийг нэгтгэн дүгнэж, цэргийн урлагийн хөгжлийн үйл явцыг судлан, түүний зүй тогтлыг нээж, ингэснээрээ орчин үеийн цэргийн шинжлэх ухааны онолын хөгжилд тусладаг”¹⁴.

Цэргийн урлаг бол жанжид, цэргийн сэтгэгчдийн ажиглалт, туршлага дээр үндэслэн үй түмэн дайчдын цусаар бичигдсэн, дэлхийн ууган шинжлэх ухааны нэг юм. Цэргийн толь бичигт “Цэргийн урлаг” нь хоорондоо нягт холбоотой стратеги, тактикийн урлагаас бүрдэх бөгөөд тэдгээрийн үндсэн үзэл санаа нь дайны бодит хуулиудыг практикт хэрэглэх арга замыг зааж, стратеги, тактикийн аль алинд ижил үйлчлэх ерөнхий зүй тогтол болсон цэргийн урлагийн зарчмуудад илрэлээ олдог”¹⁵. "Цэргийн урлаг: Эх газар,далай тэнгис, агаар мандалд байлдааны ажиллагаа бэлтгэж явуулах онол, практик",тэр нь "стратеги, оператив /бага стратеги/, тактик"-аас бүрдэнэ хэмээн томъёолж байна¹⁶.

Зарчим гэдэг нэр томъёо нь латины principium буюу эхлэл, үндэс гэдэг үгнээс гаралтай үг.“Цэргийн урлагийн зарчим” гэдэг нь байлдааны бүх үндсэн төрлийн практикт нийцсэн, байлдаан, операц ба дайныг зохион байгуулж явуулах тухай үндсэн гол үзэл санаа, чухал зөвлөмж”¹⁷, "цэргийн ажиллагааг зохион байгуулах, бэлтгэн явуулахад баримталбал зохих үзэл санаа, үнэт зүйлсийн нэгдэл" гэсэн тодорхойлолтууд ноёлож байна.

Шинжлэх ухаан техник, цэргийн хэргийн хөгжлийг даган шинэ шинэ зарчим төрж гарч байхад хүн төрөлхтний хэдэн мянган жилийн дайн байлдааны түүхээр шалгарч өнөө хүртэл тогтонги байгаа зарчмууд ч байдаг. Түүнчлэн улс орнууд өөрсдийн цэргийн номлолтой уялдуулан цэргийн урлагийн зарчмуудыг нэрлэх нь ч байдаг.

¹³ Военный энциклопедический словарь.М.,1986;с. 301.

¹⁴ Мөн тэнд.с. 301

¹⁵ Мөн тэнд.с. 139

¹⁶ Цэргийн нэр томъёоны тайлбар толь.УБ.,2014.т.359

¹⁷ Савкин.В.Е. Основные принципы оперативного искусства и тактики.М., 1972.с.3

Өнөөгийн Оросын цэргийн мэргэжилтнүүд бол “Байлдаанд цэргийг удирдах нь хатуу тогтоосон загвар журамгүй гэдэг нь түүнд ямар нэгэн дүрэмгүй гэсэн үг бус. Тийм дүрэм нь олон мянган жилийн практикаар боловсруулсан *цэргийн урлагийн зарчимд* тусгалаа олдог. Эдгээр зарчмыг үл баримтлах нь заавал алдаа эндэл, бүр ялагдалд хүргэх ба эсрэгээр, эдгээрийг чадварлаг хэрэглэх нь амжилт, ялалтад хүргэнэ”¹⁸ хэмээн тодорхойлж байдаг.

Мөн энэхүү зарчим нь дарах болон сөнөөх /устгах, мөхөөх/ байлдааны алинд ч адил үйлчилнэ. “Дарах байлдаан”-аар дайсны цэргийг мохоон цохиж буруулуулан, ард иргэд мал хөрөнгийн зохих хэсгийг олзлон авдаг бол сөнөөх /мөхөөх/ байлдаан нь дайсагнагч улс, овог аймгийн төр, захиргааг бүрэн нурааж, ард иргэдийг дагуулан, газар нутаг, мал хөрөнгийг нь бүрэн эрхшээлдээ нэгтгэн авдгаараа ялгаатай юм. Орчин үеийн цэргийн шинжлэх ухаанд “дарах” нь тухайн анги нэгтгэл, салбарын хүн хүч, зэвсэг, байлдааны техникийн хөдөлгөөнийг хязгаарлах, удирдлагыг сарниулах буюу байлдах чадварыг түр зуур алдагдуулах нөхцлийг бүрдүүлэхүйц хохирол учруулахад оршино. Байны 25-30 хувийг жагсаалаас гаргавал дарсан гэж үздэг. Сөнөөх нь дайсны байлдах чадварыг бүрэн алдагдуулахуйц хохирол учруулахад оршино. Орчин үед бүлэг байны 50-60, тусгай байны 70-90 хувийг жагсаалаас гаргавал устгасан /мөхөөсөн/-д тооцно.

Чингис хаан, түүний жанжид, залгамжлагчид байлдаанаас байлдаанд туршлагажиж цэргийн урлагийн сангаа арвитгасаар иржээ. Жишээ татбал, Чингис хаан 1178-1202 оны зун хүртэл 14 байлдаан хийхдээ Жүрхэнийг эс тооцвол бүгд дарах байлдаан хийж ирсэн бол 1202 оноос эхлэн дан устгах /мөхөөх/ байлдаан хийсэн нь түүний байлдааны түүхэнд гарсан нэг эргэлт байлаа.

Цэргийн стратеги: нь дайны зорилгод байлдааныг ашиглах тухай сургаал буюу байлдаануудыг дайны ерөнхий зорилготой холбох урлаг”¹⁹ “Улс орон, зэвсэгт хүчнийг дайнд бэлтгэх, дайн стратегийн операцыг төлөвлөж хийх онол, практикийг багтаадаг цэргийн урлагийн бүрэлдүүн хэсэг, түүний дээд салбар. Стратегийн онол нь орчин үеийн дайны шинж чанар, зүй тогтол, түүнийг хийх олон аргыг судалж, дайн, сратегийн операц бэлтгэж хийх, төлөвлөх онолын үндсийг боловсруулна. Цэргийн стратеги нь цэргийн практик үйл ажиллагааны салбарын хувьд Зэвсэгт хүчний стратегийн зорилтыг тодорхойлж, түүнд шаардлагатай хүч хэрэгслийг урьдчилан тооцож, болзошгүй дайнд хүн ам, эдийн засаг, байлдааны ажиллагааны театр, зэвсэгт хүчнийг бэлтгэх, стратегийн операцыг төлөвлөх, зэвсэгт хүчнийг дэлгэн байрлуулах, дайны нөхцөлд цэргийн удирдлагыг зохион байгуулах, болзошгүй дайсны дайн, стратегийн операц хийх арга, боломжийг судлах зэрэг өргөн хүрээтэй асуудлыг боловсруулдаг. Цэргийн стратеги нь тухайн орны улс төрийн бодлого, цэргийн номлолын шаардлагаас урган гарах бөгөөд улс орны эдийн засаг, нийгмийн байгуулал, үйлдвэрлэл, шинжлэх ухаан, техникийн хөгжлийн төвшин, хүн амын улс төр, ёс суртхууны байдлаас их шалтгаалдаг. Цэргийн стратеги нь дайн, байлдаан хийхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж, оперативын урлаг, тактиктэй салшгүй холбоотой ба тэдгээрийн бололцоог цаг тухайд нь тооцож

¹⁸ Воровьев.И.Н. О тактике. -"Военная мысль.№1,3,5.М.,2002.с.20

¹⁹ Клаузевиц.К.О войне.М.,1998.с,

үздэг²⁰. *“Тактик нь зэвсэгт хүчнийг байлдаанд ашиглах тухай сургаал буюу тодорхой байлдаануудыг зохион байгуулж явуулах урлаг юм.*

Онолын эдгээр тодорхойлолтуудад тулгуурлан Хамаг Монгол болоод Их Монгол Улсын цэргийн урлагийн зарчим, стратег, бага стратеги, тактикийг улируулан судалж, түүхэн баримт түшиглэн босгохыг зорьжээ.

"Цэргийн урлагийн зарчим, стратеги" гэх зүйлд дээрх онол баримтлалын үүднээс Их Монгол Улсын хаадаас хийсэн дайн байлдаануудад шинжилгээ хийсний үндсэн дээр тэд цэргийн урлагийн дараах зарчмуудыг ягштал баримталж байжээ гэдгийг түүхэн баримтаар нотлон тодорхойлсон байна. Үүнд:

- *Улс төр /дипломат/, цэргийн бодлогын хослолын зарчим:*

- *Холбоотон, нягт харилцан ажиллагааны зарчим:*

- *Байлдааны өндөр бэлэн байдлыг хангах зарчим:*

- *Цэргийн ов мэх, сэтгэл зүйн цохилтын зарчим:*

- *Хурд-маневрын зарчим:*

- *Тасралтгүй, шийдвэртэй байх зарчим:*

- *Цэргийн аюулгүй байдлыг хангах зарчим:*

- *Үйл ажиллагааны чөлөөт байдлын зарчим:*

- *Тэмцэл хүмүүнлэг, энэрэнгүй байх зарчим:*

- *Ашигтай байрлалаас түрүүлж гэнэтийн цохилт өгч, байлдааны санаачилгыг гартаа авах зарчим:*

- *Хүч, хэрэгслээ гамнах зарчим:*

Зохиогч эдгээр зарчмуудыг нотлон гаргасны эцэст "Их Монгол Улсын хаадын баримталж байсан цэргийн урлагийн эдгээр зарчим дайн байлдааны ялалтын нь гол үндэс болж байжээ" гэсэн дүгнэлт хийсэн байна.

"Бага стратеги /Операци/" зүйлд дараах 5 операцийг яг байлдаан болсон газар орон дээр нь буулгаж тактикийн зураг зурж гарган цэргийн урлагийн шинжилгээ хийжээ. Үүнд:

- *Сартуулын операци*

- *Маневрын операци*

- *Нанжины задын операци*

- *Шайо голын тулалдаан*

- *Хөх мөрний операци*

Дээрх 5 операцийн шинжилгээний үр дүнгээр Их Монгол Улсын хаад, жанждын төлөвлөн хэрэгжүүлж байсан операци нь:

Нэгд. Асар өргөн фронт, нэн алс гүнтэй орон зайд төлөвлөн хэрэгжүүлж чадаж байсан тод онцлогтой байна.

Бат, Сүбэдэйн жолоодсон 3 замын арми өнөөгийн Киевээс хөдлөн Будапешт-д операци амжилттай дуусгаж байна. Чингис хааны армиуд Тэнгэр уулаас Арал тэнгис хүртэлх өргөн фронт, Сырдарьяа мөрнөөс Самарканд хот хүртэлх 700 км орчим гүнд гурван талаас Самаркандад зэрэг уулзан операциаа амжилттай дуусгаж байна. Өнөөгийн Бээжин, Люпаншань уул орчмоос цувран хөдөлсөн Мөнх хааны армиуд Бээжин-Ухань, Люпаншань уулаас-Ханой, Ханойгоос Хөх мөрний эрэг дээрх Ухань хот хүртэлх, тэндээс Сычуань мужийн төв хоорондын улс улс дамжин туулсан

²⁰ *Цэргийн нэр томъёоны тайлбар толь.УБ., 2014.т.355-356*

цөлх уудам орон зайд операц хэрэгжүүлж байна. Эдгээр орон зайн хэмжээ далайц нь дэлхийн II дайнд улс орнуудын фронтын гүйцэтгэж байсан үүргээс хэдэн арваас хэдэн зуу дахин илүү байна.

Хоёрт: Эдгээр операцид Их Монгол Улсын хаад, жанжид цэргийн урлагийн сонгодог зарчмуудыг яв цав баримтлахын зэрэгцээгээр хээрийн байлдааны болоод хот сууриныг дайлах арга, барилуудыг дангаар буюу давхарлан нэн уран чадмаг хэрэглэж байсан нь харагдаж байна.

Гуравт: Бага стратеги /Операци/-ийн урлаг нь улс орон, түүний батлан хамгаалах чадвар, зэвсэгт хүчний нь дайтах, байлдах чадварын нь сорил болсон шалгуур үзүүлэлт байжээ гэсэн дүгнэлт хийсэн байна.

1.3. "Тактик" гэсэн зүйлд Их Монгол Улсын цэргийн аяны болон байлдааны журмын зохион байгуулалтыг сурвалж, судалгааны зохиолуудын мэдээллийг харьцуулан судалсаны үндсэн дээр зураглан гаргаж, үндэслэл тайлбарыг сийрүүлэн, монгол цэргийн аяны ба байлдааны журмын нягт уялдаа холбоо, тэдгээрийн давуулиг чанар, ач холбогдлыг тодорхойлжээ. Тухайлбал,

1. Аяны ба байлдааны журмын хамгийн ашигтай хувилбарыг монголчууд бодож, туршиж олсон байжээ.

2. Шаардлагатай үед гүнээсээ шинэ сэргэг хүч татан өвөр эгнээгээ солих буюу хүч сэлбэх, хэд хэдэн угсраа цохилт өгөх, чухал чиглэлд чөлөөтэй маневрлах бололцоогоор хангадагт ийнхүү гүн цувраажуулсан байлдааны журам үлэмж давуу талтай аж.

3. Гүн цувраажуулсан салбар ангиуд байлдаанд гэзэг даран орохул нэг нь нөгөөгийн нөөц хүчин маягаар хэрэглэгдэх боловч анги бүр бие даасан үүрэгтэйгээр байлдаж бас болдог.

4. Тактикийн хувьд харилцан ажиллагаатай буюу эсвэл бие даасан үүрэгтэй бүлэг цэргүүдээс /баруун, зүүн, төв/ бүрдсэн өргөн фронт нь дайсанд нэгэн зэрэг хүчтэй цохилт өгөх, хажуугаас юмуу аль ч зүгээс гэнэтийн цохилт ирэхэд гүн тийшээ гурван цувраатайгаар тулалдах бололцоо олгож буйн дээр дайсанд бүслэгдэх аюулаас чөлөөлж байна.

5. Аяны ба байлдааны журмаа 9 бүлэгт хуваан "жижиглэсэн" нь цөөнөөр олныг цохих ажиллагааны нь бодлоготой нягт холбоотой бөгөөд морьт цэргийн маневрын чадварыг дүүрэн ашиглах зохион байгуулалтын чухал арга хэмжээ мөн. Байлдааны журмын энэхүү 9 бүлэглэлээ Чингис хаан хамгийн авьяаслаг, зоригтой 9 жанжнаараа толгойлуулдаг байсан бөгөөд "9 өрлөг" гэсэн үг үүнээс гарснаас биш 9 хүн байгаагүй гэсэн дүгнэлтэд хүргэнэ.

6. Байлдааны журмын аль ч бүлэг буюу эд эсэд хүн хүчний яс тогтсон тоо хэмжээ байсангүй. Жишээлбэл: баруун, зүүн гарын цэргийг хоёр бүлгээс, эсвэл нэг бүлгээс бүрдүүлж болох ажээ.

7. Аль ч үед гол цэрэг нь эцсийн цувраанд /хөтүүдийг эс тооцвол/ байдаг байна. Энэ нь гол цэргийн жагсаалд Монгол цэргийн туг сүлд, хааны ордон явах бөгөөд туг сүлд олзлуулах, эзэн хаанаа бариулах буюу алуулбал ялагдсанд тооцдог байсантай холбоотой. Түүнчлэн хааны орон гэр, хатад хүүхэд, хамаг үнэт эд агуурс, хүнс тэжээл гол цэргийн жагсаалд явж түүгээр хамгаалуулж явдагтай холбоотой.

8. Монгол цэргийн байлдааны журмыг сайтар шинжвэл, уут шуудайны хэлбэртэй харагдах бөгөөд энэ нь санамсаргүй хэрэг бус дайсныг өгдөөн дуудах,

отох, төөрөгдүүлэх зүсэн зүйлийн аргаар энэхүү байлдааны журмынхаа “уутанд” буюу “нууранд” оруулж бүслэн бут цохих нь Их Монгол Улсын жанждын байлдааны бодлогын амин сүнсний нэгэн байв гэсэн дүгнэлт хийсэн буй.

"1.3.3. Хээрийн байлдааны арга" гэсэн зүйлд зохиогч сурвалж бичгүүдийг шүүрдэн үзэж судалсаны үндсэн дээр дундад зуунд монгол цэрэг хээрийн байлдаанд дараахь үндсэн 3 төрөл хэрэглэж байсныг тогтоожээ. Энэ нь:

- 1/ Дайрах (өнөөгийн цэргийн хэлээр “давших”);
- 2/ Буруулах (өнөөгийн цэргийн хэлээр “ухрах”);
- 3/ Хороолох (өнөөгийн цэргийн хэлээр “хориглох”) болно.

Энэ 3 төрлөөс дайрах, буруулах нь үндсэн, хороолох нь туслах төрөл аж.

Зохиогч,эдгээр төрлүүд нь дотроо баялаг олон аргуудыг багтаадаг, тэр бүр оноосон нэр томъёотой байсан нь монгол цэргийн урлагийн гайхамшигт үзэгдэл мөн гэж дүгнээд, монгол цэргийн хээрийн байлдааны дараах аргуудыг тодорхойлон гаргаж, мөн тэдгээрийн зургийг зурж тайлбарлан таниулжээ. Үүнд:

“Нуман түлхүүр”, “Хэрээ цэргийн дайралт”, “Нэхэх” ,“Үлдэх” ,“Дэрлэх”, “Тойрох”,“Нүүр дээр асгах”,“Алгинчлах”,“Харгана зорчил”,“Нуур байрт байлдах”,“Цүүц хатгаа”,“Буруулах”,“Нохой хэрэл”, “Өдөх”, “Бүгэх”, “Отоо”,“Цацсан одны жагсаал”, “Хүрээлэн хороолох”, “Шивээлэн хороолох”-Эдгээр аргуудын мөн чанарыг тодорхойлж, тус бүрд шинжлэх ухааны тодорхойлолт өгчээ.

1.3.4. Хот сууриныг байлдах арга"-зүйлд зохиогч хотыг байлдах арга нь 4 шат дараалан өрнөдөг гэж үзсэн байна.Үүнд:

Нэгд: Зэвсэг хөдөлгөлгүйгээр авах арга

Хоёрт: Хотоос нь гаргаж хээр талд байлдах арга

Гуравт: Бүслэн байлдах арга

Дөрөвт: Боймлон авах.

Улмаар эдгээр арга нь дотроо олон хувилбар барилуудтай болохыг оноон сийрүүлсэн буй.

Хоёрдугаар бүлэг. "Байлдааны хангалт"-д цэргийн агтыг ямар аргаар хэрхэн хангаж байсан, улс төр-цэргийн тагнуул, холбоо мэдээлэл, инженерийн хангалт, ар талын хангалтыг тухайн үед ямар аргаар, яаж зохион байгуулж байсныг сурвалж, судалгааны зохиолуудын мэдээллийн үндсэн дээр тодорхойлон бичжээ.

III АНГИ "Хамаг Монгол, Их Монгол Улсын цэрэг,зэвсэгт хүчний байгуулалт, Их Монгол Улсын дайны үр дүн"

"Цэргийн байгуулалт: Улс орныхоо батлан хамгаалах чадамжийг хангах, цэргийн хүчин чадлыг бэхжүүлэх талаарх тухайн улсын төрийн байгууллагаас авч хэрэгжүүлж буй хоорондоо харилцан уялдаа холбоо бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, мэдээллийн болоод цэргийн арга хэмжээний цогц. Улс орноо батлан хамгаалах төрийн бодлогыг тодорхойлох, дэс дараатайгаар хэрэгжүүлэхэд цэргийн байгуулалтын үндсэн арга хэмжээ чиглэгдэнэ²¹. **"Зэвсэгт хүчний байгуулалт:** Зэвсэгт хүчнийг байгуулах, бэхжүүлэх, бэлтгэх талаар хэрэгжүүлдэг харилцан уялдаа холбоо бүхий арга хэмжээний тогтолцоо"...

-“Зэвсэгт хүчний ай цэргийн хоорондын тоо, чанарын харьцаа,

²¹ Цэргийн нэр томъёоны тайлбар толь.УБ.,2014.т.347-348

-төрөл, тусгай болон мэргэжлийн цэргийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог тогтоох,

-зэвсэг техникээр зэвсэглэх, нөхөн хангах,

-цэргийн алба хаах журмыг тогтоох,

-байлдааны ба дайчилгааны бэлэн байдлын хангах,

-цэргийн нэгтгэл, ангиудыг байршуулах,

-батлан хамгаалахын материалаг нөөцийг бүрдүүлэх...зэрэг арга хэмжээг багтаадаг"²² гэсэн үзлийг баримталж судалгаагаа хийсэн байна. Энэ үзлийн үүднээс тухайн үед Хамаг Монгол, Их Монгол Улсын хаад цэргийн байгуулалтаа 5 шат дамжуулан хөгжүүлсэн хийгээд цэрэг-засаг захиргааны ямар **бүтэц, зохион байгуулалтад** оруулж /Үүнийг схемээр үзүүлэн тайлбарласан/, ямар зарчим баримталж байсныг сурвалж, судалгааны зохиолуудад түшиглэн тогтоожээ. Үүнд:

Хөгжлийн шатыг:

I шат. 1178 оноос 1189 он. Цэргийн байгуулалтын суурь тавьсан

II шат. 1190 оноос 1204 оны хавар. Цэргийн зохион байгуулалтаа аравтын тогтолцоонд шилжүүлсэн

III шат. 1205 -1206 он. Аравт, мянгатын тогтолцооны төгөлдөржил

IV шат. 1206 оноос хойш. Улс орныхоо аюулгүй байдлыг хангах, суурин орныг дайлах шаардлагад байгуулалтаа зохицуулан хөгжүүлсэн гэж үзжээ.

Цэргийн байгуулалтын зарчмын хувьд:

Тухайн үеийн Монгол орны нөхцөлд тохируулж, цэргийн байгуулалтдаа дараах зарчмуудыг баримталж ирсэн гэж үзсэн. Үүнд:

-Цэргийн байгуулалтыг төрөөс удирдах,

-Төвлөрсөн удирдлага, нэгтгэн захирах ёс,

-Байлдааны байнгын бэлэн байдал,

-Чанд сахилга,

-Цэргийн эрдэмд сургах зарчмуудыг голчлон баримталж иржээ гэж үзжээ.

Түүнчлэн, Чингис хаан, түүний залгамжлагчид цэргээсээ ямар сахилга шаардаж, тэрхүү чанд сахилгыг хүмүүжлийн ямар арга, зарчмаар дамжуулан суулгаж чадсан бэ? гэдэгт хариу өгсөн байна. Үүнд:

1. Төр, эзэндээ үнэнч шударга байх зарчим

2. Өтгөс, ихсээ хүндлэх зарчим

3. Эе эв, хамтын зарчим

4. Нөхрөө аврах

5. Үүргээ гүйцэтгэсэн цэрэг эрийг хүний өөрийнгүй хүндэтгэн дээдлэх ёс

6. Шударга хуулийн зарчим гэсэн 6 үндсэн зарчим баримталж байсныг түүхэн баримтаар нотлон сийрүүлжээ.

1.2. "Цэргийн сургалт, байлдааны бэлэн байдал" зүйлд Их Монгол Улсын цэрэгт цэргийн сургалтын тогтолцоо үйлчилж байжээ гэж дүгнээд сургалтын дараах хэлбэрүүд байсныг баримт түшиглэн сийрүүлжээ. Үүнд:

1. Хүүхдийг хар багаас нь ёс мэт морь унуулж улмаар нум сум харвуулж сургана.

2. Энэхүү бүх нийтийн сургалт, байлдааны бэлэн байдлын асуудал эмэгтэйчүүдийг ч тойрч гардаггүй

²²Цэргийн нэр томъёоны тайлбар толь. УБ., 2014. т. 170-171

3. Эрийн гурван наадам цэргийн сургалтын шалгуур байсан
4. Эрчүүд ан агнаж, нум сумаар харвах дасгал байнга хийдэг
5. Ав хомрого бол оператив тактикийн ажиллагаа боловсруулах цэргийн маневр, цэрэг иргэний хүнс бэлтгэлийн арга, нийтийн зугаа цэнгэлийг хослуулж монгол ахуй амьдралаас урган гарсан өвөрмөц үйл, сургалт байв.
6. Цэргийн тоглоомын хэлбэрийг Чингис хаан цэргийн сургалтад ашигладаг байжээ.
7. Тэмцээн зохиож ур чадвараа хөгжүүлэн, цэргийн өндөр боловсролтыг шалгаруулан гаргадаг арга Чингис хааны цэрэгт байсан байна.
8. Албан ёсны мэргэжлийн сургалт явуулдаг байв.
9. Ноёдын жилийн тайлан нь сургалт, байлдааны бэлтгэлийнхээ төвшинг тодорхойлон, ээлжит зорилт тавьж хэрэгжүүлэх чухал хэлбэр байжээ.
10. Цэргийн дээд удирдлагуудтай хийх оператив- тактикийн тоглолтын хэлбэрээр Чингис хаан жанждынхаа мэргэжлийн бэлтгэл, ур чадварыг хөгжүүлэхийн сацуу цэргийн байгуулалт, оператив тактикийн тулгамдсан асуудлуудыг боловсруулан шалгадаг байжээ хэмээн үзсэн байна.

1.3 дүгээр зүйлд Их Монгол Улсын үед хэрэглэж байсан зэвсэг, байлдааны хэрэгслүүдийг зориулалтаар нь ангилан 32 зургаар баримтжуулж үзүүлэв.

Зохиогч судалгааныхаа үр дүнгээр дараах дүгнэлтэд хүрсэн байна. Үүнд:

-Чингис хааны нэгтгэн байгуулсан Их Монгол улсын үе нь монгол цэргийн түүхнээ давшилтын стратеги давамгайлсан шинж чанартайгаар тодорхойлогдож буйгаараа онцлог. Монгол цэргийн тоо 10,5 түм хүрч, зэр зэвсгийн хувьд илд, жад, хутга, бялуу тэргүүтэн 9 төрлийн охор зэвсэг, нум, урвуур, харвуур, түншүүр, занчуур зэрэг 5 төрөл хэлбэрийн уртын зэвсэг, сөргөө хэмээх нэгэн төрөл хориглолтын зэвсэг болон дарьт, галт зэвсэг, нийт байлдааны 16 төрлийн зэвсэг хэрэглэж байжээ. Мөн туг хиур, зэвлэх морь, хуяг дуулга, төмөр гутал, үүлэн шат зэрэг нийт 15 төрлийн байлдааны хэрэгсэлтэй байжээ

-Тухайн цагийн “Монгол цэрэг-морь-нум” хэмээх хүчин зүйл бол хооронд нь салгахын аргагүй, давтагдашгүй онцгой чанартай, дайны хэрэглэгдэхүүн байжээ.

Монгол цэрэг ийм өвөрмөц шинж бүхий байлдааны хөдөлгөөнт хэрэгсэлтэй байсан нь хувьсах хөдөлгөөний (маневрын) боломжоор бусад улс орны цэргээс хавьгүй илүү байх нөхцөлийг бүрдүүлж, тэр нь тухайн үед дэлхий дахины цэргийн хэрэгт цоо шинэ зүйл болох дан морьт цэргийн маневрын тактикийг үндэслэн хэрэгжүүлэх боломж олгожээ.

- Монгол цэргийн гол зэвсэг нь нум сум, бусад улсынх илд, жад зэрэг охор зэвсэг байв. Эртний судлалын баримтыг түшвээс XIII зууны үед монгол туургатан наад зах нь 4-5 төрлийн эвэр нум, 7 бүлэг, 30 төрөл, хэлбэрийн төмөр, төмөрлөг зэв сум хэрэглэж байж. Зэв, сумын ашигтай тусгал 200-300 метр, хаймсах алсын тусгал 600-700 метрт хүрч байсан нь монгол цэрэгт тулалдааныг 200-300 метрийн алс зайнаас эхлэх боломж олгож байв. Энэ нь охор зэвсэгт суурин улсын ихэнх цэрэгт амжилттай тулалдах бололцоогүй холын зай байлаа;

-Их Монгол улсын цэргийн эрдэм ухаан, зэр зэвсгийн хөгжил хөрш зэргэлдээх суурин соёл иргэншилт улс орнуудынхаас илт давамгайл болж ирсэн учраас хүн ам, цэргийн тоогоор олон дахин илүү тэдгээр улс аймгийн эзлэн түрэмгийлэх бодлого, өнгөлзлөгийг таслан зогсоосноор барахгүй ахар богино хугацаанд эрхшээлдээ

оруулж, түүхнээ “Монголын үе” хэмээн нэрлэгдэх болсон эрин зууны эхлэлийг тавьжээ гэсэн дүгнэлт хийсэн байна.

1.4 дүгээр буюу **"Хууль цааз"**-ын зүйлд Их Монгол Улсын хаадын хэлбэрэлтгүй баримталж байсан Их засаг хуулийн цэргийн салбарт холбогдох заалтууд дээр шинжилгээ хийж, Чингис хааны цэргийн хууль цаазыг: Нэгт. Чингис хааны дотоодын байлдан дагуулал ба Хамаг Монгол улсын цэргийн цааз, Хоёрт. Их Монгол улс байгуулагдсаны дараах цэргийн цааз хэмээн ангилж, уншигчдад ойлгомжтой байхын үүднээс заримыг хүснэгтлэн тайлбарлаж сийрүүлсэн байна.

Тэрбээр, Их Монгол улсад мөрдөгдөж байсан “Их засаг” нь Монголын эзэн гүрний төрийн бататган бэхжүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэсэн юм. “Их засаг”-т захирагдан Монгол тугийн дор нэгдсэн морьт цэргээр тухайн цаг үеийн шилдэг технологийг ашигласан хүчирхэг армийг байгуулсан нь дэлхийн ямар ч улстай эн зэрэгцэх Их Монгол улсын батлан хамгаалах хүчин болж чаджээ.

Тэмүжин-Чингис хаан, түүнийг залгамжлагчид Их Монгол улсын тулгар төрийг байгуулж, Монголын эзэнт гүрнийг удирдахад хууль зүйн хамгийн дээд хүчин чадал бүхий, хүчирхэг тулгуур түшиг нь “Их засаг” хууль байсан бөгөөд Монгол цэргийн цааз хууль, байлдааны арга, тактик, стратеги, бодлого нь дэлхийн цэргийн түүхэнд баларшгүй ул мөрөө үлдээсэн юм хэмээн дүгнэжээ.

2.1 дүгээр зүйл буюу монгол цэргийн ялалтад нөлөөлсөн хүчин зүйлсэд зохиогч дараах хүчин зүйлсийг авч үзжээ. Үүнд:

Сөргөлдөгч дайсны хувьд:

Нэгд: Ази, Европын орнууд феодалын бутрал, дотоодын хямралд нэрвэгдсэн байсан нь монголд ялагдахын нэг шалтгаан байв.

Хоёрт: Шашны хагарал мөргөлдөөнд нэрвэгдсэн орнууд харийн довтолгооны зууш болж байлаа.

Гуравт: Чингис хааны эсрэг ард түмнээ жолоодон тэмцэх улс төр ба шашны шалгарсан удирдагч (Лидер) байсангүй.

Дөрөвт: Ази, Европ хаана ч монголын цэргийн хүчийг зөв үнэлж, түүнтэй дайтах, байлдах бодлогоо зөв боловсруулж чадсангүй.

Тавд: Гадаад харилцааны гол “хэл” нь дайн байснаас XII-XIII зууныг дамнан ер хаа сайгүй л дайтаж тэр нь бие биеийн хүч тамирыг барж сульдүүлсан нь сөргөлдөгч талын ялагдах, монгол цэргийн ялалтын хүчин зүйл болжээ.

Монгол цэргийн ялалтын хүчин зүйлс, давуу тал юунд оршив? гэвэл:

Нэгд: Дотоодын зөрчлийг давж, Чингис хааны байгуулсан нэгдмэл Их Монгол Улсын нарийн нягт зохион байгуулалт

Хоёрт: Цэргийн урлагт нэвтэрсэн монгол жанждын авьяас билиг

Гуравт: Дөрвөн улиралын хатуу ширүүн уур амьсгал, экологийн цэвэр хоол тэжээл бүхий Монгол хүний физиологийн өндөр чадамж

Дөрөвт: Тухайн үедээ дэлхийн цэргийн зэвсгээс хүчин чадлаар давсан монгол зэвсэг

Тавд: Цаг улирал, цас зудын алинд ч торохгүй монгол морины чадавхи

Зургаад: Монголчууд-нүүдэлчдийн амьдралын хэвшлээс улбаалан тогтсон байлдааны бэлтгэл сургалт, байнгын дадлага

Долоод: Чингис хааны цэргийн зохион байгуулалт, чанд сахилгын ялалт байжээ хэмээн дүгнэж байна.

2.2 дугаар зүйлийн тухайд авч үзвэл:

Израилийн засгийн газрын гишүүн Эйтан Харлевын 1965 онд офицерийн сургуульд зориулан бичсэн “Монголын цэргийн тусгай отряд” номын оршилд тус улсын Батлан хамгаалах яамны сайд асан Шимон Пересийн өгүүлсэн “Гарамгай зохион байгуулагч, цэргийн догшин жанжин Чингис хаан хоёр тивийн хөрс шороонд гүнзгий ул мөрөө үлдээж...дэлхийн ихэнх орны ард түмний түүхэнд нөлөөлөөгүйсэн бол үлгэр домог төдий үлдэх байлаа. Тэрээр...цэрэг дайны цоо шинэ түүхийг цогцлоон бүтээж,...тухайн үеийг хүртэл үзэгдээгүй хурд эрчим, хязгааргүй эр зориг, зохион байгуулах хосгүй авьяас, улс төрийн өвөрмөц бодлого баримтлалаараа тоотой хэдхэн бүдүүлэг овог аймгийг бүхий л саад тотгорыг гэтлэн туулагч, дэлхийн цараатай цохилтын хүч болгон хувиргасан юм” гэсэн үнэлгээ болон Английн цэргийн мэргэжилтэн, цэргийн алдарт түүхч Лиддель Харт: “Монголын аян дайн бол дайн, байлдааны зарчмууд, сахилга батын практикийн дээд зэргийн төгс үлгэр жишээ мөн бөгөөд дайн, байлдааны түүх судлаачдын хувьд ихээхэн үнэ цэнэтэй, эдгээр зарчмыг байлдааны тодорхой үйл ажиллагаанд хөрвүүлэхэд чухам юу юм бэ? гэдгийг ойлгоход тусалдаг хийгээд энэ нь цэргийн урлагийн тухай лекц (Катехизис) залхуутайгаар уншиж чадахаас огт өөр зүйл гэдгийг хэлэх хэрэгтэй” хэмээн цохон тэмдэглэцгээснийг бүх талаар батлан, дэлхийн цэргийн хэрэгт монголчуудын оруулсан хувь нэмрийг:

а. Цэргийн байгуулалтад

б. Цэргийн урлагт хэмээн хоёр хуваан толилуулжээ.

Тэдгээрийг Чингис хаан, түүний залгамжлагчдаас дэлхийн цэргийн хэрэгт оруулсан ширгэшгүй хувь нэмэр мөн гэж цохолжээ.

Ерөнхий дүгнэлт

-Хамаг Монгол, Их Монгол Улс байгуулагдсан нь монголын төдийгүй дэлхийн түүхийн онцгой нэгэн үзэгдэл байсан бөгөөд эдгээр улсыг байгуулахад тухайн үеийн монгол цэрэг тэргүүн зэргийн үүрэг гүйцэтгэжээ.

-Их Монгол Улс байгуулагдмагц хөрш орнуудын аюул занал идэвхжиж,үүний улмаас монголчуудын аян дайн эхэлжээ. 1205-1260 оны хооронд 55 жил буюу монгол тооллоор бараг нэгэн жарны турш харьд хийсэн их аян дайны шалтгаан нь Их Монгол Улсынхаа тусгаар тогтнолыг аюулаас хамгаалахын төлөө тэмцэл байсан учраас өөрийгөө хамгаалах шударга дайн хийжээ.

- Дайны зорилгоо хэрэгжүүлэх арга нь маневрын болон сэтгэл зүйн дайны шинжийг агуулж байна.

-Өөрөөсөө хэдэн зуу дахин илүү цэрэг, хүн амтай улс орнуудыг Их Монгол Улсын цэрэг ялан дийлж байсан нууц нь нүүдэлч соёл иргэншлийн давуу чанарт шүтэлцсэн цэргийн байгуулалт, цэргийн урлагийн зарчмуудыг яв цав баримталсан, бүтэц, зохион байгуулалт төгөлдөр, хурд, маневрын чадвараар тухайн үедээ хэтийдсэн монголын хөнгөн морьт цэргийн гайхамшигт оршин байжээ.

- Орчин үед дайн, байлдаан энэрэнгүй /хүмүүнлиг/ байх тухай ярьж, олон улсын хууль ч үйлчлэх болжээ.Тэгвэл энэ үзэл санааг Их Монгол Улсын хаад, жанжид дундад зуунд баримтлан хэрэгжүүлж байсныг түүхийн баримтууд өгүүлж байна.

-Хамаг Монгол, Их Монгол Улсыг байгуулан төвхнүүлэх тэмцлийн явцад монгол цэргийн жанждын хэдэн үе өсөн торниж, монгол цэргийн урлагийг төгс төгөлдөрийн туйлд хүргэж өгчээ.

-Тэдний үлдээсэн цэргийн соёл,цэргийн байгуулалт, цэргийн урлагийн зарчмуудын үзэл санаа, өнөөдөр ч ач холбогдлоо алдаагүй, сургамжтай хэвээр байна.

ГУРАВДУГААР БОТЬ ЮАНЬ УЛСЫН ЦЭРЭГ

“Юань улсын цэрэг” хэмээх эл боть удирдтгал, нийт 6 зүйл бүхий 3 бүлэг, төгсгөл, эш татсан сурвалж бичиг, судалгааны ном зохиолын жагсаалт, хавсралт бүхий нийт 210 тал хуудаснаас бүрдэж байна.

“Удиртгал-д уг сэдвийг судлах болсон учир шалтгаан хийгээд судлагдсан байдлын тоймыг дэлгэрэнгүй гаргасан ба нэгдүгээр бүлэгт Монголын Юань улсын мандал, буурал, төр, цэргийн бүтэц, зохион байгуулалт, хоёрдугаар бүлэгт Юань улсаас хийсэн аян дайн, гуравдугаар бүлэгт цэргийн зэр зэвсэг, байлдах, дайлах арга, тактикийн уламжлал, хөгжил хувьслын талаар хийсэн судалгааны үр дүнг багтаав.

“Юань улс, түүний төр, цэргийн бүтэц, зохион байгуулалт” гэсэн **нэгдүгээр бүлэгт** Юань улс байгуулагдсан түүх, Хубилай болон Аригбөх тэргүүтэн ноёдын зэвсэгт тэмцэл, Юаний төрийн байгуулалт, цэргийн бүтэц зохион байгуулалтын талаар дэлгэрэнгүй авч үзэв.

Чингис хаан нас барахынхаа өмнө дөрвөн хүүдээ Их Монгол Улсын нутаг дэвсгэрийг хуваан өгөхдөө отгон хүү Толуйд монгол ёс заншлаар язгуурын Монгол нутаг болон Умард Хятадын газар нутгийг тус тус соёрхож, Толуйг нас барсны дараа 1236 онд Өгээдэй хаан Хубилайд арван мянган өрх бүхий хүн амтай Хөбэй мужийн нэг бүс нутаг Синжоу (одоогийн Хөбэй мужийн Син тай) гэх эзэмшил газрыг өгсөн нь чанагшид Хубилай Хятадад төвлөрөн суурьших эх суурийг тавьжээ.

1251 онд Мөнх хаан Хубилайг дорно зүгийн цэргийн ерөнхий захирагчаар томилсны дараа Хубилай өөрийн ордоо Лянь Чуань (одоогийн Луан Хө-гийн Шан Юаний ойролцоо байгаа газар) гэх газарт байгуулав. 1256 оны хавар Хубилайн зарлигаар “Кайпин фу” (монголоор “Хүрдэн балгас” гэх утгатай) хотыг байгуулсан бөгөөд 1264 онд эл хотоо “Дээд нийслэл Шанду” гэж өөрчлөн нэрлэжээ.

Мөнх хааны зарлигаар тэрбээр Өмнөд Сүн улстай хийх байлдаанд оролцож эхэлсэн ба Хубилай 1258 оны 12 дугаар сард Кайпин фу дахь ордноосоо өмнө зүгийг зорин аян дайнд морджээ. Гэтэл ийнхүү түүнийг Сүн улсад дайтаж байх үед Мөнх хаан тэнгэрт хальсан бөгөөд Хархорумд Аригбөх хан суурийг залгамжлах бэлтгэлийг хийж эхэлсэн тул ханы суудалд эртнээс санаархаж асан Хубилай яаравчлан Кайпин хотдоо ирж, дэмжигчдийнхээ тусламжаар 1260 оны 5 дугаар сарын 5-нд Их хурилдайг хуралдуулж өөрийгөө их хан болсныг тунхаглан зарлажээ.

Жич, эл ташрамд өгүүлэхүй: “Хан” гэдэг нь тэр үед улсын эзний “Албан тушаалын нэр”, харин “Хаан” гэдэг нь их ханд өргөсөн цол байсан билээ. Тиймээс энэ тайланд бид албан тушаал буюу улсын эзний суудлын тухай яригдаж буй үед “Хан” гэдгээр нь, бусад тохиолдолд цолоор нь буюу “Хаан” гэдгээр нь бичсэн болно.

Хубилай тийн хан сууринд өргөмжлүүлж байхад нөгөө талд, 1260 оны 5 дугаар сарын 12-ноос 6 дугаар сар хүртэл Орхон голын эхэнд Монгол ноёдын Их хурилдай хуралдаж, Аригбөхийг “Их хан”-аар өргөмжилсөн байна. Ийнхүү тухайн үед Монгол Улсад хоёр хан сууж, хоёр нийслэлтэй болов.

Аригбөх хан ор суумагцаа Хубилай ахдаа элч илгээн: “Ману төрийн язгуурын зан хууль нь их ханыг хурилдайгаар тогтооно. Эдүгээ чи дээдсийн сургаалыг огоорч Хятад газар сууж, Хятад хууль дүрмийг дуурайн зоригоор үйлдэх нь юун?” хэмээн асуулгасанд²³ Хубилай үл тоомсорлосноор үл барам төдөлгүй ах, дүү хоёрын зэвсэгт тэмцэл эхэлжээ.

Ах, дүү хоёр 1260-1262 онд хэд хэдэн удаа тулалдаж ихэнхэд нь Аригбөх дийлдэж, төдөлгүй Цагаадайн улсын эзэн Алгуутай ч түнжин хагарснаас

²³ Балжинням Б. Дэлхийн монголчуудын түүх. Дөтгөөр дэвтэр. УБ. 2012. 346-347 дахь тал

Аригбөхийн хувьд байлдааны цагийн байдал таагүй болж, хоёр хүчтэй дайсны дунд хавчигдаж, хоёр фронтод хүчээ тарамдуулах болсноор барахгүй нутагт нь жил дараалан ган гачиг тохиолдсон тул цэргийн хангалт доголдож хоол хүнс, өвс уснаас эхлэн сум, жад тэргүүтэн зэр зэвсгийн болон хүн хүчний нөөцөө ч барж хүнд байдалд орсон байна.

Тиймээс Аригбөх арга буюу 1264 онд Хубилайд ирж буун өгч “буруугаа” хүлээснээр тэмцэл тулаан шувтрав. Түүнээс хойш 2 жилийн дараа буюу 1266 онд Аригбөх өвчнөөр нас барсан гэдэг.

Аригбөхийг тэнгэрт халимагц Хубилай “Илбэн тохинуулах яамны ерөнхий юаньшуайгийн ордон”-ыг байгуулж Хархорумыг шууд захируулжээ.

Ийнхүү дөрвөн жил үргэлжилсэн ах, дүү хоёрын тэмцэл төгсгөл болж Хубилай хаан Их Монгол Улсын хан суурийг эзэгнэн авав.

Гэвч Хубилай, Аригбөх нарын тэмцэл зөвхөн тэр хоёрын хувийн тэмцэл төдийхөн байгаагүйг түүхийн дараа, дараагийн үйл явц тодорхой харуулж байна.

1251 онд Толуйн удмынхан Их Монгол Улсын хан ширээнд суусны дараа 1250-иад оны үед Өгээдэйн удмын ноёдын “Хуйвалдаан” илэрч олон хүн цаазлуулснаас үлдсэн цөөн хүний нэг нь Өгээдэй хааны тавдугаар хөвгүүн Хашин ноёны хөвгүүн Хайду байв.

Хайду 1267 оноос эхлэн Хубилайн эсрэг идэвхтэй үйл ажиллагаа явуулж, хан ширээг Толуйн угсаанаас Өгээдэйн угсаанд эргүүлэн авахаар 50 шахам жил тэмцсэн бөгөөд 1301 онд Хархорумын ар дахь Хар хад гэдэг газар Төмөр ханы ач Хайсантай тулгаран байлдаж байгаад шархдан буцах замдаа нас баржээ.

Хубилай, Хайду нарын зэвсэгт тэмцлийг Хайдугийн хамсаатан Силжи, Тугтөмөр, Ширмэн, Зургаадай, Хадаан, Ёсухор ноён тэргүүтэй ноёд үргэлжлүүлж олон жил тэмцсээр байжээ.

Тэр үед монгол ноёдын эсэргүүцлээс гадна нанхиад үндэстний Ли Тан тэргүүтэй ноёдын тэмцэл, урвалт, бослого гарч тэр бүхнийг няцаан дарах шаардлага Хубилайд тулгарч байв.

Хубилай Аригбөхтэй хийсэн дайнд ялж, Ли Таны урвалтыг амжилттай дарснаар Хятадын дээдэс, ноёдын дэмжлэгийг олсон байна.

Хубилай хааны Өмнөд Сүн улсыг мөхөөж бүх Хятадыг нэгтгэх гэсэн хүсэл нь 1279 онд биелэлээ олсон хэдий ч эргэн тойрон дайсагнах улс гүрэнгүй болж, харь бүхий л улсыг эрхшээлдээ оруулж, газар нутгаа өргөтгөх гэсэн түүний хүсэл үүгээр хязгаарлагдсангүй. Тэрбээр хэдийгээр 1274, 1281 онд арлын Японыг дайлсан довтолгоон нь бүтэлгүйтсэн хэдий ч гүрэн улсынхаа аюулгүй байдлыг хангах геополитикийн зорилгын үүднээс Солонгосыг түшмэг улс болгон, Вьетнам, Бирм зэрэг Зүүн Өмнөд Азийн орнуудыг эрхшээлдээ оруулж, дөрвөн зүг найман зовхисоос өдөөх аюулгүй болгосон нь түүний цэрэг-улс төрийн бодлогын гол үр дүн байлаа.

Хубилай хаан Өмнөд Сүн улсыг мөхөөж Хятад орныг нэгтгэснээр 400 гаруй жил үргэлжилсэн дайн самуун эцэс болж, өөр өөр хэл соёлтой ард иргэд нэгэн жолоонд орсон төдийгүй Хятад орон цаашид хөгжингүй их гүрэн болж бүрэлдэх замдаа оржээ. Хубилай хаан хэдийгээр өөрийн эх нутгаа хөгжүүлэхэд анхаарч байсан боловч монголчуудын уугуул нутаг аажимдаа эзэнт гүрний төв байх шинж

чанараа гээж, дэлхийн соёл иргэншлээс тодорхой хэмжээгээр тусгаарлагдаж эхэлжээ.

Хубилай Их Монгол Улсын хан ширээг эзлэн Юань улсыг байгуулсны дараа түүний өмнө тавигдсан гол зорилго нь нэгдүгээрт, Юань улсыг Монголын эзэнт гүрний төв байлгах, хоёрдугаарт, бүх Хятадыг эрхшээх, гуравдугаарт, Монголын эзэнт гүрний нутаг дэвсгэрийг өргөтгөн тэлж дэлхийн эзэнт гүрнийг байгуулах явдал байв.

Тэгэхдээ Хубилай хааны эн түрүүнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь хууль цаазат төр, засгийг байгуулахад чиглэж байсныг харуулж байгаа бөгөөд Юань улсын нэг онцлог бол хууль цаазыг эрхэмлэсэн хаант төртэй байсанд оршино.

Юань улсын төрийн гүйцэтгэх засаглалыг Төвлөн засах яам (Төрийн хэргийг ерөнхийлөн захирах), Үйл таслах яам (бичгийн хэргийг мэдэх), зарга шийтгэх яам (дэвшүүлэх, бууруулахыг тогтоох)-аар бүрдүүлэв. Төвлөн засах яам нь дороо зүүн гарын гурван яам (Түшмэлийн явдлын яам, Сангийн яам, Ёслолын явдлын яам) ба баруун гарын гурван яам (Цэргийн явдлын яам, Шүүх явдлын яам, үйлдэх явдлын яам) гэсэн нийт 6 яамтай байв²⁴.

Мөн түүнчлэн улсын гол 6 яамтай харьцуулвал явцуу чиг үүрэгтэй, бүтцийн хувьд жижиг боловч мөн яам нэртэй байсан “Судар, түүхийн хүрээлэн”, “Мэргэдийн хүрээлэн”, “Судар бичгийн хүрээлэн ба монгол хөвгүүдийн сургуулийн хэрэг эрхлэх алба” зэрэг 15 байгууллагыг дараа дараалан байгуулжээ.

Хубилайн хаанчлалын эхэн үед орон нутгийн засаг захиргааны дээд байгууллага нь арван “Чөлгөөний илбэн тохинуулах яам” байсан бөгөөд төр, засгийн байгууламжийн дээр дурдсан тогтолцоо Юань улсыг оршин тогтнож байсан бүхий л үеийн турш үндсэндээ хадгалагдсаар байжээ.

Юань улсын үед уугал монгол нутаг нь “Давааны арын муж” гэж нэрлэгдэж байсан бөгөөд энэ нь Хархорум төвтэй, одоогийн Монгол Улсын нутаг дэвсгэр, түүнчлэн Байгал нуур, Алтай, Хангай, Урианхайн хязгаарыг багтаасан газар нутгаас бүрдэж байжээ. Харин Хятадын нутгийг засаг захиргааны 11 мужид хувааж, муж бүр дотроо зам, тойрог, хошуу, гацаанд хуваагдаж байв. Эдгээр засаг захиргааны томоохон нэгжүүдийг 25-аас дээш насны монгол даргач удирддаг байжээ.

Хубилайн дараа түүнийг залгамжлагч 10 хан төр барьж байв. Эрх мэдлээрээ ханы удаад хатан, хунтайж, хан хөвгүүд, угсаа төрлийн вангууд орж байлаа²⁵. Мөн Хубилай хааны үеэс ширээ залгамжлах хан хөвгүүн заавал Хархорумд сууж, бүх Монголын төрийн хэргийг ерөнхийлөн барьж, төрийн ёсонд биеэ боловсруулах, цэрэг захирах зэрэг үүрэгтэй болсон²⁶ онцлогтой.

Харин Хубилай хааныг таалал төгссөний дараа алтан ургийнхны дотор хан ширээний төлөөх тэмцэл томоохон тулгамдсан асуудал болж хувирсан бөгөөд тэр нь эцсийн эцэст улсыг мөхөөхөд шийдвэрлэх нөлөө үзүүлсэн хүчин зүйлийн нэг болсон билээ.

Хятадыг эрхшээж байсан Юань улсын Хятад дахь сүүлчийн хан Тогоонтөмөр хаан “Улаан алчууртны бослого”-ынхны хүчинд автан 1368 онд Дайдуг орхиж уугал Монгол нутагтаа очсон боловч 1370 онд 51 насандаа өөд болтлоо Юань улсаа

²⁴ Ганболд Ж, Мөнхцэцэг Т, Наран Д, Пунсаг А. Дээр дурдсан зохиол. 39-40 дэх тал

²⁵ БНМАУ-ын түүх. 3 боть, Тэргүүн дэвтэр. УБ., 1966. 303 дахь тал

²⁶ Далай Ч. Монголын түүх /1260-1388/. УБ., 1992. 62 дахь тал

сэргээн байгуулах бодлоо орхилгүй тэмцсээр байсан ба 1372 онд Монгол нутагт цөмрөн орж ирсэн Мингийн их цэргийг Хөхтөмөр жанжин тэргүүтэй Юаний цэрэг хиар цохисноор Юань-Мингийн харилцаанд үндсэн өөрчлөлт гарсан билээ.

Ийнхүү их ялалт байгуулснаар Мин улсын цэргийн түрэмгийллийг тас цохиж, цэрэг-дайны давуу байдлыг олж авсан төдийгүй Монголын төр улсын тусгаар тогтнол, гал голомтыг сахин хамгаалж чадсан байна. Тэгээд ч Мин улс Юань улсыг цэргийн хүчээр түрэмгийлэн давамгайлж чадахгүйгээ ухаарч харилцаагаа сайжруулах бодлогыг баримтлах болж 1374 онд хоёр улсын хооронд найрсаг харилцаа тогтоох хэлэлцээр байгуулжээ.

Эл нэгдүгээр бүлгийн 2 дугаар зүйлд Юань улсын цэргийн удирдах байгууллага, цэргийн бүтэц, зохион байгуулалтын талаар тодорхой өгүүлэв.

Юань улсыг байгуулмагцаа Хубилай хаан засаг захиргаа, цэргийн зохион байгуулалтад шинэчлэл хийсэн бөгөөд Юань улс төрийн хэргийг ерөнхийлөн захирах Төвлөн засах газар (中书省 zhong shu sheng), Үйл таслах яам буюу цэргийн эрх барих цэргийн явдлын яам (枢密院 shu mi yuan), албан тушаал дэвшүүлэх болон буулгах асуудлыг хариуцдаг Зарга шийтгэх яам (御史台 yu shi tai) гэсэн гурван гол яамтай байгуулжээ.

Үйл таслах яам, Төвлөн засах газар хоёр мөн цэргийн хэргийг хавсран хариуцдаг байжээ. Эдгээр гурван гол яамнаас гадна Шуан жэнь юань (宣政院 xuan zhen yuan) буюу Засаг уламжлах хороо гэж байв. Уг байгууллага нь Монголын Юань улсын үед бүх улсын бурхан шашны үйл хэрэг хийгээд Түвд орны төр, засгийн хэргийг голчлон шийтгэдэг газар байжээ.

Дээр дурдсан гурван яамнаас “Төвлөн засах” хэмээх байгууллага нь Юань улсын үеийн төрийн хамгийн дээд шатны, төрийн хэргийг ерөнхийлөн шийтгэх газар байв.

Төвлөн засах газрын дор харьяат 6 яам байдаг. Тухайлбал, баруун гарын 3 яаманд Цэргийн явдлын яам, Шүүх явдлын яам, Үйлдэх явдлын яам, зүүн гарын 3 яаманд Түшмэдийн явдлын яам, Сангийн явдлын яам, Ёслолын Явдлын яам ордог байсан байна.

Цэргийн явдлын яамны хэрэг мэдэгч нь Цэргийн явдлын яамны дэд түшмэлээс байр суурь, албан тушаал, эрх мэдлээр илүү байв. Цэргийн дээд албан тушаалд монгол болон өнгөт нүдтэн хүмүүс томилогдох ба хятад хүмүүсийг дэд түшмэлээс доош албан тушаалд л томилдог байв.

Говийн ард орших Монголын олон овог аймгийн төр, цэргийн нэгдлийг хангахын тулд Хубилай Монголын уламжлалт зүүн, баруун жигүүрийн түмтийн тогтолцоог татан буулгаж мянгатын ноёд Цэргийн явдлын яамны тушаал шийдвэрийг шууд дагадаг болгожээ. Юань улсын ордноос хэрэг мэдэгч түшмэл нэгийг томилж говиос хойших нутгийн цэргийн хэргийг захируулах болжээ.

Юань улс усан болон хуурай замын цэрэг гэх хоёр ай цэрэгтэй байв. Хуурай замын цэрэгт: морьт цэрэг, явган цэрэг, их бууч цэрэг, нумч цагдах цэрэг, аж ахуй арын албаны цэрэг багтаж байсан.

Юань улсын цэрэг Их Монгол улсын нэгэн адил аравтын тогтолцоонд суурилсан бүтэц зохион байгуулалттай байв.

Юань улс байгуулагдаж, бүх Хятадыг нэгтгэсний дараа Хубилай хаан улсын цэргийг ерөнхийд нь “Хэвтүүл цэрэг (宿卫)” болон “Орон нутгийн сахин хамгаалах цэрэг (镇戍) хэмээн хоёр хуваасан байх бөгөөд энд бид их бууч, усч цэрэг зэрэг ай, төрөл мэргэжлийн цэргийг тусгайд нь авч үзэв.

Юань улсын хэвтүүл цэрэг нь монгол цэргийн уламжлалт “Хишигтэн цэрэг” (怯薛) болон шинээр байгуулсан “Шадар хамгаалагч цэрэг” (侍卫亲军)-ээс бүрдэж байв.

Хишигтэн. Хубилай хаан хишигтэн цэргийнхээ тоог нэг түм болгосон ба Юань Вэнсуны (元文宗) үед хишигтэн цэргийн тоог 1,3 түм болгосон байлаа²⁷.

Юань улсын түүхийн туршид нийт гуч гаруй “Хэвтүүлийн захиргаа” байгуулагдсан байсан ба тэдгээрийг түмтийн ноёнтон тэнцүү эрхтэй захирагч ноён удирддаг байв.

Ийнхүү хишигтний байгуулалтын өвөрмөц тогтолцоо нь Монголын байнгын цэргийн гол цөм болсоор байв.

Шадар хамгаалагч цэрэг. Хубилай хаан Үйл таслах яамны саналыг хүлээн авч Жунтунгийн анхны онд /1260/ шадар хамгаалагч цэргийг байгуулсан ба анхны цэргүүд нь “Зэвсэгт хамгаалагч цэрэг” хэмээн нэрлэгдэж байв. Зэвсэгт хамгаалагч цэрэгт олон замын хятад цэргээс эрэлхэг зоригтой, шилдэг, чийргийг нь сонгон авч оруулдаг байжээ.

Шадар хамгаалагч цэрэгт дээрхээс гадна уугуул монгол цэрэг, мөн Тангуд (1281), Кипчак, Куча (1287 он), баруун орны буюу Архун цэрэг (1295 он), Канли (1308 он, 1311 онд татан буулгасан), Асу, Лунжэн цэрэг (1312 он), Луни цэрэг (1328 он), орос хамгаалагч (1331 он), вэйвү Асу цэрэг (1333 он) зэрэг хамгаалагч цэрэг багтаж байв.

Монгол тамачи цэргийн зарим хэсэг мөн Шадар хамгаалагч цэргийн бүрэлдэхүүнд багтаж байв. Арай хожуу мөн “Монгол шадар хамгаалагч цэрэг”-ийг (1280 он, 1303 онд зүүн, баруун хоёр жигүүрт хуваагдсан) байгуулсан байна.

Юань улсын үед нийтдээ 34 хамгаалагч цэрэг байгуулагдаж байжээ. Юань улсын сүүлчээр Шадар хамгаалагч цэргийн тоо 20-30 түмийн хооронд хэлбэлзэж байсны дотор нийт цэргийн 3/2-ыг хятад цэрэг эзлэх болсон байна.

Юань улсын шадар хамгаалагч цэрэг нь гүйцэтгэж буй үүргээсээ хамааран

-Тойрон хамгаалах цэрэг;

-Ёслолын цэрэг;

-Цагдан тойрох цэрэг;

-Шадар дагалт цэрэг;

-Дарангуйланх цэрэг;

-Сахиул цэрэг

-Таван хамгаалагчийн шадар цэрэг гэх зэргээр ялгаатай байв.

Орон нутгийн сахин хамгаалах цэрэг. Эл цэргийг төвийн “Үйл таслах яам” болон орон нутгийн салбар “Үйл таслах яам”-наас удирддаг байсан ба хил хязгаарын хол нутгийн цэрэг нь “Ухуулан тохинуулах журган”-ы “Бүгд юаньшуайгийн

²⁷ 高锐, 射国良, 李维民. 中国军事史略. 中册. 北京., 1992. 第292页

шилтгээнд захирагддаг байв. Тэдгээр цэрэг нь нийт улсын газар бүрт байрлаж сахин хамгаалах үүрэг гүйцэтгэдэг байжээ.

Хубилай хаан Сүн улсыг эзлэн авсны дараа “Орон нутгийн сахин хамгаалах цэрэг” нь:

-“Монгол цэрэг” (дан монголчуудаас бүрдсэн цэрэг), Монгол-нанхиад цэрэг (олон үндэстнээс бүрдсэн цоохор цэрэг);

- Юань улсын өнцөг булан бүрт тархан байрлах “Тамачи” цэрэг;

- дарангуйлан суух цэрэг;

-“Нөхвөр цэрэг” (хятад цэрэг болон Өмнөд Сүн улсын цэргээс бүрдсэн)

- “Нумч цагдах цэрэг” зэргээс бүрдэх болов.

Монгол сахин хамгаалах цэргийг таван том нэгтгэл (Шилтгээн)-д хувааж байв. Үүнд:

1. Хөнань, Хуайгаас хойших Монгол цэргийн түмтийн шилтгээн;
2. Шандун, Хөбэйгийн монгол цэргийн “Бүгдийг хянах шилтгээн;
3. Сычуаны Монгол цэргийн бүгд түмтийн шилтгээн;
4. Шэньсигийн Монгол цэргийн бүгд түмтийн шилтгээн;
5. Зүүн чөлгөөний Монгол цэргийн ванхуфу.

Түмтийн тогтолцоо нь монгол цэргийн зохион байгуулалтын үндэс болсон хэвээр байсан ба Сүн улс мөхсөний дараа тамачи цэргийн нэг хэсэг нь хамгаалах цэргийн бүрэлдэхүүнд орсон ба ихэнх нь Шандун, Хөнань, Шэньси, Сычуань зэрэг цэргийн хүч хэрэгтэй газруудад суух болсон бөгөөд тэдний ар гэр ч мөн дотор газар нүүн ирж суурьших болжээ.

Хубилай хаан стратегийн чухал ач холбогдолтой газар, эзлэн авч чадаагүй улсын хил залгаа нутагт болон үймээн самуун дээрэм тонуул ихээр гардаг газарт Ерөнхийлөн захирах газар байгуулах, цэргийн хүчийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ авч байжээ.

Юань улсын үед мөн дээрх цэргээс гадна улсад хүнс будаа нийлүүлдэггүй, цэргийн бүртгэлд ордоггүй боловч дайн байлдааны үед их цэргийг даган явж уухайлан хашгирч сүр хүч нэмэх, уулгалан булаах, түйвээн бусниулах зорилготой тусгай цэрэг зохион байгуулдаг байсан ба тэднийг “Дархан” (答剌罕)²⁸ хэмээн нэрлэж байжээ.

Юань улсын төрөл мэргэжлийн цэрэг нь их бууч цэрэг, усч цэрэг болон тэсэлж дэлбэлэх, зам гүүр тавих зэрэг цэргийн инженерийн ажил гүйцэтгэдэг тусгай зориулалтын анги, салбаруудаас бүрдэж байв.

Юань улс байгуулагдсаны дараа Монголын олон овог аймгууд урьдын адилаар насанд хүрсэн эр хүн (15-70 нас) бүр эр цэрэг болдог, бусад үндэстний ардууд цэргийн албанд хүчээр явдаг байв.

Эрчүүдийг цэргийн албанд татахдаа “Өрх бүр 2-3 эртэй бол нэг хүн, 4-5 эртэй бол 2 хүн, 6-7 эртэй бол 3 хүнийг” цэрэгт татах хуультай байжээ. Энэ хуулийг монгол айл өрхөөс цэрэг татахдаа баримталж байжээ. Үүний зэрэгцээ Хятад газар байсан Юань улсын цэргийн нөхөн хангалтыг цэргийн өрхөөс цэрэг татах аргаар явуулж

²⁸ 中国军事通史第十四卷-元代军事史. 军事科学出版社. 1998. 第188 页

байжээ. Цэргийн өрх гэдэг нь хятад газар нүүн очсон монгол айл өрх хийгээд эзлэн авсан Алтан улс, Сүн улсын буун өгсөн цэргийн ар гэр юм²⁹.

Эцэст нь өгүүлэхэд Хубилай хаан Их Монгол Улсын нийслэлийг Хятадад шилжүүлж Юань улсыг байгуулснаар Их Монгол Улсын төдийгүй хятад цэргийн бүтэц, зохион байгуулалтад нэлээд өөрчлөлт оржээ. Тэрбээр Их Монгол Улсын үеийн төр, цэргийн нэгдмэл зохион байгуулалтыг өөрчилж, төр, цэргийн салангид бүтэц зохион байгуулалтай болгожээ. Энэ бүтэц, зохион байгуулалт нь нүүдлийн болон суурьшмал соёл иргэншилт ард түмнийг багтаасан асар өргөн уудам газар нутгийг нэгтгэн захирах тохиромжтой хэлбэр байсан байна.

“Монголын Юань улсаас явуулсан аян дайн” хэмээх хоёрдугаар бүлэгт Сүн, япон болон Аннам, Ява, Тямпа зэрэг зүүн өмнөд азийн улс орнуудыг дайлсан байлдааны ажиллагаануудын талаар тодорхой өгүүлэв.

Монголын их цэрэг Умард Хятадад довтлон Алтан улсыг эзлэн авах үед хятадын өмнө зүгт Сүн улс³⁰ ноёрхож байв.

Монголчууд Сүн улстай 40 гаруй жил дайн, байлдаан хийсэн ба бид Сүн улстай хийсэн дайн байлдааныг:

1. Өгээдэй хаан дайлсан нь (1235-1237);
2. Мөнх хаан дайлсан нь (1252-1259);
3. Хубилай хаан дайлсан нь (1273-1279) гэсэн гурван үе шатанд хуваан авч үзсэн бөгөөд энэ ботид Хубилай хааны Сүн улстай хийсэн дайн байлдааны талаар өгүүлэв. Харин Өгээдэй, Мөнх хаадын дайлааны талаар энэхүү “Монгол цэргийн түүх”-ийн 9 ботийн 2 дугаар ботид тодорхой өгүүлсэн болно.

Хубилай хаан 40 гаруй жил үргэлжилсэн Монгол, Сүн улсын дайныг ялалтаар төгсгөж, Тан улсаас (НТ 618-907) хойш хагаралтай байсан хятад үндэстнийг монголчууд нэгтгэж нэгэн төрийн жолоонд оруулжээ.

Хубилай 1260 онд хан сууринд сууснаасаа хойш улсынхаа газар нутгийг өргөтгөн тэлэх ёстой хэмээн үзэж байсан гэж судлаачид дүгнэжээ. Түүнээс гадна энэ нь орчин тойрноос учирч болзошгүй аюул занал, түрэмгийллийг урьднаас зайлуулах гэсэн геополитиктой нь ч холбоотой байв.

Тэрбээр Сүн улсыг эзэлж, Солонгосыг дагаар оруулсныхаа дараа эргэн тойрондоо дайсагнаж болзошгүй бүхий л улс орныг эрхшээн, цэрэг зэвсгийн хүчээр төвшитгөх бодлого баримтлах болжээ.

Энэ бодлогынхоо хүрээнд Японыг 1274, 1281 онд дайлсан боловч далайн хар салхинд флот нь өртөн бүтэлгүйтсэн билээ. 1254 онд Төвдийг, 1255 онд Далийг, 1257 онд Юньнанийг эзлэн аваад улмаар Аннам, Бирма, Тямпа, Ява арал дахь Сингасарагийн вант улсыг дайлжээ.

Аннам буюу Вьетнамын нийслэлийг анх 1257 онд Монголын цэрэг анх удаа Аннам руу довтлон нийслэлийг нь эзэлсэн ба 1261 онд Аннамыг буулган авч, Ттүнээс хойш хоёр улсын харилцаа 20 гаруй жил эвтэй найртай явсаар ирсэн боловч 1277 оноос зөрчилдөн тэмцэх болж, монгол цэрэг Аннам улсын нутагт 1285 онд нэвтрэн орж, нийслэлийг нь эзлэн авч байв. Мөн 1288 онд Аннамыг дахин

²⁹ Монгол цэргийн түүхийн товчоо. Тэргүүн дэвтэр., УБ. 1996. 296 дахь тал.

³⁰ Хятадын Сүн улс 960 онд байгуулагдсан ба XII зууны эхээр Зүрчидын Алтан улсад бутцохигдон 1126 онд нийслэл Нанжинаа алдаад Хөх мөрнийг гатлан урагш нүүж Өмнөд Сүн улс /1227-1279/-ыг байгуулжээ.

дайж, хоёр удаа довтолсон авч халуун нар, өвчин тахалд нэрвэгдэн бүтэлгүйтэн буцжээ. Ийнхүү цэргийн ажиллагаа бүтэлтэй болоогүй ч 1289 онд Юань улс Аннам, Чампа улсуудын эзэн вангуудтай энхийн гэрээ байгуулж, төрийн бүрэн бие даасан байдлыг нь хүлээн зөвшөөрч, харьяат улс гэсэн ёс төдий тохироо хийжээ.

Монголын цэрэг 1253 онд Дали улсыг эзэлсний дараа хуурай газраар Бирмтэй хиллэх болсон бөгөөд 1277 оны хавар Хуту ноён 700 морьт цэрэг авч Бирм рүү анх довтлов. Эхний тулалдаандаа монголууд хүчээр давамгайлж, Бирм цэргийг ухраасан авч тулалдааны гурав дахь өдөр Худу жанжин шархадсанаас мөрдөхөө зогсоож, маргааш нь Хятад руу буцжээ.

Мөн оны 11 дүгээр сард дахин довтолсон боловч аагим халуунаас дайжин арга буюу гэдрэг буцсан³¹ ба 1283 онд дахин довтолж 1283 оны 12 дугаар сар гэхэд монголчууд нийслэлийг нь эзлэн авсан байна. Бирмийн ван III Кансу Иравиди мөрний сав газарт зугтаажээ³². Гэхдээ тэрбээр 1285 онд элч зарж бууж өгснөө мэдэгдсэнд “Хаан эзэн түүнийг өршөөн соёрхож”³³ нийслэлдээ буцаж очихыг нь зөвшөөрчээ. Ийнхүү Монголын дагуул улс болсон бирмчүүд монголчуудыг Хятадаас хөөгдөн гарах хүртэл алба гувчуур өргөн барьсаар байжээ.

Хубилай хаан Бирмийг (1282) байлдан дагуулахын зэрэгцээ **Тямпа** улс руу (Энэтхэг-хятадын хойгийн зүүн өмнө этгээдэд оршиж байсан бөгөөд өнөөгийн Вьетнамын төв, өмнөд хэсэг) довтлов.

Юаний Сод жанжны цэрэг 1282 оны эцсээр Тямпын боомтод (өнөөгийн Бүгд Найрамдах социалист Вьетнам улсын Пиндин мужийн Гуйрэн хот) хүрч, 1283 оны 2 дугаар сарын 19-нд Тямпын нийслэл Дажоу хотыг эзлэн авав.

1284 онд Тямпын вангийн бүгсэн уул руу Юань улсын цэрэг довтолсон боловч амжилт олсонгүй. Дараа жилийнх нь эхээр Атахай жанжин 15000 цэрэг удирдан Содод туслахаар гарсан боловч намагт шигдээд олигтой үр дүнд хүрсэнгүй. Юань улсын цэрэг нэмэлт хүч ирээгүйн улмаас цааш давшилтад орох ямар ч боломжгүй болж улмаар 1284 оны хавар нутаг буцжээ.

Харин Юань улсын дараагийн дайралт ирэхээс эмээсэн Тямпа улс 1285 оноос эхлэн Юань улсад жил бүр цагаан заанаар алба өргөх болсон байна³⁴.

Өмнөд далайн Тямпаг нөлөөндөө оруулсан Юань улсын эрх баригчид түүнтэй хил залгаа оршдог Камбож улсад 1283 онд элч зарсан боловч тэд элчийг нь урьдын адил (Камбожууд 1278 онд Юань улсын элчийг барьж хорьсон) барьж хорьжээ.

Иймд Юань улсын цэрэг тэднийг довтолсон байна. Юань улсын дипломат болон цэргийн үйл ажиллагаа амжилтанд хүрч **Камбожийн** хаан 1285 онд Хубилай хааны ордонд элч илгээж, дагаар орох хүсэлтээ илэрхийлж алба өргөжээ.

1293 онд Юань улсын цэрэг Ява арал дахь Сингасарагийн вант улс руу довтлон мөн оны 4 дүгээр сарын 26-нд Даха-д анх шийдвэрлэх тулалдаанд хийж, явачууд 5 мянган хүнээ алдаж үлэмж их хохирол амсан ялагдал хүлээжээ.

Гэвч түүнээс хойших том, жижиг тулалдаануудад Юань улсын цэрэг төдийлөн амжилт олохгүй байсан ба эцэст нь Юань улсын Ши Би жанжин ар талаасаа

³¹ 中国战典. 上卷. 北京. 2008. , 第836页, 周良霄. 顾菊英. 元史. 上海., 2008. 第350页

³² Монголын эзэнт гүрний гадаад харилцаа. УБ., 1995. 104-105 дахь тал

³³ 元史. 卷二百一十

³⁴ Монголын эзэнт гүрний гадаад харилцаа. УБ., 1995. 106 дахь тал

тасарсны улмаас 3000 орчим цэргээ алдаж их хохирол амсаж ухрахад хүрчээ. Ийнхүү Сингасарагийн вант улсын эсрэг хийсэн байлдааны ажиллагаа амжилтгүй болж Юань улс цэргээ татан авахаас аргагүй болсон байна.

Монголчууд 1211 оны 5 дугаар сард өнөөгийн Бээжин хотын ойролцоо солонгос цэрэгтэй анх тулгарсан бөгөөд түүнээс хойш 1259 он (Солонгосын Кожон вангийн 46 дугаар он)-д хоёр улс найрамдал тогтоох хүртэл үндсэндээ 30 шахам жил үргэлжилж, нийт 6 удаа дайтан тулалдсан. Харин Монголын 6 дахь удаагийн довтолгооны дараа монголчууд ч, солонгосчууд ч бие биенийхээ эв эеийг олох бодлого баримталж эхэлснээр хоёр улсын харилцаанд шинэ үе эхэлсэн ажээ. Энэ байдал Юань улсыг мөхөх хүртэл тэдний хооронд дайн тулаангүй байсан түүхтэй.

Гэвч Солонгосын тал зарим үед хэлэлцээ, хэлцээнээсээ няцаж, 1356, 1367 онд томоохон зэвсэгт мөргөлдөөн гаргаж байв. Улмаар Юань улсын дотоод хямрал эрчимжиж, Солонгос байтугай улсууд хараа, хяналтнаас нь сугарч эхэлсэн 1374 онд Солонгосын Чао Ён жанжин 25600 цэрэг, 314 хөлөг онгоцоор Чэжү арал руу довтолж, 100 орчим жил эрхшээсэн Юань улсын ноёрхлыг таслан зогсоожээ.

Дээр дурдсан дайн, байлдааны зорилго, шалтаг, шалтгаан, ажиллагааны явцад дүн шинжилгээ хийвээс Хубилай хаан тэргүүтэй Юань улсын эрх баригчид гол дайсан болох Сүн улсыг мөхөөх, улмаар шинэ тулгар байгуулагдсан Юань улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хангах зорилгын үүднээс Зүүн өмнөд Азийн улс орнуудыг Сүн улстай эвсэн хүчирхэгжүүлэхээс сэргийлэх, бүс нутгийн хэмжээнд түрэмгийлэх аюулгүй болгох, эдийн засгаа хүчжүүлж олон улсын худалдаа, арилжааг хөгжүүлэх бодлого баримталж, эрхшээлдээ оруулаагүй улс орнуудтай найрсаг харьцахыг хичээж байсан нь илэрхий байна.

Харин гадаад улс орнууд Юань улсын элч зардасыг удаа дараа алж хөнөөн, улмаар Юань улсын тэр хавийн эзэмшил газарт халдах зэрэг үйлдэл гаргаж байсан нь дайн үүсэх шалтгаан болж байсан ажээ. Тэгээд ч их гүрний хүчиндээ эрдсэн шахамдуу тулгуу бодлого эрхшээлд нь орсон улс орнуудад хүнд дарамт болж байсан тул тэд Юань улсын эсрэг тэмцэж эхлэх нь зөвхөн цаг хугацааны асуудал төдий болсон байсан агаад төдөлгүй Юань улсын эрхшээлд байсан бүхий л улс орон тусгаар тогтнолоо сэргээхээр эсэргүүцэн тэмцэх болсон ажээ.

“Юань улсын цэргийн зэр зэвсэг, цэргийн урлагийн хөгжил” хэмээх гуравдугаар бүлэгт зэр зэвсгийн уламжлал, хөгжил, байлдах, дайлах эрдэм ухааны талаар өгүүлэв.

Юань улсын үед Монголын эзэнт гүрний Зэвсэгт хүчний бүтэц, бүрэлдэхүүнд гарсан өөрчлөлттэй уялдаатайгаар цэргийн зэр зэвсэгт ч багагүй өөрчлөлт хувьсал гарчээ. Тухайлбал, Зэвсэгт хүчин нь дан морьт цэрэг байхаа больж орчин үеийн ойлголтоор Монголын арми түүхэндээ анх удаа “Хуурай замын цэрэг” болон “Тэнгисийн цэрэг” хэмээх хоёр том “Ай” цэрэгтэй болж, хуурай замын цэрэг нь морьт цэрэг, явган цэрэг болон одоогийн ангиллаар бол “Инженерийн”, “Их бууны” гэх мэт хэд хэдэн төрөл мэргэжлийн цэргээс бүрдэх болжээ.

Гэхдээ цэвэр монгол цэргийн хувьд гол зэвсэг нь нум сум, байлдааны гол хэрэгсэл нь зэвлэх морь хэвээр байсан ба гагцхүү хот, цайзыг дайлах байлдаанд гал урвуур, чулуу урвуур, төрөл бүрийн хүчит харвуур, түншүүр, дарьт зэвсэг зэрэг бүслэлтийн техник хэрэгслийг түлхүү хэрэглэх болсон байв.

Харин Юань улсын цэргийн бүрэлдэхүүнд багтаж асан хятад тэргүүтэн улсын явган цэргийн гол зэвсэг нь илд, жад, холхувч нум зэргийн зэвсэг байсан ба тэд монгол хийцийнхээс гадна өөр өөрсдийн үндэсний хэлбэр хийцтэй хуяг дуулга, дадаж заншсан зэр зэвсгээ ч хэрэглэж байсныг түүхийн дурсгалууд нотолж байна.

Юань улсын морьт цэргийн агсамжид нум сум, саадаг хоромсого, илд жад, хутга, хуяг дуулга, бялуу шийдэм багтдаг байв.

Монгол цэргийн нум сумын ашигтай тусгал 200-300 метр, хаймсах алсын тусгал 600-700 метр хүрч байсан гэдэг.

Дундад эртний үед монгол цэрэг хоёр талдаа иртэй, шулуун “Дам /дэм/ илд”, “Ширвэх дам илд”, “Хотгор илд”, “Шөр илд”, “Ширүү”, “Мадга” хэмээх охор илд, “Чавчих илд”, “Сэрвээт жад”, “Морин жад”, “Жалан” буюу “Хануур жад”, “Хутган жад”, “Сарт жад”, “Дөрү жад (Дөрүгү жад, дөрөг жад, тор жад)” зэрэг олон төрлийн жадтай байжээ. Мөн бялуу, шийдэм, бэрээ, бороохой, сүх зэрэг дэлдэх, занчих, цавчих зэвсгийг өргөн дэлгэр хэрэглэж байв.

Монголчууд эрт цагаас ерөнхийдөө хоёр төрлийн бүтэц хийцтэй хуяг, тухайлбал, бүхэл биеийг бүтнээр халхлах “Өвч хуяг”, эсвэл богино хантааз маягтай “Охор хуяг” хэмээх хуягийг хэрэглэдэг байв. Харин Юань улсын үеийн Монгол бус үндэстний цэрэг гол төлөв өөрсдийнхөө үндэсний хэв маягийг хадгалсан хуяг дуулга хэрэглэдэг байсан нь сурвалж, судалгаанаас илэрхий байна.

Юань улсын төрөл, мэргэжлийн цэргийн зэвсэглэл ч өвөрмөц хийц, хэлбэртэй байв.

Эл гуравдугаар бүлэгт бид Юань улсын цэрэг “Хотон буу” буюу гал, чулуу урвуур, чөдөр оньс тэргүүтэн бүслэлтийн олон төрлийн техник хэрэгсэлтэй байсан тухай тодорхой өгүүлсэн.

Монгол цэрэг XIII зууны 20-иод оноос дарьт, галт зэвсгийг өргөн хэрэглэх болж, дэлхий дахинаа дарьт зэвсгийг үйлдвэрлэх, хэрэглэх технологийг таниулан түгээхэд гол үүрэг гүйцэтгэсэн билээ.

Юань улсын цэрэгт бусад улс, түүний дотор хятадаас гаралтай “Галт жад”, том жижиг “цоргилго (пуужин)”, утаат сум, дарьт тэсрэх бөмбөг зэрэг галт, дарьт зэвсгийн уугал хэлбэрүүд болсон зэвсгүүдийг өргөнөөр хэрэглэж байв.

Улмаар Жү шүний 3 дугаар онд (1332) онд хүрлээр цутгасан галт буу хийсэн нь дэлхий дээрх хамгийн эртний үхэр буу байлаа³⁵. Энэ бол өрнө дахинд галт буу цутгахаас даруй 40-50 жилийн өмнө Монгол цэрэг галт буу хэрэглэж эхэлсэн гэсэн үг юм.

Тийнхүү олон төрлийн бөмбөг, сум үйлдвэрлэж, гуурсан хоолой ашиглан харваж буудах болсноор анхны их буу (Пушка) буй болжээ. Тийм бууны хамгийн эртнийх нь болох 1288 онд үйлдвэрлэсэн буу Хятадаас олдсон бий.

Энэ бүх баримт нь монголчууд гол төмөр бүхий “жинхэнэ” их бууг зохион бүтээж, их бууны тусгай мэргэжлийн цэргийг мөн анх үүсгэн байгуулж, гол төмөртэй галт бууг усан онгоцон дээр анх суурилуулсан нь дэлхий дахины цэргийн хэргийн хөгжилд шинэ эриний эхлэлийг тавьсанг гэрчилж байна.

³⁵ Пунсаг А. Тэнгэрийн их Юань улсын түүхэн тэмдэглэл. Улаанбаатар. 2010 он. 37 дахь тал

Юань улс XIII зуунд дэвшилтэт технологи ашиглан хамгийн бат бэх хөлөг онгоц үйлдвэрлэж, хөлөг онгоцууддаа ус нэвтрүүлэхгүйн тулд каучук түрхдэг байсан бөгөөд төмөр огт ашигладаггүй байснаараа онцлог байна.

Хөлөг онгоцны зэвсэглэл нь галт зэв, сум харвагч “Тийрэлтэт харвуур” буюу шинэ хүчит урвуур, чөдөр оньс, “Буопао” хэмээн Хятад сударт тэмдэглэгдсэн “Цоргилго”, гол төмөртэй их буу зэрэг тухайн цагтаа шинэлэг, хүчтэйд тооцогдох зэвсгээс бүрдэж байжээ.

*

*

*

Юань улсын үе гэхэд Тангуд, Сартаул, Зүрчиний дайнд туршлагажиж мэргэшсэн Монгол цэрэг тухайн үеийнхээ шилдэг технологиор бүтсэн зэвсэг техникээр, түүний дотор хот суурины байлдаанд хэрэглэх бүслэлтийн техник хэрэгслээр өвч хангагдсан буюу тусгай замын мянгат, түмтүүд нь байлдан тулалдах газартаа очмогц тийм хэрэгслийг өөрснөө хийж угсрах чадвартай, тийм мэргэжлийн анги, багуудтай болчихсон байснаараа бусад үеүдээс өвөрмөц байна. “Монголчууд хот сууринг дайлах бүслэлтийн технологийг амжилттай эзэмшсэнээр барахгүй туйлын үр дүнтэй систем болтол нь хөгжүүлсэн юм”³⁶ гэж судлаачид дүгнэжээ.

Юань улсын цэргийн урлагийн уламжлал, хөгжил. Чингис хаан хийгээд Их Монгол Улсын төр-цэргийн зүтгэлтнүүдийн боловсруулан хэрэгжүүлж асан дайлах бодлого буюу цэргийн стратегийг Хубилай сэцэн тэргүүтэй Юань улсын удирдагчид цэрэг-улс төрийн цагийн байдлын огт өөр эрин үед, нүүдлийн болон суурин соёл иргэншлийн уулзвар зааг дээр, нийгэм, үйлдвэрлэхүй хүчний технологийн цоо шинэ нөхцөлд бүтээлчээр авч хөгжүүлсэн билээ.

Монголчууд цохилтын гол чиглэл болон туслах чиглэлүүдийг оновчтой тодорхойлж, дайны цагийн байдалд зохицуулан өөрчлөн хувьсгаж, цэргийн овыг дээд зэргээр ашиглаж, нууцлалыг чанд хадгалан дайснаа төөрөгдүүлэх, сатааруулах маневр, цохилтыг чадамгай хийснээр дайснаа ацан шалаанд оруулан мэхэлж чаддаг байсанд стратегийн гэнэдүүлэлтийнх нь гол арга оршиж байв. Үүнд хамгийн содон зүйл бол хүч хэрэгслийн маневр буюу одоогийн хэллэгээр “Маневрын дайны стратеги”-ийн хэрэгжилт юм.

Тэгээд ч олон тулалдаанд дайсны цэргийн жанжин нь монголчуудыг гарцаагүй яллаа хэмээн бодох агшин нь түүний армийн ялагдал хийгээд өөрийнх нь эцэслэлийн эхлэл болдог байжээ гэж судлаачид дүгнэсэн байна.

Тактикийн тодорхой аргуудын тухайд гэвэл Их Монгол Улсын цэргийн хэрэглэж асан “Өдөж хөдөлгөх”, “Нуур байр”, “Бух сэжүүр байр хийх”, “Өлөмлөх”, “Дэрэлгэх”, “Тойрох”, “Бүслэх”, “Бүчих”, “Нүүр дээрээс нь асгах”, “Нохой хэрэл хэрэх”, “Харгана зорчил зорчих”, “Хүрээлэх”, “Хороолох”, “Шивээлэх” зэрэг хориглолтын хэлбэрүүд зэрэг бүхий л арга цөм хэрэглэгдэж байлаа (Эдгээр аргын талаар 9 ботийн 2-р ботид тодорхой өгүүлсэнийг үзмү?).

Харин Юань гүрний үед хээрийн байлдаанаас илүүтэй хот цайзын байлдаан, гол мөрний хийгээд далай тэнгисийн байлдаан давамгайлах болсон нь түүний нэг онцлог байсан бөгөөд хот цайзыг дайлахдаа “**Гахай хорих**” хэмээх аргыг хэрэглэж “Хулгана орох зайгүй”-гээр бүчин бүслээд буулгаж авдаг байжээ.

³⁶ Храпачевский Р.П. *Военная держава Чингисхана. Москва. 2005 г. стр.256*

Гол мөрний байлдаанд хоёр талын эрэг дээр харвуур буюу “буу”-нуудыг нягт байрлуулж гол мөрнөөр давшин ирж буй хөлөг онгоцуудыг “буудах” аргыг өргөн ашиглах болов. Мөн хээрийн байлдаанд ч дарьт болон дарьгүй их, бага “буу”-нуудыг их хэмжээгээр ашиглах болсон нь энэ үеийн монгол цэргийн байлдааны нэг гол онцлог байв.

.....
Хубилай хаан Сүн улсыг мөхөөж Хятадын умард, өмнөд хоёр хэсгийг нь нэгтгэж Монгол төрийн нэгэн жолоонд оруулсан нь одоогийн бидний “Хятад” хэмээн нэрлэх болсон хан үндэстний олон зуун жилийн хагарал тэмцлийг зогсоож, хожим нь “Дундад улс” хэмээн өөрснийгөө нэрлэх болсон их гүрэн байгуулагдахын үндэс суурь болсон түүхэн их ач холбогдолтой үйл явдал байсан билээ.

Монгол цэрэгт сайн дураар элссэн, дагаар орсон, олзлогдон ирсэн олон улс орны цэргийн мэргэжилтэн, урчууд дархчууд Монголын эзэнт гүрний аж үйлдвэрийн салбарт ажиллаж өөр, өөрийн өвөрмөц арга технологийг нэвтрүүлэн бие биенээс харилцан суралцах боломж нээгдсэн байв. Тиймээс Монгол цэргийн хэрэглэж байсан зэр зэвсэг нь хүртэл тухайн үедээ өвөрмөц агаад шинэлэг зүйл олонтой байжээ. Монгол нум сум л гэхэд хамгийн хүчтэй, төгс төгөлдөр, хатангу хатууд тооцогдож байсан бөгөөд дарийг хятадад нээсэн хэдий ч дэлхий дахинд түгээн дэлгэрүүлэгч нь монголчууд бөгөөд бүр Хятаны үеэс галт буу үйлдэх болж, XIII зуунд усан онгоцон дээр гол төмөрт их буу суурилуулан тулалдаж байснаараа анхдагч нь байв. Хятад хэдийгээр галт, дарьт зэвсэг, гал чулуу урвуур, хүчит харвуур зэрэг олон төрлийн зэвсэг, техникээр тухайн үедээ тэргүүлэгч улс орны хэмжээнд байсан боловч монгол цэрэг тэднээс дутуугүй хүчтэй зэр зэвсэгтэй байсныг Юань улсын цэргийн их ялалт амжилт, Азид хийсэн аян дайных нь түүх харуулж байна. Зөвхөн "Хотон буу"-г хэрэглэсэн түүхийг аваад үзэхэд л монгол зэвсэг хятадынхаас юугаараа давуу байсныг харуулах бодит баримт болно. Энэ нь дээр өгүүлсэнчлэн монголын үйлдвэрлэхүй хүчин, түүний дотор зэр зэвсгийн технологи нь ялангуяа араб, перс хийгээд бусад улс орны болон монголчуудын өөрсдийнх нь эрдэм ухаанаар бүтсэн техник, технологийн огтлолцол дээр бүтсэн цоо шинэ зүйл байсны тод томруун жишээ юм.

Түүний зэрэгцээ Хятад зэрэг дорнын улс орны цэргийн хэргийн хөгжил монгол цэргийн зэр зэвсэг, цэргийн хэргийн хөгжилд ч бас ихээхэн түлхэц өгсөн билээ.

Энэ нь Чингис хаанаас эхлэн түүний үе залгамжлагч монголын их хаад, түүний дотор Хубилай сэцэн хаан болон түүнийг залгамжлагчид үйлдвэрлэл, шинжлэх ухааныг хөгжүүлж, цэрэг армия хамгийн сүүлийн үеийн шилдэг зэвсэг техникээр хангахад онцгой анхаарч байсны үр дүн. Монголчууд олон улсын цэргийн байлдах, дайлах эрдэм ухааны хөгжилд ч шинэ эргэлт гаргажээ. Дундад эртний монгол жанжнууд дан морьт цэргийн хувьсах хөдөлгөөнд тулгуурласан өвөрмөц стратеги, тактикийг боловсруулан хэрэгжүүлж байсан нь зөвхөн тэр үедээ, дорно дахинд төдийгүй, дэлхий дахины хэмжээнд аваад үзсэн ч цоо шинэ зүйл байсан төдийгүй орчин үеийн цэргийн стратеги, тактикийн үндэс суурь болсон “Маневрийн дайн”-ы эх хувилбар болж өгсөн билээ.

Ийнхүү Юань улсын цэргийн жанжнууд, дундад эртний бусад монголчуудынхаа нэгэн адил дэлхий дахины цэргийн хэргийг хөгжүүлэхэд ихээхэн түлхэц өгснийг тэдний түүх харуулж байна.

**ДӨРӨВДҮГЭЭР БОТЬ
ЭЗЭНТ ГҮРНИЙ МОНГОЛ ЦЭРГИЙН ТҮҮХ**

Сэдвийн судлагдсан байдал. Монгол цэргийн түүхийн судалгаануудаас Их Монгол Улсын болон Юань улсын XX зууны үе харьцангуй ихээр судлагдсан байдаг бөгөөд харин Эл хаант улс, Цагадайн улс, Алтан ордны улсын цэргийн түүхийн судлгаа тун бага судлагджээ.

Ил хант, Цагадайн, Алтан ордны улсын цэргийн түүхийн судалгаа харьцангуй шинэ түүхийн судалгаа болно. Түүхчид ихэвчлэн улсын бүтэц зохион байгуулалт, аж ахуй, соёлын талаас нь судалдаг ч цэргийн түүхийн судалгааг орхигдуулж ирсэн нь өнөө үед судалгаа явуулахад ихээхэн хүндрэл учруулж байгаа юм. Гэсэн бид өөрсдийн бүхий л нөөц бололцоо мэдлэг туршлага дээрээ тулгуурлан дээрх гурван улсын цэргийн түүхийг цогцоор нь өргөн хэмжээнд судалж дуусгалаа.

Энэ чиглэлийн судалгаа нь ихэвчлэн Орос, Турк, Араб, болон бусад хэл дээр өргөн хэмжээнд судлагдсан ч Монгол хэл дээрх судалгаа гарын таван хуруунд багтахаар цөөн байна. Тухайлбал: Алтан ордны улсын цэргийн түүхийг доктор Т.Сүхбаатар судлан 2016 онд түүхийн ухааны докторын зэрэг хамгаалсан бол Цагадай болон Эл хант улсын цэргийн түүхийн судалгааг Монголд судалсан хүн хараахан алга байгаа бөгөөд бид энэхүү судалгаагаараа энэ орон зайг нөхөхийг хичээлээ.

Уг судалгааны ажил үндсэн 3 бүлэгтэй ба тухайн улсын түүхэнд гүйцэтгэсэн үүрэг жин нөлөөгөөр нь эхлээд нэгдүгээр бүлэгтээ Алтан ордны улсын цэргийн түүхийг, хоёрдугаар бүлэгтээ Ил хант улсын, гуравдугаар бүлэгтээ Цагадайн улсын түүхийг судлан боловсрууллаа.

АЛТАН ОРДНЫ УЛСЫН ЦЭРЭГ

§1.1. Алтан ордны улсын төр, цэргийн зохион байгуулалт.

Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүнд багтаж асан томоохон улсын нэгэн болох Чингис хааны ууган хүү Зүчийн (Жочийн ч гэх нь бий) байгуулсан улсыг монголчууд хан эзнийх нь нэрээр “Зүчийн улс” гэдэг байсан бөгөөд хожим нь төр барьж байсан удмынхны нь нэрээр Батын улс, Бэрхийн улс гэх мэтээр ч нэрлэж байв.

Харин оросууд “Государство Монголо-татар (Монгол-татаарын улс)”, “Татары (татаарууд)” гэж нэрлэдэг байсан ба монголчууд ханыхаа хүрээ, нийслэлийг “Ханы ордон”, “Орд” гэж ярьдгаас улбаалан оросууд хоорондоо бас товчоор “Орда” гэж ч нэрлэдэг байжээ.

Дундад эртний түрэг угсааны улс аймгууд Зүчийн улсыг “Улу Улус (Их улс)” гэдэг байсан ба баруун Европын сурвалжуудад “Comania” (Коман улс), “Dasht-i-Qifchag” (Дашт-и-Кибчаг буюу Кибчагийн тал) гэх мэтээр нэрлэж иржээ.

Харин “Алтан ордон (Золотая Орда)” гэдэг нэр томъёог анх 1566 онд хэвлэгдсэн “Казаны түүх (Казанская история)” хэмээх бүтээлдээ нэр нь үл мэдэгдэх нэгэн зохиогч хэрэглэсэн байх бөгөөд түүнээс хойш оросын түүхчид “Золотая орда” гэх нэр томъёог хэрэглэх болж, XX зууны дунд үеэс гадаадынхан төдийгүй Монголын түүхчид ч ийн бичих болжээ. Ийнхүү “Алтан” гэж нэрлэх болсны учир нь Зүчийн удмын хан ноёд орд өргөөгөө дотор, гадаргүй алт, мөнгөн эдээр чимэглэж байсантай холбоотой юм.

Бат хан 1242 онд “Кибчагийн аян”-аас эргэн ирээд эзэмшил улсаа төвхнүүлэх үе нь Их Монгол Улсын эзгүйрсэн хан ширээний төлөөх тэмцэл эрч хүчээ ид авч, тэрхүү өрсөлдөөнд Дөргэнэ хатны талынхан ялж, Өгэдэй хааны зарлигийг зөрчин Гүюгийг хан ширээнд залах нь тодорхой болж ирсэн цаг үе байлаа.

Тиймээс эцэг Зүчээс өвлөн авсан газар нутагтаа Хархорумаас харьцангуй тусгаар улс байгуулах, түүний тулд Гүюг хаанаас дутахааргүй хүчтэй цэрэг, армитай

байх зорилт түүний өмнө тулгарчээ. Гэтэл Бат ханы захиргаанд байсан монгол цэрэг харьцангуй цөөхөн байсан тул эргэн тойрон оршиж асан Булгар, Кибчаг болон бусад улс аймагтай зохицон урьд өмнө олон жил дайтаж эрхшээлдээ оруулсан тэдгээр ард түмнийг төрийн нэгэн жолоонд бат тогтвортой барьж, тэдний цэргийн хүчинд дулдуйдан тулгуурлахаас өөр гарц байхгүй байв.

Цэрэг улс төрийн цагийн байдал ийм онцлогтой байсан учир Бат ханы цэргийн бодлого ч түүнд зохицож, цэргийн байгуулалт нь ч цаг үе, орчинтойгоо нийцсэн өвөрмөц шинжтэй байжээ. Тухайлбал, Бат ханы цэрэг нь олон үндэстнээс бүрдсэн байсан ба цэргийн тооны хувьд авч үзвэл Кибчаг, Булгаар, алан, черкес, армян, мордов, орос, тэр ч байтугай мажар болон бусад овог аймгийн цэрэг дийлэнх нь болж байжээ.

Алтан ордны улсын арми үндсэндээ Чингис хааны тогтоосон аравтын систем дээр үндэслэгдэн монгол маягаар зохион байгуулагддаг байжээ. Цэрэг нь үндсэн гурван хэсгээс бүрдэж байв. Үүнд: баруун жигүүр, зүүн жигүүр, төв буюу их гол.

Төвийг улсын эзэн хан шууд удирдах бөгөөд баруун, зүүн хэсгийг ханы томилсон ноёд удирддаг. Төв хэсгийн цэргийн гол хүч буюу “их гол” нь ханы шадар туслах хишигтэн цэрэг байв. Цэргийн жигүүр бүр цэргийн хангамжийн нэгжтэй байж, түүнийг “Букаул” /интендант/ хэмээх цэргийн албан тушаалтан захирч байв. Жигүүр бүр нь түмт, мянгат, зуут, аравтад хуваагдаж байжээ. М.Горелик бас өөрийн бүтээлдээ төв, баруун, зүүн гэсэн бүтцийн талаар дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг. Энэ бүтэц цаашид ч хадгалагдан үлджээ. Бат ханы цэргийн гол хүчийг энэхүү монголчууд бүрдүүлж байсан боловч тооны хувьд авч үзвэл олонх хэсгийг исламын шашинт түрэг гаралтай хүмүүс зонхилж, мөн үнэн алдартны болон католик шашинт слав гаралтай болон кавказын уулынхан ч алба хашиж байжээ. Гэхдээ үе үеийн хангуудын цэргийн бүрэлдэхүүн, хүн хүчний тоо харилцан адилгүй байсныг дурдах ёстой.

1.1.2. Алтан ордны улсын цэргийн бүрэлдэхүүн дэх олон үндэстний цэргийн бүтэц зохион байгуулалт.

Булгарын цэргийн бүтэц зохион байгуулалтын талаарх анхны мэдээг X зууны үед Булгарт айлчлан очсон Багдадын халифатын элч Ибн Фадлана тэмдэглэж үлдээсэн байна.

X-XI зууны Булгарын цэрэгт барсил, эсгилей (чигилей), сувар, баранжар, мажар, (мажгардов-бажгардов), огузо-печенегов зэрэг овог аймгийн цэрэг алба хашиж байжээ. Булгарын холбоотон Кибчагууд зүүн өмнөд хилийг нь халхалж байв.

Монголчуудын довтолгооноос өмнөхөн, XII-XIII зууны үед Булгар цэргийн бүтцэд нэлээд өөрчлөлт орж, цэргийг овгийн ноёд бус “Эмир” захирах болж, удирдлага шаталсан тогтолцооны хэлбэрт шилжсэн байна. Тухайлбал, булгар цэрэг нь нэгд, эмирийн өөрийнх нь цэрэг; хоёрт, “Хашам” буюу овог аймгийн дээдэс, ноёд, тэдний шадар цэрэг (оросууд “Личная гвардия” гэсэн буй); гуравт, орон нутгийн “Беки” хэмээх ноёд, тэдний шадар цэрэг (“Дружина”) болон “Чирмеш” гэж нэрлэж асан дайчилгааны цэрэг; дөрөвт, мордов, кипчаг болон бусад улс аймгаас ирсэн хөлсний цэрэг; тавд, кибчаг зэрэг холбоотноос ирсэн туслах цэрэг болон хилийн харуулын цэрэг тус тус бүрдэж байв. Мөн Йори (Чури) гэж нэрлэсэн байдаг, европын рыцарь цэргийн маягийн хүнд зэвсэгт морьт цэргийн бие багууд ч үүсэн

байгуулагдсан байжээ. Монголын нөлөөнд байх үед энэ бүтэц үндсэндээ үгүй болж монгол цэргийн аравтын тогтолцоогоор зохион байгуулагдах болсон байна.

Кибчагууд эртнээс дайнч, нүүдэлчин ард түмэн байжээ. Тэд 1116-1236 он хүртэлх 129 жилийн дотор л гэхэд Оросын тал руу 5 удаа томоохон аян дайн хийж, Оросын өвөр хоорондын байлдаан тулалдаанд аль нэгнийх нь холбоотон хэлбэрээр 16 удаа оролцжээ.

Зэвсэг барих чадалтай бүхий л Кибчаг хүмүүс дайчинд тооцогддог байжээ. Византын түүхчдийн бичиж үлдээснээр Кибчагийн дайчид нум сум, жад, хотгор илд, төмөр ялтсан хуяг дуулгаар зэвсэглэсэн байжээ. Хөнгөн морьт цэрэгтэй, мөн морьдоо хуягласан хүнд морьт цэрэгтэй байв. Оросын судлаачдын бичсэнийг үзвэл кибчагууд цэргээ байлдааны журамд оруулахдаа тэргүүн анги-баруун гар-зүүн гар-хүнд морьт цэрэг хэмээх дөрвөн үндсэн хэсэгт хуваадаг байжээ.

Кибчаг цэргүүд Алтан ордны улсын бүрэлдэхүүнд орсны дараа Монголын эзэнт гүрний байлдан дагуулалтад оролцдог байсан бөгөөд Юань гүрний үед Хубилай хааны цэрэгт “Кибчаг цэргийн хороо” бий болжээ. Хубилай, Аригбөх, Хайду нарын тэмцэлд ч кибчаг цэрэг оролцож явсан мэдээ бий.

Алан (Асуд)-ууд скиф-сармат гаралтай нүүдэлчин түмэн. Нийтийн тооллын эхэн үеэр Готын хараат байхад нь өрнө зүгт нүүдэллэн очсон Хүннү нар Готуудыг бут цохиход Хүннүгийн захиргаанд оржээ. XIII зуунд Алтан ордны улсын захиргаанд орсон ба Кибчагийн аянд хан хүү Атачи-гийн удирдсан мянган оролцсон ба Эл хант улстай Бэрх ханыг дайтаж эхлэх үед аланууд идэвхтэй оролцон тусалж байжээ. Хятадын Сүн улсыг байлдан дагуулах үед ч мөн цэрэг нийлүүлж байсан ба Хубилай ханы хишигтэн цэргийн бүрэлдэхүүнд ч оролцож, алан цэргийн түмт Бээжингийн дэргэд тусгай үүрэг гүйцэтгэж байв.

Юань улс мөхөх үед алан цэрэг ч мөн ухран гарч Монголд очин суурьшжээ. Монгол руу олноор очиж суурьшсан аланчууд өнөөгийн Асуд аймгийн өвөг бөгөөд нутагтаа үлдэгсэдийнх нь удам одоогийн Осетууд юм. Монголын үеэс эхлэн Алтан ордны бусад цэрэг лүгээ адил аравтын тогтолцоогоор зохион байгуулагдах болжээ.

Арабын түүхч Ибн Дастын бичсэнээр эртний оросууд нь ойд амьдардаг, гол төлөв явганаар тулалддаг байжээ. Орос орон ой мод, намаг ихтэй байсан бөгөөд адууг голдуу зөвхөн аж ахуйн зориулалтаар ашиглаж байсан боловч цөөн тооны морин цэрэгтэй байжээ. Тиймээс Орос цэрэг гол төлөв явган цэргээс бүрдэж гол зэвсэг нь илд болон арбалет буюу холхивч нум сум, жад, байлдааны сүх зэрэг байжээ.

Цээживчтэй дуулга өмсдөг, зүүн гартаа хүнд бамбай, ардаа нум сум (хортой) үүрч, сэлэм, жадаар зэвсэглэдэг байсан байна. Харин X зууны үеэс эхлэн морин цэрэг үүссэн байна. Байнгын цэрэг арми гэж байхгүй шаардлага гарсан үед зэвсэг барих чадалтай бүхий л хүмүүс дайн тулаанд оролцдог байжээ.

Ер нь тухайн үеийн Оросын нийт вангууд 100 мянга гаруй дайчид цуглуулах боломжтой байсан гэдэг тооцоо бий. 1223 онд Калка голын хөвөөнд болсон тулалдаанд Оросын нэгдсэн арми 80.000 цэрэг гарган монголчуудын эсрэг байлдаж байсан билээ.

Гюнтер Штөклийн судалгаагаар Киевийн үеийн Оросын вангуудын цэрэг нь ихээхэн ялгаатай хоёр хэсгээс бүрдэж байжээ. Үүнд нэг нь вангийн шадар нөхөд, нөгөө нь дайчилгаагаар бүрдүүлдэг “Журамт цэрэг (Ополчение)” болно.

Вангуудын цэргийн гол хүч нь “Дружина” хэмээх цэрэг байв. Эл цэрэг нь дотроо “Ахлах” (старейшая дружина,) мөн “Бага” (младшая дружина) гэх ялгаатай. Ахлахад нь ван, бояр ноёдын зэрэг зиндаатай хүмүүс багтдаг байсан бөгөөд тэд сэнгүн (воевода), мянгатын ноён (тысяцкий) гэх мэт цэрэг, иргэний дээд тушаалтан байж, вандаа зөвлөх эрхтэй байдаг байв. Харин “Бага дружина (нөхөр-цэрэг)” нь доод тушаалын хүмүүс байсан бөгөөд вангийн орд өргөө ордны дэргэд байж ванд үйлчлэх, хамгаалах зэрэг үүрэг гүйцэтгэдэг байсан байна.

Мөн Орос болон Алтан цэргүүд Хятадын Ляоян муж буюу Солонгосын хил дээр алба хааж байжээ. Тэдгээр Оросууд байнгын оршин суугчид болж 1339 оныг хүртэл амьдарч байсан хэмээн хятадын албан ёсны түүхэнд тэмдэглэсэн нь буй. Мөн Алтан ордны улс өөрийн холбоотон байсан Египетийн мамлюкуудад кибчак болон орос боол мөн цэргүүдийг илгээж байжээ. Эндээс үзэхэд Орос цэрэг Алтан ордны улсын цэрэгт алба хаахын зэрэгцээ бусад холбоотон улсуудын цэрэгт ч гэсэн алба хааж байсан нь тодорхой харагдаж байна.

§1.2. Алтан ордны улсын цэргийн зэр зэвсэг, байлдааны хэрэгсэл

Алтан ордны улсын цэрэг явган болон морьт цэрэг, усч цэрэг, мөн одоогийн ойлголтоор их бууны, инженерийн гэх мэт тусгай мэргэжлийн цэргээс бүрдэж байсан нь тэдгээрийн зэвсэглэл, хүн нэг бүрийн агсамжид ч тусгалаа олсон байв. Тухайлбал улсын цэргийн “Гол хүч” нь болж байсан монгол цэрэг нь дан морьт цэрэг болон одоогийнхоор бол их буу, инженерийн мэргэжлийн мянгат зуутаас бүрдэж байжээ. Харин булгар, кибчаг зэрэг бусад бүрэлдэхүүн улс аймгийн хийгээд орос мэт түшмэг улсын цэрэг нь морьт, явган, усч цэрэг зэрэг холимог бүтэцтэй байсан. Оросын болон бусад үндэстний ихэс ноёдынх нь шадар цэрэг байнгын цэргийн шинжтэй “Дружинник”-үүд, тариачид, эгэл ардаас бүрдүүлдэг дайчилгааны цэрэг байжээ. Ижил орчим, Крым, Кавказ, бусад газраас гаралтай хөлсний цэргүүдийн зэвсэглэл нь өөр өөр байсан онцлогтой.

Судлаачид эртний цэргийн зэвсэглэлийг нийтэд нь байлдаанд хэрэглэгдэх зэр зэвсэг, байлдааны хэрэгсэл гэх үндсэн хоёр том бүлэгт хуваадаг. Үүнд:

“Зэр зэвсэг” хэмээх тодорхойлолтод дайтан тулалдах явцад хүн, амьтан, байгаль орчинд шууд аюул хөнөөл учруулах үйлчлэл бүхий зүйлсийг;

“Байлдааны хэрэгсэл” хэмээх ухагдахуунд байлдааны явцад хүн амьтанд хохирол учруулдаггүй авч тулалдаанд шууд нөлөөлдөг болон байлдах нөхцөлийг бүрдүүлэх үйлчлэл бүхий зүйлсийг хамруулдаг байна. Мөн хээрийн байлдааны болон хот цайзыг дайлах зэвсэг хэрэгсэл ч ялгамжаатай байжээ.

Алтан ордны улсын нөлөө, жишгээр орос болон бусад улсын цэрэгт галт, дарьт буу дэлгэрсэн бөгөөд 1382 онд Тохтамыш хан Москвад цөмрөн орох үед хоёр тал их буу хэрэглэж байсан байна. Энэ бол түүхэнд оросууд их буу хэрэглэсэн анхны тохиолдол юм. Энэ тухай Новгородын он дарааллын бичигт ч мөн тэмдэглэсэн байна.

1400 онд дарьтай буруу харьцсаны улмаас Москвад томоохон хэмжээний дэлбэрэлт болж гал түймэр дэгдэж байжээ. Энэ нь тухайн үед Орос оронд дарь хэдийнээ нэвтэрсэн гэдгийг харуулж байгаа юм.

1408 онд Москва хотыг Алтан ордны Эдигей бүслэх үед их буу хэрэглэж байсан байдаг ба Эдигей Москваг бүсэлснийхээ дараа Тверь рүү, их ван Иван Михайлович руу элч довтолгож их буутайгаа Москвад бэлэн байхыг тушааж байжээ.

Ийнхүү галт зэвсэг монголчуудаар дамжин Орост нэвтэрсэн бөгөөд галт, дарьт зэвсэг нь XIII зууны үеийн Монгол цэргийн төдийгүй дэлхийн цэргийн урлагт техник болон тактикийн шинэ үеийг авчирсан түүхтэй байна.

§1.3. Алтан ордны улсын цэргийн урлаг, стратеги, тактик

1.3.1.Цэргийн стратеги. Монголчуудын үйлдвэрлэхүй хүчний хөгжил, зэр зэвсгийн ир хат хийгээд амьдрал ахуйн хэвшил, ертөнцийг үзэх үзэл, эрдэм ухааны уламжлал зэрэг олон хүчин зүйл дайлах, байлдах өвөрмөц арга ухааны нь үүсэл, хөгжилд шийдвэрлэх нөлөө үзүүлжээ. Нэн ялангуяа хөрш зэргэлдээх улс аймгийнхнаасаа хүн хүчний тоогоор ямагт үлэмж дутуу байсан нь тоог бус, чанарыг эрхэмлэсэн олон аргыг байгаль орчин, дайн байлдааны цагийн байдалд зохицуулж санаачлан сэдэхэд хүргэдэг байв.

Чингис хааны үеэс улбаатай Монгол цэргийн жанжнуудын боловсруулан хэрэгжүүлж байсан цэргийн стратеги нь дайтагч улс орон хийгээд дайн, тулаан болгоны хувьд тэдгээрийн онцлог нөхцөлд тохируулсан өвөрмөц шийдэлтэй байсан учир харилцан өөр өөр байсан хэдий ч зарим нэг зарчмын нийтлэг хандлагыг агуулж байснаас, хамгийн түрүүнд ажиглагдаж буй зүйл бол “Улс орныхоо аюулгүй байдлыг хангах” гэсэн стратегийн нэг л зорилго тавьж байсан нь юм. Тэгэхдээ юуны өмнө дайсан этгээдээ эсэргүүцэлгүй юмуу өөртөө аль болох бага хохиролтойгоор буулган авахад чиглэгдэж байсан нь Монгол цэргийн жанждын боловсруулан хэрэгжүүлж асан стратегийн нэг гол онцлог байв. XIII зууны үе нь дэлхийн ихэнх улс орны цэргийн урлаг нэгэн хэв загварт баригдан зогсонги байдалд орсон бөгөөд тэдний “Цэрэг дайны стратегид давшилтаас хориглолт давамгайлж, ил задгай орон зайн байлдааны оронд бүслэлтийн (цайзыг хамгаалах, дайран эзлэх) дайн зонхилж”, “Хэрэм цайзын дайны стратеги” ноёрхож асан үе. Тэгээд ч олон жижиг ханлиг, ванлигууд өвөр зуураа тэмцэлдэн, орон нутгийн чанартай дайн байлдаан тасралтгүй үргэлжилж байв. Оросыг аваад үзэхэд л XIII зууны эхэн үед нэгдсэн төрт улс хараахан бүрэлдэн бий болоогүй байсан учраас бүх нийтийг хамарсан их аюул тулгарсан үед ч нэгдмэл цул удирдлага, зохион байгуулалттай цэрэг, армийг бий болгох чадамжгүй байжээ. Тийм учраас олон вангууд нь түр зуур эедэн нийлэлдэвч нэгдсэн бодлого, стратеги гэх юм байхгүй байдаг асаныг монголчуудтай 1223 онд анх нүүр тулсан Калка голын байлдаан харуулсан ба Кибчагийн аяны үед ч нэгдэж чадаагүй нь ялагдал хүлээх нэгэн гол урьдчилсан нөхцөл болж байжээ.

Дэлхий дахины байдал, цэргийн урлагийн хөгжлийн түүхийн энэ ерөнхий дэвсгэр дээр авч үзвэл Монголын нэгдсэн төрийн бодлого, цэргийн стратеги нь дэвшилтэт зүйл байсан нь илэрхий байна.

1.3.2. Байлдах арга (тактик)

Монгол цэргийн жанжнууд дайн, байлдаанд **тоог бус чанарыг эрхэмлэх зарчмыг** тууштай нэвтрүүлж, ямагт цөөнөөр олныг ялан дийлж байсан тактикийн өвөрмөц аргуудыг хэрэглэж байсан нь тэр үеийн дэлхий дахины цэргийн урлагт цоо шинэ зүйл байв.

Тэр үед олон улс даяар ноёрхож байсан гол хандлага бол улс аймгуудын цэрэг бүр байлдаанд ерөнхийдөө ямар нэгэн тогтсон хэв загварт баригдсан байлдааны журам, тактик хэрэглэдэг байсанд оршино.

Европын улсуудын шилдэг цэрэг болох Рыцарь хэмээх “Морьтон баатар”-ууд гэхэд “Шивээ”, “Бодонгийн толгой” буюу “Төмөр гахай” ч гэж оросуудын нэрлэж асан

байлдааны журам, түүндээ тохирсон тактикийг л байлдаанд зонхилон хэрэглэдэг байв.

Орос тэргүүтэн славууд ихээхэн хүчтэй “Төв” болон арай бага хүчтэй хоёр жигүүрийн нэг, нэг гурвалжин бүхий гурван гурвалжин жагсаалаар байрлаж тулалддаг.

Рыцариуд ч, славууд ч байлдааны явцад анхлан сонгосон тэр журам, жагсаалаа алдахгүйг эрмэлздэг байсан ба өөр тактикийн хувилбар бараг байхгүй байжээ.

Харин монгол цэргийн тактикийн үндэс нь дээр дурдсан маневрын дайны стратегийг хэрэгжүүлэх гол нөхцөл болсон дан морьт цэргийн хувьсах хөдөлгөөн буюу маневр болж байв. Байлдааны журмыг бүрдүүлэгч хэсэг, тэдгээрийн хүн хүчний тоо хэмжээ нь байлдаан бүрт харилцан өөр өөр байхаас гадна нэгэн тулалдааны явцад ч цагийн байдлын өөрчлөлтөд зохицуулан хүч, бүлэглэлээ хялбархан өөрчлөн хувьсгаж, гэнэтийн дайралт, сөрөг цохилт хийх боломжоор илүү байсан юм. Монгол цэрэг хүний тоогоор бусдаас ямагт үлэмж цөөн байсан авч түүний хүчин чадавх, цохилтын жин нь хурд, маневрын ачаар олон дахин нэмэгддэг байжээ.

Ийнхүү олон улсад, ялангуяа өрнөдийн орнуудад тархаж түгээд байсан байлдах аргын “тогтонги хэв загварчлал (Шаблон)”-ыг таягдан хаяхад хүргэсэн нь цэргийн урлагийн хөгжлийг зогсонги байдлаас гаргахад хүчтэй түлхэц өгсөн юм.

Доктор, профессор Х.Шагдар Чингис хаан хээрийн байлдаанд дараах үндсэн 3 төрөл хэрэглэж байсан, тухайлбал:

1. Дайрах (өнөөгийн цэргийн хэлээр “давших”);
2. Буруулах (өнөөгийн цэргийн хэлээр “ухрах”);
3. Хороолох (өнөөгийн цэргийн хэлээр “хориглох”) юм. Энэ гурван төрлөөс дайрах, бууруулах нь үндсэн, хороолох нь туслах төрөл гэсэн байх ба эдгээр төрлүүд нь дотроо баялаг олон аргуудыг багтаадаг, арга бүр нь оноосон нэр томъёотой байсан нь монгол цэргийн урлагийн гайхамшигт үзэгдэл юм хэмээн тодорхойлжээ.

Хээрийн байлдааны журам нь фронтын дагууд их гол ба зүүн, баруун гар гэдэг үндсэн гурван хэсгээс бүрдэх ба гүн тийшээ манлай, их гол, хөтөд хэмээх цувраануудаас бүрддэг байжээ.

Монгол цэргийн байлдаан нь цэргийн овыг дээд зэргээр ашиглаж, тактикийн гэнэтийн ажиллагааг сэтгэл зүйн довтолгоонтой хавсран дайсныхаа цэргийг цочроон сандаргаж, бараг зэр зэвсгийн сүр хүчнээсээ өмнө сэтгэлээр нь мохоох аргыг их хэрэглэдэг байсан учир байлдааны арга нь “Суман мөндөр буулгах болон шоконд оруулах (*Schocktaktik*)” тактикийн гайхалтай хослол байв” гэж судлаачид өгүүлсэн байна

§1.4. Алтан ордны улсын байлдан дагуулалт

Алтан ордны улс оршин тогтносон 300 орчим жилийн хугацаанд Сартуул болон Кибчагтай хийсэн аян дайнд голлох үүрэгтэй оролцож, Юань гүрнээс Сүн улсыг дайлсан хийгээд Азид хийсэн байлдаан, тулалдаануудад цэргийн хүчээр тусалж, гадаад, дотоодод нийт 200 гаруй удаа байлдаан, тулаан хийж, 80 гаруй хувьд нь ялан дийлж байжээ. Алтан ордны улсын зүгээс гадаадын улсуудын эсрэг

хийсэн дайн тулалдааны 25 хувьд нь, дотоодод явуулсан дайн тулалдааны 30 орчим хувьд нь Оросууд хамтран оролцож байжээ.

Булгар улсын нийслэл Булгар, мөн Кернек, Сувар хотуудыг эзэлж 1237 оны хавар гэхэд ижил мөрний Булгар Монголчуудад бүрэн эзлэгдсэн. Булгарыг эзлэн авсны дараагаар монголын цэрэг Кибчагийн нутагт цөмрөн оржээ.

Бат хан Кибчагийн нутагт цөмрөн ороод цэргээ 3 гар болгон хуваасан байна. Гүюг, Мөнхийн цэрэг Дон мөрөн, уамрд Кавказын чиглэлээр, Мөнх, Сүбээдэй нар Алан болон Кибчагийн чиглэлээр довтолж. 1237 оны өвөл гэхэд кибчагуудыг эзлэн авав. Кибчагийн хан Котян албат иргэдээ аван дутаан одож, бусад нь эзлэгдэн дагаар орсон боловч бослого хөдөлгөөн гаргасаар 1243 онд бүрэн дарагдсан байна.

Харин гол дайсан Котян хан 50 мянга орчим цэрэгтэйгээр өрнө зүг өөрийн худ Унгарын IV Бела вангийн зүг Оросын нутгаар дамжин явсан тул монголчууд ч Оросын нутагт цөмрөхөөс аргагүй болжээ. Тийнхүү монгол цэрэг Ижил мөрнийг гатлан Оросын вант улсуудын нутагт гурван замаар цөмрөн оржээ.

Бат хан Орос болон Европт явуулсан аян дайны ерөнхий зорилго биелсэн тул 1242 онд Кибчагын талд буцан ирж өөрийн улсын хөгжилд анхаарсан юм. Харин түүнийг залгамжилсан хангуудын үед гадаад аян дайныг нэлээд хийжээ. Алтан ордны улсын тэргүүн сайд Ногай 1265 онд Византи руу 1270 онд Литва болон Польшуудын эсрэг дайралт хийсэн боловч амжилт олж чадаагүй юм.

Мөнх-Төмөр хан 1271 онд Византийн Константинополь хот руу 1274-1275 оны өвөл Оросын Галиц-Волыны вангуудтай хамтран Литва руу, 1277-1278 онд Оросын ихэнх вангуудын хамт Осетин үндэстнүүдийг байлдан дагуулж Жулат хотыг (Оросын түүхэнд Дедакууд гэдэг) эзэлсэн байна. Энэ ялалтаар Алтан ордны улс Ар кавказад өөрсдийн байр суурийг бэхжүүлсэн юм.

Алтан ордны хан ширээнд 1380 онд Тохтамыш суугаад Бат ханы үеийнх шиг улс орноо хүчирхэг болгох үүднээс нэлээд өргөн хэмжээний аян дайныг эхлүүлсэн юм. Тохтамыш хан эхлээд 1383 онд Хорезм ба Азербайжаныг, 1386 онд Ширван болон Дербент руу, 1387 онд Мавераннахр руу, 1388- 1390 онд Төмөрийн эзэнт гүрэн руу байлдан дагуулалт хийжээ. Тухайн үед Хорезм нь эмир Төмөрийн (догolon Төмөр) мэдлийн газар нутагт тооцогдож байсан юм.

Ахмед ханы үед Алтан ордны улс дахин хүчирхэг болж ирсэн бөгөөд тэрээр 1480 онд Польш руу халдаж Мценск, Перемышь, Воротынск, Белев, Одоев, Козельск зэрэг хотуудыг 6 долоо хоногийн турш тонон дээрэмдэж байсан байна. Ахмед ханы хүү Шейх Ахмед хан 1500 онд Литва-тай дайтаж Литвагийн Рылск, Новгород-Северскийг эзлэн авсан нь Алтан ордны улсын түүхэн дахь гадаад улс руу халдсан сүүлчийн тулалдаан байжээ.

Алтан ордны улс гадаад улсуудын эсрэг аян дайн хийхээс гадна дотооддоо аян дайн хийж байжээ. Ялангуяа бослого үймээн гаргасан Оросын вангуудын эсрэг залхаан цээрлүүлэх дайныг олон хийж байсан юм. Монголын эрхшээлд байсан Оросууд Литва болон Польш, Византи зэрэг өрнөдийн улсуудтай нууцаар холбоо тогтоох гэж оролдож байсан, мөн Оросын их вангийн төлөөх тэмцэл зэргээс үүдэн сөргөлдөх болсон юм. Тиймээс Сарайн зүгээс залхаан цээрлүүлэх мөн бослогыг дарах шаардлагын үүднээс дотооддоо аян дайн хийх болсон юм. Алтан ордны улс Монголын эзэнт гүрний харъяа улсууд болох Ил хаант улс, Цагаадайн улс, Алтан ордны улсаас салан тусгаарласан Крымын хант улстай олон удаагийн дайныг

хийжээ. Энэ бол ахан дүүсийн, алтан ургийн хооронд болсон дайн юм. Монголчууд өвөр зуураа тэмцэлдээд л харилцан нэг нэгнийгээ бут цохисоор Орос гүрэн сэргэн мандах суурийг тавьж өгчээ. Тиймээс ч Оросууд энэ удаагийн тулгаралтыг “Стояние на Угре” гэдэг нь “Угра дахь сөрөн зогсолт” гэж түүх бичлэгт бичдэг.

Алтан ордны улсын сүүлчийн хан гэгддэг Шейх Ахмед өөрийн улсаас салан тусгаарласан Крымын хант улстай 1490, 1500 онд Черкесүүдтэй 1498-1500 оны хооронд байлдан ялсан ч 1502 онд Крымын хант улсад ялагдаж Алтан ордны улс мөхөх үндэс суурь нь тавигджээ.

Алтан ордны улс Ил хант улс хоёр 1262-1358 оны хооронд нийтдээ 100 гаруй жилийн турш байлдсан бөгөөд ихэвчлэн Ил хант улсын ялалтаар төгссөн юм. Нийтдээ 20 гаруй удаагийн том жижиг дайн болсноос 80 гаруй хувьд нь Ил хант улс ялж байжээ. Монголын эзэнт гүрний дотоодод болсон энэ дайн хоёр талын хөгжилд ихээхэн саад учруулсан нь дамжиггүй юм.

ИЛ ХАНТ УЛСЫН ЦЭРЭГ

“Эл бүлэг” Ил хант улс байгуулагдсан нь”, “Ил хант улсын төр, цэргийн бүтэц, зохион байгуулалт”, “Ил хант улсын гадаад, дотоод цэргийн бодлого, аян дайн” гэсэн хуудаснаас бүрдэж байна.

Ил хант улс (“Эл хант”, “Хүлэгүгийн улс”, “Иран дахь Монголын улс” гэх мэт нэрлэсэн нь ч буй)- ыг үндэслэн байгуулагч нь Чингис хааны хүү Толуйн Сорхагтани хатнаас төрсөн 5 дахь хөвгүүн Хүлэгү бөгөөд Перс буюу одоогийн Иранд төвлөрч асан түүний энэ улс 100 шахам жил оршин тогтносон түүхтэй.

Ил хант улсын нутаг дэвсгэр нь өнөөгийн Иран, Ирак, Афганистан, Туркменистан, Гүрж, Турк, баруун Пакистаныг хамарч байлаа. Гүрж, Трапензундын улс, Конийн султант улс, Киликийн Армени, Киприйн вант улс, Герат дахь куртын улс зэрэг улс аймгууд Ил хант улсын түшмэг улсууд хэлбэрээр оршиж байв. Улсын нийслэлээр эхлээд Мераге, дараа нь Тебриз, Сольтание, эцэст нь дахиад Тебриз тодорч байв.

Ил хант улсыг Хүлэгүгээс гадна 8 хан захирч Иранд төвлөрөн сууж байлаа.

Эл тайлангийн 2.1.1 дүгээр дэд зүйлд “Ил хант улс байгуулагдахын өмнөх Монголын цэрэг, улс төрийн цагийн байдал”-ын талаар өгүүлэв.

Өгээдэй хаан 1241 оны 12 дугаар сард өөд болсноос хойш 4 жилийн дараа шинээр сонгогдсон Гүег хаан Сүн улсыг байлдах төлөвлөгөөгөө үргэлжлүүлэхийн зэрэгцээ өрнө зүгийн аюулыг зайцуулах бодлого баримталж, “1247 оны намар Элжигдэй ноёнд цэрэг өгч Исмаилыг дайлуулахаар томилов. Тэгэхдээ 100 монгол айл тутмаас 1 эр, Иранд байсан цэргийн 10 хүн тутмаас 2-ыг тус тус гаргуулж Элжигдэйд хүч нэмжээ”. Ийнхүү монголчуудаас өрнө зүгт хийж асан аян дайны шинэ үе шат эхэлжээ.

Гэвч Гүег хаан Баттай учраа ололцохоор шийдэж Батыг Илийн хөндийд дуудаад өмнөөс нь аялан гарсан боловч зам зуураа чилээрхэж, 1248 оны 4 дүгээр сарын 24-нд нас баржээ.

Гүегийн үхсэнээс хойш Өгээдэй, Тулуйн үр удмынхны дундахь хагаралдаан тэмцэл улам өрнөжээ.

1251 оны 7 дугаар сарын 1-нд Монголын хан ширээнд Мөнх тодров. Гэтэл энэ нь 1218 онд Зүч, Цагаадай нарын хооронд үүссэн зөрчил үр удам дамжин улам даамжирч эхэлсэн үе байж таарсан бөгөөд Цагаадайн ач Бүри, Өгээдэйн хөвгүүн Гүег нар 1238 оноос Баттай тэрсэлдсэнээс болж зөрчилдөөн улам дэгжиж, эзэнт гүрний бүрэлдэхүүний улсууд бие даан салах хандлага газар авч эхэлсэн байв.

Мөнх өөр рүү нь халдаар ирсэн Ширэмүнийг баривчлан хорьж, 70 ноёныг нь цаазлан Өгээдэйнхэнийг номхотгоод, улмаар Цагаадайнхны “учрыг олж”, Гүегийн төрийн түшмэд Чингай, Элжигдэй нарыг шийтгэн, цаазлахыг нь цаазалж, цөлөхийг нь цөлж дуусгаад Өгээдэйн улсыг Цагаадайн улсад нэгтгэв. Өгээдэйнхнээс Хадаан, Хайду хоёр хаанд ирж мөргөсний учир өршөөв. Тэрбээр сайд ноёд хийгээд харьд суух даргач нараа шинэчлэн томилж, хан хөвгүүд дур дураар татвар татахыг хорив. Өртөөг цэгцэлж, зөрчигдсөн дүрмийг чангалав. Элдвийн шашныг адил хүндэтгэж, эе эвийг аль болохоор сахих бодлого барьж байлаа.

Энэ үед францын IX Луйс (Людовик) лалынхны (сарацины) эсрэг Монголтой хамтран ажиллах аргыг ахин идэвхтэй хайж эхэлсэн бөгөөд Мөнх хаан ч IX Луйс-д “Бид энх амгалан амьдрах ёстой”, “бидний эсрэг цэрэг гаргавал бид юу хийж чадахаа мэднэ” гэсэн “даруухан” үгтэй захидлыг хариу илгээсэн байв.

Гэтэл Багдадын Халиф буюу исмаилийнхны зүгээс учруулж болзошгүй аюул занал улам бүр даамжирч, тэр ч байтугай Мөнх хааныг алахаар завдаж, зүсээ хувиргасан 40 ассассиныг илгээсэн нь хааны ордонд харагдсан тухай сурвалж бичигт өгүүлсэн байна.

Ийнхүү Исмаилынхан илт дайсагнах болсон учраас Мөнх хаан тэднийг төвшитгөх шийдвэр гаргахад хүрч, тэр үүргийг Хүлэгү-д хүлээлгэжээ.

Тайлангийн 2.1.2 дугаар дэд зүйлд “Ил хант улс байгуулагдахын өмнөх үеийн Персийн цэрэг, улс төрийн байдал”-ын талаар дэлгэрэнгүй өгүүлэв.

Перс (Иран) нь 4-5 мянган жилийн түүхтэй эртний соёлт орон. НТӨ VI зуунаас ихэд цэцэглэн мандаж, НТ VII зуунаас доройтон, XIII зуунд одоогийн нутагтаа Аламут хотоор нийсэллэсэн Исмаилитын улс нэрээр оршиж, ард түмэн нь 360 гаруй хот цайзад тархан сууж байв.

Исмаилитын улс (1090-1256) нь “Аббасид халифын болон “феодалын төв засгийн эсрэг орон нутгийн ноёд, феодалуудын тэмцэл “Карматын хөдөлгөөний” үр дүнд XI зууны сүүлээр байгуулагдсан” ба исмаилитууд нь өөр улсын болон шашны толгойлогчдын аллага (террор)-аар нэрд гарч, хавь ойрын улсуудыг терророор айлган сүрдүүлж, гартаа атгасан байжээ.

Монголчууд хаяанд нь ирэх үед исмаилитын дээдсүүд урт удаан хугацаанд дайсагналцаж байсан суннитуудтайгаа эвлэрэх бодлого баримтлах болж, Монголын эсрэг илэрхий сөргөх бодлого баримтлах болов.

Тайлангийн 2.1.2 дугаар дэд зүйлд Хүлэгүгийн аян дайны эхлэл буюу Ил хант улс байгуулагдсан тухай тодорхой өгүүлэв.

1255 онд Мөнх хаан дүү Хүлэгүдээ их цэрэг өгч баруун өмнөд Азид үлдэж хоцрон, эзэнт гүрэнд байнгын аюул занал учруулж байсан Исмаилынхан болон Багдадын Халиф тэргүүтэн лалын шашинт улсуудыг дайлуулахаар мордуулав.

Хүлэгүгийн дайн, байлдааны бодлого нь цэрэг, дипломатын аргыг хослуулан аь болох бага хохиролтойгоор буулган авах, эс чадвал эдийн засгийн гол, гол төвийг олон замын цэргээр нэгэн зэрэг бүслэн цохиход оршиж байжээ.

Хүлэгүгийн аяны цуваа аажим аялсаар Цагаадайн улсаар дайрч, 1256 оны 1 дүгээр сарын 2-нд Амударья мөрнийг гатлаад чанагш шуурхалын аялж өвөл болоход Хорасан хүрчээ.

1256 оны гуравдугаар сард Хүлэгүгийн цэрэг Тус (Фердоус) хотод хүрсэн ба мөн оны 6 дугаар сард Исмаилитын султан хур Шах Рукн ад-Дин өөрийн дүү Шахын шахыг элчээр илгээн Хүлэгүд бууж өгөн “хаан төрд хоёр сэтгэлгүй зүтгэхээ” илэрхийлжээ, Гэвч энэ нь цаг хожсон мэх байжээ. Тиймээс 1256 оны намар Хүлэгү цэргээ дөрөв хувааж хур Шахыг дайлахаар Куркен орчмоос хөдлөв.

Тийнхүү аялан дайтаж явсаар 1256 оны 11 дүгээр сарын 19-нд исмаилитын Хур Шахыг буулган авч, улмаар мөн оны 12 дугаар сарын 20-нд исмаилчуудын улсын нийслэл Аламут (“Бүргэдийн үүр”) хотыг эзлэн авав.

Ийнхүү Аламутыг эзлэн 172 жил (1084-1256) тогтсон Исмаилчуудын улсыг бут ниргэснээр Персийг байлдан дагуулах хэргийг дуусгаж, **Армян, Гүрж дэх монголчуудын ноёрхлын “Жүржистан муж” (1236-1256)-ийн суурь дээр Хүлэгүгийн буюу Ил хант улс (1256) байгуулагджээ.**

Хоёрдугаар бүлгийн 2.1 дүгээр зүйлд “Ил хант улсын төр, цэргийн бүтэц, зохион байгуулалт”-ын талаар дэлгэрэнгүй өгүүлэв.

Ил хант улсын дээд эрхийг баригч нь хан бөгөөд дайн зарлах, найрамдах зэрэг гадаад бодлогоос гадна улс орны удирдлагыг томилох, удирдах зэрэг хязгааргүй эрхээр хангагдсан нэгэн байв. Ил хант улсын хан сонгох ба өргөмжлөхдөө Их Монгол улсын адилаар алтан ургийн язгууртнууд, хан хөвүүд, хатад, эрхшээлд нь буй улсын ноёд ба мужийн захирагчид хийгээд гадаад орны элч нарын бүрэлдэхүүнтэй Их хуралдайгаар гүйцэтгэдэг байв.

Ил хант улсын төр, цэргийн байгуулалт нь монгол, персийн уламжлалыг хосолсон шинжтэй байснаараа онцлог байна. Тэгэхдээ төр, цэргийн дээд удирдлага шууд монголчуудын гарт байсан бөгөөд харин иргэний засаглалын нэгжүүд нь персийн уламжлалт хэлбэрийг хадгалсаар байсан байна

Ил хант улсын цэргийн бүтэц нь ерөнхийдөө нэгд: монгол цэрэг, хоёрт: бусад цэрэг буюу дагаар орогсдын болон дайчилгаагаар татагдсан цэрэг хэмээх хоёр том бүлэгт хуваагдаж байлаа.

Монгол цэрэг нь ханы шадар хишигтэн цэрэг ба бусад цэргээс бүрдэж байсан бөгөөд тэд бүгд морьт цэрэг байв.

Төрөл мэргэжлийн хувьд цэрэг нь нэгд: морьт цэрэг, хоёрт: явган цэрэг, гуравт: их бууч цэрэг, гуравт: инженерийн цэрэг гэх мэт тусгай мэргэжлийн цэргээс бүрдэж байжээ.

Төрийн цэргийн хэргийг голлон мэдэгч буюу одоогийнхоор бол “Бүх цэргийн ерөнхий командлагч” нь Ил хан байв. Түүний удирдлагад өнөөгийн ойлголтоор дэд хан (Нияабет-и салтанат), персээр “Бэглэрбэй” хэмээх албан тушаалтан тэргүүтэй монгол ноёд, “Эмир” хэмээн перс судруудад тэмдэглэсэн албан тушаалтнууд, везирүүд, муж, улсын захирагч, даргач нар ажиллаж тус тусын эрх мэдэлд тохирсон хэмжээгээр цэрэг мэдэж, цэргийн үйлийг эрхэлдэг байжээ.

Ил хант улсын төр, цэргийн байгуулалт нь дээр өгүүлсэнчлэн Монгол, Персийн аль алиных нь төрт ёсны уламжлал дээр үндэслэгдсэн хосолмол шинжтэй байсан учир монгол ноёд хийгээд Персийн уламжлалт везирийн тогтолцооны хооронд харилцан хамааралтайгаас гадна харилцан зөрчилдөх зүйлс ч багагүй байжээ. Энэ тухай 2.2.1 дүгээр дэд зүйлд дэлгэрэнгүй өгүүлсэн болно.

Ил хант улсын төрийн удирдлага нь хоёр үндсэн хэсгээс, тухайлбал нэгдүгээрт, төр-цэргийн удирдлага, хоёрдугаарт, иргэний буюу санхүү, эдийн засгийн удирдлагыг хариуцсан иргэний захиргаанаас тус тус бүрдэж байв. Үүнд, төр, цэргийн удирдлага монгол ноёдын гарт төвлөрч байсан агаад харин иргэний захиргааг “Везирийн тогтолцоо” бүрдүүлж, везирүүд төвлөрүүлэн барьснаар улс орны эдийн засгийн амьдралыг зохицуулах үүргийг гүйцэтгэж байв

Өөрөөр хэлбэл төр, улсыг үндэслэн байгуулагч монгол ноёдын бүлэг дээд удирдлага (аристократ)-ыг гартаа атгаж байсан авч засаг захиргаа, сангийн хэргийг орон нутгийн гаралтай иран түшмэд барьж “Үзэгтэн” буюу түшмэлүүдийн хэсгийг төлөөлдөг байв.

Ийнхүү төрийн удирдлага нь хоёр үндсэн хэсгээс бүрэлдэх бөгөөд Ил хан тэдний хооронд тэнцвэрийг зохицуулагч шүүгчийн үүрэг гүйцэтгэж байлаа. Энэхүү хоёр хэсгийн хооронд өрсөлдөөн болон зөрчил хэмээн тодорхойлж болохуйц харилцаа бүр 1230-аад оны Хорасан диванатын үеэс эхэлсэн байдаг.

Гэхдээ яваандаа монгол ноёдын бүлэг улс төр, цэргийн эрх мэдлээс гадна эдийн засгийн салбарт ч шийдвэр гаргах томоохон эрхтэй болжээ.

Ийнхүү монгол ноёд өөрсдийн эрх мэдэл, хүч нөлөөгөө амжилттай хамгаалж чадаж байсан тул байр суурийн хувьд везирээс илүү байв. Гэхдээ монгол ноёд болон везирийн хооронд улсын төсвөөс гаргах зарлага, ялангуяа цэргийн зардлыг хэрхэн хангах тухайд байнгын санал зөрөлдөөн, зөрчил гардаг байв.

Харин Ахмед Тэгүдэр хан нь төрийн хэлбэрийг лалын төрт ёсны уламжлалын дагуу шинээр зохион байгуулах шийдвэр гаргасны дагуу везир Шамс Ад-Дин Жүвейни тэргүүтэй Иран түшмэд уг ажлыг оройлон гүйцэтгэж эхэлсэн байдаг.

Ийнхүү Ил хант улсын төрд лалын нөлөө ихсэж, “Үзэгтэн” хэмээн түүхнээ тэмдэглэгдсэн Иран түшмэдийн гүйцэтгэх үүрэг ч шийдвэрлэх хэмжээнд хүрэх хандлага бий болов.

Энэ бүхэнд монгол ноёд, язгууртны давхраа ихээхэн дургүйцлийг төрүүлж, улсын дотоод дахь хямрал зөрчлийг улам хурцатгажээ.

Тийм ч учир төрийн удирдлагад байх Ираны нөлөөг арилган уламжлалт нүүдэлчдийн төрийн системийг хэрэгжүүлж эхлэв. Харин түүний эсрэг хүчтэй тэмцсэний хүчинд Ил хан Аргунын үед иргэний удирдлага буюу везирийн албан тушаалд монгол ноёныг, тухайлбал Жалайрын Буха ноёныг томилсоноор Ил хангуудын түүхэнд анх удаа цэрэг-иргэний захиргаа Монгол ноёдын хяналтанд бүрнээ орсон байна. Өөрөөр хэлбэл нь төрийн байгууламж дахь цэрэг-иргэний харилцааг зөвхөн нэг гарт атгуулах шинэ хувилбарыг санаачлан хэрэгжүүлэх бодлогыг явуулсанаар төрийг найдвартай гараар буюу Монгол ноёдоор удирдуулан Иранчлагдах аюулаас сэргийлнэ хэмээн тооцсон бололтой байдаг. Гэвч энэ нь эргээд ханы засаглалыг сулруулах аюултай болж эхэлсэн тул даан их удалгүйгээр иргэний захиргааг дахин Иран түшмэдүүдийн гарт шилжүүлсэн байна.

“Цэргийн бүрэлдэхүүн” хэмээх 2,2,2 дугаар дэд зүйлд Ил хант улсын цэргийн байгуулалтын талаар өгүүлэв. Ил хант улсын цэргийн зохион байгуулалт нь Их Монгол улсын адил аравтын тогтолцоонд суурилсан мянгатын байгуулал байсан бөгөөд сурвалжийн мэдээлж буйгаар Их Монгол Улсын нийт цэргийн 2/10 хувийг Хүлэгүгийн мэдэлд өгч баруун зүг мордуулсан гэдэг. Ил хант улсын нийт цэрэг 10-12 түмтээс бүрдэх бөгөөд түмт нь дотроо 4 мянгаас 10 мянган цэрэгтэй байдагтай харьцуулж үзвэл улсын цэрэг эхэн үедээ 80-100 мянгын хооронд байсан байна. Харин хожим нь цэргийн тоо өсөж түмтийн нутгийн хуваариуд ч нарийн зохион байгуулалттай болж иржээ.

Ил хант улсын цэрэг нь монгол уламжлал ёсоор дотоод, гадаад мянган гэсэн хоёр үндсэн төрөлд хуваагдах бөгөөд ай, төрлийн хувьд бол морьт цэрэг, явган цэрэг, тусгай мэргэжлийн цэргээс тус тус бүрдэж байжээ. Үүнд, жинхэнэ монгол цэрэг нь дан морьт цэргээс бүрдэж байсан бол суурин улс аймгаас дайчилсан, дагаар орсон цэргийн нэлээд хувь нь явган цэрэг байв.

Хишигтэн цэрэг. Их Монгол Улсын адилаар Ил хант улсад ч хишигтний тогтолцоо оршиж байв. Перс сурвалжид “кезиктан, гэзиктан, кешиктан” хэмээн тэмдэглэгдсэн уг цэрэг нь ихэвчлэн их ноёдоор толгойлуулах бөгөөд Ил ханы тусгай хамгаалалтын үүргийг гүйцэтгэж байв.

Газан ханы үед хишигтэн цэргийн тоо даруй 2 түмтийн хэмжээнд хүрсэн ажээ.

Езек/караул (Манлайн харуул) цэрэг. Езек цэргийн ангийг ихэвчлэн тэргүүн буюу манлайн анги хэмээдэг ба Ил хант улсын түүхэнд тэмдэглэснийг үзвэл ихэвчлэн тагнах, заншлах үүрэг гүйцэтгэж байжээ.

Перс сурвалжид Манклай, Мангклай гэх зэргээр монголоороо тэмдэглэгдсэн байдаг. Бас “Гэээг цэрэг”, “Туслах цэрэг”, “Цуглуулсан цэрэг”, “Ар талын хүчин/Агрук”, “Хатдын ордны хамгаалах цэрэг”, “Чөдөр оньст цэрэг” гэсэн утга бүхий нэр томъёо цөөнгүй тааралдана.

Ноён/эмир, шахне, букавул, ясавул (засуул), Юртчи, Буларгучи, Кутвал, Таважи, Сургавул гэх мэт цэргийн ноёдын зэрэг дэвийг тодорхойлсон нэр томъёо цөөн бус тааралдана. Эдгээр нь араб дахины эртний уламжлалт нэр томъёо байсан бөгөөд тухайн үед перс, араб цэргийн анги, салбарууд уугуул бүтэц, зохион байгуулалтаа хадгалж байсан учир албан тушаалтны нэр нь тэр хэвээр тэмдэглэгдэн үлдсэн нь тэр байв.

“Ил хант улсын гадаад, дотоод цэргийн бодлого, аян дайн”- талаар эл хоёрдугаар бүлгийн 3 дугаар зүйлд дэлгэрэнгүй авч үзэв.

Ил улс лалын шашинт улс орнуудын хүрээлэлд оршиж байсан нь геополитикийн өвөрмөц нөхцөлийг бүрдүүлж байв. Мөн тухайн бүс нутагт исламын болон загалмайн шашны зөрчил хурцадмал хэлбэртэй байсан нь шинэ тулгар улсад учирч болзошгүй аюул заналыг улам нэмэгдүүлж байлаа.

Ил хант улсад заналхийлж байсан аюулыг ерөнхийд нь:

нэгд: Эзэнт гүрний дотоод дахь хийгээд Ил хант улсын дотоод зөрчил, тэмцлийн улмаас үүдсэн аюул занал;

хоёрт: гадаад аюул занал гэж ангилж болно.

Үүнтэй уялдаатайгаар Ил хант улсын төр, цэргийн бодлогыг мөн дотоод, гадаад хоёр хүрээнд авч үзлээ.

Гүрний дотоод дахь хийгээд Ил хант улсын дотоод зөрчил, тэмцлийн талаар 2.3.1 дүгээр дэд зүйлд дэлгэрэнгүй өгүүлсэн болно.

Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүн улсын хувьд Ил хант улс нь гүрний бусад бүрэлдэхүүний улсуудын адил гүрнийхээ төвтэй нягт холбоотой байж их хааны зарлиг, захирлагыг цаг тухайд нь биелүүлж байсан юм.

Монголын эзэнт гүрэн байгуулагдсан эхэн үед Ил хант улс орших, эс орших нь гагцхүү Эзэнт гүрний их хааны зарлиг, шийдвэрээс хамаарах асуудал байв.

Нөгөө талаар хил залгаа оршиж асан Алтан ордны улс хийгээд Цагаадайн улстай харьцах харилцаанаас бас ихээхэн зүйл шалтгаалж байлаа.

Тиймээс Ил хан Хүлэгү, түүнийг залгамжлагчдын үеийн төр, цэргийн бодлогын нэг гол шугам нь гүрний дотоодоос учирч болзошгүй аюул заналыг зайлуулахад чиглэгдэж байжээ.

Анх 1255 оноос баруун зүгт хийсэн Хүлэгүгийн аян дайнд Монголын их хааны зарлиг ёсоор Цагаадайн болон Зүчийн улс цэрэг, зэвсгийн хүчээр тусалж байжээ.

Гэвч энэ найрсаг харилцаа удаан үргэлжлээгүйгээр үл барам зөрчил маргаан нь даамжирч дайны хэмжээнд хүртэл өргөжсөн юм. Энэ нь олон шалтгаантай байлаа. Үүнд:

1. Эзэнт гүрний их хааныг сонгоход алтан ургийнхны дотор үүдсэн хагарал тэмцлээс эхтэй;
2. Газар нутгийн маргаанаас үүдэлтэй;
3. Өш хонзонтой холбоотой байв;
4. Шашны хүчин зүйлээс улбаатай;
5. Ашиг орлогын хуваарилалтаас үүдэлтэй зөрчил ч бас нөлөөлсөн байжээ.

Анх Зүчийн болон Цагаадайн улстай хэвийн харилцаатай байж, тэдний зүгээс явуулж байсан дайн байлдааны ажиллагаанд ч цэргийн хүчээр тусламж дэмжлэг үзүүлдэг байжээ. Гэвч Бэрх (1257-1266) ханы үеэс Ил хант болон Зүчийн улсын хоорондын зөрчил тэмцэл илт хурцдаж эхэлж бараг 100 орчим жил үргэлжилсэн ба Цагаадайн улсыг оршин тогтнож байсан бүхий л үеийн турш мөн дайсгалцаж байжээ.

Ил хант улсын монголчуудын гадаад дахь гол дайсан нь Египетийн мамлюкууд байсан ба 1260 оноос эхлэлтэй хоёр улсын хоорондох дайн дажин 60 жил үргэлжилж, Ил хант улсын сүүлчийн хан Абу Са'идын үед сая төгссөн байна.

Гэвч Абу Са'ид Бахатур хан ор залгамжлах хөвгүүнгүй байсан ба түүнээс хойш Ил хант улсын дотоодын зөрчил тэмцэлдээн улам хурцдаж, Чопан, Жалайр, Сарбадар овгийнхны тэмцэл дунд монгол, түрэг хийгээд перс гаралтай жижиг хангуудын бие даасан жижиг улсууд болон задарчээ.

ЦАГАДАЙН ХАНТ УЛСЫН ЦЭРЭГ

§3.1. Цагадайн улсын төр, цэргийн зохион байгуулалт

Цагадайн улс бол дундад Азид 1222-1370 оны хооронд оршин тогтнож байсан Монголын улс юм. Чингис хааны хоёрдахь хүүгийн нэрээр түүхэнд мөнхөрсөн Цагадайн улсын нутаг дэвсгэр нь орчин үеийн Казахстан, Киргизстан, Узбекистан, Таджикистан, Туркменистан, Афганистан болон БНХАУ-ын Шинжан Уйгурын нутгийг хамарч байв.

Цагадай хувь улсаа тохинуулахад ихэд анхаарч өөрийн ордуудыг өргөтгөн байгуулжээ. Цагадай зуны ордоо Алмалиг хотын хаяанд Или голын хөндийд Куяш (*Наран*) нэртэй газарт байгуулсан бол өвлийн ордоо Или голын эрэгт Мераурик-Ила нэрт газарт байгуулжээ. Цагадайн орд өргөөг Улуг Иф буюу Улуг Их хэмээдэг байв. Цагадайн улсын нийслэл нь түүхэн хугацаанд олон удаа нүүн шилжиж байсан бөгөөд ихэнхдээ Алмалиг, Нахшеб, Карши, Аксу зэрэг хотод төвлөрч байв.

Цагадайн улс нь 1221 оноос 1370 он хүртэл 150 орчим жил оршин тогтносон бөгөөд XIV зууны дунд үед Цагадайн улс задарч тус улсын баруун хэсэг болох Мавераннахрт Цагадайн удам бодит эрх мэдлээ бүрмөсөн алдаж, харин зүүн хэсэгт буюу Моголистанд төрийн дээд эрх мэдлээ авч үлдэн ХҮI зууны эхэн үе хүртэл төр барьж байв.

Цагадайн улс нь баруун, зүүн, төв гэсэн 3 хэсэгт хуваагдаж байв. Төр засаг захиргааны зохион байгуулалтандаа монгол заншил, Хорезмын эзэнт гүрний хуучин засаг захиргааны зохион байгуулалтыг хослуулан хэрэглэсэн байна. Улсынхаа муж, хот, суурингуудад даргач нарыг тавьж, цэрэг суулган захирчээ.

1206 онд Чингис хаан эх, хөвүүд, дүү нартаа улс иргэнийг хувааж өгөхөд Цагадайд оногдсон 8 мянган иргэний ихэнх нь *Жалайр, Барлас, Каучин [Хуучид]* болон *Арлуад* аймгийн харьяат байв. Дараа нь Чингис хаан тэнгэрт халихын өмнө хөвгүүддээ их цэргээ хувааж өгөхөд Цагадайд 4 түмэн цэрэг мөн оногджээ.

Чингис хаан, Цагадайд дээрх аймгийн иргэнийг оноохдоо “Харачар, Мөнх, Идухадай гурвыг тушааж” өгчээ. Үүнтэй холбогдуулан Чингис хаан хэлэхдээ: “Цагадай хэцүү буюу. Нарийн авирт буюу. Хөхөчос, үдэш өглөө дэргэд инү байж, сэтгэснээ хэлэн атугай” гэж зарлиг болгожээ. Өөрөөр хэлбэл Чингис хаан Цагадайд *Харачар, Мөнх, Идухадай, Хөхөчос* нарын дөрвөн ноёныг нэр зааж томилов.

Эдгээр ноёдыг овог аймгийн харьяаллаар нь авч үзвэл, Харачарыг Барлас аймгийн ноён гэж “Монголын нууц товчоо”-нд тодорхой заасан байгаа тул судлаачдын санал нэг байна.

Мөнх ноёны тухайд гэвэл “Судрын чуулган” болон XIII-XIV зууны үеийн Цагадайн улсын түүхийн үйл явдал хийгээд Чингис хааны Алтан ураг болон Доголон Төмөрийн удам угсааг өгүүлсэн “*Му’узз ал-ансаб*” (“*Уг гаралын алдар*”) хэмээх XV зуунд перс хэлнээ бичигдсэн сурвалжид уг ноёныг Жалайр аймгийн ноён гэж заасан байна. Харин *Идухадай* ноёныг чухам аль аймгийн хүн болохыг тогтоох мэдээ олдоогүй байна. Чингис хааны Цагадайд оноож өгсөн дөрвөн ноён бүгд Их Монгол улсын 95 мянгадын ноёдын дотор байгаа бөгөөд эдгээр ноёд цөм мянганыг захирч байжээ.

“Судрын чуулган”-нд өгүүлсэн ёсоор Чингис хааны Цагадайд өгсөн 4 түмэн цэргийн нэг нь “Барлас аймгийн Харачар ноёны түмэн” байсан хэмээх мэдээнд тулгуурлан Цагадайн улсад ирж суурьшсан *Барлас, Жалайр, Арлад, Каучин* аймгийн ноёдыг түмтийн ноён болгож зэрэг дэвийг нь ахиулан тогтоожээ гэж дүгнэж болхоор байна. Өөрөөр хэлбэл, Их Монгол улс байгуулагдахад мянганы ноёноор томилогдсон Барласын Харачар нарын тэргүүтэн Цагадайн улсад очоод түмтийн ноёноор дэвшиж, Цагадайн цэрэг улс төрийн гол өмөг түшиг нь болсон байна.

Дээрх дөрвөн монгол аймгийн ноёд, цэргийн жанжин нар үеийн үед залгамжлан аймгийнхаа түмтийн ноён байж Цагадайн удмын хаадын түших гол хүчин нь болсоор иржээ.

Цагадай нэрийг эдүгээ хүртэл зарим газар оронд хэрэглэсээр байна. Тухайлбал, орчин үеийн Узбекистан улсын Ташкент хотын эртний нэг дүүргийг Цагадай хэмээх бөгөөд тус дүүрэгт цагадайн удмынхан эртнээс аж төрж ирсэн тул ийнхүү нэрлэсэн гэж үздэг байна. Иранд Цагадай (Джагатай) нэрийг эдүгээ хүртэл хэрэглэсээр байна.

Цагадайг эзэн Чингис хааны хоёрдугаар хөвгүүн болон 1183 оны харагчин туулай жилд төрсөн гэж нэг хэсэг судлаачид үздэг бол нөгөө хэсэг нь түүнийг 1185 оны хөхөгчин могой жил төрсөн гэнэ. Чингис хааны намтар түүхийн “харанхуй” үетэй холбож үзвэл Цагадай 1183 онд бус бүр түүнээс ч өмнө мэндэлсэн байж болно. Өөрөөр хэлбэл ууган хөвгүүн Зүчийгээ Бөртэ Мэргидийн олзноос 1179 оны 12 дугаар сард буцаж ирэх үедээ төрүүлсэн бол удаах хөвгүүн Цагадай нь 1180 оны сүүл 1181 оны эхээр мэндэлсэн байх бүрэн боломжтой.

Цагадай багаасаа ухаалаг, авьяастай гэгдэж байсан бөгөөд эцгийн билиг сургаалыг ах дүү нараасаа илүү сайн тусган авч чадсан учир хожим хойно Чингис хаан ноёд түшмэддээ хандаж хэлэхдээ: “Яса хууль, дүрэм журам, ёс заншлыг илүүгээр мэдэж, хаант ёсыг сахих хүсэлтэй тэр хүмүүс Цагадайг дага” гэж зөвлөж байв. Цагадай бага залуугаасаа эцгээ дагаж, Их Монгол улсыг байгуулахын төлөөх тэмцэлд оролцож явжээ.

Цагадайг 20 гарсан хойно буюу 1203 онд Чингис хаан Хэрэйдийн Ван хантай дайтах үед Өгэдэйг шархагдсан тухай сурвалжид өгүүлдэг. Дөнгөж 17 нас шүргэж байсан Өгэдэй энэ байлдаанд оролцсоноос үзэхэд эрийн цээнд хүрсэн ах Цагадай нь дайтаж явсан нь эргэлзээгүй юм.

Цагадай 1211 оноос бие даан цэрэг удирдаж дайнд оролцох болжээ. Чингис хаан анх удаа Алтан улсыг дайлахдаа нэгэн замын цэргийг Зүчи, Цагадай, Өгэдэй нараар захируулжээ. Ах дүү нарын хамт Цагадайн удирдсан замын цэрэг Юньнэй, Дуншэн, Үжоу, Шужоу зэрэг Жунду, Датуну завсарын олон хотыг буулган авч байлаа.

Чингис хааныг 1213 онд Алтан улсад довтлоход Цагадай ах Зүчийн хамт мөн нэгэн жигүүрийн цэргийг удирдан одоогийн Баодин, Динсянь, Синтай зэрэг газрыг эзлээд Шар мөрөн (Хатан гол) хүрсэн байна.

Алтан улсыг дайлах үед цэргийн авьяаслаг жанжин болохоо харуулсан Цагадай 1219 онд Чингис хаан Хорезмын хаант улсыг дайлахад дүү Өгэдэйн хамт нэгэн замын цэрэг удирдаж Отрар хотыг эзлэн авсан. Нийслэл Самарканд болон хуучин нийслэл Ургенчийг эзлэн авах байлдаанд Цагадай идэвхтэй оролцжээ.

Чингис хаан 1223 онд их цэргээ хурааж Аму-Дарья мөрнийг гаталж Самаркандад ирж өвөлжих үедээ Цагадай, Өгэдэй хоёрыг Хар нуур тийш явуулж хун, галуу зэрэг усны шувуу агнуулж, замын хүнсээ базаалгажээ. Цагадай, Өгэдэй хоёр эцгийн зарлигийг дагаж өдөр тутам шувуу агнаж, долоо хоног бүр 50 тэмээнд ачин Чингис хаанд өргөн явуулж түүнийг баярлуулж байв. Чингис хаан Цагадай хоёрын харилцааг тодотгох хэрэг явдал Сартуул улсыг дайтах үед болжээ.

Чингис хаан 1225 онд Тангуд улсыг дайлаар мордохдоо Цагадайг ар талын цэргийг удирдуулан нутгаа сахиулав. Үүний шалтгаан нь Чингис хаан ахмад хүү Зүчи хоёрын хоорондын харьцаа муудсантай холбоотой гэж үзэж болох юм. Гэвч Цагадайд эх нутгаа сахиулан үлдээснийг нь гагцхүү Чингис хаан Зүчи - Цагадайн зөрчилтэй холбон тайлбарлах нь өрөөсгөл хандлага болов уу. Сартуулын

сүүлчийн шах Желал-ад-дины морьт цэрэг хэдхэн хоногийн дотор дэргэд бууж болох байсантай бас холбоотой байв.

“Судрын чуулган”-д тэмдэглэснээр Чингис хаан Зүчийг Килард, Башкир, Урус, Черкес, Дешт-и Кипчак болон бусад нутгийг байлдан дагуулахыг зарлиг болгосон юм. Тэрбээр үүнд оролцохоос зайлсхийж, өөрийн суурин өргөө рүүгээ очсонд Чингис хаан ихэд хилэгнэн “Би түүнийг өршөөхгүйгээр цаазлана” хэмээн хэлсэн гэжээ. Зүчийн санаа хувиран эцгийнхээ үгийг дагахгүй болжээ гэж үзсэн Чингис хаан түүний зүг Цагадай, Өгэдэйг цэрэгтэй нь хамт эхэлж хөдөлгөөд дараа нь өөрөө явахаар зэхэж байв. Энэ үед Зүчи хан нас барлаа гэсэн гашуудлын мэдээ иржээ. Олонхи судлаачид Зүчийг 1227 оны 2 дугаар сард нас барсан гэж үздэг.

Чингис хааныг тэнгэрт хальсны дараа 1229 онд Өгэдэйг хаан ширээнд залах Их хурилдайд Цагадай отгон дүү Толуйн хамт чухал үүрэг гүйцэтгэв. Өгэдэйн хаанчлалын үед Цагадайн нэр хүнд өндөр байсан төдийгүй Толуйг нас барснаас хойш улам ч дээшилжээ. Өгэдэй хааныг 13 жил төр барихад түүний өмөг түшиг болж байсан Цагадай их хааны ахын хувьд, “Их засаг” хуулийг гарамгай мэдэх хүний хувьд Их Монгол улсыг бэхжүүлэх үйлсэд бүхий л оюун ухаан, зүрх сэтгэлээ зориулсан юм. Өгэдэй хааныг тэнгэрт хальсанаас хойш хэдхэн сарын дараа 1242 оны дундуур Цагадай мөнх бусыг үзүүлжээ.

“Өгэдэй хаан өөд болоход Цагадайн өргөө бүх хүн төрөлхтний чуулдаг байр болон хувирчээ. Түүнийг хүндэтгэн дээдэлдэг хол ойрын олон орны ихэс дээдэс энд морилон ирдэг байлаа” хэмээн Ата-малик Жувейни тэмдэглэжээ. Эл мэдээгээр их хааныг нас нөхчөсний дараа Цагадай их гүрний төрийн хэргийг түр хамаарч байжээ.

Цагадай бол хаан эцгийнхээ явуулсан бүх аян дайнд оролцож, тусгай үүрэг даалгаврыг биелүүлж ирсэн Чингис хааны найдвартай хамтран зүтгэгч, түүний их үйлсийг бүтээхэд хүч чадал, авъяас билигээ харамгүй зориулсан нэр төртэй залгамжлагч нь төдийгүй цэргийн гарамгай зүтгэлтэн юм.

3.1.2.Цагадайн улсын зэр зэвсэг, байлдах урлаг

Цагадайн улсын талаар судалгааг Монголын эрдэстэн судлаачид хийсэн ч яг цэргийн тал руу нь нарийвчлан судалсан нь хараахан үгүй юм. Ер нь Алтан ордны улс, Эл хаант улс, Цагадайн улсын зэр зэвсэг нь XIII зууны үеийн Их Монгол Улсын цэргийн зэр зэвсэгтэй нэгэн адил байсан бөгөөд өөрийн гэсэн Цагадайн гэсэн хэв маягийн зэвсэг байсангүй.

Цагадайн улсын цэрэг нь үндсэндээ явган болон морьт цэрэгтэй байжээ. Морьт цэрэг нь хүнд болон хөнгөн гэж хуваагдаж байсан нь тодорхой бус харин хөнгөн морьт цэрэг, хүнд хөнгөн хосолсон явган цэрэгтэй байжээ.

Зэр зэвсгийн хувьд Цагадайн улсын цэрэг нь нум сум, илд, жад, хөрөө, зүү, шөвөг, оосор, бугуйл, сүх, зэргээс бүрдэж байжээ. Эдгээр зэр зэвсэг XIII зууны үеийн Монголын эзэнт гүрний улсуудад байдаг тийм нийтлэг зэвсэг байсан байна. Монголын эзэнт гүрэнд үйлдвэрлэгдэж хийгдсэн сайн чанарын зэр зэвсэг нь эзэнт гүрний өнцөг булан бүрт илгээгдсэн цэргүүдийн хамт тархаж байжээ. Цагадайн улс нь өөрөө байгалийн өвөрмөц цагийн цаг уур газар нутгийн байдлаасаа болж зэр зэвсэг хийх тал дээр түүхий эдийн дутагдалтай байсан учир Монгол болон бусад газар орноос зэр зэвсэг нийлүүлэгддэг байжээ.

Цэргийн урлаг. Цагадайн улсын цэргийн урлаг нь тэр чигээрээ XIII зууны Монгол цэргийн урлаг байжээ. Тухайн үедээ Монгол цэргийн урлаг нь дэлхий

дахинаа гайхагдаж байсан хэдий ч түүнийг нууцлах нь зайлшгүй байсан бөгөөд Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүн улсуудад үе дамжин өвлөгджээ.

Цагадайн улс нь хо суурин хэрэм балгад ихтэй байсан учир хот цайзыг байлдан эзлэх тактик түлхүү хэрэглэж түүнийгээ хэрэгжүүлэх арвин их туршлагатай байсан юм. Үүнийг нь ч хожим өрнө зүгт хийсэн аян дайн болон Багдадыг буулгах аян дайнд Цагадайн улсын цэргүүдийг өргөнөөр ашиглажээ.

XIII зууны Монгол цэргийн нэгэн адил “өдөж хөдөгөх” аргыг өргөнөөр ашиглаж байжээ. 1262 онд Цагадайн улсын эзэн Алгуй Монголын Аригбөх хаантай муудалцан Сайрам нуурын хөвөөнд Аригбөхийн жанжин Харбөхийг алс холоос ядарч ирсэн байдлыг нь ашиглан өдөж хөдөлгөн араасаа дагуулан туйлдуулан бут цохин ялалт байгуулж байжээ.

Чингис хааны цэргийн урлаг буюу стратеги, тактик нь эсгий туургатан, монголчуудын үе үеийнхний боловсруулан хэрэглэж ирсэн цэргийн эрдэм ухааны төгөлдөржсөн хэлбэр байсан бөгөөд Чингис хаан тэргүүтэй цэргийн жанжнуудын суу ухаанаар үржигдэн агуусаж дундад эртний монгол цэргийн түүхэн их ялалт амжилтуудын үндэс суурь нь болсон билээ.

Их Монгол Улсын цэргийн стратегийн үндэс нь “Маневрын дайн”-ы стратеги байснаараа бусдаас онцлог. Орчин үеийн цэргийн шинжлэх ухаанд стратегийн түвшинд маневрыг голлон хэрэглэж буй дайныг ийнхүү нэрлэдэг. Чингис хаан ийнхүү “Маневрын дайн”-ы стратегийг боловсруулах явцдаа түүнтэй холбоотой олон зүйлийг мөн анх санаачлан хэрэгжүүлсэн юм. Жишээ нь тагнуулын бүхэл бүтэн сүлжээг анх зохион байгуулсан бөгөөд өрнийн улс орны армиудын штабууд XX зуун гэхэд л сая цэргийн тагнуулын тусгай байгууллагатай болсон билээ. Монгол цэрэг аль ч улс оронд өөрийн нутагт байгаа мэт чөлөөтэй, түргэн шуурхай довтолгож асан нь чухамдаа бүх төрлийн тагнуулын сүлжээ найдвартай ажиллаж байсны үр дүн мөн.

XX зуунд АНУ-ын Зэвсэгт Хүчинд үүсгэн байгуулсан “Түргэн байрлуулах хүчин” болон бусад улсын ийм маягийн цэрэгтэй үүрэг, зориулалтын хувьд ижил гавшгай цэрэг болох “Тама” (“Тамачи”) хэмээх цэргийг монголчууд бүр XIII зуунд цэргийн хэрэгт хэрэглэж эхэлсэн билээ.

Үүнээс гадна “Дайны ажиллагааны театр”-ыг сайтар тандан судалж, их цэрэг явах зам, гүүр барих зэргээр урьдчилан бэлтгэж, төхөөрөмжилдөг байсан аргыг ихэнхи улс орон XX зуун хүрч байж л сая хэрэглэх болсон билээ. Түүнчлэн:

1. Цэрэг, дипломатын аргыг хослуулан дайсан улсаа ганцаардуулах;
2. Стратегийн операцыг явуулахдаа цэргийг заавал гурван гар болгох буюу нэг нэгнийгээ халхалсан байдалтай илгээх;
3. Дайсан улсынхаа газар нутгийн тал талаас зэрэг давшилт хийж хүчийг нь тарамдуулах;
4. Гол цохилтын чиглэлийг зөв сонгож, стратегийн гэнэтийн ажиллагаагаар дайснаа мохоох;
5. Гол объект, хаад, ноёдыг нь тасралтгүй мөрдөн хөөж дайсныхаа нэгдсэн удирдлагыг алдагдуулах;
6. Сэтгэлзүйн хүчтэй довтолгоон хийх зэрэг стратегийн төвшинд санаачлан хэрэгжүүлсэн зүйл олныг дурдаж болно.

Энэ бүхэн нь орчин үеийн дайны урлагт ч зарчмын чухал ач холбогдолтой зүйлс хэвээр байгаа юм.

Ийнхүү дайны санаачлагыг эхнээс нь гартаа авч, байлдааны ажиллагааг тасралтгүй, идэвхитэй явуулдаг байсан нь ямагт ялан дийлэхийнх нь үндэс суурь болдог байжээ.

Чингис хаан тэргүүтэн монгол цэргийн жанжнууд дайн, байлдааны ажиллагааны технологид тоог бус, чанарыг эрхэмлэх зарчмыг тууштай нэвтрүүлж, ямагт цөөнөөр олныг ялан дийлж байсан тактикийн өвөрмөц аргуудыг хэрэглэж байсан нь тэр үеийн дэлхий дахины цэргийн урлагт цоо шинэ зүйл байв.

Хятадын алдарт Сүнзийн сургаальд "...Хүн хүч дутуу ахул дутаан одогтун, хүч ихээр дутуу ахул хүчлэн тулалдахаас бултагтун. Учир нь хүчээр дутмаг цэрэг хатгалдан тулалдах аваас хүчирхэг дайсны олз болмуй" гэсэн байдаг бол Чингис хаан: "Олноос олон, цөөнөөс цөөн гарз болмуй за" хэмээсэн байдаг нь зарчмын эсрэг тэсрэг хандлагын нэгээхэн илрэл болой. Ийнхүү "Цөөнөөр олныг ялах ухаан" хэмээн томъёолж болох зарчим нь тэр үед улс орноо батлан хамгаалах стратеги, тактикийн бүхий л асуудлыг боловсруулж ирсэн онолын үндэс суурь болж байсан нь одоо ч ач холбогдлоо алдаагүй бөгөөд дэлхий дахинаа цэргийн тактикийн чухал нэг зарчим хэвээр байсаар байна.

Тактикийн тухай.

Тэр үед олон улс даяар ноёрхож байсан гол хандлага бол улс аймгуудын цэрэг бүр байлдаанд ерөнхийдөө ямар нэгэн тогтсон хэв загварт баригдсан байлдааны журам, тактик хэрэглэдэг байсанд оршино.

Европын улсуудын шилдэг цэрэг болох Рыцарь хэмээх "Морьтон баатар"-ууд гэхэд "Шивээ", "Бодонгийн толгой" буюу "Төмөр гахай" ч гэж оросуудын нэрлэж асан байлдааны журам, түүндээ тохирсон тактикийг л байлдаанд зонхилон хэрэглэдэг байв.

Орос тэргүүтэн славууд ихээхэн хүчтэй "Төв" болон арай бага хүчтэй хоёр жигүүрийн нэг, нэг гурвалжин бүхий гурван гурвалжин жагсаалаар байрлаж тулалддаг.

Рыцариуд ч, славууд ч байлдааны явцад анхлан сонгосон тэр журам, жагсаалаа алдахгүйг эрмэлздэг байсан ба өөр тактикийн хувилбар бараг байхгүй байжээ.

Зүрчидийн "Алтан улс", Тангудын армид хүнд зэвсэгт явган цэрэг зонхилж асан тул байлдааны жагсаалаа аль болох чигжүү, нягт агаад гүн тийшээгээ олон шахуу эгнээ болгон зохион байгуулж, фронтынхоо энгээр дайснаа ааглан түрж цохихыг эрмэлздэг байжээ. Ийм учраас хувьсан өөрчлөгдөх чанар багатай, хөшүүн нүсэр байснаас тактикийн нэг их олон хувилбар, арга хэрэглэх боломж ч үгүй байв. Сүн, Тангудын аль нь ч ялгаагүй, амиа авардаг гол тактик нь хэрэм, цайздаа бүгж халхлан тулалдах явдал байв.

Харин монгол цэргийн хувьд бол тийм бус. Цэргийн тактикийн үндэс нь дээр дурдсан маневрын дайны стратегийг хэрэгжүүлэх гол нөхцөл болсон дан морьт цэргийн хувьсангуй хөдөлгөөн буюу маневр болж байв. Байлдааны журмыг бүрдүүлэгч хэсэг, тэдгээрийн хүн хүчний тоо хэмжээ нь байлдаан бүрт харилцан өөр өөр байхаас гадна нэгэн тулалдааны явцад ч цагийн байдлын өөрчлөлтөд зохицуулан хүч, бүлэглэлээ хялбархан өөрчлөн хувьсгаж, гэнэтийн дайралт, сөрөг

цохилт хийх боломжоор илүү байсан юм. Монгол цэрэг хүний тоогоор бусдаас ямагт үлэмж цөөн байсан авч түүний хүчин чадавхи, цохилтын жин нь хурд, маневрын ачаар олон дахин нэмэгддэг байжээ.

Ийнхүү олон улсад, ялангуяа өрнөдийн орнуудад тархаж түгээд байсан байлдахуй аргын “Тогтонги хэв загварчлал (Шаблон)”-ыг таягдан хаяхад хүргэсэн нь цэргийн урлагийн хөгжлийг зогсонги байдлаас гаргахад хүчтэй түлхэц өгсөн бөгөөд энэ нь дэлхий дахины цэргийн урлагийн хөгжилд Чингис хааны оруулсан нэг гол хувь нэмэр байсан билээ.

§3.2. Цагадайн улсаас явуулсан дайн, байлдаан

3.2.1. Монголын эзэнт гүрнээс явуулсан аян дайнд Цагадайн улсын оруулсан хувь нэмэр

Монголчуудын Өрнө зүгт 1236-1241 хийсэн аян дайны түүхийг гадаад, дотоодын эрдэмтэн судлаачид тал бүрээс нь судалсаар ирсэн билээ. Уг дайны нэг онцлог нь Чингисийн охид, хөвгүүд болон үр ач нарын ахмад төлөөлөл оролцсонд оршдог.

Энэхүү монголчуудын Өрнө дахинд 1236-1241 онд хийсэн аян дайныг амжилттай явуулахад Чингис хааны хоёрдугаар хүү Цагадай болон түүний үр хөвгүүд чухал хувь нэмэр оруулжээ.

Өгэдэй хаан 1235 онд Хархорум хотноо Их хуралдай хуралдуулж, Өрнө зүгт хийх аян дайны ажиллагааг нарийвчлан хэлэлцэж, хааны угсааны ахмад хөвгүүдийг явуулах болсон бөгөөд олон ноёдын дотроос Сүбэдэй баатар дээдлэн захирах болжээ. Энэ аян дайны талаар Алтан ордны улсын түүх дээр дэлгэрэнгүй өгүүлсэн.

3.2.2. Цагадайн улсаас эзэнт гүрний дотоодод явуулсан дайн, байлдаан

Цагадайн хант улс нь оршин тогтнох хугацаандаа олон удаагийн аян дайн, байлдааныг хийж байсны ихэнх нь монголын эзэнт гүрний бүрэлдэхүүн улсуудын дотор явагджээ. Алтан ордны улс, Эл хант улс, Юань гүрэнтэй эв түнжин муудаж байлдан дайтаж байсан юм. Газар нутгийн маргаан, эрх мэдлийн зөрчлөөс үүсч ихэнх дайн байлдаан гарсан.

Цагадайн улсын зүгээс эзэнт гүрний дотоодод явуулсан аян дайныг Алтан ордны улстай явуулсан, Эл хант улстай явуулсан, Юань гүрэнтэй явуулсан аян дайн гэж үндсэн гурван хэсэгт хуваасан бөгөөд гүйцэтгэсэн үүрэг, дайнд хүргэсэн шалтгаан, үр дүн, оролцсон цэргийн тоо, тулалдаанд ашигласан зэр зэвсэг, стратеги тактик зэргийг гаргаж өгсөн.

Нэг. Алтан ордны улс, Цагадайн улс, Эл хант улс нь эртний уламжлалт “Гурван түмний” буюу “Гурван гарын тогтолцоо” бүхий цэрэг-захиргааны нэгдмэл шинжтэй байгуулалттай байжээ.

Энэхүү “Гурван түмний тогтолцоо” нь наанадаж Хүннүгийн үеэс уламжлалтай бөгөөд орчин үеийн ойлголтоор бол “Орон нутгийн хамгаалалт”-ын өвөрмөц нэг хэлбэр ч гэж тодорхойлж болно. Учир нь тэр үед нийт улсыг төвийн түмэн, баруун, зүүн түмэн гэсэн үндсэн 3 хэсэгт хуваадаг байсан ба аливаа байлдаанд цэргээ мөн л их гол, баруун, зүүн гар гэж хуваан тулалддаг, бас тийнхүү гурван гарлахыгаа “Гурван түмэн болж” гэж нэрлэсэн байдаг. Тэр үеийн энэхүү цэрэг-захиргааны “Түмэн” гэдэг ухагдахуун нь яг таг 10000 гэсэн тоон утгыг илэрхийлдэггүй, харин одоогийн “Ард түмэн” гэдэгчлэн олныг заасан нэр томъёо байв.

Алтан ордны улс, Цагадайн улс нь мөн л тэр ёсоор төв, баруун, зүүн түмэн (гар, оросууд жигүүр ч гэсэн байдаг) гэсэн үндсэн гурван хэсэгт хуваагдаж байв. Энэ бүтэц нь цаашид ч олон жил уламжлагдан явсан юм.

Хоёр. Алтан ордны улс, Цагадайн улс, Ил хант улсын цэрэг нь эртний уламжлалт аравтын тогтолцоонд тулгуурласан мянгатын байгуулалттай байжээ. Өөрөөр хэлбэл цэргийн байгуулалтын хамгийн бага нэгж нь аравт бөгөөд бие даан харьцангуй томоохон хэмжээний байлдаан явуулах чадвартай тактикийн дээд нэгж нь мянгат, оперативын хэмжээний нэгж нь түмт байсан байна.

Алс аялан дайлах үед мянгат, түмтүүдийг ихэвчлэн гол, баруун, зүүн гар гэж хуваарилан гурав гурваар нь илгээдэг. Мөн одоогийн “түргэн байрлуулах хүч” маягийн үүрэг бүхий “Тамачин” хэмээх цэргийг томилон байлдааны үүрэг гүйцэтгүүлдэг байжээ.

Гурав. Улсын цэрэг нь хуурай замын болон усан замын буюу усч цэрэг гэсэн үндсэн хоёр том “ай”-д хуваагддаг ба хуурай замын цэрэг нь морьт, явган болон одоогийн томьёоллоор тусгай мэргэжлийн цэргийн түмт, мянгатуудаас бүрдэл болдог байжээ. Энэхүү тусгай мэргэжлийн цэрэгт их бууны (галт буу, чөдөр оньс, урвуур харвуураар зэвсэглэсэн), инженерийн (цайз, бэхлэлтийг эвдэх түншүүр, тэсэлж дэлбэлэх, гал, утаан хөшиг тавих, суваг шуудуу ухах юм уу бөглөж таглах, хүрээ хороо байгуулах гэх мэт үүрэг гүйцэтгэх), ар тал хангалтын (зэр зэвсэг үйлдвэрлэх дархчууд, эмч домч, хөтөч гэх мэт хүмүүсээс бүрдсэн, мөн өртөө зам хариуцсан нэгжүүд) гэх мэт нэгжүүд хамаарна.

Түүнээс гадна олзны цэрэг, иргэдээс бүрдүүлдэг “Хашал” (Хашар ч гэсэн байдаг) түр зуурын тусгай багуудыг байгуулж хот, цайзыг дайлах байлдаанд манлай цэргийн өмнө илгээж хотыг тойруулсан хамгаалалтын гуу жалгыг бөглүүлж таглуулах, хотыг тойруулан шөрөг хүрээ босгуулах гэх мэт үүрэг байлдааны үүрэг гүйцэтгүүлдэг байжээ.

Дөрөв. Алтан ордны улсын цэрэг нь бүрэлдэхүүний хувьд анх улс байгуулах үед Зүчид хувь болгон өгсөн харьяат иргэн болох 9000 албат иргэн, 4000 цэрэг, мөн Их Монгол Улсыг байгуулах үед нутгаасаа дүрвэн гарч кибчагтай нийлсэн байсан найман, хэрэйд, мэргэдийн үлдэгдэл болох монголжин овог аймгийнхнаас гадна кибчаг, булгар, огуз, орос, алан, черкес, армян, мордов зэрэг олон үндэстэн угсаатнаас бүрдэл болж байснаараа онцлог байв. Харин Цагадайн улсын цэрэг нь 1206 онд Чингис хаан эх, хөвүүд, дүү нартаа улс иргэнийг хувааж өгөхөд Цагадайд оногдсон 8 мянган иргэний ихэнх нь *Жалайр, Барлас, Каучин [Хуучид]* болон *Арлуад* аймгийн харьяат байв. Дараа нь Чингис хаан тэнгэрт халихын өмнө хөвгүүддээ их цэргээ хувааж өгөхөд Цагадайд 4 түмэн цэрэг мөн оногджээ.

Харин тэднийг ихэвчлэн аравтын тогтолцоогоор зохион байгуулж байсан нь тэдгээр улсуудын хувьд шинэлэг агаад удирдлагыг тодорхой, шуурхай болгож өгсөн, зохион байгуулалтын дэвшилтэт арга хэлбэр байжээ. Цэргийн гол хүч нь монгол цэрэг, ханы дэргэдэх гол тулгуур болсон шадар хишигтэн нь цэргийн зонхилох нь ч дээр дурдсан монголжин овог аймгийн цэрэг байжээ.

Харин нийт цэргийн тооны хувьд авч үзвэл дийлэнх олонхийг нь исламын шашинт түрэг гаралтай хүмүүс бүрдүүлж байсан ба Алтан ордны улсын хувьд үнэн алдартны болон католик шашинт слав гаралтай болон кавказын уулынхан ч алба хашиж байжээ. Харин Цагадайн улсын цэрэгт ислам шашинт ард иргэд түлхүү

зонхилж байжээ. Гэхдээ үе үеийн хангуудын цэргийн бүрэлдэхүүн, хүн хүчний тоо харилцан адилгүй байсан байна. Тухайлбал: Алтан ордны улсын Бат, Бэрх, Мөнх-Төмөр, Тохта нарын үед 250 мянга, Узбек, Жанибег, Тохтамыш хангуудын үед 170 мянга орчимд тус тус хэлбэлзэж байжээ.

Тав. Монгол цэргийн жанжнууд дайн, байлдаанд тоог бус чанарыг эрхэмлэх зарчмыг тууштай нэвтрүүлж, ямагт цөөнөөр олныг ялан дийлэх ухааныг сийлж, маневрын дайны стратеги, тактикийн өвөрмөц аргуудыг хэрэглэж байсан нь тэр үеийн дэлхий дахины цэргийн урлагт цоо шинэ зүйл байв.

Монголчууд стратегийн төвшинд:

-Эн түрүүнд стратегийн тагнуулыг сайтар зохион байгуулж, дайсны талаар шаардлагатай бүхий л зүйлийг тагнан судалдаг. Тэгэхдээ цэргийн тагнуулын албыг дэлхийн түүхэнд анх удаа байгуулан ашиглаж байсан бол Европын армиудад бүр хожим, тухайлбал XIX зуун хүрч байж л сая Жанжин штабын мэдлийн тусгай албад бий болгосон бөгөөд тэр үеэс л болзошгүй дайснаа урьдчилан тагнах ажиллагааг байнга явуулах болсон ажээ.

Мөн монгол цэрэг гадагш дайлах болсон цагаас эхэлж дагнан стратегийн тагнуул хийх, дайсан этгээдийн гэнэтийн ажиллагаанаас гол хүчээ сэргийлэн халхлах, дайлан өнгөрсөн газар нутагт гарч болзошгүй бослого, үймээнийг дарах үүрэгтэй “Тамачин цэрэг” хэмээх гавшгай цэргийн ангиудыг тусгайлан томилох болжээ.

Тийнхүү стратеги, тактикийн тагнуулыг маш нарийн зохион байгуулдаг байсан нь дайны талбарт амжилт олохынх нь нэг үндэс болдог байв;

- Тагнуул, судалгааныхаа үндсэн дээр дайны ажиллагааны театр буюу байлдаан явуулах газар орныг урьдчилан бэлтгэж төхөөрөмжлөх арга хэмжээг авдаг.Энэ нь одоогийн цэрэгт шинэ юм биш боловч тэртээ XIII зуунд бол шинэлэг зүйлийн нэг байв ;

-Дайсан улсаа бусад улс оронтой эвсэн нэгдэхээс урьдчилан сэргийлж, ганцаардуулах ажиллагааг цэргийн хийгээд улс төр, дипломатын бүхий л шугамаар явуулдаг.

-Дайн, байлдааны ажиллагааг тодорхой тодорхой үе шаттайгаар нарийвчлан тооцоолж гаргадаг;

-дайныг эхлэхдээ дайсныхаа хүчийг тарамдуулж, хэсэглэн хувааж цохих зорилгоор гол чиглэлд үндсэн хүчээ төвлөрүүлэхийн зэрэгцээ дайсныхаа нутаг дэвсгэрт аль болох олон чиглэлээр зэрэг довтолдог.

Монгол цэрэг хэдий олон салж, хэдий олон чиглэлээр аялан явавч шийдвэрлэх тулалдаан хийх газарт нэгэн зэрэг тал талаасаа хуралдан ирж чаддаг, тэгэхдээ хожимдох нь бүү хэл урьтаж түрүүлэлгүйгээр, яг тогтсон цагтаа ирдэг байсан ба аялан дайлах ийм зарчмыг Германы цэргийн нэрт онолч Мольтке “Саланги явж, хамтдаа тулалдах” хэмээн томъёолсон нь одоогийн цэргийн урлагийн хэвшмэл нэгэн нэр томъёо болжээ;

-монголчууд ямар нэгэн улстай дайтахдаа хүчээ ерөнхийд нь манлай, их гол, баруун, зүүн гар хэмээн хуваахаас гадна онцлог чухал чиглэлүүдэд стратегийн зориулалтаар тусгай замын түмтүүдийг томилон, туулан өнгөрсөн газруудын орчимд “Тамачин” цэрэг суулгадаг байжээ

-“Стратегийн гэнэдүүлэлт”-ийг чадамгай гүйцэтгэж, одоогийн хэллэгээр “Маневрын дайны стратеги”-ийг дэлхийн түүхэнд анх удаа хэрэгжүүлсэн;

-дайсагнагч улсынхаа цэрэг, хүн амын сэтгэл санаанд нөлөөлөх зорилгоор цэрэг дайны хөлөөс урьд сэтгэл зүйн хүчтэй довтолгоон хийдэг;

-Чингис хааны үеэс эхлэн монголчууд аль ч шашныг үл гадуурхах бодлогыг стратегийн төвшинд ч хүртэл хэрэгжүүлж байв

-монголчууд дайснаа бутран сарнисан ч гэлээ бүрэн устгаж сөнөөх хүртлээ мөрдөн хөөдөг байсан ба тэр нь тухайн үед Европынхон дайснаа зөвхөн бутраагаад орхидог байснаас онцлог байв

-цэрэг арми нь хангалтын нүсэр том бааз буюу “Ар тал” хэмээн одоогийн цэргийн нэрлэдэг зүйлээс огт хамааралгүй, Эрэнжен Хара-Даваны өгүүлсэнчлэн “хувь хувьдаа өөрийн “Бааз”-ыг авч явдаг” байсанд, мөн зүйрлэн хэлбэл ар талдаа биш, харин урд талдаа хангалтын “Бааз”-тай байсанд цэргийн хангалтын онцлог оршиж байв. Өөрөөр хэлбэл “Дайн дайнаа тэжээх ёстой” хэмээн Юлий Цезарийн өгүүлсэн хэмээх зарчмыг монголчууд жинхэнэ бодитойгоор хэрэгжүүлж байжээ.

Монгол цэрэг аянд явахдаа суурин харуул, алгинч, манлай, гол хүч, гээглүүр, ар цагдуул, хажуугийн харуул хэмээн хуваагдаж дайсны гэнэтийн довтолгооноос сэргийлэн хамгаалах бүхий л талын бололцоог бүрдүүлж явдаг байсан нь тэр үед өөр хаана ч байгаагүй нарийн зохион байгуулалт бөгөөд энэ нь харин ерөнхий бүрдэл хэсэг, зохион байгуулалтын зарчмын хувьд одоогийн цэргийн нэгтгэл, ангиудын аяны журамтай таарч байгаа юм.

Хээрийн байлдааны журам нь фронтын дагууд их гол ба зүүн, баруун гар гэдэг үндсэн гурван хэсгээс бүрдэх ба гүн тийшээ манлай, их гол, хөтөд хэмээх цувраануудаас бүрддэг байжээ.

Тактикийн түвшинд “Нуман түлхүүр байр хийх”, “Бух сэжүүр”, оросын түүх бичлэгт “Хоровод” хэмээн нэрийдсэн тасралтгүй суман мөндөр буулган довтлох өвөрмөц арга, “Алгинчлах” буюу байлдан тагнах арга, эртний уламжлалт “Өдөж хөдөлгөх”, “Нуур байрт байлдах”, “Бух сэжүүр байр хийх”, “Өлөмлөх”, “Дэрэлгэх”, “Тойрох”, “Бүслэх”, “Бүчих”, “Нүүр дээрээс нь асгах”, “Нохой хэрэл хэрэх”, “Харгана зорчил зорчих”, “Сундаргах”, “Гэнэтгэж, жич харин татах”, “Огторгуй эрвээлжлүүлэх”, хожим нь “Монголын Ла’ва” гэж нэрлэгдэж XX зууны морьт цэрэгт хүртэл уламжлагдан хэрэглэгдэж байсан арга тактик, мөн өрнөдийнхөн “Тулугама (Tulughama)” хэмээн нэрийдэх болсон тулгам байлдааны арга зэрэг олон аргыг хэрэглэж, цэргийн ов мэхийг дээд зэргээр ашигладаг байсан нь монгол цэргийн эрдэм ухааны нэгэн онцлог байв. Эдгээр арга нь тэр үедээ өөр хаана ч хэрэглэж байгаагүй маневрын тактикийн арга хэлбэрүүд байв.

Зургаа. Алтан ордны улс, Ил хант улс, Цагадайн улсын цэрэг олон улс, үндэстний цэргээс бүрдэж байсан нь зэвсэглэл, хүн нэг бүрийн агсамжид нь ч тусгалаа олсон байв.

Тухайлбал Алтан ордны улсын цэргийн “Гол хүч” нь болж байсан монгол цэрэг нь дан морьт цэрэг болон одоогийнхоор бол их буу, инженерийн мэргэжлийн мянгат, зуутуудаас бүрдэж байсан бол булгар, кибчаг зэрэг бусад бүрэлдэхүүн улс аймгийн хийгээд орос, асуд мэт түшмэг улсын цэрэг нь морьт, явган, усч цэрэг зэрэг холимог бүтэцтэй байснаар үл барам тэдгээрийн ихэс ноёдынх нь шадар цэрэг, байнгын цэргийн шинжтэй “Дружинник”-үүд болон тариачид, эгэл ардаас бүрдүүлдэг

дайчилгааны журамт цэрэг, Ижил орчим, Крым, Кавказ, бусад газраас гаралтай хөлсний цэргийн хэлбэрээр алба хашиж байсан цэрэг гэх мэт цэргийн зэвсэглэл нь өөр өөр байсан онцлогтой. Цагадайн улсын цэрэг нь ихэвчлэн Түрэг гаралтай ард түмнээс бүрдэж байсан бол Ил хант улсын цэрэг араб персүүдээс бүрдэж байжээ. Төв Азийн өнөөгийн ихэнх улс үндэстэн Цагадайн улсын цэрэгт алба хааж байжээ. Тэгвэл ойрх дорнодын ихэнх улс Ил хант улсын цэрэгт алба хааж байсан юм.

Гэхдээ монгол цэргийн гол зэвсэг нь нум сум хэвээр байсан ба цэрэг бүр байлдаанд наанадаж 2-3, түүнээс ч олон нумтай явдаг байжээ. Монгол цэргийн ердийн нум доод тал нь 30-32 кг-ын таталттай, 20-30 алхмын зайд тэр үеийн бараг бүх хуягийг нэвт харвадаг, сумны ашигтай тусгал нь 200-300 метр байсан бол хамгийн хүчит “Төмөр буюу болд ширхэгт нум” нь 70-80 кг-ынтаталт бүхий бөгөөд ашигтай тусгал нь 500-600 метр хүрдэг байжээ.

Монгол нум тухайн үедээ хамгийн хүчтэй, ончтой бөгөөд бараг ижил бүтэцтэй гэж одоо судлаачдын үзэж буй бусад нүүдэлчин улс аймгийн болон хятад, орос нумаас хүчин чадал, найдвараар илүү байсан тул Алтан ордны улсын бүрэлдэхүүнд багтаж байсан улс аймгийнхны нумын технологид шууд нөлөө тусгалаа олж, шинэчлэл өөрчлөлт хийхэд хүргэснийг эртний судлалын баримтууд нотолж байна.

Алтан ордны улсын болон Цагадайн улсын цэргийн бүрэлдэхүүнд багтаж байсан улс үндэстнүүд илд, жадны уламжлал сайтай бөгөөд мөн араб дахины дам нөлөөгөөр Их Монгол Улсын үетэй харьцуулахад монгол цэргийн хэрэглэж байсан илд, жад, бялуу шийдэм, байлдааны сүх зэрэг ойрын байлдааны зэвсгийн төрөл хэлбэр олшрон төгөлдөржиж, тэр үед Евроазид хэрэглэж байсан бараг бүх төрлийн цавчих, зүсэх, дэлдэх, занчих зэвсгээр өвч хангагдсан байжээ.

Гэхдээ Алтан ордны улс, Цагадайн улсын морьт цэрэгт хотгор илд харьцангуй их дэлгэрсэн байсан бөгөөд тэр нь морьт цэргийн цавчилдаанд бусад төрлийн илднээс илүү зохицолдолгоотой байсантай нь холбоотой байжээ. Харин Ил хант улсын цэрэгт араб даманск илд голлох байр суурьтай байжээ.

Мөн байлдаанд бие хамгаалах хэрэгсэл буюу хуяг, дуулга, халх бамбайны технологид ч хувьсал дэвшил гарч төрөл, хэлбэр нь олширсон онцлогтой байна. Гэхдээ XIII зуунаас хойш Алтан ордны бүрэлдэхүүн улсууд болон европын суурин улс орнууд “Хатангу дээл” мэт монгол хуягуудаас үлгэр авч жижиг тушим хэлхэн хийсэн уян хатан хуяг ихээр хэрэглэх болсон нь мөн л хэрэглээний зохицолдолгоо илүүтэй байсантай холбоотой байна. Тийм хийцийн хуягаа европынхон “Бригантина” (гер. Brigantine) гэдэг байсан ба оросууд монгол нэрээр нь “Куяк” хэмээн нэрлэх болжээ. Монголчууд мөн төмөр цагираг хэлхэн үйлддэг байсан хөө хуяг (хөө дээл, цагираг хуяг, гархин хуяг, төмөр хуяг ч гэдэг байсан)-ийг ч хэрэглэдэг байсан ба ийм төрлийн хуяг орос, болгар, кибчагт ч ихэд дэлгэрчээ. Цагадайн улсын цэргүүд ч XIII зууны монголчуудын нэгэн адил ижил төрлийн хуяг хэрэглэж байжээ.

Бас монголчууд тушим ба гархийг хослон үйлдсэн хуягуудыг ч өргөн дэлгэр хэрэглэдэг байсан ба “Бэхтэр” хэмээх богино, дэглэй маягийн нэгэн төрөл хуягийг үйлдэхдээ цээж, суга, ташааны зарим газарт төмөр цагариган хэсгийг оруулж өгсөн байдаг байжээ.

Монголчууд хот суурин, цайз бэхлэлтийг дайлах эртний уламжлалтай бөгөөд XIII зууны Алтан ордны улсын, Ил хант улсын, Цагадайн улсын цэрэг ч тэр үедээ тэргүүлэх хэмжээнд байсан техник, технологийг эзэмшсэн, одоогийнхоор бол

инженерийн тусгай мэргэжлийн мянгат, зуутуудтай, үүлэн шат, хуягт цамхаг, хуяг халхат тэрэг, урвуур, харвуур, чөдөр оньс зэрэг техник хэрэгсэлтэй байсан нь ялалт, амжилт байгуулахад нь шийдвэрлэх нөлөө үзүүлж байв. Ялангуяа Чингис хаан Хорезмын хаант улсыг байлдан дагуулах үед хот хэрэм эвдэх төрөл бүрийн зэвсгүүд уламжлагдан үлджээ.

Монголчууд Хятан (907-1125 он)-ы үед анх галт зэвсэг бүтээж, Их Монгол Улсын үеэс галт, дарьт зэвсгийг дайн байлдаанд өргөнөөр хэрэглэж эхэлсэн уламжлал Алтан ордны улсын үед улам хөгжиж иржээ. Монгол цэрэг кибчагуудыг мөшгин тулалдсаар өрнө зүгт цөмөрсөн их аян дайны үеэр Батын баруун гарын цэрэг Легницагийн дэргэд Польш, герман, чех зэрэг улсуудын нэгдсэн цэрэгтэй тулгарахдаа аймшигт их дуу чимээ, утаагаргадаг нэгэн шинэ төрлийн зэвсэг хэрэглэж ялсан гэж түүхэнд тэмдэглэжээ. Ямар боловч тэр үеэс монгол цэрэг галт, дарьт зэвсэг хэрэглэх болсон байсан нь баримттай байна.

Ийнхүү галт зэвсэг монголчуудаар дамжин Орос, Европ, төв Азийн бусад улсад нэвтэрсэн бөгөөд галт, дарьт зэвсэг нь XIII зууны үеийн Монгол цэргийн төдийгүй дэлхийн цэргийн хэрэгт шинэ үеийг авчирсан түүхтэй.

Долоо. Алтан ордны улс, Ил хант улс, Цагадайн улсууд оршин тогтносон хугацаандаа өөр хоорондоо болон бусад улс орнуудтай байлдан дагуулалтыг олонтоо хийж байжээ. Европ, ойрх дорнод, төв Ази гээд бүс нутгууд бүгд Алтан орд, Цагадайн улс, Ил хант улсын эрхшээлд байжээ. Дайн байлдаанд амжилт олж байсан учир шалтгаан нь ердөө Монгол цэргийн байлдах арга ухаан, зэр зэвсэг, стратеги тактик байжээ.

ТАВДУГААР БОТЬ
ЭЗЭНТ ГҮРНИЙ ДАРААХ ҮЕИЙН МОНГОЛЫН ЦЭРЭГ
(ХIҮ ЗУУНЫ II ХАГАС-ХҮII ЗУУНЫ II ХАГАС)

Цэргийн түүх судлал нь монголын эх түүхийн судалгааны салшгүй бүрэлдэхүүн хэсэг, түүний нэн чухал салбар болохын хувьд өргөн хүрээнд хөгжих үндэс суурь нэгэнтээ тавигдаж, түүх бичлэгийн шинэлэг арга зүй, чиг хандлагад тулгуурласан сурвалж, судалгааны томоохон бүтээлүүд цөөнгүй хэвлэгдэн гарч, нийтийн хүртээл болсоор байна. Гэсэн хэдий ч монгол цэргийн түүхийн судалгаанд “Эзэнт гүрний дараах үеийн Монгол цэрэг (ХIҮ зууны II хагас-ХҮII зууны II хагас)”-ийн түүхийн асуудлыг цогцоор судлан шинжилж, тухайн үеийн монгол цэргийн урлагийн түүхийг шинээр авч үзэх шаардлага хэвээр байгаа болно. Иймд өнөөгийн судалгааны түвшинд “Эзэнт гүрний дараах үеийн Монгол цэрэг (ХIҮ зууны II хагас-ХҮII зууны II хагас)”-ийн түүхийн судалгааг дараах үндсэн чиглэлд хандуулж, сурвалж, судалгааны шинэлэг баримт материалд тулгуурлан судалж, цэргийн түүх судлалын үүднээс үнэлэн дүгнэх шаардлага /үндэслэл/ чухлаар тавигдаж байна. Үүнд:

1) Монголын цэрэг, улс төрийн гадаад, дотоод харилцаа, түүнд нөлөөлсөн эерэг, сөрөг хүчин зүйлийг тодорхойлох;

2) Монгол цэргийн байгуулалт (удирдлага, бүтэц, зохион байгуулалт)-ын өөрчлөлт, түүний онцлог, шинж чанарыг харьцуулан судлах;

3) Монгол цэргийн урлаг (*стратегии (цэргийн)-стратегие военная, strategy-улс орон, зэвсэгт хүчнийг дайнд бэлтгэх онол, практик; стратегийн операц, дайныг бүхэлд нь төлөвлөж хийх үйл ажиллагааг хамарсан цэргийн урлагийн бүрэлдэхүүн дээд хэсэг*), (*мактук-мактика, tactics-Зэвсэгт хүчний төрөл, тусгай мэргэжлийн цэргийн нэгтгэл, анги салбарууд байлдааны ажиллагааг газар, агаарт бэлтгэн явуулах онол, практикийг багтаасан цэргийн урлагийн бүрэлдэхүүн хэсэг*)-ийн уламжлал, цэрэг, дайны туршлага, сургамжийг тодорхойлох;

4) Монгол цэргийн түүхийн судалгааг цогц байдал (*цэргийн байгуулалт, хууль-цааз*), (*зэвсэглэл, байлдах арга ухаан*), (*цэргийн намтар судлал-хаад, нэрт жанжин, зүтгэлтэн*), (*цэргийн археологи-байлдах зэвсэг, хэрэгслийн олдвор, түүхэн дурсгал*), (*цэргийн газар зүй- дайн, байлдааны газар орны байрлал, түүхт газар нутаг г.м*)”-аар судлан боловсруулсны үр дүнд эрт, дундад болон шинэ үеийн цэргийн түүх судлалын залгамж чанарыг тодорхойлж, цэрэг, түүхийн зарим тодорхойгүй асуудлыг шинжлэх ухааны үндэстэй танин мэдэх, нийтийн хүртээл болгох” зэрэг болно.

Энэхүү судалгааны үр дүнд дараах санал, дүгнэлтийг бүлэг тус бүрээр дэвшүүлсэн болохыг хураангуйлан авч үзвэл:

МОНГОЛЫН ЦЭРЭГ-УЛС ТӨРИЙН ГАДААД, ДОТООД БАЙДАЛ

Нэгдүгээр бүлэг, зүйлийн хүрээнд:

1) Монгол-Мингийн харилцаа (1368-1644) гол байр эзэлсээр ирсэн түүхтэй бөгөөд тус хоёр улс үндэсний эрх ашгийн үүднээс ихэвчлэн цэрэг, дайны аргаар харилцаж байсан ажээ. Энэ хугацаанд Монголын хаант төрийн эрхийг богино хугацаанд барьсан Эсэн тайш, алтан ургийн угсаа залгамжлагч хаан Батмөнх Даян хаан, Түмэн Засагт нар улс орны цэрэг, улс төрийн гадаад харилцаанд давуу талыг олж, харь улсын халдан түрэмгийлэх бодлого, үйл ажиллагааг их хэмжээнд сулруулж чадсан нь монголын гадаад харилцаанд гарсан дэвшилт үзэгдэл байсан юм. Энэхүү гадаад харилцааны давуу талыг хадгалан бэхжүүлэх талаар Чингис хааны алтан ургийн Түмэн засагт хаан, Батмөнх Даян хаан, Лигдэн хутагт хаан болон Халхын хан, ноёд, тухайлбал, Түшээт хан Гомбодорж, Сэцэн хан Шолой, Засагт хан болон Зүүнгарын Эрдэнэбаатар хунтайж, Галдан бошигт хаан нар ихээхэн хүчин чармайлт гарган тэмцэж, манжийн эзлэн түрэмгийлэх бодлого, түүний дотор өөр хооронд нь хагалан бутаргаж, цэрэг, зэвсгийн хүчийг сулруулахад чиглэсэн арга бодлогыг таслан зогсоох талаар багагүй амжилтанд хүрсэн ажээ. Гэсэн хэдий ч Монгол-Мин улсын гадаад, дотоод бодлого, түүний зөрчилт тал нь эцэстээ Манж үндэстнийг (1616-1911) сэргэн хүчирхэгжих нөхцлийг бүрдүүлээд зогсохгүй тусгаар байдлаа алдан харийн эрхшээлд ороход хүргэжээ.

2) Монгол-Дундад Азийн харилцаа (1368-1691)-нд Монголын бүрэлдэхүүн улс түмнээс Зүүнгарын хаант улс амжилттай гадаад бодлого явуулсны үр дүнд цэрэг, улс төрийн давуу байдлыг олж, Манж Чин, Орос улсын эзлэн түрэмгийлэх бодлогод томоохон цохилт өгч байснаараа онцлог юм. Түүний дотор Галдан бошигт хааны цэрэг, улс төрийн гадаад бодлого, байр суурь нь гол төлөв Чингис хааны удмын угсаа залгамжлагч хаадын захирсан Дундад Ази, Дорнод Туркестаны улс орнуудын эсрэг чиглэж байсан нь яваандаа манж Чин, Орос, Түвэд зэрэг харь улсуудын эзлэн түрэмгийлэх бодлогыг идэвхжүүлж, түүхэн цаг хугацааны хувьд өөр хоорондоо эвсэн найрамдах, нэгдэн нягтрах хэрэгт боломж бололцоог олгож байсан сөрөг талыг тэмдэглэх хэрэгтэй.

3) Монгол-Оросын харилцаа (1606-1691) нь бусад улс оронтой харьцуулбал харьцангуй эрх тэгш шинж чанарыг агуулж байсан хэдий ч Оросын зүгээс газар нутгийн түрэмгийлэл явуулж, дагаар оруулах бодлогыг тууштай хэрэгжүүлж байсан нь тус хоёр улсын харилцааг хурцатгах нөхцлийг бүрдүүлж байв.

Оросын дорно зүгт хил хязгаараа тэлэн өргөжиж, Сибирийг эзэмшин болсонтой холбогдон Халхын хаад, ноёд газар нутаг, хил хязгаараа сахин хамгаалах, бие даасан эрх тэгш харилцааг тогтоохын төлөө чармайн зүтгэж байсан нь улс орны гадаад харилцаанд багагүй нөлөө үзүүлсэн юм. Халх Монголын төр, цэргийн зүтгэлтнүүдийн Оростой харилцах бодлогын гол зорилго, чиглэл нь манжийн халдлага, түрэмгийллийг хязгаарлан зогсооход чиглэж байсан нь цаг үеэ олсон дэвшилт бодлого байсан гэж үзэж болно.

4) Монгол-Түвэдийн харилцаа (1576-1691)-нд Монгол улс нь хятадын Мин, Манж Чин болон Орос улсын цэрэг, стратегийн чухал түшиц газар нутаг болж

байснаараа нэн онцлогтой юм. Түүний дотор Монгол-Түвэдийн харилцаа нь төр, шарын шашны чиглэлээр нийтлэг эрх ашгийг эрхэмлэж, харийн түрэмгийллийн эсрэг оюун санааны хувьд нэгдэн тэмцэх зорилгыг агуулсан шинж чанартай байв. Гэсэн хэдий ч шашны үзэл суртлын зөрчилд автагдаж, харилцан тэмцэлдэх болсон нь тус хоёр улсын тусгаар тогтнолд сөрөг үр дагаврыг буй болгосон байна. Учир нь Халх Монгол, өмнөд Монгол болон Зүүнгарын хаант улсын хоорондын харилцааг хурцатгах нь гадны улсууд, нэн ялангуяа Манж Чин, Орос зэрэг улсуудын гадаад бодлогын гол зорилго болж байсан бөгөөд энэхүү бодлогодоо Түвэдийн шарын шашны нэр нөлөөг ашиглах, түүгээр дамжуулан нийт Монголын тусгаар байдал, үндэсний эв нэгдлийг задлан бутаргах, цэрэг, зэвсгийн хүчийг сулруулах зэрэг олон талын арга хэмжээг авч хэрэгжүүлсээр иржээ. Энэхүү арга бодлогодоо манж нар Түвэдийн Далай лам тэргүүтнийг өөрийн талд урвуулан авч, улмаар Халх Монгол болон Зүүнгарын хаант улсын хооронд хагалан бутаргах далд санаа зорилгоо хэрэгжүүлэхийг голлон чармайж байв

5) Монгол-Манж Чин улсын харилцаа (1616-1691) ная шахам жил үргэлжилсэн бөгөөд тус хоёр улсын цэрэг, улс төрийн харилцааны түүхэнд бүхий л үеийн туршид үндсэндээ харийн нөлөөлөл давамгайлж байсан бөгөөд Орос, Түвэд улсын идэвхтэй оролцоотойгоор дотоодын зөрчил, тэмцлээс болж 1636 онд Өмнөд Монгол, 1691 онд Халх Монгол дараалан манжийн эрхшээлд орсон байна. Энэ хугацаанд Монголын хаад, зүтгэлтнүүд, нэн ялангуяа Лигдэн хутагт хаан, Түшээт хан Гомбодорж, Сэцэн хан Шолой, Засагт хан Субадай, Зүүнгарын Эрдэнэбаатар хунтайж нар дотоодын нэгдсэн хүчээр манжийн эсрэг тэмцэхийг чухалчлан үзэж байсан бол Зүүнгарын Галдан бошигт хаан гадаад бодлогодоо Орос, Түвэд улсын тусламж дэмжлэгтэйгээр манжийн түрэмгий бодлогыг сөрөн тэмцэхийг зорьж байсан ажээ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ МОНГОЛ ЦЭРГИЙН БАЙГУУЛАЛТ

Хоёрдугаар бүлэг, зүйлийн хүрээнд: Монгол дахь улс төрийн бутралын гол шалтгаан нь нэг талаас, хаад, ноёдын улс үндэстний нийтлэг эрх ашиг, нэгдэл нягтралыг сэргээн бэхжүүлж, нэгдсэн хүчээр харийн түрэмгийллийн эсрэг тууштай тэмцэх; нөгөө талаас бие даасан амин хувийн явцуу ашиг сонирхолд автагдан, эрх мэдэл, байр сууриа нэмэгдүүлэхэд чиглэсэн цэрэг, улс төрийн эерэг, сөрөг үзэл бодлого, байр суурийн харилцан хамааралд оршиж байв.

Монголын хаант төрийн нэгдмэл, хүчирхэг байдал Элбэг Нигүүлсэгч (1393-1399) хааны үеэс эхлэн уруудан доройтох болсон хэдий ч хаант төрийн эрхийг богино хугацаанд барьсан Эсэн тайш (1452-1454), алтан ургийн угсаа залгамжлагч Батмөнх Даян хаан (1470-1517), Түмэн Засагт (1558-1592) хааны үед багагүй хугацааны туршид дахин сэргэсэн нь чухамхүү улс үндэстний нэгдэл, нягтралын бодит үр дүн байсан төдийгүй Монгол цэргийн сүр хүч, байлдан тулалдах чадвар дээшлэхэд томоохон нөлөө үзүүлэх болсон байна. Гэсэн хэдий ч манж Чин улс Засагт ханы ширээний төлөөх тэмцлээр шалтаглан, цэрэг-улс төрийн эзлэн түрэмгийлэх арга бодлогыг тууштай хэрэгжүүлэх болсноор Халх Монгол-Зүүнгарын хаант улсын эв эеийг сахисан түүхэн уламжлалт харилцаа тасалдахад хүрээд зогсохгүй эцэстээ харь улсын түрэмгийлэлд өртөхөд хүргэжээ.

Халх-Ойрадын тэмцэл нь гадаад хүчин зүйл буюу хөрш зэргэлдээх манж Чин, Орос, Түвэд улсын зүгээс монголын талаар явуулсан хагалан бутаргах, эзлэн түрэмгийлэх бодлогоос голлон үүдэлтэй юм. Ялангуяа Монголын дотоод хэрэгт манж Чин, Түвэд улсууд ил, далд хэлбэрээр илэрхий оролцох болсны дотор Түвэдийн эрх баригчид Халх Монголын тэргүүлэх зүтгэлтний нэг Өндөр гэгээний байр суурийг бууруулахын тулд шарын шашны нэр нөлөөг ашиглах замаар Зүүнгар улсын хаан Галдан бошигтыг Халхад цэрэглэн довтлох явдлыг далдуур дэмжиж, Халх-Ойрадыг дотор нь хагалан бутаргаж, сүр хүчийг сулруулснаар манжийн эрхшээлд оруулах, улмаар манжийн эрхшээл нөлөөнөөс өөрсдийн тусгаар байдлыг хэвээр авч үлдэн бэхжүүлэх гэсэн эчнээ далд бодлогыг эртнээс авч хэрэгжүүлсээр иржээ. Чингэж үзвэл, Халх-Ойрадын тэмцэл нь монголчуудын хувьд тусгаар тогтнолоо алдахад хүрсэн гол “шалтгаан” бус, харин харь улсуудын цэрэг, улс төрийн эзлэн түрэмгийлэх далд санаа зорилгоос үүдэлтэй зөвхөн “шалтаг” нь болжээ.

Цэргийн үндсэн төрөл нь морьт цэрэг хэвээр байж, цэрэг, дайны гол хүч болж байсан тул түүний “хурд, хөдөлгөөн”-ий уян хатан, давуу чанар нь гадаад, дотоодын эсэргүүцэл тэмцэл, их, бага хэмжээний дайн, байлдаанд ялан дийлэхүйн үлгэр жишээг ямагт үзүүлсээр ирсэн төдийгүй цэргийн бүтэц, зохион байгуулалтын уламжлалт шинжээ хадгалан, хувьсан хөгжиж байв. Түүнчлэн явган цэрэг, бууч цэрэгтэй байжээ.

Өгүүлэн буй үед хамаарах монгол цэргийн бүтцэд тугчин, бүрээчин, энгийн лүвчтэн, дэглэй хуягт, дуулгат зэрэг нэр цол бүхий цэргийн албан тушаалтнууд зохих байр эзэлж, дайн, байлдааны цагт үүрэг гүйцэтгэх чадвар, эрх үүргийн хувьд өөр хоорондоо нэлээд ялгаатай байжээ. Энэ үед 15-16 түм орчим цэргийн хүчийг тус тус татан бүрдүүлж, тусгаар улс орноо хамгаалан сахиж байв

XIV-XVII зууны үед Монголын хаад, зүтгэлтнүүд дотоодын зөрчил тэмцэл хийгээд хөрш зэргэлдээх улс орны түрэмгийллийг таслан зогсоох зорилгоор их, бага хэмжээний хорь орчим тооны цэргийн цаазыг хэлэлцэн боловсруулж, улс, орон бүс нутгийн хэмжээнд чандлан мөрдүүлж байв. Тухайн үеийн цэргийн цаазын агуулга, шинж чанар нь 1) Монголын уламжлалт цэргийн цааз; 2) Манжаас Монголд тогтоосон цэргийн цааз хэмээх хоёр үндсэн хэсэгт хуваагдаж байсан гэж үзэж болохоор байна.

Монголын уламжлалт цэргийн цаазын агуулга нь цэргийн удирдлага, бүтэц, зохион байгуулалт, сургалт, бэлтгэлийг эс тооцвол байлдаан (цэргийн дайчилгаа, татан бүрдүүлэлт, тагнуул хамгаалалт, сахилга, дэг журам, зэвсэглэл, агт морь)-ы хангалт болон ар тал (цэргийн хувцас хэрэгсэл, хоол хүнс г.м)-ын хангалтын асуудалд голлон чиглэж байснаараа нэн онцлогтой юм. Ялангуяа цэргийн тагнуул, сахилга, дэг журам, агт морьдын талаар тухайн үеийн ихэнх цаазын бичгүүдэд чандлан сахиж мөрдөхийг заасан нь Монгол цэргийн байлдах, дайтах чадварыг нэмэгдүүлэхэд зохих нөлөө үзүүлж байжээ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ ЦЭРГИЙН УРЛАГИЙН УЛАМЖЛАЛ

Гуравдугаар бүлэг, зүйлийн хүрээнд: Эзэнт гүрний дараах үеийн Монголын хаант төр зүүн, баруун (Ойрад) Монгол хэмээн хоёр үндсэн хэсэгт хуваагдан оршиж байсны дотор зүүн Монгол нийт зургаан түмэн (зүүн 3 түмэн-халх,

цахар, урианхай, баруун 3 түмэн-ордос, түмэд, юншээбүү), баруун (ойрад) Монгол дөрвөн аймаг (хошууд, торгууд, дөрвөд, чорос)-аас тус тус бүрэлдсэн нь Монголын эртний цэрэг, засаг захиргааны уламжлалт аравтын тогтолцооноос үүссэн өвөрмөц хэлбэр юм.

Монголын уламжлалт цэрэг, засаг захиргааны аравтын тогтолцооны түмт-мянгат-зуут-аравт хэмээх нэгжийн ор суурийг түмэн-отог-хошуу-дөчин-хорин-арван-хот айл гэсэн нэгжээр нэрлэх болсон байна. Тэдгээрээс “түмэн”, “отог-хошуу” нь засаг захиргаа, цэргийн зохион байгуулалтын хосолсон хэлбэр болж байсан бол бусад нэгжүүд нь иргэний шинжийг илүүтэй агуулж байснаараа онцлогтой ажээ.

Тухайн үеийн төр, цэргийн удирдлага, бүтэц, зохион байгуулалтын дээрх өөрчлөлтийн хүрээнд авч үзвэл, Монгол дахь улс төрийн бутралын гол шалтгаан нь төр улсын батлан хамгаалах үүрэг зорилт бүхий “байнгын нэгдсэн Зэвсэгт хүчин”-тэй байх чадвар алдагдсанд оршиж байв. Өөрөөр хэлбэл, улс орны тусгаар тогтнол, бие даасан хүчирхэг байдал гагцхүү цэргийн хүчний нэгдмэл тогтолцоо, түүний үүрэг гүйцэтгэх олон талт чадвараас шууд хамаарч байсан түүхэн уламжлал тасалдсан нь тухайн цаг үед улс үндэстний нийтлэг эрх ашигт сөргөөр нөлөөлж, эцэстээ харийн түрэмгийлэлд өртөн тусгаар байдлаа алдахад хүргэсэн гол хүчин зүйлийн нэг болсон байна.

Монгол цэрэг нийт 10 гаруй төрлийн байлдах зэвсэг, 20 гаруй төрлийн байлдааны хэрэгслийг дайн, байлдаанд өргөн хэрэглэдэг байсны дотор байлдах уртын зэвсгээс нум сум, охор зэвсгээс илд (сэлэм), жад, хутга зэргийг түгээмэл хэрэглэж байв. Харин Монгол цэргийн байлдааны гол хэрэгсэл урьдын нэгэн адил агт морь хэвээр байсан төдийгүй цэргийн агт морьдыг тусгайлан хамгаалах, өсгөн үржүүлэхээс гадна цэрэг, дайны зориулалтаар хуяглан бэлтгэж байжээ. Мөн галт зэвсгийг үйлдвэрлэн хөгжүүлж, цэрэг, дайны хэрэгт өргөн ашиглаж байсан нь Монгол цэргийн зэвсэглэл тухайн үед өндөр төвшинд уламжлагдан хөгжиж байсны бодит илрэл юм.

Монгол цэргийн стратеги, тактикийн зарчим юуны өмнө Чингис хааны цэргийн урлагийн түүхэн уламжлалд тулгуурлан хөгжиж байжээ. Монгол цэргийн дайтах, байлдах урлагийн үндсэн зарчим нь 1) Дайсан этгээдийн хямрал, зөрчлийг ашиглах; 2) Цэргийн холбоотноо зөв сонгох; 3) Улс төр, зэвсгийн хүчийг хослуулах; 4) Гол цохилтын чиглэлээ зөв сонгон, түүнд хүчээ зөв хуваарилах; 5) Монгол цэргийн стратеги, тактикийн уян хатан чанарыг баримтлах; 6) Дайн, байлдааны санаачлагыг гартаа авах; 7) Нэгэн удирдлага, нягт харилцан ажиллагааны зарчмаас бүрдэж байжээ.

Монгол цэргийн аяны журам нь гүн тийшээ туршуул цэрэг, хошууч (манлай) цэрэг, Эхи (их гол) цэрэг гэсэн үндсэн цувраанаас бүрдэж байсан бол цэргийн цувааны хоёр талд хажуугийн хамгаалалт болгон, хүн, хүчний хувьд дайсны гэнэтийн довтолгоог няцаах үүрэгтэй баруун, зүүн гарын хайгуул (туршуул) цэрэг ба цэргийн цувааны араар тойрон ирж болзошгүй дайсны гэнэтийн довтолгооноос сэргийлэн хамгаалах буюу “Цэргийн сүүлийг хамгаалан явах” үүрэгтэй арын хайгуул (халхавч) цэргээс тус тус бүрдэж байв. Харин ХҮ зууны үеэс цэргийн аяны журмын үндсэн зарчимд тулгуурласан уулга хийх буюу гэнэтийн дайралт, довтолгоо хийх гол зорилготой “туршуул цэрэг, уулгач цэрэг, эхи цэрэг”-ээс бүрдсэн цэргийн аяны журмын нэгэн өвөрмөц төрөл шинээр буй болсноороо онцлог юм. Эдгээрээс үзвэл,

өгүүлэн буй үеийн Монгол цэргийн аяны журам нь бүрэлдэхүүний хувьд дотроо “цэргийн аяны журам” болон “уулга хийх үеийн аяны журам” гэсэн үндсэн хоёр төрлөөс бүрдэж байсан гэж дүгнэж болохоор байна.

Монгол цэргийн байлдааны журам нь “гүн тийшээ хошууч цэрэг (манлай), эхи цэрэг (их гол), хөтөл (ар тал) цэргээс, харин фронтын дагуу хавиргын анги (баруун, зүүн гар) болон эхи (их гол) цэрэг”-ээс тус тус бүрдэж байсан нь чухамдаа Чингис хааны цэргийн аяны болон байлдааны журмын зарчим үндсэндээ хэвээр үргэлжилж байсныг харуулжээ. Үүнээс гадна тухайн дайн, байлдааны зорилго, чиглэл, цар хүрээнээс хамаарч өдөөх цэрэг, илэрхий цэрэг, өм цэрэг, бүгэх цэрэг, бэлдэх цэрэг бүхий байлдааны журмын зохион байгуулалт болон байлдах арга (тактик)-ийн шинэ төрөл, нэгжүүдэд хуваагдан өөрчлөгддөг байснаараа онцлог байв.

Монгол цэргийн байлдах арга ухаан нь дундад зуунаас уламжилсан 1) Хээрийн байлдаан, 2) Хот, сууринг дайлах байлдаан гэсэн үндсэн хоёр хэсгээс бүрдэж байсны зэрэгцээ түүний байлдах, дайтах аргын үндэс нь хөнгөн морьт цэргийн маневрын өргөн боломжид түшиглэсэн хэвээр байсан ажээ. Эцэст нь дүгнэвэл, 1368 онд Монголын эзэнт гүрний төв болох Юан гүрэн мөхсөнөөс хойш үүсэн тогтсон цэрэг, улс төрийн гадаад, дотоод харилцааны ээдрээ төвөгтэй нөхцөл байдал, хүчин зүйлийн улмаас манж Чин улсын засаг захиргааг арга буюу хүлээн зөвшөөрсөн сөрөг үйл явцыг даруй хоёр зуу гаруй жилээр хойшлуулж чадсаны дотор 1636 онд Өвөр Монголыг эзлэх хүртэл 20 жил, 1691 онд Халх Монголыг эзлэх хүртэл 75 жил, 1758 онд Зүүнгарын хаант улсыг эзлэх хүртэл 140 гаруй жилийн туршид төр улсын тусгаар байдлаа тууштай хамгаалан тэмцсэн нь чухамдаа эр зоригт, эрэмгий дайчин Монгол цэрэг (XIV зууны II хагас-XVII зууны II хагас)-ийн гүйцэтгэсэн үүрэг, түүхэн гавьяа зүтгэлтэй салшгүй холбогдоно.

Судалгааны ажлын шинэлэг тал:


- Аливаа улс орны албан ёсны нэрийдэл нь үндэсний тусгаар тогтнол, бие даасан байдал хийгээд гадаад, дотоод харилцааны үндэс суурь болж, олон улсын хэмжээнд зүй ёсоор хүлээн зөвшөөрөгдөхийн баталгаа, нэр төрийн хэрэг цэрэг, түүхийн судалгаанд чухал ач холбогдолтой юм. Гадаад, дотоодын түүхийн сурвалж, судалгааны зохиол бүтээлүүдэд XIV-XVII зууны үеийн Монгол улсын нэрийг "Мин улсын үеийн Монгол", Юань улс мөхсөний дараах Монгол, "Юаний үлдэгдэл", "Юаний хойчис", "Хуучин Юаний хүчин доройтсон ба Мин улсаас ван өргөмжлөл зассан үе", "Самуурлын үе", "Татар, Ойрад, Урианхайн аймаг", "Монголын хаант улс", "Бэйлу", "Нан Вэй", "Дөчин түмэн их Монгол улс", "Монгол, Ойрадын улс", "Улс төрийн бутралын үеийн Монгол", "Ар Юань улс", "Умард Өн улс", "Бага хаадын үе" хэмээн янз бүрээр бичиж тэмдэглэжээ. Харин монголын албан ёсны түүх судлалд өгүүлэн буй үе [XIV зууны II хагас -XVII зууны II хагас]-ийн улс орны нэрийн тухайд 1954 оноос “феодализм”, “феодалын бутрал”, 1966 оноос “XIV-XVII зууны үеийн Монгол орон”, 1968 оноос “XIV-XIX зууны үеийн Монгол орон”, 1984 оноос “XIV-XVII зууны үеийн Монгол орон [Феодлын бутрал]” гэх зэргээр тэмдэглэсэн буй. Эдгээр нэр томъёо нь монголын түүх бичлэгт марксист онол, арга зүйн нөлөө хүчтэй дэлгэрч байсантай холбоотой юм. Өдгөө Монгол улсын албан түүхийн бүтээлд хууль цааз болон сурвалж бичгийн мэдээ баримтанд үндэслэн “Дөчин, Дөрвөн хоёрын үе”, “Монгол улсын үе” хэмээн авч үзэх болсон байна. Гэвч эдгээр нэрийдэл нь нийгэм, улс төр болон цэрэг, түүхийн асуудлыг хараахан бүрэн хэмжээнд тусган

илэрхийлэх боломжгүй юм. Иймд сүүлийн үеийн судалгааны ажлын үр дүнд улс орны нэрийдэл болон тухайн цаг үеийн онцлогийг харгалзан “Эзэнт гүрний дараах үеийн Монгол цэрэг (XIV зууны II хагас-XYII зууны II хагас)” хэмээн нэрийдэх саналыг анхлан дэвшүүлсэн;


- Монгол цэргийн цаазны шинж чанар, цэрэг-улс төрийн түүхэн ач холбогдлыг цэргийн түүх судлалын үүднээс тусгайлан судалж, үнэлэн дүгнэсэн;
- Монгол цэргийн гадаад, дотоодод явуулсан дайн, байлдааны тоо баримтыг ойролцоогоор тооцон гаргаж, түүний ялалт, ялагдлын хувь хэмжээ, учир шалтгааныг тоон график аргаар судлан дүгнэх оролдлого хийсэн;
- Монгол цэргийн зэр зэвсгийн хөгжлийн түүхийн асуудлыг тусгайлан авч үзэхдээ сүүлийн үеийн түүх, археологийн олдвор, баримт материалаар баяжуулан, цэргийн түүх судлалын үүднээс судлан шинжилж, судалгааны эргэлтэнд оруулсан зэрэг болно.

Судалгааны ажлын үр дүнг график байдлаар дор үзүүлэв.

Монголын цэрэг гадаад улс орнуудын халдлага, түрэмгийллийн эсрэг ойролцоогоор нийт дөрвөн зуу гаруй удаагийн их, бага хэмжээний дайн, байлдааны ажиллагааг явуулсны 70 шахам хувьд ялалт байгуулсан нь цэрэг-улс төрийн харилцааны давуу тал болон байлдан тулалдах чадвараа зохих хэмжээнд хадгалан оршиж байсныг харуулж байна (1.2-3 дугаар график).




1.2 дугаар график. Монгол цэргийн гадаад улс орнуудын эсрэг явуулсан дайн, байлдааны үр дүн (XIV зууны II хагас-XYII зууны II хагас)



1.3 дугаар график. Монгол цэргийн гадаадад явуулсан дайн, байлдааны үр дүн (XIV зууны II хагас-XVII зууны II хагас)


Монгол дахь улс төрийн бутралын үеийн урт удаан жилийн туршид үргэлжилсэн дайн, байлдааны шалтгаан, зорилго чиглэл, үр дүнг судлан тодорхойлж дүн шинжилгээ хийх нь цэрэг-түүхийн олон талт асуудлыг танин мэдэхэд чухал ач холбогдолтой юм. Иймд ойролцоогоор Монгол цэргийн дотоодод явагдсан их, бага хэмжээний 100 удаагийн дайн, байлдааны ажиллагаа (**2 дугаар хавсралт**)-г тоон үзүүлэлтийн аргад үндэслэн дараах байдлаар үнэлэн дүгнэж болно. Үүнд:

1) Монголын дотоодод өрнөсөн дайн, байлдааны цэрэг-улс төрийн гол шалтгааны талаар авч үзвэл, **A)** Хаант төрийн нэгдмэл байдлын төлөөх тэмцэл-25%, **B)** Хаант төрийн эсрэг бослого, тэмцэл-25%, **C)** Бие даасан ноёд, язгууртнуудын хоорондын тэмцэл-33%, **D)** Гадны хүчин зүйлийн оролцоо-7% гэсэн үзүүлэлт гарч байна. Энэ нь улс төрийн бутралын түүхэн эгзэгтэй цаг үед улс үндэстний нийтлэг эрх ашгаас илүүтэй амин хувийн явцуу ашиг сонирхолд автагдсан, бие даасан ноёд, язгууртны эрх мэдэл, байр суурийн төлөөх өөр хоорондын байнгын зөрчил, тэмцэл хийгээд “хаант төрийн тухайд төвд тэмүүлэх хүч ямагт багасаж, төвөөс зугтах хандлага хүчтэй болсон”-д оршиж байсныг харуулжээ (**1.4 дүгээр график**).




1.4 дүгээр график. Монгол цэргийн дотоодод явуулсан дайн, байлдааны цэрэг, улс төрийн шалтгаан (XIV зууны II хагас-XVII зууны II хагас)

2) 1368-1691 онд хүртэлх гурван гаруй жилийн туршид үргэлжилсэн дайн, байлдааны түүхэн цаг хугацааг 100 жилийн давтамжтай авч үзвэл, **A)** 1368-1468 он-48%, **B)** 1469-1569 он-28%, **C)** 1570-1691 он-24% болж байна. Эндээс дүгнэвэл, Монголын дотоодод эхний 100 жилийн хугацаанд хамгийн олон удаагийн дайн, байлдаан болж, цэрэг, улс төрийн тогтворгүй байдал ихэд давамгайлж байжээ. Энэ нь 1368 онд Монголын Юань улсын ноёрхол эцэс болсноос шалтгаалан алтан ургийн угсаа залгамжлагч хаадын сүр хүчин ихэд бууран доройтож, хаант төрийн нэгдмэл, хүчирхэг байдал алдагдах болсонтой холбоотой юм. Харин Эсэн, Батмөнх Даян, Түмэн Засагт нарын хаад Монгол дахь улс төрийн бутралыг амжилттай даван туулж, хаант төрийн нэгдсэн цэрэг, засаг захиргааг сэргээн тогтоогоод зогсохгүй харь улсын түрэмгийллийн эсрэг шийдвэрлэх цохилт өгөх болсны үр дүнд дотоодын дайн, байлдаан харьцангуй буурах хандлагатай болжээ **(1.5 дугаар график)**.




1.5 дугаар график. Монголын дотоодод өрнөсөн дайн, байлдааны түүхэн цаг хугацааны давтамж (XIV зууны II хагас-XVII зууны II хагас)

3) Аливаа дайн, байлдааны амжилт, ялалтын үндэс нь байлдах арга ухаан, зэр зэвсгийн хүчин чадлаас гадна цэрэг, стратегийн ашигтай байрлал, нэн ялангуяа орон зайн давуу талыг хэрхэн эзлэхээс ихээхэн шалтгаалдаг билээ. Иймд монгол цэргийн дотоодод явагдсан дайн, байлдааны цохилтын гол чиглэл, газар орны тойм судалгааг **A)** Зүүн (Халх) Монгол, **B)** Баруун (Ойрад) Монгол, **C)** Өмнөд Монгол, **D)** Тодорхойгүй гэсэн дөрвөн үндсэн хэсэгт хуваан авч үзвэл, даруй зүүн Монголын нутаг дэвсгэр, хил хязгаарын дотор ихэнхдайн, байлдаан болж өнгөрчээ. Энэ нь юуны өмнө Монголын төр ёсны уламжлал, хаант төрийн гал голомт эртнээс тухайн бүс нутагт оршин байсаар ирсэнтэй шууд холбоотой бөгөөд түүний цэрэг-улс төрийн үндсэн гол зорилго, чиглэл нь хаант төрийн эрх мэдэл, байр суурийг өөрийн эрхшээл нөлөөнд оруулахад оршиж байсан ажээ **(1.6 дугаар график)**.



1.6 дугаар график. Монголын дотоод дахь дайн, байлдааны газар орны тойм судалгаа (XIV зууны II хагас-XVII зууны II хагас)

4) Халх-Ойрадын цэрэг-улс төрийн харилцаа гол төлөв дайн, байлдаанаар илэрч байсан бөгөөд тэдгээрийн үр дүнг харьцуулан үзвэл, **A)** Зүүн (Халх) Монгол-47%, **B)** Баруун (Ойрад) Монгол-43%, **D)** Тодорхойгүй-10% гэсэн үзүүлэлт гарчээ. Эндээс үзвэл, Халх-Ойрадын хоорондын дайн, байлдааны үр дүн үндсэндээ адил хэмжээнд байсан нь мэдэгдэх бөгөөд энэ нь байлдах арга ухаан, зэр зэвсгийн хувьд өөр хоорондоо ижил төсөөтэй олон шинж чанар, арга ухааныг агуулж байсантай холбоотой ажээ. **(1.7 дугаар график).**



1.7 дугаар график. Халх-Ойрадын дайн, байлдааны үр дүн (XIV зууны II хагас-XVII зууны II хагас)

ЗУРГААДУГААР БОТЬ

МАНЖИЙН ЭРХШЭЭЛИЙН ҮЕИЙН МОНГОЛ БА ЗҮҮНГАРЫН ХАНТ УЛСЫН ЦЭРЭГ

Зургаа дугаар боть нь удиртгал, 4 бүлэг 15 зүйл, төгсгөл, ном зүйгээс. “Монгол цэргийн түүх” төслийн зургаадугаар ботид XVI зууны эцсээс эхлэн монголчууд Чин улсын түрэмгийллийн эсрэг тэмцсэн түүх, түүнчлэн дотоодын дайн самуун, Манжийн эрхшээлийн үеийн монгол цэргийн түүхийг улс төрийн түүхийн нь дэвсгэр дээр тодруулан гаргахыг оролдов. Манай Монгол улсын эрт, дундад үеийн түүх бол ерөөс цэрэг дайны түүх гэж хэлэхэд хилсдэхгүйн адил өгүүлэн буй үеийн түүх ч мөн энэ зарчмаас хазайхгүй, ялангуяа харийн түрэмгийлэгчдийн эсрэг тууштай тэмцсэн тэмцлийн түүх учир ийнхүү улс төрийн түүхтэй холбон бичихээс өөр аргагүй юм. Нэгэнт цэргийн түүх учраас харийн түрэмгийллийн эсрэг тэмцсэн дайн тулаанаас гадна дотоодын дайн самууныг бас оруулсныг дурдах нь зүйтэй. Энэ нь түүхэн сургамжийн ач холбогдолтой гэж үзэж байна.

Тус ботийн тэргүүн бүлэгт XVII зууны эхэн үеийн Монголын улс төрийн байдал, Монгол, Зүрчидийн харилцаа, Өвөр Монгол манжийн эрхшээлд орсон үйл явц, Цахарын Бүрни ван нарын манжийг эсэргүүцсэн бослого, дэд бүлэгт XVII зууны Халх түмний улс төрийн байдал, халхчуудын Манжийн эсрэг тэмцэл, Халхын дотоод хямрал, Халх-Ойрадын дайн, улмаар халхчууд Манжийн эрхшээлд орсон үйл явцыг дэлгэрэнгүй өгүүлсэн төдийгүй манай түүх бичлэгт урьд өмнө төдий л тусгадаггүй байсан 1686-1688 оны Монгол-Оросын дайны талаар тусгай зүйл оруулав. Харин гутгаар бүлэгт Зүүнгарын хаант улс байгуулагдсан үйл явц, Манжийн эсрэг Зүүнгарын хаант улсын тэмцэл, ойрадуудын цэргийн стратеги, урлагийн талаар нарийвчлан өгүүлэв.

Тус ботийн дөрөвдүгээр бүлэгт Манжийн эрхшээлд орсны дараах монгол цэргийн байгуулалт, монгол цэргийн зэвсэглэл, цэргийн урлагийн асуудлыг өнөөгийн Монгол улсаар суурь болгон өгүүлэхийг оролдсоноос Манжийн эрхшээлийн үед монгол цэргийн дайчлагдан оролцсон дайн байлдааны тухай оруулсан нь урьд өмнө манай түүхэнд төдий л тусгагдаж байгаагүй шинэлэг хэсэг болно.

Ерөнхийдөө өгүүлэн буй үеийн Монголын цэргийн түүхийг сүүлийн жилүүдэд судалгааны эргэлтэд орж буй архивын шинэ баримт хэрэглэгдэхүүн, сурвалжийн мэдээ, шинэ судалгаанд тулгуурлан бичихийг оролдов. Мэдээжийн хэрэг, тус бүтээлийг туурвихад манай ахмад эрдэмтдийн туурвисан суурь судалгааны бүтээлүүд гол суурь болсон агаад зохиогчид өмнөх судалгааг нарийвчлан тодруулах, зарим талаар засаж залруулах, шинэ санал дэвшүүлэхийг зорьсон болно.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ӨВӨР МОНГОЛ МАНЖИЙН ЭРХШЭЭЛД ОРСОН НЬ

§ 1.1. XVII зууны эхэн үеийн Монголын улс төрийн байдал, Монгол, Зүрчидийн харилцаа

Зохиогч нэгдүгээр бүлгийн нэгдүгээр зүйлдээ XVII зууны эхэн үеийн Монгол улс төрийн гадаад, дотоод байдал болоод бүс нутгийн байдал түүн дотроо Зүрчидийн овог аймгуудын хүчирхэгжилт, Мин улсын нүүдэлчдийн дунд явуулсан бодлого зэргийг авч үзжээ.

XVII зууны эхэн үед Монгол улс дэлхийн хэмжээнд бодлого явуулж чадахаа больсон боловч, бүс нутагтаа ихээхэн үүрэг бүхий хүчирхэг улс хэвээр байсан юм. Монголчууд энэ үед Өмнөд Сибирээс Түмэн газрын урт цагаан хэрэм хүртэл, Ляодунгийн хойгоос Ижил мөрөн хүртэлх асар уудам нутагт оршиж байжээ.

§ 1.2. Өвөр монголчууд манжийн эрхшээлд орсон нь

Нурхачи хүчирхэгжин, хөрш зэргэлдээ улс орнуудын талаар түрэмгий бодлого явуулах болсон тул Монголын их хаан Лигдэн өөрийн улсын эв нэгдэл, хүчин чадлыг бэхжүүлэх, Манжийн халдан довтлох аюулаас сэргийлэх зорилгоор Мин улстай найрамдах бодлого баримтлах болжээ. Мин улс Лигдэн хааны эв найртай харилцаж, Манжийн эсрэг холбоо тогтоох саналыг өөрийн эрх ашигт тохируулан хүлээн авч, зүүн хойд хил хязгаараа Манжаас хамгаалахад монголчуудыг ашиглахыг зорьж байв.

Манжийн хаан Нурхачи 1621 онд Мин улсын Шэньян зэрэг хэдэн хотыг эзлэн, Ляодунд бэхжсэнийхээ дараа Монгол аймгуудын талаар явуулах бодлогодоо өөрчлөлт оруулав. Нурхач Мин улсын хязгаарыг эзлэн газар нутгаа өргөтгөхөд гол анхаарлаа хандуулж, Монгол аймгуудын элдэв хатгалгад тэвчээртэй хандаж, тэднийг биедээ эээр татах бодлого явуулж байснаа 1623 оноос айлган сүрдүүлж, цэргийн хүчээр дагуулах бодлогод аажмаар шилжжээ. Үүний дагуу манж нар монголчуудыг дотроос нь задлан, хүчийг нь тарамдуулж цувруулан эзлэх бодлого явуулжээ.

Лигдэн хутагт хаан нас нөгчсөнөөр Өвөр Монголын олон аймгийн ноёд шил шилээ даран Манжийн хаанд дагаар орох болов. 1636 оны хавар Манжийн их ноёд, Өвөр Монголын 16 аймгийн 49 ноён Манжийн нийслэл Мүгдэнд чуулж, Манжийн хаанд “эрхэм цол өргөсүгэй” хэмээсэн тул Манжийн хаан энэ тухай Солонгосын ванд мэдэгд хэмээн элч илгээжээ.

1636 оны зуны тэргүүн сард Манжийн их ноёд, Өвөр Монголын ноёнд тэргүүтэй манж, монгол, хятад ноёд Мүгдэнд чуулж, Манжийн хаанд “эрхэм цол өргөсүгэй” хэмээн манж, монгол, хятад 3 хэлээр тус бүр нэг хувь бичиг үйлдэж өргөн барьсан бичигтээ “... Солонго улсыг оруулав, Монгол улсыг нэгтгэв. Бас хас эрдэнэ тамгыг олсон” тул “эрхэм цол өргөхийг зөвшөөрөх ажааму” хэмээн гуйсанд

Манжийн хаан хэдэнтээ татгалзсаны эцэст зөвшөөрсөн гэж сурвалжид тэмдэглэжээ. Мөн сарын хөхөгчин тахиа өдөр Манжийн хаанд цол өргөх ёслол болж, тэнгэр газарт өчин тахиад, “Агууд өршөөгч найрамдуу Богд хаан” хэмээн өргөмжлөөд, улсын нэрийг өөрчлөн Дай Чин (Их ариун) улс, оны цолыг Дээд эрдэмтийн тэргүүн он хэмээн халжээ. Ийнхүү Өвөр Монгол Чин улсын харьяат болов.

§ 1.3. Цахарууд манжийг эсэргүүцэн тэмцсэн нь. Бүрни вангийн бослого

Монголын сүүлчийн их хаан Лигдэний том хүү нь Эжэй хонгор, бага нь Абунай билээ. Эцгээ нас барсны дараа хоёул Манжид дагаар оржээ. Ах Эжэй хонгорыг 1641 онд нас барсны дараа 1648 онд дүү Абунай нь ахынхаа чин вангийн хэргэмийг залгамжилжээ.

Гэвч Абунай анхнаасаа л Манжийг төдий л таашаахгүй, тэдэнд хүчлэн зүтгэхгүй байжээ. 1659 онд Абунайн харьяат Ажиса нь Ням гэгч хүнийг хутгалахыг завдсан хэрэг гарч, тэрхүү хэргийг үйлдсэн Ажиса-г Манжийн хууль ёсоор өөр хошууны засаг ноёдод хэлж шийтгүүлэх ёстой байтал, Абунай дур мэдэн Ажиса-г алсан тул түүний чин вангийн хэргэмийг эвдэж, 1000 адуугаар торгох, Ажиса-гийн эцэг эх, дүү, эхнэрийг нь Абунайд хэлэлгүй дураар алж, тус хэргийг шүүсэн хошууны эзэн Ахлах, Гармасэрэнг цаазаар аваачиж, гэр барааг нь талах, бас тэдэнтэй хамт хэргийг шүүсэн хүмүүсийн гэр барааг нь талах саналыг Гадаад Монголын төрийг засах явдлын яамнаас гаргасан боловч Эеэр засагч хаан Абунайн хэргэм зэргийг нь хасалгүй, гагцхүү торгох ялыг хэвээр нь үлдээгээд, Ахлах, Гармасэрэн нарыг цаазаар авах ялаас хэлтрүүлсэн ажээ.

1661 онд Эеэр засагч хаан нас барахад гашуудлын ёслолд нь Абунай оролцоогүй ажээ. Ял торгууль хүлээсний дээр, угаасаа Манжийн төрд таагүй ханддаг байдал нь нөлөөлсөн бололтой. Харин Энх амгаланг хаан сууринд суух ёслолд оролцжээ. Гэвч түүнээс хойш 8 жилийн турш Абунай Манжийн хаанд бараалхаагүй учир 1669 онд түүний хүү Бүрни-д хошой чин вангийн хэргэмийг залгамжлуулж, Абунайг Мүгдэн хотод хорьжээ. Түүний хөвгүүд эцэгтэйгээ уулзахыг оролдсон боловч бүтээгүй ажээ. Энэ үеэс эхлэн Абунай, Бүрни нар Чин улсын эсрэг бослого гаргах гэж байна гэсэн цуу яриа сонсогдож эхэлжээ.

1673 оны эцсээр Хятадын өмнөд нутагт Чин улсыг эсэргүүцсэн У Саньгуй нарын бослого гарчээ. Чин улсын Энх амгалан хаан Бээжинд байсан бүх цэргээ дайчлан бослогыг даруулахаар өмнөд нутагт илгээсэн тул өвөр монгол, манжийн зүүн хойт нутгийн харуул хамгаалалт нэлээд суларсан байжээ.

Цахарын Азар лам, Цахарын Сэнгэ хонжин, Гармасэрэн, Будари тэргүүтэй хүмүүс Бүрни, Лувсан нарыг энэ тохиоллыг ашиглан, бослого гаргахыг ятган өдөөсөн ажээ. Бүрни, Лувсан нар юуны өмнө Мүгдэнд хоригдож буй эцгээ суллан авч, дараа нь Бээжинг довтлохоор төлөвлөсөн бөгөөд Цахарын баруун гарын 4 хошууны цэргийг давшилтад бэлдүүлж байжээ.

Бас Цахарт хавсаргасан Халх (Өвөр Монголд багтсан Халхын баруун гарын хошуу)-ын гүн Чойжав, Цахарын хошууны эзэн Жинжин, Найманы Дархан жүн ван Жамсан нар бослогыг идэвхтэй дэмжжээ.

Бүрни нарын бослогын төлөвлөгөө илчлэгдсэн тул төлөвлөсөн ёсоор 1675 оны хаврын сүүл сарын 25-ны өдөр бослого гаргажээ. Манжийн төр Бүрнийн босогчид юуны өмнө Мүгдэнг довтлохоос сэргийлж эхлээд тус хотыг хүүхэд

хөгшдөөр сахиулаад, дараа нь цэрэг дайчлан, жанжин Өнөбаатар, Нингүта-гийн жанжин Бахай нараар сахиулжээ.

Мөн Энх амгалан 1675 оны зуны тэргүүн сарын шинийн 6-нд зарлиг буулгаж, хаан яаравчлан төрийн Итгэлт жүн ван Ужа-г их жанжин, хошууны эзэн, бичгийн эрхин түшмэл Тухай-г туслагч жанжин болгож цэрэг авахуулан, цахарын агт морь туранхай байгаа үеийг ашиглан, үтэр түргэн Бүрни-гийн эсрэг дайлаар мордуулжээ. Нөгөөтэйгүүр Бүрнид хүн зарж ялаа хүлээн бууж өгөхийг шаарджээ.

Манжийн цэрэг 1675 оны зуны тэргүүн сарын 22-ны өдөр Дал хэмээх газарт Бүрни, Лувсан нар 3000 цэрэгтэй тулгаран байлдсанд, Цахарын цэрэг мяочанаар буудаж, угтан байлджээ. Ийнхүү Манжийн цэргийг довтолж байх үед гэнэт хажуугийн жалганаас Цахарын 200 цэрэг гэнэт гарч зууралдан байлджээ. Бүрнийн цэрэг дарагдаж, энэ үед Цахарын хошууны эзэн агсан Жинжин бууж өгчээ. Гэвч Бүрни цэргээ дахин цуглуулж, дахин хоёр удаа тулж байлдсан боловч ялагдаж, дүү Лувсаны хамт 30 шахам морьтныг дагуулан бүслэлтийг сэтлэн гарч Жаруудын нутгийн зүг дутаажээ. Мөн Халхын гүн Чойжав тулалдааны талбараас дутаан гарсан боловч хожим нь бууж өгчээ.

Хорчины төрийн бэйл, эфү Шажин Бүрни, Лувсан нарыг нэхсээр мөн оны зуны дунд сарын эхээр Жарудын нутгийн захад хүрээд, Гүйлстэйн газарт буудаллажээ. Бүрни, Лувсан нар уулын умар этгээдэд буруулан нуугдаж, Шажины цэрэг хүрч ирснийг сонсож, хүн зарж, Лувсангийн эхнэр (Шажины охин дүү)-ийг хүргүүлж, түүгээр Шажинд хэлүүлж араас нэхэхийг байгтун гэжээ. Гэвч Шажин тэрхүү үгэнд орсонгүй, цэрэг авч Бүрни нарыг бүслэхээр одоос Бүрни хэдүйн зугтаажээ. Харин Лувсан байсан тул Шажин түүнд ахыгаа олж ирэх даалгавар өгч, 30 морьтой цэргийг гаргаж, хамтаар одуулжээ. Гэвч Лувсан түүний үгэнд оролгүй, нууцаар Бударийг Бүрнид илгээн дайсан нэхэж байгаа талаар мэдээ хүргүүлжээ. Үүнийг мэдсэн Шажин өөрийн биеэр нэхэж тэднийг гүйцээд, Лувсан, Будари нарыг харваж алжээ. Шөнөөр Бүрнийг нэхсээр маргааш өглөө нь гүйцсэнд, Бүрни-гийн 12 морьтой цэрэг үхэх сэхэхээ үзэн тулж байлдахад нь Шажин тэднийг бүгдийг харван алжээ. Шажин Бүрнийн толгойг огтолж Бээжин хотод, Лувсангийн толгойг огтолж Ужа вангийн цэрэгт тус тус хүргэжээ.

Бүрни нар алагдсаны дараа Найманы жүн ван Жамсан аргагүйн эрхэнд Манжид бууж өгсөнд түүний хэргэм зэргийг ховхлон, төрсөн ахынх нь хөвгүүн Очирт залгамжлуулжээ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. АР МОНГОЛ МАНЖИЙН ЭРХШЭЭЛД ОРСОН НЬ

Энэ бүлэг нь Халх түмэн хүчирхэгжсэн нь; Халхчууд Манжийн эсрэг тэмцсэн нь; Халхын дотоод хямрал; Халх-Ойрадын дайн, халхчууд Манжийн эрхшээлд орсон нь; Монгол-Оросын дайн гэсэн 5 зүйлтэй.

XVI зууны эхэн хагаст Батмөнх даян хаан харьяат улс иргэнээ хөвгүүддээ өмч болгон хуваахад 5-р хөвгүүн Алчуболд, хөвгүүн Гэрсэнз нарт Халх түмнийг бүрдүүлж байсан 12 отгийг хуваан өгчээ.

Батмөнх Даян хаан нийт Монголын хэрэг явдлаар оролдох чөлөөнд Жалайр, Хэргүүдийн ноёд хэсэгхэн зуур Ар Халхыг өмчлөн захирч явжээ. Тиймээс Халхын Чинос овгийн Удаболд хэмээх хүн Халхыг захирах хөвгүүнийг Батмөнхөөс гуйсанд Жимсгэн хатны их хөвгүүн Гэрэболдыг өгч явуулжээ. Гэвч Удаболд Гэрэболдыг догшин хэрцгий авиртай хэмээн дараа жил нь буцаан өгч, оронд нь Гэрэболдын дүү

Гэрсэнз (1513-1549)-ийг авч оджээ. Ийнхүү 1520-оод оны үед Гэрсэнз Арын долоон отог Халхын эзэн болов. Гэрсэнз анх Халхад ирэхдээ тухайн үед хамгийн хүчирхэг байсан Жалайрыг эзэгнэн сууж байснаас түүнийг “Гэрсэнз Жалайр хунтайж” хэмээн нэрлэх болсон бололтой.

Харин Халхын өвөр хэсгийн 5 отгийг Батмөнх даян хааны 5-р хөвгүүн Алчуболд мэдэх болсон агаад түүнийг “Өвөр Халх” гэдэг. Гэрсэнзийн мэдэлд очсон 7 отгийг сурвалжид “Арын долоон отог халх”, “хойт долоон отог халх” гэх мэтээр тэмдэглэгджээ. Анхандаа жалайр, бэсүд, элжигин, горлос, хөхүйд, хатагин, урианхан гэсэн 7 отгоос бүрэлдэж байснаа хожим нь үнэгэд, хэрэгүд (гэрүүд), хүрээ хороо, цоохор, тангуд, сартуул гэсэн 6 отог нэмэгдсэнээр нийт 13 отогтой болжээ.

1650-аад оны эх хүртэл Халхын хаад ноёд дангаар Манжийн эсрэг тэмцэл явуулж, манжийн харьяанд орсон өвөрлөгчдийг урвуулан өөртөө татах, Манжийн харьяат хүн малыг уулгалах, Манжийн эсрэг шууд цэрэглэн байлдах, бичиг захидал илгээн эсэргүүцэх гэх мэт аргаар тэмцэж байв. Гэвч Манжийн эсрэг гар нийлэн, нэгдмэл бодлого явуулж байсан Засагт хан Субади 1650, Сэцэн хан Шолой 1652, Түшээт хан Гомбодорж 1655 оны үед тус тус нас барж, нөгөө талаар Манж Чин улс, Хаант Орос улс гэсэн харийн түрэмгийлэгчдийн газар нутгийн түрэлт хийгээд улс төрийн дарамт шахалт улам нэмэгдсэн нь Халхын дотоод, гадаад байдлыг нэн эгзэгтэй болгов.

Халхын хаад ноёдыг эвлэрүүлэх үүрэгтэй байсан Хүрэн бэлчирийн чуулган Халхын хаадын эвдрэлийг зогсоосонгүй, харин улам дэвэргэж орхив. Ойрадын Галдан бошгот уг чуулганы шийдвэрийг эсэргүүцсэнээр барахгүй, хэд хэдэн зүйлийн шалтгаан тоочиж, Түшээт ханд цэрэглэн орохоо албан ёсоор мэдэгджээ. Хүрэн бэлчирийн чуулганы үеэр Жибзундамбыг Далай ламын элч Галдан ширээттэй адилхан олбог суудал хэрэглэж, зэрэгцэн суулаа хэмээн буруушааж, үүнийг эвдрэлийн нэг шалтаг болгожээ.

“Халх Ойрадын дайн” гэж нэрлэсэн энэхүү дайнд Галдан бошогтын тэргүүлсэн Дөрвөн Ойрадын нэгдсэн хүчний эсрэг Түшээт хан, Шамба Эрх дайчин ноён, Мэргэн ноён гэсэн Халхын гурван хошууны цэрэг л тулалдсан агаад хүчний харьцаанаас үзэхэд тулалдаан хэрхэн төгсөх нь бараг тодорхой байсан гэж хэлж болно. Чихундорж нар Цогдос нуурт чуулган нийлж, найрамдахыг хүлээн суух хооронд Галдан бошогт гэнэдүүлэн довтолж, Халхын нутгийг дундуур нь хуваасан тул Түшээт хан нар цэргээ гүйцэд цуглуулж амжаагүйн дээр Сэцэн хан Илдэн Равдан нас барж, Сэцэн ханаас цэргийн тусламж гуйх оролдлого бүтээгүй ажээ.

Улмаар 1688 оны намрын сүүл сард Түшээт хан, түүний дүү Сидишир Баатар тайж нар зүүн баруун гарын тайж нарыг авч, Жибзундамба хутагт өөрийн шавь нарыг авч, цөм харуулд ороод дагаар орсугай гэж гуйжээ.

XVII зууны эхээр Хаант Орос улс дорно тийш нутгаа тэлж, Соёны нуруу, Байгал нуур орчим газарт нэвтэрч Халхын хойт талаар орж ирэв. Ингэхдээ оросууд дээрх нутагт оршин сууж байсан Халхын ноёдын харьяат нарт албат татвар оноож, нутагт нь бэхлэлт шивээ барих зэргээр Монголын газар нутгийг түрэмгийлэн эзлэх бодлого явуулсан юм. Ийнхүү галт зэвсэг бүхий цөөн тооны оросууд умард хилийг түрэмгийлэн эзлэх болсон нь халхчуудыг өөрийн эрхгүй Чин улсын зүг хандах бас нэгэн бодит шалтгаан болсон юм.

1620-оод оны үеэс эхлэн оросууд Байгал нуур орчмын нутагт үе үе нэвтэрч шивээ бэхлэлт байгуулан суугаад, ойр орчмын овог аймгуудад алба татвар оноох болов. Гэвч нутгийн оршин суугчид болох буриадууд Оросын дарамт шахалтыг шууд хүлээн зөвшөөрсөнгүй, эсэргүүцэн тэмцэлдэж, шивээ бэхлэлтийг нь довтлон оросуудыг алж хороох, эсвэл Халхын зүг зайлан нүүх зэргээр эсэргүүцэх болжээ. Халхын зүг нүүдэллэсэн иргэдийг Халхын ноёд найрсгаар хүлээн авч, нутагтаа суулгах болжээ.

Харин нутагтаа үлдсэн буриадууд нь аргагүйн эрхэнд Халх, Оросод давхар алба төлөх болсон байна.

Оросууд халхчуудтай нүүр тулан учирснаас хойш тэдний хараат буриад гэх мэтийг төдийгүй, халхчуудыг өөрсдийг нь дагаар оруулах бодлого баримталж байжээ. Халхын хаад ноёд Оросын харьяат болохыг хүсэхгүй, тусгаар тогтнолоо сахин хамгаалах бодлогыг тууштай баримталж байв. Гэтэл энэ үед Чин улс ч Халхыг дагаар оруулах түрэмгий бодлогыг энэ мэтээр шууд явуулж байгаагүй гэдгийг дурдах нь зүйтэй.

Ийнхүү оросууд шивээ, бэхлэлт барьж газар нутгийг түрэмгийлээд, Халхын харьяат байсан буриадуудаас алба татах болсонд Халхын хаад ноёд эхэндээ яриа хэлэлцээр хийж, тайван замаар шийдэхийг оролдсон ажээ. 1675 онд Түшээт хан Чихундоржийн илгээсэн Гарма билигт тэргүүтэй элч нарын хариуд 1677 оны эцсээр Түшээт хааны өргөөнд ирсэн Оросын элч Тобольскийн боярын хүү Федор Михалевский нарын элч нар татгалзсан хариу өгсөн учир Түшээт хан Сэлэнгийн шивээний ойр орчмыг довтлон талж оросуудыг Сэлэнгэ мөрнөөс ус уулгахгүй хэмээн сүрдүүлж байжээ. Тэгээд Федор Михалевский нарыг Сэлэнгийн шивээнээс мордмогц монгол цэрэг Байгал нуураас Сэлэнгийн шивээний хоорондох газарт орос цэргүүдийг тааралдсан газарт нь барьж алан Сэлэнгийн шивээний адуу малыг бүгдийг хөөж аваачин 1678 оны 10 сараас эхлэн тус шивээг тал бүрээс нь бүслэн хаав. 11-р сард нь тавнангууд нар Ярууны шивээг довтолж адуу малыг нь хөөж аваачжээ. 1681 онд Сэлэнгийн адгаар сууж байсан оросууд болон 1680 онд Сэцэн хааны Дай хунтайжийн дэргэдээс босч Байгал нуур, Ойхон арлын зүг нүүдэллэн очсон хори хэмээх барга нарыг довтолсон байна. 1684 онд Түшээт хан Эрхүүгийн шивээнд элч илгээж буриад нараас хүний нэг булга татварлан авах шаардлага тавьсан боловч оросууд эрс эсэргүүцжээ.¹ Зөвхөн Түшээт хан төдийгүй Оростой зах нийлсэн бусад ноёд ч албат иргэдийн улмаас Оростой тэмцэлдэн тулалдах явдал цөөнгүй гарч байжээ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЗҮҮНГАР УЛСЫН ДАЙН БАЙЛДААН, ЦЭРГИЙН УРЛАГИЙН АСУУДАЛ

Энэхүү бүлэг нь Галдан бошигт халхад довтолж, манжийн цэрэгтэй тулалдсан нь; Цэвээнравдан хунтайж Түвдэд дайтсан нь; Зүүнгар улсын цэргийн зэр зэвсгийн шинэтгэл; Улсын цэргийн урлаг гэсэн 4 зүйлтэй болно.

Энэ бүлэгт Зүүнгар Улсын эздээс бусадтай хийсэн олон удаагийн байлдааныг авч үзсэнгүй. Учир нь, тэдгээрийн ихэнх нь Гадаад харилцааны болон Мөхөлийн бүлэгт өгүүлэгдсэн болно. Гагцхүү Зүүнгар улсын төрөөс санаачилж, Галдан бошигтын Халх Монголд довтолсон, Цэвээнравдан хунтайжийн Түвдэд дайтсан

түүхийг авч үзэв. Дотоод гадаадад хийсэн энэ хоёр дайн Зүүнгар Улсын төр, цэргийн түүхийн талаас ач холбогдол, цэрэг улс төрийн үр дагавараар өндөр юм.

Нэгдүгээр зүйлд дараах асуудлыг авч үзэв.

1. 1670 онд Галдан бошигтод Сэнгэ хунтайж алагдсан мэдээ авсан, хошоодын Очирт цэцэн Цорост довтлон Сэцэн тайжийг алсанд Цоросын зарим хэсэг Хөх нуур, Халхад дүрвэн гарсан зэрэг явдал Галдан бошигтыг Халх Монголд довтлох нэг шалтгааныг дагуулжээ;

2. 1675 онд Очирт цэцэн 7000 цэргээр Галдан бошигтын нутагт цөмрөн Өрөнгө, Булган, Цэнгэлийн гурван тайжийг салгасан хэрэг газар нутаг, хүн амынхаа төлөө зэвсэглэн тэмцэх шалтгааныг Галданд төрүүлжээ;

3. 1676 оны цагаан сарын 24. Галдан бошигт довтолж Очирт цэцэний салган авсан албатуудаа буцаан авах зорилгоор түүнийг Тарвагатайд Эмиль голын тал нутаг руу дайран цохив. Энэ үед түшээт хан Чахундорж Очирт цэцэнийг өмгөөлөх цэрэг гаргасан боловч тэр амжиж хүрсэнгүй, замаас буцсаныг Галдан бошигт мэдсэн нь Түшээт хан Чахундоржтой байлдах бас нэгэн шалтгаан үүсгэжээ. Чахундоржийн өвөг Эрхий мэргэний гэргий, хошоодын Очирт цэцэний гэргий нар эгч дүү хоёр байснаас Чахундорж, Очирт цэцэн нар ургийн холбоотой биесээ дэмжиж байсан аж;

4. 1677 онд Галдан бошигтоос Бээжинд зарсан элчийг Чахундорж баривчилсан хийгээд энэ хирд Засагт хан Галданг түшиглэх болсон нь Халх ба Баруун Монгол өрсөлдөн тэмцэх бас нэгэн шалтаг болжээ;

5. 1676 оны эхээр Түвдээс Далай ламын элч ирж Галдан бошигтыг Зүүнгар Улсын хан өргөмжлөв. Ингэснээр Монгол Улсыг Цэцэн хан, Засагт хан, Түшээт хан, Зүүнгар Улс хэмээх ижил эрхтэй дөрвөн ханд Монголыг хуваасан явдал монголчууд хоорондоо мөргөлдөн тэмцэлдэх шалтгааныг бүрдүүлэв;

6. 1686 оны 8 дугаар сарын 16-ны Хүрэн бэлчирийн шийдвэрийг Түшээт хан Чахундорж зөрчиж Засагт ханаас булаан авсан хүн малынхаа хагасыг л буцааж өгчээ. Халх Монголтой хил залгаа Зүүнгар Улсыг түшиглэх болсон Засагт ханыг өмгөөлөн тэмцэх үүрэг Галдан бошигтод ноогдов;

7. 1688 оны цагаан сар. Түннэт хан Чахундорж 10000 цэргээр Засагт ханыг дайлж эздийг нь алав. Манжийн Энх-Амгалан хаан Халх Монголыг Өмнөд Монголын адил эе эвээр залгих бодлогоо тууштай барьж Далай ламаар зуучлуулж Түшээт хан Чахундоржийн дээрмийн аяныг зогсоожээ. V Далай лам 1682 оны 2 -р сарын 25-нд нас нөгчсөн боловч түүнийг маш нууцаар оршуулж Түвдийн засаг төрийг Галдан бошигтыг Түвдэд ном үзэж байхад ойртон нөхөрлөсөн див Санзайжамц барьж, бүхнийг Далай ламын нэрээр явуулах болсон байв. Үүнийг манжийн Энх-Амгалан хаан ч тухайн үедээ мэдсэнгүй. Энэ тухайд ойрад сурвалжид: - "... Долоон хошуун /Халх монгол, Дөрвөн ойрадын хооронд их эвдрэл болж туулай жил гаран, луу жил /1688/ орохуй Цогтсайн хаан /Түшээт хан/ цэргээр ирж шинэ ханыг барив. Сайн хан ч нааш /Дөрвөн ойрадын нутаг руу/ явсанд Гүнзан /цоросын/, Доржжав /Галдан бошигтын дүү/ тэдний туршуул лугаа нь учирч байлдан Доржжавыг хороов", "... Бошгот хан ... луу жилийн цагаан сард /1688/ ... Дөрвөн ойрадын хөвгүүдийг дагуулж, долоон хошуу Монголын /Халхын/ дунд орж, олзлохыг нь олзлон, барихыг нь барин, дутаахыг нь дутаан үйлдэв" ¹ хэмээн тэмдэглэсэн нь бас дайны шалтгааныг нотлон өгүүлж байна;

8. Мөн 1688 онд Чахундоржид Засагт хан алагдсаныг Галдан бошигт мэдээгүй байснаас Засагт ханд явуулсан элчийг Чахундорж барьж алжээ;

9. Эцэст нь Чахундоржоос ял асуух цэрэг мордуулах зөвшөөрөл дэмжлэгийг Галдан бошигт хуурамч Далай лам див Санзайжамцаас олжээ¹. Галдан бошигт Халх Монголд довтлох шалтгаан нөхцөл дээрх үйл явдлуудын улмаас бүрджээ.

Ийнхүү Галдан бошигтын тэмцэл нь ялагдал, үхлээр төгсөв. Түүний ялагдалд: - Зүүнгарт шарын шашин дэлгэрүүлэх төвдийн бодлого, Далай ламын шавь Галдангийн дуулгавартай номой бодлого; - Энх-Амгалан хааны өнгө мөнгө, зэрэг хэргэм, эергүү бодлогод халхын ноёд хууртаж, түүнд үнэнч зүтгэсэн нь үлэмж нөлөө үзүүлсэн зэрэг олон хүчин зүйл нөлөөлжээ.

1. Эрдэнэбаатар, Галдан хунтайжууд бол дундад зуунд эх орондоо галт зэвсэг нэвтрүүлсэн монголын анхны жанжин, галт зэвсэг цэргийн хэрэгт нэвтэрсэн нөхцөлд монгол цэргийн урлагийг шинэ зэвсэгтэй уялдуулан цаашид хөгжүүлэхийг зорьсон анхны гавьяатнууд юм;

2. Их Цэрэндондов дүн өвлийн цагаар монгол цэрэг, морины гайхамшгийг үзүүлэн Тэнгэр уулын мөсөн даваануудыг давж, Түвд, манжийн санаанд багтаагүй гэнэтийн цохилт өгч дайны зорилгодоо хүрсэн түүх нь XIII зуунд хийсэн Зэв, Сүбэдэйн алдарт аянтай эн тэнцэх, монголчуудын болон Дэлхийн цэргийн түүхийн гарамгай нэгэн хуудас мөн аж;

3. Төрийн төвлөрсөн удирдлага буюу Зүүн гар улсын засгийн газар байгуулагдсанаар тусгаар улсын нэгдмэл цэрэг-армийг байгуулж чадсан байна. Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхэт байдал, ард түмнээ хамгаалах армийг байгуулж чадсан нь тухайн үеийн өндөр дэвшил мөн;

4. Зүүнгарчууд “нуман түлхүүр”, “задын арга” зэрэг монгол цэргийн тактикийн урлагууд, стратегийн зарчмуудыг өвөг дээдсээс өртөөлөн хэрэглэж ирсэн баатарлаг дайчин улс байжээ.

МАНЖИЙН ЭРХШЭЭЛИЙН ҮЕИЙН МОНГОЛ ЦЭРЭГ хэмээх дөрөвдүгээр бүлгийг Монгол цэргийн байгуулалт; Монгол цэргийн оролцсон дайн байлдаан; Цэргийн зэвсэглэл, урлагийн асуудалд гэсэн 4 зүйлээр авч үзэв.

Монголчууд угаас цэрэг-иргэний хавсарсан зохион байгуулалттай байсан юм. Тэр ёсоор өрх бүр тодорхой тооны цэрэг гаргах үүрэгтэй, шаардлагатай тохиолдолд эр хүн бүр цэрэг болдог байжээ. Тиймээс аливаа аян дайнд цэрэг дайчлах хэргийг цааз гарган зохицуулдаг байв. Хаад, ноёд нь пайн тулааны үед цэргийн захирагч болж, дайн тулалдаанд оролцох үүрэгтэй байжээ.

Цэргийн зохион байгуулалт, удирдлага: Халхын цэргийг Улиастайн жанжин ерөнхийлөн захирч, түүний доор аймаг бүрт “туслагч жанжин” хэмээх албан тушаалтан байж, түүнд манжид итгэлтэй ноёдыг томилдог байв. Энэ нь Улиастайн жанжны туслагч гэсэн утгатай агаад анх 1724 онд туслагч жанжны албан тушаалыг бий болгож, Цэрэн, Бүүвэй, Данзандорж нарыг тохоон томилжээ. Бас энэхүү туслагч жанжны орлогч хэбэй хэмээх албан тушаалтан байжээ.

Аймгийн туслагч жанжны газар нь тухайн аймгийн чуулганы дэргэд ажиллаж цэргийн хэргийг шийтгэдэг байжээ. Хошууны засаг ноён өөрийн хошууны цэргийг захирах боловч “аймгийн туслагч жанжин” ерөнхийлөн эрхэлдэг байв. Туслагч жанжин нь цэргийн хэргээс гадна, өртөө харуулын хэргийг бас эрхэлдэг байжээ.

Цэрэг дайчлах тогтолцоо, бэлтгэл сургуулилт: Манж нар өөрийн гол дайсан Зүүнгар улсыг байлдан мөхөөсний дараа Халхад байрлаж цэргийнхээ ихэнхийг гэдрэг татаж, голдуу халх цэргээс бүрдсэн хэдхэн мянган цэргийг үлдээжээ. Гэвч Чин улсын төрд монголчууд умар хилийг хамгаалах, бослого хөдөлгөөнийг дарахад нь зайлшгүй шаардлагатай байсан тул монголчуудын цэргийн хүчийг бүрмөсөн сулруулахыг хүсээгүй нь мэдээж. Тиймээс цэргийн бүртгэл, бэлтгэл сургуулилтыг тогтмол хугацаанд явуулж, шаардлагатай цагт дайчилгаанд бэлэн байхыг шаарддаг байжээ.

Манж нар XVII зууны эхний хагаст Чосөнъ улсыг хоёронтоо довтолсон бөгөөд үүнийг Солонгосын түүхэнд “Улаагчин туулай жил (1627)-ийн самуун”, “Улаан хулгана жил (1636)-ийн самуун” гэж нэрлэдэг. Эдгээр дайнд хоёуланд нь монгол цэрэг оролцжээ.

Монгол цэрэг Хятадын Мин улсыг дайлахад оролцсон нь: 1621 онд Өвөр Халхын Гүрбүши тайж, Мангол тайж нар нийт 600 өрхийг авч Манжид дагаар орсонд Нурхачи Манжаас 300 албат, монголоос 300 алба гаргаж, 2 сум болгон Гүрбүшид олгоод, Гүрбүши, Мангол тайж нарт цзунбингуань хэмээх цэргийн цол өгснөөр Манжийн цэрэгт анхлан монгол цэргийн анги бий болсон бололтой. Улмаар 1622 онд дагаар ирсэн монголчуудаар уруд 1, өвөр халх 1 хошуу зохиосноор 2 монгол хошуу буй болжээ. Энэ үеэс эхлэн монгол цэрэг Манжид хүч хавсран дайн тулалдаанд оролцсон гэж үзэж болно. Эдгээр нв яваандаа Манжийн 8 хошуутай адил 8 хошууны зохион байгуулалтад багтаж “Монгол 8 хошуу” буюу Дотоод Монгол гэж нэрлэгдэх болжээ. 8 хошууны монголчууд бүр анхнаасаа Манжийн цэргийн бүрэлдэхүүнд багтаж дайн тулалдаанд оролцдог байсан агаад хожим нь Чин улсын нийслэл хот болон олон мужид дарангуй сууж байв.

Харин Гадаад Монгол буюу Цагаан хэрмийн гаднах монгол нутгийн цэрэг Манжийн цэргийн бүрэлдэхүүнд багтаж Хятадын Мин улсын эсрэг дайн тулаанд оролцох болсон нь 1620-оод оны сүүлчээс эхэлжээ.

Монгол цэрэг Хар тамхины хоёрдугаар дайнд оролцсон нь: 1856 онд Хар тамхины 2-р дайн эхлэхэд Чин улсын засгийн газар Тайпингийн бослогыг дарах хэрэгт гавьяа байгуулсан, хорчин гаралтай алдарт жанжин Сэнгэринчинийг¹ ерөнхий командлагчаар томилон Тяньжинг хамгаалах ажиллагааг удирдуулжээ.

Хар тамхины дайнд оролцсон Чин улсын цэргийн захирагч нь монгол жанжин Сэнгэринчин байсны дээр, тэрхүү цэргийн гол хүч болох морьт цэргийн ихэнх нь Жирим, Зост, Зуу уд зэрэг Өвөр Монголын аймаг хошуудаас татсан монгол цэрэг байсан тул энэхүү дайн тулалдаан нь монгол цэргийн түүхтэй холбоотой гэдэг нь илэрхий билээ.

XVI зууны сүүлчээс XX зууны эхэн хүртэлх монгол цэргийн түүх бол бүхэлдээ харийн түрэмгийллийг эсэргүүцсэн, дотоодын эв нэгдлээ бэхжүүлэхийг оролдсон, улмаар Манжийн эрхшээлээс гарахыг эрмэлзсэн тэмцлийн түүх мөн.

1590-ээд оноос эхлэн Монголын зүүн хөрш Зүрчидийн Нурхачи баатар зүрчид аймгуудыг нэгтгэж, улмаар хөрш зэргэлдээ улс орнуудын талаар түрэмгий бодлого явуулж эхэлжээ. Манж нар Монголыг эзлэхийн тулд дан ганц эргийн хүч хэрэглэсэнгүй, хооронд нь хагалан бутаргаж хүчийг нь сулруулах, шан хишиг, хэргэм зэргээр урхидах гэх мэт олон аргыг хэрэглэж байв.

Лигдэн хаан тэргүүтэй Монголын эрх баригчид Манжийн түрэмгийллийн эсрэг тууштай тэмцсэн боловч бүтэлгүйтлээр төгсөж, 1636 онд Өмнөд Монгол Манжийн эрхшээлд орсон юм. Өмнөд Монголыг эзлэн авсны дараа манж нар Халх Монгол, Ойрадыг эрхэндээ оруулах бодлогыг тууштай явуулахдаа мөн л дээр дурдсан аргуудыг хэрэглэж байв.

Чин улс 1691 онд Халхыг, 1758 онд Зүүнгар улсыг тус тус эрхэндээ оруулав. Ийнхүү манж нар бүх Монголыг эзлэхэд 120 гаруй жилийн хугацааг зарцуулсан юм. Харийн эрхшээлд орсон үндсэн шалтгаан нь дотоодын хямрал, эрх мэдлийн төлөөх тэмцэлтэй холбоотой агаад хэрэв эе эвээ нэгтгэж чадсан бол манж нар цэргийн хүчээр тийм ч амархан эзлэх боломжгүй байсан билээ.

Монголчууд харийн эрхшээлд ямар ч эсэргүүцэлгүйгээр орсонгүй, эцсээ хүртэл эсэргүүцэн тэмцсээр байсан агаад Манжийн дарлалд орсны дараа ч түрэмгийлэгчдийн эсрэг бослого хөдөлгөөн тасраагүй билээ. Сүнидийн Тэнгис вангийн бослого хийгээд түүнийг дэмжсэн Халхын хаадын цэргийн үйл ажиллагаа, Цахарын Бүрнэ вангийн бослого, Хөхнуурын Лувсанданзан, Хойдын Амарсанаа, Хотогойдын Чингүнжав нарын бослого нь түүний тод томруун жишээ мөн.

Нөгөө талаар, өгүүлэн буй үед монголчууд зөвхөн Чин улстай байлдаад зогсохгүй, эхэн үедээ Хятадын Мин улс, бас Хаант Орос, Дорнод Туркестан, Хасаг, Киргиз, Узбек, Түвэд зэрэг улстай зэвсэг зөрүүлэн байлдаж байв. Тухайлбал, умар зүгээс хүч түрж газар нутгийг түрэмгийлсэн Хаант Оростой зэвсэг зөрүүлэн тулалдсаны жишээ бол Түшээт хан Чихундорж, Зүүнгарын Галданцэрэн нарын явуулсан тулалдаан юм.

Харин Дорнод Туркестан, Хасаг, Киргиз, Узбек, Түвэд зэрэг улстай Ойрад, Зүүнгар улс дайн тулалдаан хийж байсан нь улс орноо хүчирхэг болгох, үүний үндсэн дээр харийн түрэмгийллийг сөрөн зогсох гэсэн зорилготой холбоотой боловч заримдаа үүний эсрэг үр дүнд хүрэх тохиолдол байсныг үгүйсгэж болохгүй. Тухайлбал, Цэвээравдангийн Түвэдэд хийсэн аян дайн нь Түвэд, Хөхнуурыг Манжийн дарлалд бүрэн орох явдлыг улам түргэтгэж өгсөн гэж үзүүштэй.

Түүнээс гадна дотооддоо самууран байлдсан тохиолдол цөөнгүй бөгөөд эв эеэ нэгтгэхийн оронд ийнхүү харилцан эвдрэлцсэн нь харийн эрхшээлд орох суурь нөхцөл болсныг дурдах нь зүйтэй. Гэвч эдгээр дотоодын дайн тулааныг харийн түрэмгийлэгчдийн эсрэг хүчээ нэгтгэх гэсэн зорилготой дайн тулалдаан, бас зөвхөн эрх мэдэл, эд баялгийн төлөөх дайн байлдаан гэх мэтээр ялгаж үзэх боломжтой. Тэр дундаа Халх-Ойрадын олон жилийн тэмцлийг эцэс болгож 1640 онд Монгол-Ойрадын их цаазыг баталсан нь харийн эсрэг эв эеэ нэгтгэх гэсэн манай өвөг дээдсийн мэргэн бодлогын жишээ мөн.

Өгүүлэн буй үед дэлхийн цэрэг дайны түүхэнд эргэлт болсон галт зэвсгийн эрин үе нэгэнт эхлээд байсан учир урьдын хүлэг морь, хүчит нумаар гайхуулдаг монголчуудад ихээхэн халгаатай болж иржээ. Энэ үеийг “галт буу нум сумтай харшилдсан үе” гэж томьёолдог. Гэвч монголчууд тухайн үеийн технологийн том дэвшил болсон галт зэвсгийг хэрэглэж сураад зогсохгүй үхэр буу ч хэрэглэж байжээ. Гэхдээ цэрэг зэвсгээ бүрэн шинэчилж, галт зэвсгээр орлуулах боломж байгаагүй тул ихэнхи тохиолдолд урьдын адил нум сум, илд жад гол зэвсэг нь байж, галт зэвсэг бүхий харийн түрэмгийлэгчдийн өмнө хүчин мөхөсдөхөд хүрч байсныг Монголын ард түмний 1755-1758 оны зэвсэгт тэмцэл харуулдаг. Харийн эрхшээлд орсноос

хойш ч зэр зэвсгийг бүрэн шинэчилсэнгүй, урьдын адил хоцрогдсон зэр зэвсэг ихэнх хувийг эзэлж байжээ.

Монголын цэргийн түүхэнд тод ул мөрөө үлдээсэн улс бол Зүүнгар улс агаад тэд өрнө зүгт байлдан дагуулал явуулж Монголын хамгийн сүүлчийн эзэнт улсыг байгуулсан юм. Галдан бошогтын Зүүнгар улсад тусгаар тогтнол, ард иргэнээ батлан хамгаалах чадвартай хүчирхэг армийг байгуулжээ. Цэргийн урлагийн хувьд, Эрдэнэ баатар хунтайж, Галдан бошогт нар улс орондоо галт зэвсэг анх нэвтрүүлж, цэргийн урлагийг энэхүү шинэ зэвсэгтэй уялдуулан цаашид хөгжүүлэхийг зорьж байжээ. Мөн ойрадууд “нуман түлхүүр”, “задын арга” зэрэг монгол цэргийн тактик, стратегийн зарчмуудыг уламжлан хэрэглэж байжээ. Зүүнгар улс өөртөө цэргийн төрөл бүрийн зэвсгийн үйлдвэрлэлийг бий болгож, өргөжүүлэхийг оролдож байсан нь цэрэг арми хүчирхэг байх үндсийг бэхжүүлсэн ажээ.

Цэргийн байгуулалтын хувьд, манж нар монголчуудыг эрхэндээ оруулсны дараа цэрэг-засаг захиргааны үндсэн нэгж болох хошуу болгон зохион байгуулаад, хошууг дотор нь сум хэмээх цэрэг-захиргааны нэгжид хуваадаг байв. Гэвч энэ нь шинэ зүйл огт бус, харин Монголд хуучин байсан цэрэг маягийн зохион байгуулалтыг нь хэвээр үлдээж, зарим нэгэн өөрчлөлт оруулсан хэрэг болно. Монгол эрчүүдийг цэргийн албанд бүрэн дайчлахын тулд Манжийн төр хатуу чанд хууль дүрэм зохион мөрдүүлж байв. Манжийн ноёрхогчид монголчуудыг өөрсдийн цэрэг дайны хэрэгт ашиглахын тулд байнгын цэрэг дайны бэлтгэлтэй байлгахын төлөө хичээж байлаа.

Манж нар эрхшээлдээ оруулсан монголчуудын цэргийн хүчийг бусад улс орныг эзлэн түрэмгийлэх, бослого хөдөлгөөнийг дарангуйлахад ашиглахыг зорьж байжээ. Тухайлбал, Солонгосын Чосөн улсыг 2 удаа дайлахад Өмнөд Монголын цэрэг оролцсон, Хар тамхины дайн, Цагаан малгайтны буюу Дунганы бослогыг дарахад монгол цэргийг дайчлан оролцуулж байжээ.

Бас манж нар Зүүнгарыг байлдан эзлэх зорилгоор Халх, Өвөр Монголоос цэрэг дайчилж байсан агаад үүнд халхчууд илт дургүйцэж, байлдааны газраас цэргээ авч буцах зэргээр эсэргүүцэл үзүүлж байв. Мөн 1755-1758 онд Зүүнгарыг эзлэхэд Өвөр Монгол, Халх, Ойрад цэргийг дайчилсан боловч тэрхүү цэрэгт дайчлагдсан монголчууд, тэр дундаа халхчууд цэргийн албыг хаяж эсэргүүцэж байв. Ийнхүү монгол нь монголынхоо эсрэг дайтахад хүрч байсан нь монголчуудын өөрсдийн хүслээр болсон бус, харийнхны дарамт шахалтын доор болсон юм.

XVIII зууны дунд үед Зүүнгарыг байлдан дагуулах дайн дууссантай холбогдуулан, 1760 оны орчимд манжийн их цэргийг Ар Монголоос хойш татаж, оронд нь Халх, Солон, Захчин, Дөрвөд, Урианхайн 3 мянга шахам цэргийг зах хязгаарт хуваан суулгаснаас гадна Халхын дөрвөн аймгийн 4 мянган цэргийг Улиастайн орчим жил бүр лавлан боловсруулж байжээ. Гэвч үүнээс хойш 100 гаруй жил Ар Монголд дайн дажин гаралгүй, энх амгалан цаг байсан тул Хүрээний сайд, Улиастайн жанжин нар цэргийн бүртгэл буюу “эр төөлөх” ажлыг явуулахдаа нарийн чанд шалган үзэхээ үндсэндээ больж, тогтмол нэгэн тоо хэмжээгээр өргөн мэдүүлж, хээл хахуулиар энэ асуудлыг шийддэг болжээ. Түүнчлэн “авлан боловсруулах” гэх мэт цэргийн сургуулилт нь яваандаа ор нэрийн төдий, цэрэг эрийг боловсруулахад ямар ч тус нэмэргүй зүйл болон хувирчээ.

Ийнхүү манж нар нэг талаас монголчуудын цэргийн хүчийг ашиглах, нөгөө талаас тэднийг хүчирхэг цэрэгтэй байлгах аас болгоомжилж байсан нь хоорондоо зөрчилдөж байжээ. Чин улсын төр улам бүр сулран доройтохын хэрээр дайн тулалдаанд анхаарал хандуулах нь багасаж, дээр өгүүлсэнчлэн орон нутгийн эрх баригчид ч цэргийн сургуулилалт, зэр зэвсгийн бэлэн байдлыг нарийн чанд шалгаж, шаардахаа больж, хээл хахууль аван худал мэдүүлдэг болсон нь монгол цэргийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлсэн нь тодорхой.

Тиймээс XVIII зууны эцсээс хойшхи Манжийн эрхшээлийн үе нь монгол цэргийн хөгжлийг зогсонги байдалд ороход хүргэсэн ажээ. Дэлхий нийтэд галт зэвсэг, өрнийн маягийн цэргийн боловсрол, тактик дэлгэрээд байхад харийн дарлалд байсан монголчууд урьдын адил хоцрогдсон зэр зэвсэг, бэлтгэл сургуулилалттай байсан нь монголчуудын цэрэг дайны амжилтад сөрөг үр дагаврыг авчирсан гэж үзэж болно. Ялангуяа 1860-аад онд Чин улсад өрнөсөн дайн тулаанууд нь хуучин маягийн монгол цэрэг нэгэнт үеэ өнгөрөөснийг харуулсан гэж үздэг.

Гэсэн хэдий ч монгол хүний төрөлхийн цэрэг зан чанар нь бүрмөсөн үгүй бололгүй, далд хэлбэрээр оршсоор байсныг 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, Өвөр Монголыг чөлөөлөх байлдаан, 1921 оны Ардын хувьсгал зэрэг тод харуулдаг агаад 1911 онд үүсэн буй болсон тусгаар Монголын цэрэг 10 хүрэхгүй жилийн дотор хүчирхэг арми болж чадсаныг монгол эр хүний төрөлх чанартай холбон тайлбарлахаас өөр аргагүй. Ийнхүү монголчууд тусгаар тогтнолоо сэргээснээр монгол цэргийн түүхийн нэгэн балар үе дуусаж, хөгжил дэвшлийн шинэ эрин эхэлсэн билээ.

ДОЛДУГААР БОТЬ
МОНГОЛ УЛСЫН ЦЭРЭГ (1911-1921 он)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
МОНГОЛ УЛСЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛАЛТ

§ 1.1. Манжийн “Шинэ засгийн бодлого” ба монголчуудын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн

XIX зууны сүүлч болоход Чин гүрний нийгмийн дотоод харилцаанд ихээхэн өөрчлөлт орж, Манжийн төрд хятад хүний нөлөө үлэмж болж, Манж Чин гүрний дотоодод тогтворгүй байдал буй болж, газар сайгүй зэвсэгт дээрэм халдлага гарч, хятадууд Манжийн төрийн эсрэг босож, тэмцэх болжээ.

Манжийн төр хямралаас гарахын тулд 1901 онд “Шинэ засгийн бодлого” гэгчийг гаргав. Ингэснээр Монголын малын бэлчээрийг тариалангийн талбай болгох замаар нүүдлийн соёл иргэншлийг устгах, монгол газарт тариачин хятадуудыг шилжүүлэн суурьшуулах замаар монголчуудыг хятадад уусгах “хятад бодлого” Манжийн төрийн бодлогын төвшинд гарч ирсэн юм. Үүнийгээ “Шинэ засгийн бодлого” гэдэг аядуухан нэрээр халхавчилсан боловч удалгүй уг бодлогын цаад мөн чанар нь монголчуудад ил тод болжээ.

Манжийн “Шинэ засгийн бодлого” нь монголчуудыг цаашид амар тайван суух аргагүй болгожээ. Өөрөөр хэлбэл, “Шинэ засгийн бодлого” нь монголчуудын өмнө шинэ аюул заналыг учруулахын зэрэгцээ тэдэнд “өнгөрснөө эргэцүүлж, ирээдүйдээ санаа зовох” цаг тулгарсныг сануулсан юм. Ийм учраас газар газрын монголчууд Манж Чин гүрний колончлох бодлогын эсрэг, үндэснийхээ эрх чөлөөний төлөө тэмцэж эхлэв.

§ 1.2. Монгол Улс тусгаар тогтнолоо сэргээсэн нь

Монголчуудын үндэсний ухамсрын сэргэлт нь XX зууны эхээр шинэ төвшинд гарч, үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын тэмцэл болон гүнзгийрсэн байна. Энэ тэмцэл Манж, Хятадтай шууд хил залгаж байсан Өвөр Монголоос эхэлж, улмаар умарт зүгт хүрээгээ тэлж Халх, Барга, Или Тарвагатайн монголчуудыг хамарч нийт үндэсний хэмжээний тэмцэл болжээ. Улмаар Халхын нутаг, Их Хүрээ үндэсний эрх чөлөөний төлөө тэмцлийн гол төв болжээ.

Халхын ноёд, лам нар 1911 оны зун Их Хүрээнд цугларч Богд гэгээнд даншиг өргөх үеэр Манжийн “Шинэ засгийн бодлого”-д хэрхэн хандах талаар зөвлөлдөв. Дараа нь Түшээт хан аймгийн жанжин засаг Чин ван Ханддорж (1869-1915), Их шавийн Да лам Цэрэнчимэд (1872-1914), Түшээт хан аймгийн чуулганы дарга Түшээ гүн Чагдаржав (1870-1915) зэрэг хүмүүс Богд уулын аманд нууцаар хуралдаж, Хаант Орос улсаас тусламж авч, Монголын тусгаар тогтнолыг сэргээхээр хэлэлцэж, улмаар Богд гэгээнтний соёрхлыг олжээ.

1911 оны арван нэгдүгээр сарын 30-нд тусгаар тогтнолын тэмцлийг удирдах үүрэгтэй Халхын Хүрээний Газрын Бүгд Хэргийг Түр Ерөнхийлөн Захиран Шийтгэх Газар (ХХГБХТЕШЗГ)-ыг долоон хүний бүрэлдэхүүнтэй байгуулав. Тус газраас нийт Монголчуудад ухуулан гаргасан бичигт, “Хүрээнд суулгасан Чин улсын манж, хятад сайд, түшмэд улсын цааз хуулийг гажуудуулан газар орныг хувируулан зовоож, ялангуяа бурхны шашныг их л үтээрхэхэд” хүргэсэн учир тэднийг хойш буцааж, Халх Монгол тусгайлан шинэ төр байгуулахаар тогтсон гэжээ¹. Тус газрын зорилго нь юуны түрүүнд төрийн тусгаар тогтнолоо сэргээж, энэ үндсэн дээр үндэсний шашин, соёлоо мандуулахад чиглэж байсныг энэ баримт харуулж байна.

ХХГБХТЕШЗГ-аас Монголын тусгаар тогтнолыг сэргээгээд Богд гэгээнийг хаан ширээнд залах шийдвэрийг гаргасан байна. Богд гэгээнийг хаан ширээнд өргөмжилвөөс Халхын хан, ноёд төдийгүй Ар, Өвөр Монголын хооронд санаа бодол, ашиг сонирхол зөрөлдөхгүй, тусгаар тогтнолын төлөө тэмцэлд нэгдэж чадах байв.

ХХГБХТЕШЗГ-аас нэг сарын дотор нийгэм, улс төр, эдийн засаг, цэрэг, шашин соёлын олон талт үйл ажиллагаа явуулсан юм. Эдгээрийн дотор төрийн тусгаар тогтнолоо сэргээн тунхаглаж, Богд гэгээнийг хаан ширээнд өргөмжлөх төрийн ёслолын дэг журмыг боловсруулан, бэлтгэлийг нь хангах, улмаар уг ёслолыг удирдан зохион байгуулах явдал чухал байр суурь эзэлж байв. Энэ нь Манжийн амбанг Хүрээнээс хөөж гаргасны дараа орох онцгой чухал агуулга, ач холбогдолтой, нарийн төвөгтэй зорилт байв. Учир нь, энэ ёслол нь нэг талаар ХХГБХТЕШЗГ-ын үйл ажиллагааны, өөрөөр хэлбэл Үндэсний эрх чөлөөний хувьсгалын хамгийн оргил, олон түмний сэтгэл зүрхийг догдлуулсан, нөгөө талаар Монгол төрийн түүхийн шинэ хуудсыг эхлүүлсэн түүхэн чухал үйл явц болох байлаа.

Цагаагчин гахай жилийн өвлийн дунд сарын шинийн 9-нд Богд гэгээнийг хаан ширээнд өргөмжлөх их төрийн ёс сүр жавхаатай болж, монгол түмний цог хийморийг сэргээв. Дараа нь Богд хаан анхныхаа зарлигийг буулгажээ.

Ийнхүү Богд Живзундамбыг их сууринд залаад Улсын нэрийг “Монгол”, оны цолыг “Олноо өргөгдсөн” хэмээн дотоод, гадаадад нийтээр зарласнаар Монголын төрийн тусгаар тогтнол дахин сэргэн мандав.

Богд хааны зарлигаар Их Хүрээний Да лам Цэрэнчимэдийг Дотоод Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч Яам, Түшээт хан аймгийн цэргийг захирагч жанжин Чин ван Ханддоржийг Гадаадын Хэргийг Эрхлэн Шийтгэгч Яам, Сэцэн хан аймгийн засаг хошууны бэйс Гомбосүрэнг Цэргийн Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч Яам, Түшээт хан аймгийн засаг улсын түшээ гүн Чагдаржавыг Сангийн Хамаг Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч Яамны тэргүүн сайдаар тус тус томилжээ.

Богд хааны зарлигаар 1912 онд Бүгд Ерөнхийлөн Шийтгэгч Яамыг байгуулж, мөн яамны сайдаар Сайн ноён хан Намнансүрэн (1878-1918)-г томилсноор Ерөнхий сайдын албан тушаалыг буй болгожээ.

§1.3. Цэргийн удирдлага, зохион байгуулалт, хууль эрх зүй

Богд хааны зарлигаар байгуулсан яамдын нэг нь Цэргийн Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч Яам байв. Тус яам нь Цэргийн засгийг явуулах, Цэрэг тэгшлэх, Зэрэг дэв хянан байцаах хэлтэстэй байв.

Цэргийн засгийг явуулах хэлтэс нь цэргийн засаг цаазыг тархаах, хамгаалах, тохинуулах, дайлаар мордуулах, түшмэл цэргийг дайчлан мордуулах, чуулган чуулах, эр төөлөх зэрэг хэргийг, Цэрэг тэгшлэх хэлтэс нь дотоодыг хамгаалах, цэргийлэх, цагдан байцаах, Нийслэл Хүрээг манаж цагдуулах, цэргийн зэвсгийг байцаах, түшмэл цэргийг халах, нөхөх, сурган боловсруулах, шалган үзэх хэргийг, Зэрэг дэвийг хянан байцаах хэлтэс нь цэргийн түшмэлийн зэрэг дэвийг хянан байцаах, цэргийн хэрэгт хүчин гаргасан түшмэл цэргийг хөхүүлэн шагнах ба цэргийн хэрэгсэлд мөнгө туслан баригчдыг дээр айлтган хөхүүлэх хэргийг эрхлэн гүйцэтгэж байв.

Цэргийн яамны орон тооны хувьд яамны тэргүүн сайд, дэд сайд, эрхэлсэн түшмэл, эх зохиогч түшмэл, жинхэнэ бичээч, туслах бичээч, нярав, галч, хөтөл зэрэг албан тушаалтнууд багтаж байв. Засгийн газрын яамдын тэргүүн, дэд сайд, эрхэлсэн болон дэс түшмэлийг сонгох, томилох журмыг хуулиар тогтоож өгсөн байв.

Монгол Улсын Цэргийн Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч Яамны тэргүүн сайдаар Сэцэн хан аймгийн хамаарсан жанжин засаг хошууны бэйс Галсанцэвэгмидийн Гомбосүрэн (1911.12.29-1914), Сэцэн хан аймгийн Чин вангийн зэрэг Илдэн засаг төрийн жүн ван Манжбазарын Доржпалам (1915.01.21-1915.10.03), Сайн ноён хан засаг хошой чин ван Төгс-Очирын Намнансүрэн (1915.10.03-1919), Сайн ноён хан аймгийн Чин вангийн зэрэг Эрдэнэ засаг төрийн жүн ван Чойсүрэнжавын Жамъяндорж (1919.05.06-1919.11.07), Сэцэн хан аймгийн Бишрэлт ван Доржцэрэн (1921.02.21-1921.?.?), мөн аймгийн Эрдэнэ дайчин Жонон засаг хошой чин ван Намсрайжавын Цогбадрах (1921.05.21-07.10) нар ажиллаж байв.

Монгол улсын засаг захиргааны үндсэн нэгж болох Халх 4, дөрвөд 2 аймгийн цэргийг захирах жанжин дээд албан тушаалтан нь Цэргийг захирах жанжин байв. Тэд Цэргийн яамны шууд удирдлагаар харьяат аймгийн цэргийг дайчлан татах, захиран мордуулах үндсэн үүрэгтэй байв.

Сайн ноён хан аймгийн Цэргийг захирах жанжнаар Эрдэнэ засаг төрийн жүн ван Ч.Жамъяндорж, Дайчин чин ван Гүргүмжав, Түшээт хан аймгийн Цэргийг захирах жанжнаар Түшээт гүн Б.Сономдорж, Сэцэн хан аймгийн Цэргийг захирах жанжнаар Эрдэнэ далай жүн ван Г.Гомбосүрэн, Бишрэлт ван Доржцэрэн, Засагт хан аймгийн Цэргийг захирах жанжнаар гүн Базаррагчаа зэрэг хүмүүс ажиллаж байжээ.

Монгол улсын цэргийн зохион байгуулалт нь уламжлалт аравтын зохион байгуулалтад үндэслэсэн аравт, тавьт буюу анги, хорооны зохион байгуулалттай байв. Хороо нь дөрвөн анги буюу 200 цэрэгтэй байсан бөгөөд аравтын даргыг ангийн дарга томилж, ангийн даргыг хорооны цэргийг бүгд захирагч даргын газраас сонгон Цэргийн яаманд мэдүүлж, хорооны цэргийг бүгд захирагч даргыг Цэргийн яамнаас мэдүүлж, Богд хааны зарлигаар томилдог журамтай байжээ.

Анх 1911 оны сүүлчээр зүүн хоёр аймаг, Хиагтын зүүн, баруун талын харуулаас дайчлан татсан цэргийг тус бүр 500 цэрэгтэй 6 хороо болгож, Нийслэл Хүрээний зүүн, баруун хоёр газарт суулгажээ. Үүнд, Түшээт хан аймгийн тэргүүн хороог Хужирт буланд, Сэцэн хан аймгийн 3 хороог Хужирт булангийн хойт этгээдэд,

Түшээт хан аймгийн 2, 3 дугаар хороог Сонгино уулын буланд байрлуулсан байна. Дараа нь 1912 онд Улиатай, Ховдыг чөлөөлөх зорилгоор Сайн ноён хан аймаг, Засагт хан аймгаас олон зуун цэрэг дайчлан татсан байна. Улмаар Цэргийн яамнаас 1913 оны 2 дугаар сарын 27-нд Түшээт хан аймгаас 1300, Сэцэн хан аймгаас 1260, Засагт хан аймгаас 620, Сайн ноён хан аймгаас 820, бүгд 4000 цэргийг дайчлан татаж Нийслэл Хүрээнд ирүүлэн сурган боловсруулах, Ховд, Улиастайд тус бүр 300 цэрэг суулгах, 4 аймгийн нутгийн зах хязгаарт тус тусын аймгаас 500 цэрэг гаргаж зах хязгаарыг сэргийлэн хамгаалах шийдвэр гаргажээ. Энэ удаагийн дайчилгаагаар нийт 6600 цэрэг дайчилжээ¹. Энэ мэтээр удаа дараа цэрэг дайчлан татсаар Монгол улсын цэргийн нийт тоо нь 1913 оны байдлаар 10000 хүрч байжээ.

Монгол улсын цэрэг нь төвийн буюу Нийслэл Хүрээг сахин хамгаалах цэрэг, хил хязгаарыг сахин хамгаалах цэрэг, орон нутагт бэлтгэсэн цэргүүдээс бүрдэж байв. Төвийн цэрэг нь:

- Нийслэл Хүрээг сахин хамгаалахаар дайчлан татсан цэрэг
- Хужиртбулангийн цэргийн сургуулийн цэрэг
- Дотоодыг хамгаалах шадар цэрэг
- Цагдан сэргийлэх цэрэг
- Гаалийн жасаа зэрэг цэргээс,

Хил хязгаарыг сахин хамгаалах цэрэг нь:

- Түгшүүртэй үед зах хязгаарын чухал чиглэлд түр хугацаагаар сэргийлэн суулгасан цэрэг
- Хойт зүгийн хилийн харуулын цэрэг,

Орон нутгийн цэрэг нь:

- Олон хошуунд сургаж бэлтгэсэн цэрэг
- Дархан цаазтай газар, алтны уурхай, төмөр утасны харуул

Хот хамгаалах цэрэг зэргээс бүрдэж байв.

Богд хааны Олноо өргөгдсөний тэргүүн он өвлийн сүүл сарын шинийн 6-ны өдрийн зарлигаар монгол цэргийн зохион байгуулалтыг тодорхойлон тогтоосон анхны дүрмийг гаргажээ. Энэ зарлигт, “Цэргийн яаман болбоос монголчуудын бүх цэргүүдийг ерөнхийлөн захирч хэрэг шийтгэх” үүрэгтэйг тэмдэглээд, “одоо хэр хууль цаазыг тогтоон завдаагүй боловч цэргийн хууль цааз угаас нарийн чанга, явдал нь журам хэмжээтэй бөгөөд нарийн чангаар баримтлан захирч суулгаваас зохихын тулд” цэргийн байгуулалтад цаашид дагаж баримтлах дүрэм хэмжээг тогтоосныг зарлажээ¹. Нийт 11 зүйл бүхий энэ баримт бол монгол цэргийн удирдлага, зохион байгуулалтыг тодорхойлсон анхны дүрэм хэмээн үзэж болно. Энэ дүрмээр Түшээт хан, Сэцэн хан аймгаас дайчлан татсан 3000 цэргийг тус бүр 500 цэрэг бүхий 6 хороо болгож, хороо бүрт ерөнхийлөн захирах түшмэл 2-ыг томилох, 100 цэрэг бүрт захирах түшмэл 1-ийг томилох шийдвэр гаргажээ. Эдгээр 6 хорооноос Түшээт хан аймгийн тэргүүн хороо болон Сэцэн хан аймгийн 3 хороо цэргийг Хүрээний зүүн этгээд Хужиртбуланд, Түшээт хан аймгийн 2, 3-р хороог Хүрээний баруун этгээд Сонгино уулын буланд байрлуулахаар тогтоосон байна. Түүнчлэн энэ дүрмэнд, цэргүүдийг сургаж боловсруулах, тоолж бүртгэх болон чөлөө олгох, цэргүүд мөрийтэй тоглох, архи дарс уухыг цаазлан хориглох зэрэг цэргийн сургалт, сахилга журамтай холбоотой заалтууд оржээ¹. Энэ дүрмийн гол ач холбогдол нь цэргийн

зохион байгуулалтын үндсийг хуульчлан тогтоож, цэргийн эрх зүйн хөгжлийн үндсийг тавьсанд оршино.

Баруун хязгаарыг тохинуулах цэргийг захирах жанжин Манлайбаатар Ж.Дамдинсүрэн, сайд Хатанбаатар С.Магсаржав нараас Олноо өргөгдсөний хоёрдугаар он есөн сарын 15-нд түрүүлэн байлдах хорооны дүрэм гаргажээ¹. Энэ дүрэм нийт 8 зүйлтэй бөгөөд дүрмийн бас нэг онцлог нь байлдах арга тактикийн асуудлыг тусгасанд оршино.

Түрүүлэн байлдах хорооны дүрмэнд цэргийн сахилга, буу зэвсэгтэй хэрхэн харьцах, байлдах дайлах, цэрэг мордох зэрэг харилцааг зохицуулсан байна. Ялангуяа, цэргүүд давших, ухрах, дайсныг мөрдөн хөөх зэрэгт баримтлах зарчмыг нэлээд тодорхой тусгажээ. Энэ чанараараа уг дүрэм нь байлдааны дүрмийн шинжтэй болсон байна.

Цэргийн яамнаас “Дайчилсан болон элсээсэн цэргийн дагаж явах түр дүрэм”-ийг боловсруулан 1912 оны арван хоёрдугаар сарын 28-нд Богд хаанд айлтган батлуулжээ. Энэ дүрэм агуулга, хамарсан хүрээ, бүтцийн хувьд өмнөх дүрмүүдээс илүү боловсронгуй, өргөн хүрээтэй болсон байна. 23 зүйл бүхий энэ дүрмээр цэргийн удирдлага зохион байгуулалт, бэлгэдэл, харилцаа холбоо, дохио, зэр зэвсэг, цалин хүнс, сахилга журам, хууль дүрэм зөрчөгчдөд оногдуулах ял шийтгэл зэрэг олон асуудлыг зохицуулсан байна.

Өгүүлэн буй үеийн төрийн эрх зүйн харилцаанд 1915-1918 онд боловсруулан Богд хааны зарлигаар батлан мөрдүүлсэн “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг” чухал байр суурь эзэлнэ. Монгол улсын хууль зүйлийн бичигт цэргийн зохион байгуулалтын асуудал нарийвчлан тусгагдсан бөгөөд энэхүү хуулийн 37, 38, 39 дүгээр дэвтрийг цэргийн хуульд зориулжээ.

Хууль зүйлийн бичгийн 37 дугаар дэвтэр нь “Цэргийн хуулийн тэргүүн дэвтэр” бөгөөд энд дайлаар одох цэргийн ёслол болон хууль цааз, цэргийн удирдлага зохион байгуулалт, цэргийн алба хаах болон мэдээг хэрхэн хүргэх, цэргийн гэмт хэрэг өдүүлсэн хүнд хүлээлгэх шийтгэлийн талаар тусгажээ. Энэ дэвтэрт, “Цэргийн цаазын бичгийг басхүү тоо үгүй уншин цааз зарлиг чанга нарийн, цэргийн ард баатар хүчин, чин үнэнийг гүйцэтгэн зүтгэгтүн” гэжээ. Өөрөөр хэлбэл, цэргийн хууль цаазыг цэргүүдэд цаг үргэлж ухуулан таниулж, чанга хатуу дагаж мөрдөн, үнэнч шударга байхыг хуульчилан тогтоосон байна. “Цэргийн хуулийн дундад” буюу 38 дугаар дэвтэрт дотоодыг хамгаалах цэргийг байгуулж, хот балгасыг бэхлэн сахих, цэргийг сурган боловсруулах, цэргийн зэр зэвсгийн тухай, хошуудад цэргийг сурган боловсруулах тухай, “Цэргийн хуулийн доод” буюу 39 дүгээр дэвтэрт цэргийн түшмэлийн зэрэг дэв, гавьяа шагналын тухай заажээ¹.

Монгол улсын цэргийн жагсаалын дүрэмт хувцас нь 1911-1919 онд 4 зэрэгтэй байв. Үүнд, Нэгдүгээр зэрэг нь, сайд, жанжин, хорооны дарга, жагсаалын түшмэд хэрэглэнэ. Энгэрт алтадсан “Нацагдорж, дунд нь “Ум”, ардаа “Алтан хүрд”, дунд нь “Хум” гэж бичсэн дугариг улаан дэвсгэртэй бөгөөд үсгийг төвдөөр алтдан бичнэ. Баруун мөрөн дээрээ шар, зүүн мөрөн дээрээ улаан дэвсгэр дээр “Ум Аа Хум Сухаа” гэсэн үсэгтэй байна. Хоёрдугаар зэрэг нь тавин цэргийн дарга хэрэглэнэ. Энгэрт нь шар будагтай алтадсан “Нацагдорж”, мөн “Хум” үсэгтэй, ар талд алтадсан “Хүрд” дунд нь “Хум” гэсэн үсэгтэй, мөрөн дээрээ өмнөхийн адил шар өнгийн дэвсгэр дээр улаан будгаар “Ум Аа Хум Сухаа” гэсэн үсэгтэй байна. Гуравдугаар зэрэг нь аравтын

дарга нарын хувцас. Мөрөн дээрээ шар өнгийн дэвсгэр дээр улаанаар, улаан өнгийн дэвсгэр дээр шараар “Ум Аа Хум Сухаа” гэсэн үсэгтэй байна. Дөрөвдүгээр зэрэг нь цэргүүдийн хувцас. Ар, өвөртөө цагаан өнгийн дэвсгэр дээр “Нацагдорж”, “Хүрд”-ийг шар өнгөөр зурна. Мөрөн дээрээ улаан дэвсгэр дээр шараар, шар өнгийн дэвсгэр дээр улаанаар “Ум Аа Хум Сухаа” гэсэн үсэгтэй байна. Цэргийн дүрэмт хувцсан дээрх “Нацагдорж” нь ялагдашгүй бат бэхийг, “Хүрд” нь ялан дийлэх утгыг бэлгэдэж байжээ. Энэхүү дүрэмт хувцсын 1914 оноос анх хэрэглэж эхэлсэн бөгөөд энэ нь монгол цэргийн анхны дүрэмт хувцас юм.

Монгол улсын засгийн газар тусгаар тогтнолоо сэргээн бэхжүүлэхдээ хойт хөрш Хаант Орос улсыг түшиглэх бодлого баримталж байв. Хаант Оросын засгийн газар ч Монголын асуудалд онцгой анхаарч Монголд өөрийн нөлөөгөө бэхжүүлэхийг эрмэлзэж байжээ. Хаант Оросын засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч И.Я.Коростовец 1912 оны 9 дүгээр сарын 21-нд Нийслэл Хүрээнд иржээ. Хоёр тал олон удаа хуралдаж, хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр Монгол, Орос хоёр улсын хооронд 1912 оны арван нэгдүгээр сарын 2-нд найрамдлын гэрээ бичиг байгуулжээ. Энэ хэлэлцээрт Монгол улс өөрийн цэргийг байгуулахад Хаант Орос улсын засгийн газраас тусална хэмээн заажээ. Үүнийг үндэслэн “Монгол цэргийг сурган бэлтгэх тухай” Монгол, Оросын хэлэлцээг 1913 оны хоёрдугаар сарын 3-нд байгуулсан байна. Энэ гэрээгээр Хужирбуланд цэргийн сургууль байгуулж, монгол цэргүүдийг сурган боловсруулах болжээ. Улмаар 1914 оны тавдугаар сарын 15, 1915 оны наймдугаар сарын 10, 1916 оны арван нэгдүгээр сарын 2, 1917 оны арван нэгдүгээр сарын 12, 1918 оны аравдугаар сарын 22-нд монгол цэргийг сурган бэлтгэх тухай Монгол, Оросын гэрээ байгуулагдсан байна.

1912 оны сүүлчээр Гадаад яамны сайд М.Ханддорж тэргүүтэй Монгол лусын засгийн газрын төлөөлөгчид Хаант Орос улсад айлчилж, II Николай хаанд бараалхаж, Цэргийн яамны сайд В.А.Сухомлинов, Жанжин штабын дарга Зелинский гартай уулзан цэрэг зэвсгийн тусламж авах асуудлыг хэлэлцжээ. Үүний үр дүнд Хаант Оросын засгийн газар Монгол улсад 2000000 цөлхөөвийн зээллэг мөн зэр зэвсгийн тусламж үзүүлэх болсон байна. Сайн ноён хан Намнансүрэн тэргүүтэй Монгол улсын засгийн газрын төлөөлөгчид 1913 оны сүүлчээр Хаант Орос улсад айлчилж, тус улсын эрх баригчидтай төрийн тусгаар тогтнолын асуудлаар яриа хэлэлцээ хийжээ.

1912 онд Нийслэл Хүрээний зүүн зах Хужиртбуланд цэргийн сургууль байгуулагджээ. Энэ нь европын цэргийн сургалтын тогтолцоогоор монгол цэргийг сургаж бэлтгэх анхны сургууль байсан бөгөөд энэ сургууль байгуулагдсанаар монгол оронд орчин цагийн боловсронгуй цэрэг байгуулах эхлэл тавигдсан юм. Есуал А.Ф.Васильев 1912 оны 4 дүгээр сард 10 баг даргын хамт Нийслэл Хүрээнд ирснээр тус сургуулийг байгуулж эхэлсэн байна. 1912-1919 оны хооронд тус сургууль нь морьт цэрэг 3900, их буучин, пулемётчин цэрэг 450, явган цэрэг 350, бүгд 4700 орчим цэргийг сургаж бэлтгэжээ.

Энэ сургуульд цэргийн эрдэмд сурч төгссөн олон зуун цэрэг 1912 оны Ховдыг чөлөөлөх байлдаан, 1913 оны Өвөр Монголыг чөлөөлөх дайн болон хил хязгаарт болсон удаа дараагийн байлдаанд баатарлаг байлдаж, эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолыг хамгаалахад үнэтэй хувь нэмэр оруулжээ. Түүнчлэн 1921 онд

АЖЦ-ийг байгуулж, эх орноо харийн түрэмгийлэгчдээс чөлөөлөхөд ч энэ сургуульд суралцан төгссөн хүмүүс хүндтэй гавьяа байгуулсан түүхтэй.

§ 1.4. Цэрэг ба шашин

Далха бурхныг монголчууд их цэргийн сүлд шүтээн болгон залж, дайн тулааны үед тахиж байсан учраас “Дайсны тэнгэр” хэмээн нэрлэх болсон ажээ. Энэ нэр нь дайсан этгээдийн сүр сүлдийг мохоож, доройтуулах хүчтэй, өөрөөр хэлбэл, дайсны эрлэг болсон тэнгэр гэсэн утгыг илэрхийлж байгаа юм.

Далха сахиус нь нэгд, эртний Түрэг-Монголын тэнгэр шүтлэгтэй холбоотой, хоёрт, монгол угсаатнууд эртнээс дайны тэнгэр хэмээн шүтэж байсан, гуравт, дүр дүрслэлийн хувьд эртний монгол цэргийн жанжин, баатар эрийн шинжийг илэрхийлсэн учир Богд хаан Далха сахиусыг Цэргийн яамны шүтээн болгож, цэрэг эрс дайн тулаанд мордоход тахин даатгаж байсан ажээ.

Монгол улс 1913 онд Өвөр Монголыг Хятад цэргээс чөлөөлөх дайныг явуулав. Энэ дайны үед Богд хааны зарлигаар монгол цэргийн сүр сүлдийг хөгжөөх, дайсны бугийг дарах зорилготой хурал ном хурж, шашны зан үйлийг гүйцэтгэж байжээ. Богд гэгээн Өвөр Монголыг чөлөөлөх дайны үед Баруун зуугаас ид шидтэй хувилгаан ламыг Нийслэл Хүрээнд залж, ном гүрэм уншуулж, хатуу зан үйл үйлдүүлжээ. Богд хаан хил хязгаарт байлдаж буй цэргүүдэд удаа дараа хүрд, сахиус, тарни, адис, идээ зэргийг хүргүүлж байв.

Монголд буддын шашин дэлгэрснээс хойш цэргийн хувцас, зэр зэвсэгт тарни, бурхан сахиус, шашны янз бүрийн бэлгэдлийг дүрсэлдэг уламжлалтай болжээ. Тухайлбал, цэргийн хуяг дуулганд тарнийн үсэг, бурхан шүтээн зэргийг дүрсэлдэг байсан бөгөөд Монголын Үндэсний музейд ланз үсэг дүрсэлсэн дуулга, Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын музейд сахиус болон хүрд, пүрэв зэрэг шашны бэлгэдэл дүрсэлсэн дуулга хадгалагдаж байна. Энэ уламжлалын дагуу Монгол улсын цэргийн хувцсанд шашны бэлгэдлийг дүрсэлдэг байв.

Их цэрэг хил хязгаарт, дайн тулаанд мордох бүрийд Богд хааны зарлигаар томоохон хутагт хувилгаан, лам нарыг цэргийн лам, мөн эмчээр томилон мордуулж байсан төдийгүй зарим лам цэрэг удирдан дайн тулаанд орж, гавьяа байгуулж, тэмцэл тулалдааны талбарт амь насаа алдаж байв.

ХОЁРДУГААР БҮЛЭГ МОНГОЛ ЦЭРГИЙН ДАЙН БАЙЛДААН

§ 2.1. Ховд, Баруун хязгаарыг манж, хятад цэргээс чөлөөлсөн нь

Монгол Улс тусгаар тогтнолоо сэргээн тунхагласан ч баруун хязгаар, Ховдын байдал улам хүндэрч, хятадууд шавар хэрмээ засаж сэлбэн, хятад иргэдийг цэрэгт дайчлан байлдаанд эрчимтэй бэлтгэж байжээ. Гэвч шинэ тутам байгуулагдсан Монгол улсын цэрэг зэвсгийн хүч сул, хөрөнгө мөнгө хомсдолтой байснаас гадна Ховд хот Нийслэл Хүрээнээс алс хол зэрэг шалтгаанаар засгийн газар нэг хэсэгтээ Ховдод цэрэг илгээж чадахгүй байв. Ийм учраас Ховдын амбанг сүр далайлган хөөн явуулж, хотыг тайван замаар шилжүүлэн авахыг Монголын Засгийн газар эрмэлзэж байсан боловч бүтэлтэй болоогүй тул Ховд хотыг цэргийн хүчээр чөлөөлөх шийдвэр гаргаж, 1912 оны эхээр Жалханз хутагт Дамдинбазарыг Баруун хязгаарыг илбэн тохинуулах сайдаар, Өвөр Монголын түшмэл харчин гүн Хайсанг зөвлөн туслах

сайдаар томилжээ. Тэдний гол үүрэг нь баруун хязгаарын ард түмэнд учир зүйг ухуулан ойлгуулж, манжийн эсрэг тэмцэлд босгох, олон хошууд, Тагна Урианхай, Алтайн хязгаарын эрх баригчидтай холбоо тогтоож, Монгол улсын бүрэлдэхүүнд оруулах, Засагт хан болон бусад газраас цэрэг элсүүлэн Ховд хотыг чөлөөлөх ажлыг улс төр, шашны талаас нь удирдан чиглүүлэх явдал байжээ.

Улмаар Баруун хязгаарыг түвшитгэн тогтоох сайдаар Ж.Дамдинсүрэн, С.Магсаржав нарыг томилжээ. Тэд тушаал ёсоор 1912 оны зургадугаар сарын 23-нд тус бүр 25 цэрэг дагуулан Нийслэл Хүрээнээс мордов. Тэд Ховдод ирээд цэрэг татлага зарлаж, нутгийн ноёд, хутагтуудтай холбоо тогтоожээ.

С.Магсаржав, Ж.Дамдинсүрэн нар Хар-Ус өртөөний орчим байхад нэлээд тооны цэрэг хуран цугларсан тул цэргийн зохион байгуулалт хийжээ. Үүнд, цэргээ хороо, анги, аравнаар зохион байгуулж, арван хүнд галын дарга, тавин хүн тутамд ангийн дарга, дөрвөн анги тутамд хорооны ба жагсаалын дарга, бичээчийг томилсон байна.

Монгол цэргийн ангиуд 1912 оны долдугаар сарын 24-нөөс Ховдын өмнөх Талын хайрхан гэдэг газар шилжин байрлаж, Ховд хотыг бүсэлсэн байна. Улмаар Ховд хотыг чөлөөлөх төлөвлөгөө боловсруулжээ. Юуны түрүүнд хотыг бүслэн авч, хотод орох зам гарцыг хааж, гадаад орчноос нь тусгаарлахаар шийдвэрлэжээ. Энэ нь нэг талаар хотод бүгсэн Манж сайд цэргүүдийн гаднаас тусламж авах, хэл мэдээ солилцох бололцоог хаах, нөгөө талаар тэднийг хотын хэрэм дотор удаан хугацаагаар хорьж туйлдуулан тамирдуулах зорилготой байлаа. Энэ нь эртний монгол цэргийн хот тосгодыг байлдах гол арга юм. Сайд Ж.Дамдинсүрэн, С.Магсаржав нар бүх цэргээ 6 хороо болгон зохион байгуулж, давших чиглэлийг нь тогтоож өгсөн байна.

Хотыг бүслэх үед монгол цэрэг 2000 гаруй байсан бөгөөд улмаар цэргүүдийн тоо нэмэгдсээр дайралтанд орох үед 3000 орчим болжээ. Монгол цэргүүд зуны адаг сарын аравдаар хотыг бүслэн авч, сахин сууснаас хойш Ховдод байсан хятад цэргүүд хэд хэдэн удаа Сангийн хэрмээс гарч байлдахыг завдсан төдийгүй хилийн чанадаас ч тэдэнд туслах хүч ирж нийлэхийг оролдсон байна. Ж.Дамдинсүрэн, С.Магсаржав нарын удирдсан цэрэг Ховдыг чөлөөлөх байлдааны өмнө гурав, дөрвөн удаагийн тулалдаанд орж, дарийн утаа үнэрлэн, бас ч дайтах, тулалдах дадлыг олов.

Монгол цэргүүд эхлээд хотыг тойрон бүсэлж, дараа нь Рашаант уулын орой дээр гал асаан дохио өгмөгц бүх цэрэг нэгэн зэрэг дайрчээ. Их цэргийн хамгийн түрүүнд Ж.Дамдинсүрэн байлдааны туг барьсан нэр бүхий хэдэн цэргийн хамт уриа хашгиран дайрснаар монгол цэргийн давшилт эхэлсэн бөгөөд С.Магсаржав, Дамбийжанцан нар Ж.Дамдинсүрэнгийн араас цэргүүдийг давшилтанд шахан хөөн оруулж байв. Монголын морьт цэргүүд эрчимтэй давшилтаараа хотын наймаачны дүүргийг богино хугацаанд эзлэн авсан боловч хятад цэргүүд Сангийн хотод ухран орж хориглон, хүчтэй эсэргүүцэн тулалдсан байна.

Сангийн хотын нэг талаас нь Ж.Дамдинсүрэнгийн, нөгөө талаас нь Магсаржав, Дамбийжанцан нарын удирдсан цэрэг дайрсан байна. Энэ хотын төлөө тулалдаан ширүүн болж С.Магсаржав Талын улаан уул ба Алаг Толгой зэрэг газар байсан туслах хүчийг тулалдаанд оруулж, хүч нэмэгдүүлэн байлджээ. Ийнхүү удтал байлдсаны эцэст наймдугаар сарын 21-ний өдрийн наран хойш хэлбийх үед манж

хятад цэргүүд Сангийн хотын хэрмийн дөрвөн өнцөгт цагаан далбаа хатган, бууж өгөхөө мэдэгджээ. Гэвч Сангийн хотын дотор ямар ч чимээ аниргүй болж, хаалгыг тайлж өгөхгүй байсан учир хэрмэнд орох бололцоогүй болж мухардав. Ж.Дамдинсүрэн, С.Магсаржав нар Сангийн хотын хэрмийг давж орох шийдвэр гаргажээ. Ингээд С.Магсаржав цэргүүдийнхээ дотроос зориг самбаатай Мөнхийн Дорждэрэм нарын 20 гаруй хүнийг сонгон авч тэргүүлэн дүүжин шатаар хэрмийг давж оржээ.

С. Магсаржав, Ж.Дамдинсүрэн нарын цэрэг Ховд хотыг 1912 оны наймдугаар сарын 21-нд бүрэн чөлөөлсөн байна. Энэ байлдаанд монгол цэргээс 18 хүн амь үрэгдэж, хэд хэдэн хүн хүнд, хөнгөн шархадсан ба Манжийн цэргээс 200 орчим хүн амь үрэгдсэн мэдээ байна.

Ховд хотыг чөлөөлсөн нь 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалын бүрэн ялалтыг хангаж, Монгол Улсын тусгаар тогтнолыг баталгаажуулав. Энэ байлдаанд баатарлаг гавьяа байгуулсан цэрэг дарга, лам хар олон хүнийг Богд хааны зарлигаар цол, хэргэм зэргээр шагнажээ. Богд хааны зарлигаар С.Магсаржавт Хатан баатар цол, үе улиран бэйсийн хэргэм, хоёр нүдний тогосын отго, хүрэн жолоо, Ж.Дамдинсүрэнд үе улиран залгамжлах засаг төрийн бэйл, хоёр нүдний тогосын отго, Манлай баатар, Цэргийн жанжин цол шагнасан байна. Үүний зэрэгцээгээр удаа дараагийн тулалдаанд баатарлаг байлдсан хороон дарга мэйрэн Гэндэн, хороон дарга Найданжав, Цэргийн яамны занги Пунцаг, цэрэг Сэргэлэн, Доржпалам, Насантогтох, Минбуу, Дорждэрэм, Далай нарт баатар цол шагнасан байна. Ховд баруун хязгаарыг Манжийн ноёрхлоос чөлөөлөхөд сайд Номун хан Жалханз хутагт Дамдинбазар, сайд Наваанцэрэн, Гончигдамба, мөн Дамбийжанцан нар ихээхэн үүрэг гүйцэтгэсэн билээ. Ийм учраас сайд Ж.Дамдинсүрэн, С.Магсаржав тэдний гавьяа зүтгэлийг Богд хаанд өргөн айлтгаж, зэрэг хэргэм хүртээсэн байна.

§ 2.2. Өвөр Монголыг чөлөөлөх дайн

Монгол Улсын Засгийн газрын бүх монгол овогтныг нэгтгэн захирах бодлогыг Өвөр Монголын ихэнх нь талархан дэмжиж, Монголд дагаар орсон билээ. Гэтэл Бээжингийн эрх баригчид монгол түмний нэгдэх хөдөлгөөнийг таслан зогсоохын тулд Өвөр Монголд ихээхэн хэмжээний цэрэг оруулж, залхаан цээрлүүлэх болсон байна. Ийм учраас Монгол улсын засгийн газар Өвөр Монголд цэргээ оруулж, хятад цэрэгт эзлэгдсэн газар нутгийг чөлөөлөхөөр шийдвэрлэж, ЦХБЗШЯ-наас таван замаар цэрэг хөдөлгөх төлөвлөгөө боловсруулсан байна.

Богд хаан Олноо өргөгдсөний хоёрдугаар он, өвлийн сүүл сарын 18 (аргын тооллын 1913 оны нэгдүгээр сарын 25)-нд таван замаар цэрэг мордуулах тухай Цэргийн яамны бичигт, "...хэлэлцсэн ёсоор болгогтун" хэмээн цохжээ¹. Энэ шийдвэрийн дагуу 1913 оны хавраас эхлэн Нийслэл Хүрээнээс өмнө хязгаарыг зорьсон их цэрэг мордож эхэлсэн байна. Үүнд,

Орлосон дэд сайд засагт чин ван Удайн харьяат цэргийг бэйсийн зэрэг Чимэдсэрэнд захируулж, дэс түшмэл Тогтохын харьяат цэргийн хамт Егүзэр хутагт Галсандашийн хүрээний чиглэлээр, дэс түшмэл Чин зүтгэлт гүн Хайсан, дэд зэрэг түшмэл Бавуужав нарын харьяат цэргийг Дарьгангын зүг, дэд сайд Бишрэлт бэйс Насанравжихад харьяат цэргийг нь захируулан Хоёр Сөнөд, Дөрвөн вангийн зүг, Халхын сургуулийн цэргээс мордуулах 200 цэргийг сайд гүн Сономдорж нар лугаа

нийлүүлэн Хөх хотын зүг, дэд зэрэг түшмэл Зүтгэлтэд харьяат цэргийг нь захируулан Урадын гурван гүн, Хатан голын зүг мордуулахаар төлөвлөсөн байна.

Богд хааны зарлигаар өмнө зүгт таван чиглэлээр цэрэг хөдөлгөсөн боловч Өвөр Монгол дахь байлдаан үндсэн хоёр чиглэлээр явагдсан байна. Үүнд, нэгд, Түшээт хан аймгийн өмнө захаас Улаанцавын чуулган-Хөх хотын чиглэл, хоёрт, Дарьганга, Егүзэрийн хийдээс Шилийн голын чуулган Долон нуурын чиглэл орно.

Богд хаан түүний засгийн газар 1913 оны зуны сүүл сард Өвөр Монголыг чөлөөлөх байлдааныг эрчимжүүлэх талаар шат дараалсан шийдвэрийг гаргасан байна. Үүний үр дүнд 1913 оны зуны сүүл сараас монгол цэргийн давшилт нэн эрчимжиж, хятад цэрэгт хүчтэй цохилт өгч эхэлжээ.

Манлайбаатар Дамдинсүрэнгийн удирдсан их цэрэг 1913 оны найм, есдүгээр сард бүх чиглэлээр шийдвэртэй давшиж, хятад цэргийг бутцохин, гайхамшигт ялалт байгуулж, Шилийн голын чуулганыг бүхэлд нь, Зуу-Удын чуулганы ихэнх нутаг, Улаанцавын чуулганы зүүн хэсэг зэрэг газрыг хятад цэргээс чөлөөлж, монгол цэрэг Бээжингээс 100 хүрэхгүй км зайтай Долон нуурт тулж очив¹. Өөрөөр хэлбэл, 1913 оны намрын сүүл сар гэхэд монгол цэргүүд Өвөр Монголыг бараг бүхэлд нь чөлөөлж хяналтаа тогтоосон байв.

Ар, Өвөр Монголын цэрэг хамтарсан хүчээр амжилттай давшиж бараг Цагаан хэрэмд тулж ирсэн нь Орос, Хятадын эрх баригчдын санааг зовоох болсон юм. Өөрөөр хэлбэл, Бээжингийн эрх баригчид Өвөр Монголыг алдахаас эмээж байсан бол умард хөршийн эрх баригчид Өвөр Монголоос болж Хятадтай харилцаагаа муутгахаас болгоомжилж байв. Ийм ч учраас Юань Ши Кайн засгийн газар Бээжинд суугаа Оросын консулд хандан Ар Монголын цэргийг гэдрэг ухруулан Өвөр Монголоос гаргахад туслахыг хүсч байсан бол Хүрээнд суугаа Оросын консулаас “Дундад, Монголыг найрамдуулах тухай манай улсаас Хятад лугаа зуучлан хэлэлцэж буй тул Дотоод Монголын нутагт хятад лугаа байлдуулан бүхий монгол цэргийг цөм татваас зохимуй” хэмээн Монголын засгийн газарт дахин давтан шаардаж байжээ¹.

Монгол улсын засгийн газар Өвөр Монгол дахь байлдааныг зогсоож, цэргээ ухруулахаас эрс татгалзаж байв. Гэвч өмнө хязгаарын “түшмэд цэргүүд дайсны цэрэг лүгээ эсэргүүцэн байлдаж, зах хязгаарыг батлан хамгаалахад хүчин хүрэлцэхгүй, санхүүгийн үлэмжхэн зүйл ба зэвсэг, уналга зэргийн талаар сүйтгэхэд хүргүүлсэн төдийгүй тохиолдсон олон чуулган хошуудын түшмэл ард мөн талаар чирэгдэв хэмээх зэргээр гаслалдан их цэргийн хүнс хэрэглэлийг гүйцэтгэн нийлүүлэн өгч чадахгүйд хүрч хараахан маш түгшүүртэй”¹ болсон тул хөрш хоёр гүрний шаардлагыг хүлээн авахаас өөр аргагүй болжээ. Ийм учраас Богдын засгийн газар Иргэн улс цэргээ гэдрэг татаж, хятад цэргүүд Өвөр Монголын тайван суугчдыг дарлан зовоохгүй, амар амгалан байлгах аваас байлдаанаа зогсож, цэргээ ухруулж болно гэсэн шаардлага тавьсан байна.

Өвөр Монголд байлдаж байгаа их цэргийг гэдрэг ухраан татах тухай Цэргийн яамны шийдвэр 1913 оны арван нэгдүгээр сарын 7 (аргын тооллын 12 сарын 4)-нд гарчээ. Ийнхүү “Таван замын байлдаан” бараг жил хиртэй үргэлжилсний эцэст дуусав.

§ 2.3. Хил хязгаарт цэрэг илгээн төвшитгөн тогтоосон нь

Монгол Улс тусгаар тогтсоноос хойш хил хязгаар, гадаад улс төрийн байдал нь амгалан тайван байсангүй. Хөрш зэргэлдээ Орос улс Монголын тусгаар тогтнолыг хязгаарлагдмал хүрээнд зөвшөөрч, автономит эрхтэй улс байлгахыг эрмэлзэж байсан бол Хятад улс Монголын тусгаар тогтнолыг эрс эсэргүүцэж, ямар ч аргаар болов өөртөө нэгтгэхийг чармайж байлаа.

Орос, Хятад хоёр 1912 оноос эхлэн Монголын асуудлыг өөрсдийнх нь оролцоогүйгээр хэлэлцсээр 1913 оны 10 дугаар сард Бээжинд Монголын тухай тунхаглалд гарын үсэг зурж, улмаар Монголд хүчтэй шахалт үзүүлсний үндсэн дээр 1915 онд Хиагтад Гурван улсын гэрээ байгуулж, Монгол Улсын тусгаар тогтнолыг цуцлан, Өвөр Монголыг Хятадад нэгтгэж, Ар Монголыг Автономит эрхтэй болгосон юм.

Үүний зэрэгцээгээр хөрш хоёр орны дотоодод гарсан өөрчлөлт, улс төрийн тогтворгүй байдал ч Монгол Улсын хил хязгаарын байдалд сөргөөр нөлөөлж байв. 1916 оны намраас өмнө хязгаараар хятадын зэвсэгт дээрэмчид цөмрөн ирж, ард олныг түйвээн, дээрэм тонуул хийж, хил хязгаарыг тогтворгүй болгож эхэлсэн байна. Ийм учраас Монгол Улсын Засгийн газар С.Магсаржавыг Өмнө хязгаарыг батлан тохинуулах сайд, Түрэмгий баатар Баярыг туслан шийтгэх сайдаар томилж, 1000 цэрэг дайчлан захирч, хил дамнан түйвээж буй хятад цэргийг дарах тушаал өгсөн байна.

Тайж Баяр 1912 оны намар Богд хааны зарлигаар баруун хязгаарт очиж, 1912-1913 онд Цагаан түнгэд байсан хятад цэрэгтэй хэд хэдэн удаа байлджээ. С.Магсаржав, Баяр нар Цэргийн яамны тушаалаар 600 цэргийг удирдан, 1916.12.15-нд Сулинхээрээс морджээ. Тэд Өвөр Монголын Улаанцавын чуулганы Муу мянган засаг хошууны бэйсийн нутаг Ухуугийн амны Шанд хэмээх газар хүрч, хятадын дээрэмчин цэрэгтэй хоёр удаа байлдаж, ихэд хядан сөнөөсөн байна. Улмаар Муу мянганы өмнө зах Байлтага гол зэрэг газруудаар явж, хятадын хэдэн зуун цэрэгтэй удаа дараа хүчлэн байлдаж, ихэнхийг нь сөнөөн, Муна уул хүртэл хөөн зайлуулж, үлэмж зэр зэвсэг, уналга, хэрэгсэл олзлон авсан байна.

Монгол Улсын Засгийн газар 1917 оны 5 дугаар сард С.Магсаржавыг зүүн хязгаарыг сэргийлэх цэргийг ерөнхийлөн захирах сайд, гүн Баярыг туслан шийтгэх сайдад томилж, Хужирбулангийн цэргээс мянгаад цэрэг захиран мордож, харчины дээрэмчдийг устган, зүүн хязгаарыг тохинуулахыг даалгажээ. Сайдууд зарлигийг дагаж 1917 оны долдугаар сарын 12-ны өдөр Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамнаас тамгаа хүлээн авч, их цэргээ захиран, Нийслэл Хүрээнээс зүүн хязгаарын зүг өртөөлөн морджээ.

Хил хязгаарыг бусниулан байсан дээрэмчид үндсэндээ дарагдаж, үлдсэн нь хилийн чинад зүүн өмнө зүг зугатан зайлсан, мөн өвөл болж байгаа тул дээрэмчид Халх, Баргын нутагт дахин халдан ирэх боломжгүй болсон тул С.Магсаржав, туслах сайд Баяр нар 1917 оны өвөл Нийслэл Хүрээнд эргэж ирсэн байна.

1917 оны намрын сүүл, өвлийн эхэн сараар Монгол улсын баруун өмнө хилээр хятад цэргүүд цөмрөн ирж, нутаг орныг бусниулж болзошгүй болсон байжээ. Ийм учраас Цэргийн яам 1917 оны аравдугаар сард Баруун өмнө хязгаарыг батлан сэргийлэх цэргийг ерөнхийлөн захирах сайдад Хатанбаатар С.Магсаржавыг, туслан шийтгэх сайдад Сэцэн хан аймгийн Дайчин бэйс Дашцэрэнгийн хошууны Дайчин

жонон бэйсийн зэрэг Улсад туслагч гүн Дамдинжав нарыг томилжээ. Тэдний удирдсан цэргүүд дайсантай удаа дараа тулгаран байлдаж, заримыг нь алж устган, заримыг нь өмнө зүг Хятадын нутгийн гүнд зугтаалгасаар хил хязгаарын байдал харьцангуй тайван болсон байна.

Урианхайн хязгаарын байдал түгшүүртэй болсон тул Богдын Засгийн газар 1919 оны 3 дугаар сарын эхээр Хатанбаатар ван С.Магсаржавыг Урианхайд сууж хэрэг шийтгэгч сайдаар томилжээ. Цэргийн яам түүний мэдэлд 250 цэрэг өгч, нэн даруй Урианхайн газар давшин орж тохинуулахыг тушаасан бөгөөд тэрээр эл үүргийг амжилттай биелүүлсэн байна.

Аливаа улс орон тусгаар тогтнолоо хамгаалахын тулд цэрэг зэвсэгт хүчнээ байгуулдаг жамтай. Монгол улс тусгаар тогтнолоо сэргээх явцад Хиагтын зүүн, баруун харуул болон Сэцэн хаан аймгаас тодорхой тооны цэрэг дайчлан татсан нь Монгол улсын цэргийн үндэс суурь болжээ. Улмаар 1912 оноос аймаг, хошуудаас олон мянган цэрэг удаа дараа дайчлан татаж, сурган бэлтгэснээр Монгол улсын цэргийн хүч нэмэгдэж, 1913 оны байдлаар цэргийн тоо арван мянгад хүрч байв. Энэ үеийн цэргийн гол онцлог нь нэгд: монгол цэргийн уламжлалд тулгуурласан морьт цэрэг байсан, хоёр: Европ болон Хаант Оросын цэргийн туршлага, ололтыг ашиглаж, Хаант Оросын тусламжтайгаар цэргийн сургууль байгуулж, орчин үеийн галт зэвсгээр цэргээ зэвсэглэж байсан, гуравт: эрх чөлөө, тусгаар тогтнолоо хамгаалсан зэвсэгт тэмцлийг эрчимтэй явуулж байсан зэрэгт оршино.

Монгол улсын засгийн газар анх удаа цэргийн сургууль байгуулсан, цэргийн дүрэм, хууль цаазыг батлан мөрдүүлсэн, Хаант Оросоос орчин үеийн галт зэвсэг авч морьт цэргийг зэвсэглэсэн зэрэг олон шинэ зүйл энэ үед цэргийн хэрэгт нэвтэрсэн байна. Энэ нь монгол цэргийн түүхэнд онцгой нөлөө үзүүлсэн юм.

Судалгааны үр дүнд дараах санал, дүгнэлтийг дэвшүүлж байна.

Нэгд: Өнөөгийн зэвсэгт хүчний үүсэл хөгжлийн түүхийг 1921 оноос эхлэлтэй хэмээн үзэх хандлага урьдын адил байсаар байна. Гэтэл 1911-1912 онд байгуулагдсан Монгол улсын цэрэг нь Монголд орчин үеийн цэрэг зэвсэгт хүчин байгуулагдах үндэс суурь болсон бөгөөд энэ үйл явц 1921 оны хувьсгалын дараа улам эрчимтэй явагдсан байна.

Хоёрт: Судалгааны бүтээлүүдэд Монгол улсын цэргийн түүхийг 1911-1919, 1911-1921 он хэмээн хоёр янзаар үечлэн авч үзсэн байна. Монголын автономитыг 1919 онд устгасан боловч 1921 оны цагаан сард автономитыг сэргээн Богдыг хаан ширээнд залж, таван яам бүхий засгийн газрыг байгуулж, Монгол улсын засгийн газар аймаг, хошуудаас цэрэг дайчлан татаж, гамин болон цагаантнаас эх орноо чөлөөлөх зэвсэгт тэмцлийг удирдан явуулж байгаад 1921 оны долдугаар сард засгийн эрхийг Ардын засгийн газарт тайван замаар шилжүүлсэн билээ. Ийм учраас Монгол Улсын цэргийн түүхийг 1919 оноор таслан авч үзэх нь үндэслэл муутай байна. Тийм учраас цаашид Монгол Улсын цэргийн түүхийг 1911-1921 он хэмээн үечилж хэвших нь чухал байна.

НАЙМДУГААР БОТЬ
МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ ЦЭРЭГ
(1921-1945 ОН)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
МОНГОЛ АРДЫН ЖУРАМТ ЦЭРГИЙГ БАЙГУУЛЖ, ЭХ ОРНОО ГАДААДЫН
ЭЗЭРХЭГҮҮДЭЭС ЧӨЛӨӨЛСӨН НЬ

§1.1. Монголын автономит засгийг устгасан нь, харийн цэргийн эзэрхийллийн үеийн Монголын байдал

Монголчууд 1911 онд харийн эрхшээлээс ангижирснаар тусгаар тогтнолоо сэргээн, олон зууны хоцрогдлыг арилган, хөгжил дэвшилд хүрэхийг эрмэлзсэн шинэ үе эхэлсэн билээ. Гэсэн хэдий ч Монголын дотоод нөхцөл байдалд нөлөөлөх үйл явдлууд хөрш зэргэлдээ улсуудад гарч эхэлжээ. Хиагтын гэрээгээр луйвардан олсон эрхээ нэн даруй эдэлж, Монголд нөлөөгөө сэргээхийг хүссэн ДИУ-ын үйл ажиллагаа идэвхижиж эхэлсэн нь өмнийн аюулаас сэрэмжлэх болгоомжлолыг төрүүлж, улам улмаар лавшруулсаар байв.

Энэ завсар умард хөршид улс төрийн томоохон үйл явдлууд болж, 1917 оны хоёрдугаар сарын ба Октябрийн хувьсгалын тухай мэдээ Монгол нутагт тархаж эхэлжээ.

ДИУ эхлээд монголчуудад улс төр, эдийн засгийн дарамт үзүүлэх, дараад нь автономит эрхийг нь гэрээ хэлэлцээрээр цуцлахыг оролдож, эцэст цэргийн хүчээр эзэрхийлэх хүртэл дэс дараатай бодлого явуулжээ. Монголын Засгийн газар шинэ ЗОУ-тай харилцаа тогтоохоос сэрэмжилсэн хятадын тал Монголын асуудлыг дангаар шийдвэрлэх дараагийн алхамд шилжиж, 2 хороо цэргийг 1918 оны 9 дүгээр сард Хүрээнд ирүүлэв.

1919 он болоход Хиагтын гэрээ эвдэгдсэн хэмээн үзсэн ДИУ шинэ хэлэлцээр байгуулах зааварчлагыг Хүрээн дэх сайд Чен И-д өгснөөр “Гадаад Монголын өөртөө засах эрхийг устгасны хойно Дундад засгийн газраас Гадаад Монголыг хүндэтгэх ба жич хойчийг сайжруулах хууль зүйл” буюу түүхнээ “Чен И-ийн 64 зүйл гэрээ” гэж товчлон нэрлэсэн бичиг буй болов.

Хятадын засгийн эрхэнд гарсан цэргийнхэн асуудлыг хатуу аргаар шийдэхээр генерал Сүй Шу жан-ыг Монголыг тохинуулах сайдаар томилжээ. Өгүүлэн буй үед Хүрээнд 4000 орчим хүнтэй хятад цэргийн холимог бригад бий болж, Улиастай, Ховд, Хиагт зэрэг чухал боомт газруудад хятад цэрэг нэмэн ирсээр арав шахам мянган цэрэг ирсэн мэдээ буй¹.

1919 оны 11 дүгээр сарын 15-17-ны өдрүүдэд Сүй Шу жанаас Гадаад Монголын автономийг устгах нь түүний тушаалын хэрэг болохыг дахин дахин сануулж, гуйн өргөх бичгийг нэн даруй гаргаж өгөхийг шаардаж, эс өгсөн тохиолдолд Богд гэгээн, Бадамдорж нартай “ял хэлэлцэх”-ээр цэрэг жагсаан сүрдүүлжээ.

Улсын Дээд, Доод хурал Сүй Шу жаны тулгалтыг дагах эсэхийг хэлэлцэн, харилцан адилгүй шийдвэр гаргажээ. Хятадыг эсэргүүцэн тэмцэх тухай Доод хурлын саналыг Дээд хурал “цагийг таньж, хөрөнгө буурайн байдалд нийлүүлэхгүйгээр дайн байлдаан үүсгэвээс хойчийн зовлон үлэмж болохоос болгоомжлох” нэрийдлээр хүлээж авсангүй¹. Дээд хурал буй болсон нөхцөл байдлаас гарц олж чадаагүй бөгөөд олон түмний эсэргүүцэл шүүмжлэлийг үл хайхран Сүй Шужаны зохион өгсөн хятад эхийг монголоор орчуулан 5 яамны тамгыг дарж, Ерөнхийлэн шийтгэх сайд, ба яамдын тэргүүн дэд сайдуудын нэрсийг жагсаан гардуулжээ. Хятадууд өөртөө засах засгийг нь хүч түрэн устгах зорилгодоо ийнхүү хүрч, Монголын өөртөө засах эрхийг халсан тухай ДИУ-ын ерөнхийлөгчийн зарлиг 1919 оны 11 дүгээр сарын 22-нд гарч, тэр тухай 12 сарын 16-нд Халхын 4 аймаг, Шавьд зарлан мэдэгджээ.

Энэ тухай ёслол 1920 оны 1 сарын эхээр Нийслэл Хүрээнд болж хятад генерал Сүй Шу Жан Гадаад Монголын таван яамны тамгыг хураан, бичиг хэргийг битүүмжилж, Монгол цэргээс Нийслэл Хүрээнд Богдын бие хамгаалах цэрэг 60, Хиагтад хязгаарыг сахиулах 50 цэргийг тус тус үлдээн бусдын зэвсгийг хураан тараав.

Үндэс угсаагаа гэсэн хэн боловч тусгаар байдлаа дахин олохыг эрмэлзэх болсон цаг мөчид монголчууд зэрэг дэв, үзэл бодлоороо эвлэлдэн нэгдэж эхэлснээр “Түшмэдийн нам”, “Ардын нам”, Угсаатны нам” [Ноёдын нам] хэмээх бүлгүүд улс төрийн тавцанд гарч ирэв. Хятадыг эсэргүүцсэн нийт үндэсний хөдөлгөөн Монголд үүсэж эхэлсэн нь ЗОУ-ын зүгээс Монголын талаарх бодлогоо шинээр харахад хүргэв.

Үүний зэрэгцээгээр Монгол орны байдлыг өөрчилж, цэрэг-дайны өргөн хэмжээний ажиллагаа явагдахад хожмоо хүргэсэн нэгэн үйл явдал болсон нь барон Унгерний захирсан цагаантан Онон голын сав нутаг, Гилбэр харуулаар 1920 оны 10 дугаар сарын 2-нд нэвтрэн орж ирсэн явдал юм. Барон Унгерн хил залгаа Монгол дахь улс төрийн хямрал, үймээн самууныг овжноор ашиглаж “монголчуудыг хятад цэргээс чөлөөлж, автономит засгийг сэргээх, Богдыг хаан ширээнд залах” гэсэн үг уриагаар халхавчилж байв. Хэдхэн жилийн өмнө байлдан олсон тусгаар тогтнолыг нь устгасан хятадын цэргээс ангижрахын тулд хэнийг ч болов түшиглэхэд бэлэн байсан монголчуудын зарим нь түүний үгэнд итгэж Унгернд хөрөнгө хүчээр тусалж эхлэв. Оросын цагаантнууд Нийслэл Хүрээг дайрахаар завдсаны улмаас хятад цэргийн удирдлага Монголын эрх баригчдыг айлган сүрдүүлж, Унгернтэй сүлбэлдэв хэмээн Богд гэгээн, зарим ноёдыг барьж хорьжээ.

Унгерн ба хятадын хоорондын байлдаан 1921 оны 1 дүгээр сарын 24-нөөс 2 дугаар сарын 3-ийг дуустал завсарлагатайгаар үргэлжилснээс гол тулалдаан нь 2 сарын 2, 3-нд болжээ. Цагаантнууд дураар авирлаж, Хүрээний байдал төвхнөөгүй байсан ч монголчууд автономит засгаа сэргээх бэлтгэлээ шургуухан хийж, Олноо өргөгдсөний 11 дүгээр он цагаан сарын шинийн 15 буюу 1921 оны 2 дугаар сарын 22-нд Богд хааныг төрийн ордноо залж, Монгол ноёдоор бүрэлдсэн Засгийн газар байгуулагдсанаар Монголын төрийг сэргээснийг зарлав.

Гэсэн ч бүтэн хоёр жилийн турш хятад цэргийн дээрэм тонуулд туйлдаж ядарсан Монгол орныг Унгерн өөрийн дэглэм, дайчилгаа албадлага, сүрдүүлэг,

дээрэм, аллагаараа үнэхээр зутраажээ. Цагаантны дэглэмийн улмаас улс орны байдал хүндэрч, монголчууд хөрөнгө хүч, хүн ардынхаа амь насаар хохирч байв.

Унгерний цэрэг дайны бэлтгэл идэвхиж, цагаантнуудын цадиггүй, дээрэмчин шинж улам бүр тодрохын хирээр Монголын эрх баригчид байдлыг хянахад хүндрэлтэй болж, Унгернтэй түнжин хагарч, түүнээс салахыг хэн хүнгүй хүсэх болжээ.

Нөгөө талаас, Монголын умард хил орчим, Хиагтад хятад цэргийн хүч бодитойгоор оршиж нутгийн олныг дээрэмдэн талж байв. Энэ бүх байдал нь монголчуудын эрх чөлөөний тэмцэл Хүрээнд автономит засгийг сэргээснээр дуусах бус, харин дөнгөж эхэлж буйг олон түмэнд мэдрүүлж, тэд тэмцэхэд бэлэн байсан нь бодитой зүйл. Чухам эндээс монголчуудын эрх чөлөөний тэмцэл дараагийн, шинэ шатанд шилжин орсон юм.

§1.2. Ардын журамт цэргийг байгуулсан нь, Эрх чөлөөний төлөөх тэмцлийн эхлэл

Хятадын цэргээс улс орноо чөлөөлөх явдал монголчуудын хувьд зэвсэгт тэмцлийн хэлбэрээр явагдах нь бүр эхнээсээ тодорхой байж, зэвсэг хэрэгсэл олж бэлтгэх ажлыг нууц бүлгүүдийн үеэс л эхлэн оролдож байжээ. МАН-ын төлөөлөгчид ЗОУ-д очсон үед "...намын гишүүдээс бүрдсэн зэвсэгт бүлэг байгуулах, тэднийг зэвсгээр хангах, цэрэг-улс төрийн сургууль нээх" асуудал ч дэвшигджээ.

1921 оны 1 дүгээр сарын эхээр туслан өгсөн мөнгийг авсан С.Данзан Дээд-Шивээнд ирж, ЗОУ-аас ирүүлэх буу зэвсгийг Уушгийн тосгоноор дамжуулахаар болсныг мэдэгдэж, ард түмнийг тэмцэлд босгож зэвсэгт хүчийг зохион байгуулах ажилдаа түргэвчлэн оржээ.

Монгол орныг харийн цэргийн эзэрхийллээс чөлөөлөх тэмцлийг ялалтад хүргэх дотоод, гадаадын хүчин зүйлүүд бүрэлдэн буй болсон нөхцөлд хилийн чанадад байсан Монголын хувьсгалчдын 1920 оны 12 дугаар сарын 19; 1921 оны 1 дүгээр сарын 18, 23-ны зөвлөлгөөнөөр хил орчмын цэрэг-улс төрийн байдлыг судлах, цэрэг элсүүлэх асуудлыг хэлэлцээд¹ Хиагт орчмын ард олны санаа бодлыг судлан Хиагтын 50 цэрэг, Эрдэнэ ван Сумъяа бэйсийн хошууд, Хиагтын зүүн гурван харуулаас цэрэг элсүүлэхээр тогтжээ. 1921 оны 2 дугаар сарын 9-нд болсон зөвлөлгөөнөөс цэрэг элсүүлэх ажлыг Д.Сүхбаатарт даалгаж, ард олныг тэмцэлд дуудсан тунхаг бичгийг Эрдэнэ ван, Сумъяа бэйсийн хошуу, Хяраан, Чагтай, Уялга, Хүдэр, Баруун жарантай, Ортого зургаан харуул, Хиагтын тавин цэрэг зэрэг 9 газарт тараахаар тогтжээ.

Цэрэг элсүүлэх ажлын үр дүнд Орхон Сэлэнгийн бэлчир-Алтанд хүрэлцэн ирсэн цэргийн тоо 1921 оны 3 дугаар сар гэхэд 400 орчимд хүрчээ. 1921 оны 3 дугаар сарын 1-3-нд Монгол орны улс төрийн байдал, зэвсэгт тэмцлийг эхлэх асуудлыг МАН хэмээх байгууллагын удирдлага, шинэ тутам бүрдүүлсэн цэргийн анги, зарим хошууны ардын төлөөлөгчид хамтран хуралдсан зөвлөлгөөний 2 дахь өдрийн хуралдаанаас цэрэг нэмэн элсүүлэх, хүчийг зузаатгах, "Ардын намын цэргийн хэргийг захирах газар" буюу штабыг байгуулж, байлдааны тухай явдлыг Сүхбаатар, Данзан, Цэвээн, Билигсайхан, Борисов нарт даалган, цэргийн ерөнхийд Д.Сүхбаатарыг сонгожээ¹.

Цэрэг элсүүлэх ажлыг цаашид шуурхайлан явуулж цугларсан цэргийг Алтан, Хужир нуга, Эрээнээс Сэлэнгэ мөрний баруун гарт орших Ханын хөндий, Шар хад хэмээх газар шилжүүлэн 4 хороонд хуваан байрлуулжээ.

1921 оны 3 дугаар сарын 10-нд хийсэн энэхүү зохион байгуулалтаар цоохор цэргийг тэргүүн хороо болгож даргад Б.Пунцагийг хэвээр, Б.Сумъяагийн хошууны цэргүүдийг 2-р хороо болгон даргад захирагч О.Цэрэндорж, зүүн харуулуудын цэргийг 3-р хороо болгон даргад Дүйнхорын да лам Ц.Хасбаатарыг, Эрдэнэ вангийн хошууны цэргүүдээр 4-р хороог байгуулав. 3 дугаар сарын 12-нд цэргийн штабыг нэгэн адил шинэчлэн даргад Лятте, 1, 2 дугаар туслахад Беретти, Литвинцев, дэд жанжинд Л.Сумъяа бэйсийг томилж, цэргийн нэрийг “Ардын журамт цэрэг” (АЖЦ) хэмээн өөрчлөн нэрлэхээр тогтон тэр тухай тушаалыг хороо, ангиудад тараажээ¹.

1921 оны хувьсгалын анхдугаар зорилт нь хятад цэргийн эзэрхийллээс эх орноо чөлөөлөх явдал байсан бөгөөд 1920 оны намар ЗОУ-ын Засгийн газартай хэлэлцээр хийсэн МАН-ын төлөөлөгч С.Данзан нар “хятадын эзэрхийллээс ангижрах тэмцлийг монголчууд өөрийн хүчээр хийх” -ээр тохиролцож зэвсэг, санхүүгийн тусламж авсан билээ. Иймд эрх чөлөөний тэмцлийн гараа болсон Хиагтыг чөлөөлөх байлдаанаас эх орончдын жил гаруй хугацаанд чармайн зүтгэсэн үйл хэргийн амжилт, цаашилбал монголчуудын хувь заяа хамаарах тул бэлтгэлийг сайтар хангах явдал онц чухал байв.

МАЖЦ-ийн бэлтгэл хангагдмагц Хиагт дахь хятад цэргийн эрхтэнүүдэд хотыг байлдаангүйгээр өгөхийг тулган шаардсан бичгийг урьд тохирсон ёсоор Троицкосавск дахь ЗОУ-ын Гадаад хэргийн ардын комиссариатын төлөөлөгч О.И. Макстеникээр дамжуулан 3 дугаар сарын 17-нд өгчээ. Хятадын цэргийн командлал тулган шаардах бичигт хариу өгөөгүй тул Монгол Ардын бүх цэргийн штабаас “...Хиагт хотыг 18-ны өглөө байлдаар орж эзлэн авах” тушаалыг Бүгд ерөнхийлөн захирах жанжин Д.Сүхбаатар, дэд жанжин Л.Сумъяа нарт өгчээ.

АЖЦ 400 орчим хүнтэй байсан ба тэдний эсрэг 2000-аад хятад цэрэг хот ба түүний ойр орчимд байрлаж байжээ. Хиагтыг чөлөөлөх байлдааны ажиллагаа өглөөний 9 цагийн үед хятад цэргийн харуулыг дайран довтолсоноор эхэлжээ. Маргааш өдөр нь АЖЦ Хиагтыг эзэлснээр эх орноо чөлөөлөх тэмцэлдээ анхны ялалт байгуулсан юм. Ийнхүү Хиагтын ялалтаар 1921 оны хувьсгал эхлэв.

Засгийн газрын 1921 оны 3 дугаар сарын эцсээр хуралдсан хурлаас Алтайн урианхай хошууд, Ховдын хязгаар, Дөрвөд аймгийг хамарсан баруун хязгаарт цагаантны эсрэг тэмцэлд ард түмнийг зохион байгуулах үүрэг бүхий бүрэн эрхт төлөөлөгчид Ц.Хасбаатар, Ц.Дамбадорж нарыг томилон С.Нацов, Өлзийханд нарын хамт илгээжээ. Энэ нь эх орноо чөлөөлөх тэмцлийн бааз суурийг өргөтгөх, МАЖЦ-ийн шинэ хороо, анги байгуулахад чухал нөхцөл болов.

1921 оны 5, 8-9 дүгээр сард баруун хязгаар болон Хөвсгөлийн Дархадад цэрэг элсүүлэн журамт цэргийн ангиудыг үүсгэн байгуулснаар эх орноо чөлөөлөх тэмцлийн хүрээ хязгаарыг тэлэн цэрэг хүчнийг зузаатгаж чадсан юм. МАЖЦ-ийн эгнээг цаашид өргөтгөн бэхжүүлэх, нэр хүндийг дээшлүүлэхэд Улиастайд Хатанбаатар Магсаржавын удирдан суусан монгол цэрэг хувьсан, ардын засгийн талд шилжин орсон явдал чухлаар нөлөөлөв. АТЗГ, МАН-аас цагаантныг дагалдан явсан монголчуудыг тэднээс салган авч цэргийнхээ эгнээг бэхжүүлэхийг зорьж

ухуулга сурталчилгааны багагүй ажил зохиосны дүнд монголчууд цагаантнаас ангижран салах үйл явц эхэлжээ.

Хиагтыг чөлөөлснөөр АТЗГ-аас Монгол орны энд тэнд орогнож ард олныг түйвээн, монголчуудыг өөр хооронд нь тэмцэлдүүлэх хорт бодлогыг баримталсан цагаантны хүчийг устган эх орноо чөлөөлөх амаргүй зорилтыг шийдвэрлэх бололцоо нөхцөл бүрджээ.

Унгерн 1921 оны 5 дугаар сарын 22-нд Нийслэл Хүрээнээс ЗОУ-ын эсрэг эхэлсэн довтолгооны гол чиглэлийг Хиагт-Троицкосавскаар сонгон авч давших цэргийг биечлэн удирджээ. Түүний удирдлагад байсан Баяр гүний цэрэг гол хүчний түрүүнд ирж АЖЦ-тэй байлдсан ч ялагджээ. ЗОУ-ын хил рүү довтолсон Унгерний довтолгоог Улаан армийн болон АЖЦ-ийн ангиуд няцаав.

Нийтийн дайсан цагаантны эсрэг тэмцэлд улаан цэргийн хүчийг оролцуулах тухай 1921 оны 6 дугаар сарын 16-нд ОК(б)Н-ын Төв Хорооноос гаргасан шийдвэрийн дагуу 6 дугаар сарын 28-нд “Аялан байлдах корпус”-ын цэргийн түрүүч Монголд орж иржээ. Чухам энэ үеэс цагаантны эсрэг хийх тэмцлийг монгол, зөвлөлтийн цэргийн хамтын хүчээр гүйцэтгэх болсон бөгөөд тэдний өмнө дэвшигдсэн эн тэргүүний зорилт нь Нийслэл Хүрээг чөлөөлж засгийн эрхийг АТЗГ, хувьсгалт хүчний гарт шилжүүлэх явдал байв.

Аялан байлдах ангийн гол хүчний цуваа 1921 оны 6 сарын 30-нд Алтанбулагаас хөдөлж 7 дугаар сарын 8-нд Нийслэл Хүрээнд хүрэлцэн очжээ. Үүнээс 2 хоногийн өмнө 7 дугаар сарын 6-нд их цэргийн тэргүүн ангиуд Хүрээг эзлэн утасны хороо зэрэг чухал газруудыг өөрийн мэдэлд авсан байна.

1921 оны 7 дугаар сарын 9-нд Намын Төв Хорооны өргөтгөсөн хурал болж Засгийн бүх эрхийг АТЗГ-т шилжүүлэхээр шийдвэрлэж маргааш өдөр нь Богдын засгийн газрын таван яамны тамга хэргийг хураан авчээ. Монгол ардын байнгын Засгийн газрыг 1921 оны 7 дугаар сарын 10-нд байгуулахад Цэргийн яамны тэргүүн сайд бөгөөд Бүх цэргийн жанжинд Д.Сүхбаатар, дэд сайдад Хатанбаатар ван С.Магсаржав, эрхэлсэн түшмэлд бэйс Гомбо-Идшин нарыг тус тус томилж шинэ Монгол улсын Цэргийн яамыг анх байгуулжээ¹.

Богдыг 1921 оны 7 дугаар сарын 11-нд Хүрээний Төв ордонд залж хэмжээт эрхт хаанд өргөмжлөн оны цолыг хэвээр хэрэглэж Ардын эрхтэй хэмжээт цаазат улсын засгийг явуулахаар тогтон олон нийтийн баяр цуглаан хийсэн байна.

Монгол оронд үндэсний ардчилсан хувьсгал ялав.

§ 1.3. Эх орноо цагаантнаас бүрэн чөлөөлөхийн төлөө АЖЦ-ийн явуулсан байлдаан

Нийслэл Хүрээг чөлөөлсний дараагаар Монгол орны төв хэсгийг чөлөөлөх тэмцэл үргэлжлэв. Стратегийн чухал байрлал болох Вангийн хүрээг чөлөөлөх зорилгын үүднээс Сэлэнгэ мөрний савд үүрлэн байсан цагаантны хүчийг Монгол, Оросын цэрэг бут цохин, гол гол баазыг эзлэн авсан Дух нарсны тулалдаанд Унгерний дивизийн бүрэлдэхүүн ихээхэн хорогдож, цэргүүд нь сэтгэл санааны уналтанд орж сарнин бутрах эх үүсвэр тавигджээ. Цагаантнууд ЗОУ-ын нутаг нэвтрэн орсон ч улаан цэрэгт цохигдож Монголын нутаг руу ухрав. Тэднийг АЖЦ, улаан армийн ангиуд угтан байлдаж их хохирол учруулсан бөгөөд сарниж бутарсан цагаантнууд Манжуурыг чиглэн явжээ. Гэвч замдаа АЖЦ-ийн ангид цохигдож, цөөн тооны үлдэгдэл цэрэг Дорнод хятадын төмөр зам хүрч амь хоргоджээ. Барон Унгерн

ч өөрийнх нь харьяанд байсан Сундуй гүний цэргүүдэд 1921 оны 8 дугаар сард баригдсан бөгөөд түүнийг ЗОУ-ын талд шилжүүлэн өгчээ.

Монгол орны төв хэсгийг цагаантнаас чөлөөлсний дараагаар байлдааны ажиллагаа зүүн хязгаарт шилжив. АЗГ-аас зүүн хязгаарыг батлан тохиуулах цэргийг захирах сайдаар М.Дугаржавыг, түүний хамт хөдлөх 200-гаад цэрэг бүхий хорооны даргад Г.Бумцэндийг тус тус томилон 1921 оны 7 дугаар сарын 17-нд мордуулжээ. Мөн АЗГ-т захирагдсан Дугар бэйс, Балжинням нарын отрядыг нэгтгэн тусгай морьт бригад болгон даргад нь сайд М.Дугаржавыг, туслахаар нь 1 дүгээр хорооны дарга Нутугаев нарыг томилох зэрэг арга хэмжээ авчээ.

Зүүн хязгаарыг чөлөөлөх АЖЦ-ийн байлдааны ажиллагаа 1921 оны зуны сүүл сард Молцог элс хавиар довтолсон Жодовжав амбаны цэргийг эсэргүүцэн цохих явдлаар эхэлжээ. АЖЦ-ийн энэ хорооноос зүүн хязгаарт хийсэн 2 дахь удаагийн байлдаан нь Найдан вангийн цэргийг хөөж устгасан явдал юм. Хоёр худаг, Хоёр тээг, Тээгийн сүм зэрэг газраар Найданжавынхныг хөөж хамгийн сүүлд улсын хилийн орчим байдаг Шивээлж ууланд ширүүн байлдаан хийж бутцохив. Найданжав ван 30 шахам хүнтэй хил давжээ. Энэ завсар 1921 оны 7 дугаар сарын 17-нд дорнод хязгаарын гол төв Санбэйсийн хүрээг АДБНУ-ын АХЦ, монгол цэргийн хамтын хүчээр чөлөөлөв.

1921 оны 9 дүгээр сараас М.Дугаржав, Г.Бумцэнд нарын цэрэг цагаантны үлдэгдлүүдтэй байлдав. Островскийн бүлэг цагаантаныг мөрдөн хөөж зам зуур нэлээдийг устгаж, Баруун тосон зүгт зугтан явсныг Бухын хашаатын худаг хэмээх газар гүйцэн цохьжээ. Улмаар дайсан этгээд АЖЦ-ийн ар хударгаар орж Тамсагийг чиглэсэн үед Дугаржав, Бумцэнд нар нэхэн байлдаж 200-ыг нь устгаж, 30 км зайд орших Шар шороотод нутгийн олны тусламжтайгаар бүрмөсөн бутцохисноор Островский цөөн цэргийн хамт Монголын хилийг даван гарчээ. Мөн 1921 оны 9 дүгээр сард АЖЦ-ийн ангиуд нутгийн төв хэсэгт бутцохиулж хүн хүчний хувьд нэлээд сульдсан Хоботовын цагаантнуудыг байлдан устгасан байна.

Монголын зүүн хэсгийг чөлөөлсний дараа байлдааны ажиллагааны гол талбар баруун хязгаар болов. Энэ үед Монголын баруун хязгаарын байдал ихээхэн хүнд байлаа. Тэнд уулын Алтайн орос ба орос бус үндэстнүүдээс бүрдсэн 700 гаруй хүнтэй есаул Кайгородовын отрядаас¹ гадна бут цохигдон сарнисан цагаантны үлдэгдлүүд бөөгнөрөн ард олныг түйвээн сүйтгэж байжээ. Мөн Шар сүмийн зүгээс генерал Бакичийн цэрэг дөхөж яваа мэдээ ирсэн нь байдлыг улам ч түгшүүртэй болгожээ.

Кайгородовын цэргийг оруулахгүй хаахын тулд V армийн ХЦЗ-өөс баруун хязгаар дахь АЖЦ-ийн отрядад К.К.Байкаловын отрядыг туслах хүчнээр илгээжээ. Отрядын бүрэлдэхүүнд бүгд 320 цэрэг байв¹. Энэ үед Ц.Хасбаатар, Ц.Дамбадорж нар 130 гаруй хүнтэй монгол цэргийн ангийг эмхлэн бүрдүүлсэн байв.

Дөрвөн зуун тавиад хүнтэй монгол, оросын цэрэг Кайгородовын отрядыг 1921 оны 6 дугаар сарын дундаас 7 дугаар сарын сүүл үе хүртэл нэхэн байлдаж хэд хэдэн удаа бут цохин хүчийг сарниулжээ. Ц.Хасбаатар, К.К.Байкалов нар 1921 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр Саруул гүний хүрээг эзлэн авч Кайгородовынхныг зайлуулжээ. Гэвч Төв засгийн газраасаа хэт алслагдсаны улмаас хүн хүч, зэвсэг хэрэглэлийн тусламж авах боломжгүй бөгөөд хил орчмын улаан цэргийн ангиудтай

холбоо тасрах аюулд орсон тэднийг цагаантан 1000-1500 орчим хүнтэй нэгдсэн хүчээр бүслэв.

Чухам энэ үеэс Монгол цэргийн түүхэнд “Толбо нуурын бүслэлт” хэмээн алдаршсан хориглолт эхэлжээ. Дайсны давуу хүчний эсрэг гэнэтийн дайралт хийх боломжгүй болсон нөхцөлд Ц.Дамбадорж, К.К.Байкалов нар улаан цэргийн ангид хэл хүргэж тусламж авахыг зорьж казахын хошуунаас цэрэгт элссэн хоёр хүнийг илгээжээ. Тэд нутгийн олны тусламжтайгаар зорьсон хэргээ биелүүлсний дүнд Хөшөө модноос улаан цэргийн дайчид бүслэлтийн 42 дахь хоног дээр хүрэлцэн ирж цагаантныг хөөн Саруул гүний хүрээг чөлөөлжээ.

Монголын баруун хязгаарыг цагаантнаас бүрэн цэвэрлэж дуусахад цагаантны сарнимал хүч цугласан Ховдын районыг чөлөөлөх явдал ээлжит зорилт болов. АЗГ, МАН-аас Ховдын хязгаарыг цагаантнаас түргэн хугацаанд бүрэн цэвэрлэх үүргийг Цэргийн яамны дэд сайд Хатанбаатар Магсаржавт даалгажээ. Улиастайд Вандановын цагаантныг устгаж монгол цэргийн удирдлагыг гартаа авсан С.Магсаржав 7-8 дугаар сарын туршид Казанцев, Казаграндын цагаантны эсрэг байлдан Заяын хүрээ, Жалханзын хүрээг тус тус чөлөөлөв.

Энэ үед генерал Бакич, Казанцев нарын 500 цэрэг умар зүг ЗОУ-ын нутагт орохоор Торхлог хандгай, Улаангомын хүрээг дайран Тагна урианхайг чиглэн явах замдаа улаан цэргийн ангитай тулгаран байлдаж зугтжээ. Хурандаа Сокольницкийн удирдсан цагаантнууд хятадын нутагт нэвтрэхээр Ховдын Булган голыг чиглэн зугтсаныг С.Магсаржавын цэрэг Толбо нуураас урагш нэхэн байлдаж Хятадын нутагт хөөн оруулсан байна.

Ховдын хязгаарт болсон байлдааны ажиллагааны эцэст Тагна урианхайд бут цохиулан 500-гаад хүнээ алдсан генерал Бакичийг Улаангомын хүрээ чиглэн ухрахад нь Хатанбаатар Магсаржавын их цэрэг буулган авчээ. Ийнхүү гамин, цагаантнаас эх орноо чөлөөлөхийн төлөө МАЖЦ-ийн хийсэн байлдааны ажиллагаа 1921 оны эцсээр үндсэндээ дуусчээ.

МАЖЦ эх орноо чөлөөлөх явцдаа дангаараа болон Зөвлөлт Оросын улаан цэрэгтэй хүчин хавсрах, орон нутгийн баг цэргийн ба хязгаарын монгол цэргийн хүч дэмжлэгтэйгээр 200 орчим байлдаан хийж ялалт авчирсан юм.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХУВЬСГАЛТ ОЛОЛТЫГ ХАМГААЛЖ, АРДЫН ХУВЬСГАЛТ ЦЭРГИЙГ БЭХЖҮҮЛСЭН НЬ (1921 ОНЫ 7 ДУГААР САР-1924 ОН)

§ 2.1. Ардын засгаас Ардын журамт цэргийг бэхжүүлэх талаар авсан арга хэмжээ

1921 оны 9 дугаар сарын 11-13-нд НТХ, Цэргийн Зөвлөлийн гишүүдийн хамтарсан хурлаас Монгол орны эдийн засгийн хэвшил, шинэ төрийн хүч бололцоонд зохицуулан “амар түвшин цагт цэргийн тоог цагийн байдалд нийцүүлэн цөөхөн байлгаж, дайн болох тухайд харьяат улсын хязгаарыг хамгаалж чадахаар цэргийн хүмүүсийн тоо ба зэвсэгт цэргийн сүрийг бардаагаар хэрэглэж болохоор сурган бэлтгэх...”¹, өөрөөр хэлбэл цөөн тооны хүчирхэг цэрэгтэй байхаар тогтжээ. Ингэхдээ “...тусгаар тогтносон улсуудын зарчмыг харгалзахыг” заасан нь монгол цэргийг европын ёсны жишгээр байгуулахыг нэгэн адил илэрхийлсэн хэрэг юм.

Цэргийн эгнээг өргөтгөх асуудлыг АЗГ, Цэргийн яамнаас онц чухалчлан үзэж 1921 оны 7 дугаар сард анхны дайчилгааг зарлажээ. БЦЗ-ийн тушаалын дагуу цэргийн хуучин зохион байгуулалтыг өөрчлөн бригад, хороо, суман, салаагаар шинэчлэх ажил эхэлсэн бөгөөд 1921 оны 8 дугаар сараас Нийслэл Хүрээнд морьт бригад байгуулав.

1924 он гэхэд манай улсын цэрэг нь хязгаарын цэргийн 4 хороо, 2 дивизион, Нийслэл Хүрээнд 1 дүгээр морьт бригад, пулемёт ба их бууны хороо, даргын сургуулиас бүрдэх болжээ. Ийнхүү ардын эрхтэй хэмжээт цаазат Монгол улсын цэрэгт байнгын цэргийн зарчим нэвтэрч эхэлсэн бөгөөд бүх цэргийг нь төвийн, хязгаарын гэсэн хоёр үндсэн хэсэгт хувааж байв.

Түүний бүрэлдэхүүнд пулемет, их буу, холбоо, авто тээврийн зэрэг төрөл, мэргэжлийн салбарууд багтаж байсны дээр хязгаарын цэргийг анги хуваан суулгав. Хязгаарын цэрэг нь 1924 он гэхэд Баянтүмэн, Тамсагбулаг, Дарьганга, Ховдод байрласан 4 хороо, 2 дивизионоос бүрдэж байв.

Тухайн цагт авч хэрэгжүүлсэн гол арга хэмжээний нэг нь даргалах бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх явдал байв. 1923-1924 оны хичээлийн жилд Их даргын сургуулийг “Бүх цэргийн ерөнхий сургууль” болгон өргөжүүлжээ. Зохион байгуулалтын хувьд Бүх цэргийн ерөнхий сургууль нь захиргаа, бичиг хэрэг, сурах анги, хүн ба мал эмнэлэг, морин сургуулийн, их бууны анги, холимог суман, намын сургуулийн анги, холбооны сургууль гэсэн бүтэцтэй байв.

Цэргийн даргалах боловсон хүчнийг бэлтгэх хоёр дахь зам нь монгол дарга нарыг ЗОУ-д илгээн сургах явдал байв. Анх 1921 оны намар Д.Сүхбаатарын хүсэлтээр Равдан, Мончгоо, Бямба, Аюушжав нарын монгол цэргийн 4 даргыг улаан цэргийн даргын курст суралцуулахаар Эрхүү хотноо илгээснээр ЗОУ-ын сургуулиудаар цэргийн боловсон хүчин бэлтгэх ажил эхэлжээ. ЗОУ-ын цэргийн академид анх 1923 оноос нэг жилийн хугацаагаар Х.Чойбалсан, С.Цэрэнгомбо, М.Бямбаев нарыг сургажээ.

Удирдах боловсон хүчнийг сурган бэлтгэхийн хамт цэрэг дайчдыг сургах ажлыг нэгэн зэрэг хийж байсан юм. Уг ажлыг 1921 оны 5 дугаар сарын 16-нд “Ардын цэргийн сурган боловсруулах хэлтэс” нэртэйгээр байгуулагдан улмаар “Цэрэг, ардыг сурган боловсруулах хэлтэс” болсон бөгөөд цэрэг, ардыг сурган гэгээрүүлэх, бичиг үсэгт сургах, намын үзэл суртлыг нэвтрүүлэх зэрэг үүрэгт ажлыг гүйцэтгэж байжээ.

Цэргийн сургалт, хүмүүжлийн ажлыг сайжруулахад тус хэлтсээс 1923 онд гаргасан “Уриа сонин”, мөн 1924 оны 2 дугаар сарын 5-наас эхлэн гарах болсон “Ардын цэрэг” сонин ихээхэн ач холбогдолтой болов. Сонины нийтлэлийн гол зорилго нь ардын цэргийг улс төрийн байдал ба суртал, тухайн үеийн арга хэмжээ, ажилтай танилцуулахад оршиж байлаа. 1921 оны 12 дугаар сарын 30-ны НТХ-ны 15 дугаар хурлаар цэргийн анги, нэгтгэл дотор намын үүр байгуулах асуудлыг хэлэлцсэн бөгөөд 1922 онд цэргийн намын үүр 2, 1923 онд 6, дараа жилд МАХЦ-ийн хэмжээгээр 10 намын үүрт 1549 гишүүн харьяалагдаж байв.

Үүний хамт улаан цэргийн олон төрлийн дүрэм хэмжээг орчуулан нийтлэх, тэдгээрээс үлгэр авах зэргээр МАХЦ-ийн үндсэн гол дүрмүүдийг 1924-1925 онд боловсруулан мөрдүүлсэн нь цэргийн зохион байгуулалтыг бэхжүүлэх, цэргийн

байлдах хүчин чадварыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг төгөлдөржүүлэхэд чухал ач холбогдолтой болжээ.

Улсыг батлан хамгаалах хэрэгт олон түмнийг өргөнөөр оролцуулах зорилгоор цэрэгжлийн сургуулийг хөдөө орон нутагт богино хугацаагаар зохиож байв. Уг сургуулийг зуны цагт аймаг, хошуудын төвд богино хугацаагаар явуулж явган жагсаал хийх, винтов, сэлэм зэрэг зэвсгийн бие ангийг судлах, буудлага хийх зэрэг цэргийн эрдмийн анхны мэдэгдэхүүн олгож байжээ.

Мөн энэ үед цэргийн ар талын байгууллага үүсэн байгуулагдаж цэргийн хүнс, хувцас, орон байрны асуудлыг хариуцаж байсны дээр цэргийн эмнэлэг байгуулагджээ.

Ардын төр, цэргийн удирдлагаас өөрийн орны онцлог байдал, эдийн засгийн хүчин чадавхийг харгалзан үзсэний үндсэн дээр хэсэгчилсэн дайчилгааны замаар цэргийн эгнээг өргөтгөн бэхжүүлэх зорилтыг 1921-1924 онд амжилттай шийдвэрлэсэн бөгөөд улмаар цэргийг бүтэц бүрэлдэхүүний хувьд шинэ зарчмаар хөгжих нөхцөлийг буй болгожээ.

§ 2.2. Монгол, Оросын цэрэг-улс төрийн холбоо, үүсэл, хөгжил

Газар зүйн байрлалын хувьд хоёр том гүрний хүрээлэл дунд орших Монголд өөрийг нь эзлэн түрэмгийлэхийг хэзээнээс санаархагч өмнөд хөрш Хятадын цэргийн эрхшээлээс гарахын тулд хойд хөрш ЗОУ-д хандахаас өөр ашигтай хувилбар байгаагүй юм. Үүний хамт ЗОУ Монголд туслах асуудлыг аюулгүй байдлаа хангах зорилттой холбон үзэж байжээ. Мөн ЗОУ-ын хувьд Монголын нутаг дэвсгэрээс цагаантны заналхийллийг арилгах нь хойшлуулшгүй зорилт байв.

Түүнчлэн АТЗГ Хиагтын тулааны өмнөхөн буюу 1921 оны 3 дугаар сарын 16-нд цагаантныг устгах хэрэгт цэргийн тусламж үзүүлж хамтран тэмцэхийг ЗОУ-д хандан уриалсан нот бичгийг илгээж байв. Хөрш зэргэлдээ орнуудын аль алиных нь эрх ашгаас үүдэн гарсан энэхүү хүсэлтийг ЗОУ хүлээн авч тусламж үзүүлэх үүргийг дорнод фронтын V армид өгчээ. ОК(б)Н-ын ТХ-ны Улс Төрийн Товчооны 1921 оны 6 дугаар сарын 16-нд хуралдсан хурлаас Монголд цэрэг оруулах шийдвэр гарч, Улаан цэргийн командлалд өгөх удирдамжийг баталжээ.

Монголд цэрэг оруулах тухай Зөвлөлт Засгийн газрын албан ёсны шийдвэр гарч тушаал ёсоор Эрхүүд байсан V армийн бүрэлдэхүүнээс Унгерний эсрэг тэмцэлд оролцох “Аялан байлдах корпус”-ыг эмхлэн байгуулав. Корпусын бүрэлдэхүүнд буучийн 35 дугаар дивиз, Кубанийн 5 дугаар морьт дивиз, АДБНУ-ын Ардын хувьсгалт армийн Сретенскийн 2 дугаар морьт бригад, П.Е.Щетинкиний тусгай отрядын багтааж, захирагчаар буучийн 35 дугаар дивизийн дарга К.А.Нейманыг томилсон байв. Үүнээс гадна Монголын баруун хязгаарт К.К.Байкаловын удирдсан 22 дугаар тусгай отряд буюу Ховдын оперативын бүлэг үйл ажиллагаагаа зохицуулан ажиллах ёстой байв. Корпусын цэргийн нийт тоо 13000 орчим цэрэг, түүнээс 7600 нь явган, 2500 нь морьт цэрэг, хөнгөн их буу 20, хуягт отряд, байлдааны машин 2 ба нисэх хүч (тагнуулын онгоц 4)-нээс бүрдэж байжээ¹.

Аялан байлдах корпусын ангиудын түрүүч 1921 оны 6 дугаар сарын 28-нд Монголын хилд орсон байна. Хоёр орны Засгийн газрын албан ёсны шийдвэрт үндэслэсэн Монгол, Зөвлөлтийн цэргийн байлдааны ажиллагаа Нийслэл Хүрээг чөлөөлөхөөс эхлэв. Үүний дараагаар цэргийн хамтын тэмцлийг цаашид

үргэлжлүүлэх тухай асуудал нь Монгол АЗГ-аас 1921 оны 7 дугаар сарын 12-нд ЗОУ-ын Засгийн газарт хандаж нийтийн дайсны заналхийллийг бүрэн арилгах хүртэл улаан армийн ангиудыг Монгол улсын нутгаас гаргахгүй байхыг хүссэн албан ёсны хүсэлт ба түүний хариу болгон ирүүлсэн Зөвлөлийн засагт Орос улсын Гадаад хэргийн ардын комиссар Г.В.Чичериний нот бичгийн дагуу шийдэгдсэн байна. Энэ ёсоор 1921 оны 2 дугаар хагаст МАЖЦ ба Улаан армийн ангиуд цагаантныг устгаж Монгол орныг чөлөөлсөн билээ.

1921 онд Монгол орныг цагаантнаас чөлөөлөх олон арван байлдаанд улаан цэргийн нийт 13 мянга гаруй цэрэг, дарга оролцож, Монгол-Оросын цэргийн хамтын хүчээр цагаантны эсрэг болсон байлдаан тулааны гуравны нэгийг хийсэн аж¹. “Аялан байлдах корпус” байлдааны үндсэн үүргээ биелүүлж нутаг буцсаны дараагаар Монголд үлдсэн анги, хороод нь тус орны гадаад дотоод байдал тэгшрээгүй нөхцөлд туслан хамгаалах үүрэг хүлээн түр хугацаагаар байрлаж байсан юм.

Монгол, Оросын цэрэг-улс төрийн холбоо нь ЗОУ-ын зүгээс МАЖЦ-т сургагч боловсон хүчний ба зэвсэг техникийн тусламж үзүүлсэн явдлыг нэгэн адил хамарч байна. МАЖЦ-т туслалцах сургагчдын анхны том хэсэг 1921 оны 3 дугаар сард иржээ. Үүний дараагаар мөн оны 5 дугаар сард Халимагийн 5 дугаар морьт хорооны дарга нар болох Х.Б.Кануков даргатай 20 хүний бүрэлдэхүүнтэй хэсэг иржээ¹. Сургагч урин ажиллуулах нь цаашид ч үргэлжилж байсан бөгөөд тэд МАЖЦ-ийн бүтэц, зохион байгуулалтыг тус орны онцлог, байгаль цаг уурын нөхцөлд тохируулан хөгжүүлэх, цэргийн урлагийн үндсийг боловсруулах, дүрмүүд бэлтгэн гаргах, цэргийн албыг зохион байгуулах, зэвсэг техник эзэмшүүлэх хэрэгт оролцон ажиллахын зэрэгцээгээр боловсон хүчин бэлтгэх, дарга нарыг сургахад багагүй үүрэг гүйцэтгэжээ.

Монгол, Зөвлөлтийн цэргийн хамтын ажиллагааны хүрээнд багтах өөр нэгэн асуудал бол улс орноо чөлөөлөх тэмцэлдээ АЖЦ ЗОУ-аас зэвсэг-техникийн тусламж авсан явдал болно. АЖЦ-ийг зэвсгээр хангах үүргийг V арми болон АДБНУ-ын цэрэг хүлээж байв. Тусламжийн зэвсгийн анхны хэсэг болох морьт цэргийн винтов 750, сум 150 мянга шахам, бусад хөнгөн ба хүнд пулемёт, гар бөмбөгийг 1921 оны 2 дугаар сард АЖЦ хүлээн авчээ¹.

1921 оны хувьд ЗОУ-аас АЖЦ-т нийлүүлсэн зэвсгийн ихэнхийг тусламжийн хэлбэрээр өгчээ. Мөн түүнчлэн 1921 оны 11 дүгээр сарын 5-нд байгуулсан Монгол, Зөвлөлтийн найрамдлын гэрээ, түүнд хамаарах протоколын дагуу 3000 морьт цэргийг хангах зэвсэглэл, галт хэрэгслийг МАЗГ-т үнэ төлбөргүй шилжүүлэхээр болсон байна. МАЖЦ-ийг зэвсгээр хангах асуудлыг 1923 оноос эхлэн хэлэлцээрийн үндсэн дээр шийдвэрлэх болжээ.

Монгол, Оросын цэрэг-улс төрийн холбоо нь монголчуудын хувьд үндэсний тусгаар тогтнолоо олох, эх орноо чөлөөлөх АЖЦ-ийн тэмцлийн ялалтыг түргэтгэх хүчин зүйлүүдийн нэг болсноор чухал ач холбогдолтой юм.

Төр засгаас АЖЦ-ийг цаашид бэхжүүлэн хөгжүүлэх талаар дэс дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлснээр улс орны эдийн засгийн хүч бололцоог харгалзсан, цөөн тооны бие бүрэлдэхүүнтэй, зэвсэглэл сайтай, чадварлаг, улмаар зохион байгуулалтын тодорхой бүтэцтэй, түүндээ тохирсон зэвсэглэл, бие бүрэлдэхүүнтэй, цэрэг татах, цэргийн алба хаах тогтсон журамтай болж дарга, цэргийг сургах

сургалтын болон хангалтын тогтолцоог бүрдүүлж ар тал, хангалтын байгууллагуудыг байгуулж чаджээ. Цэргийн сахилга, дэг журмыг тогтоон бэхжүүлэх талаар ч багагүй зүйлийг хийсэн байна.

Энэ бүхний дүнд Монголын ард түмний эрх ашиг, тусгаар тогтнолын манаа болсон байнгын цэргийн суурь, үндэс тавигдаж эхэлсэн байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ ЦЭРЭГ БАЙНГЫН ЦЭРЭГ БОЛЖ ХӨГЖСӨН НЬ

(1925-1932 ОН)

§ 3.1. Монгол Улсын гадаад, дотоод байдал

Алс Дорнодод Орос, Япон, Хятад зэрэг улсын ашиг сонирхол төвлөрөхийн хамт хоорондоо зөрчилдөж, нөлөөний хүрээгээ тэлэхийг эрмэлзэх болжээ. Түүний хамт Коминтерний зүгээс энэ бүс нутагт социалист хувьсгалыг түгээн дэлгэрүүлэх бодлогоо хэрэгжүүлэхийг эрмэлзэж байв. Энэхүү улс төрийн ээдрээтэй нөхцөл байдалд Монгол Улс ямар нэг байдлаар татагдан орж байсан юм.

Хятадын Гоминдан нам Манжуур, Шинжаан, Ар Монголыг Хятадын засаг захиргаанд нэгтгэх явдлыг үндсний зорилт болгожээ. 1931 онд баталсан Хятадын түр Үндсэн хуулиар хан, монгол, уйгар, төвөд үндэстнийг Хятадын тулгуурууд хэмээн тодорхойлж, Чан Кайши БНМАУ-ыг өөртөө нэгтгэх бодлого явуулж байв. Энэ үеэс Япон улсын зүгээс Манжуурын талаарх үйл ажиллагаа идэвхжиж улмаар 1932 оны 2 дугаар сард Манжуурыг Өвөр Монгол, Баргын зүүн хойд хэсэгтэй эзлэн авчээ. Япончууд Манжуурыг эзлэн авсныхаа дараа 1932 оны 3 дугаар сарын 1-нд Манж го улсыг байгуулсаныг зарлаж, тэргүүлэгчээр нь Пу И-г томилсон байна.

Ийнхүү Хятадын аюулаас гадна Манжуурт Японы нөлөө тогтсон явдал нь БНМАУ-ын гадаад байдлыг түгшүүртэй болгов. Нам, төрийн эрх баригчид Хятад, Японы аюул заналаас сэргийлэх явдлыг эн тэргүүнд тавьж эхэлсэн байна.

Энэ цаг үед БНМАУ-ын дотоод улс төрийн амьдрал ч ээдрээтэй байв. Тухайн үеийн нам, төрийн эрх баригчид үндэсний ардчилсан чиг шугам баримталж, ганц ЗХУ-тай бус гадаадын, түүний дотор өрнөдийн орнуудтай харилцаагаа өргөжүүлэх байр суурь баримталж байсныг “баруунтан” хэмээн тодорхойлох болж улмаар улс төрийн тавцангаас шахан зайлуулав.

Тэдний оронд Коминтерний итгэлийг хүлээсэн, тэдний зааврыг үг дуугүй дагадаг бүлэглэлийнхнийг нам, төрийн эрхэнд томилсон бөгөөд тэднийг “зүүнтэн” хэмээн нэрлэх болжээ. Тэрхүү зүүнтнүүд нам, төрийн эрх мэдлийг гартаа авснаар нам, төрийн баримталж буй бодлого, үйл ажиллагаанд алдаа гарч эхлэв. Тэд ангийн бодлогыг гүнзгийрүүлж лам нар болон ноёд түшмэдийг хувьсгалын эсэргүү анги гэж үзэх болж “хувьсгалын эсэргүү анги болох харгис этгээдийг тэмцэн устгах”¹-ыг төрийн бодлогын хэмжээнд дэвшүүлэн тавих болов.

Төр, засгийн бодлогыг эсэргүүцсэн ард олны эсэргүүцэл хурц хэлбэрээр илэрч Чандмань уулын аймгийн Баянчандмань уулын хошууны Улаангомьын хүрээ, Төгсбуянт уулын хошуунд 1930 оны хавар, баруун аймгуудад 1932 оны хавар зэвсэгт бослого гаосан нь монгол орны нийгмийн амьдрал гүн гүнзгий хчмралд орсны илэрхийлэл байв. Эдгээр бослогыг цэргийн хүчээр даржээ.

§ 3.2. Батлан хамгаалах хүчийг бэхжүүлж байнгын цэрэг байгуулсан нь

БНМАУ-ын гадаад, дотоод байдал 1925 он гэхэд бэхжиж, улмаар Монголд байсан Зөвлөлтийн цэргийн ангиуд нутаг буцав. Ардын засгийн газраас ардын журамт цэргийг бэхжүүлэн түүний суурин дээр байнгын цэрэг болгон зохион байгуулахдаа эртний уламжлалаа хадгалсан морьт цэргийг үндсэн төрлийн цэрэг болгох бодлого баримталж байв. Байнгын цэрэг байгуулахдаа Зөвлөлтийн улаан армийн туршлагыг харгалзан үзсэн бөгөөд хориод оны дунд үеэс МАХЦ нь үндсэн ба нутгийн цэрэгт хуваагдаж байв.

МАХЦ нь 1925 оны байдлаар Улаанбаатарт Цэргийн ерөнхий сургууль, 1 дүгээр морьт бригад, их бууны хороо, уурын тэрэгний хороо, хязгаарт 1 тусгай морьт хороо, хоёр тусгай морьт дивизион, 5 тусгай морьт сумангаас бүрдэж байв¹.

Тухайн үед ангийн талаар баримталж ирсэн бодлого нь тус улсын батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх, МАХЦ-ийн бие бүрэлдэхүүнийг нөхөн хангах явдалд багагүй бэрхшээл учруулж байв. Төр, засгаас МАХЦ-ийг бэхжүүлж улсыг батлан хамгаалах хэрэгт олон түмнийг оролцуулах зорилгоор 1926 оноос нутгийн цэргийн ангиуд байгуулжээ.

МАХЦ-т шинээр хуягт, танк, нисэх зэрэг төрөл, мэргэжлийн ангиуд байгуулагдаж, 1 дүгээр морьт бригадын суурин дээр 1 дүгээр морьт дивизийг шинээр байгуулав. Мөн 1932 онд тус бүр хоёр морьт дивиз бүхий морьт корпусууд байгуулав. Ингэснээр МАХЦ нь корпус, дивиз, хороо гэсэн шинэ бүтэц, зохион байгуулалттай болов.

Даргалах бүрэлдэхүүнийг бэлтгэхэд анхаарал тавьж Д.Сүхбаатарын нэрэмжит сургуулийг 1925 онд байгуулсны дээр ЗХУ-д сургах ажил өргөжив. ЦЕС-ийн зохион байгуулалт, сургалтын агуулгыг шинэчлэн өөрчилж улс төр, морин цэрэг, пулемёт, их буу, хуягт тэрэг, танк, холбооны анги ба Сүхбаатарын сургууль, цэргийн техникийн сургуультайгаар өргөтгөжээ. Тус сургуулийг 1932 онд МАХН-ын Төв Хорооны нэрийн сургууль болгосноор сургуулийн материаллаг бааз ихээхэн сайжирч элсэгчдийн тоо нэмэгдэв. Түүнчлэн техникийн бага мэргэжилтэнг бэлтгэх урт, богино хугацааны сургуулиудыг байгуулж эхлэв.

Тухайн үед цэргүүдийг бичиг үсэгт сургах явдал чухал зорилтын нэг болж байсан бөгөөд Улсын III их хурлаас (1926) ардын улаан цэргийн 70 хувийг бичиг үсэгтэй болгох зорилт дэвшүүлэн тавив. Улсын IV их хурлын үеэр (1927) гаргасан тоо мэдээгээр бичиг үсэг мэдэх болсон хүмүүс нь 77 хувь болсон¹ бөгөөд 1928 оны 10 дугаар сар гэхэд энэхүү үзүүлэлт 85 хувь болсон байна¹. Бага дарга, цэргүүдийг бичиг үсэгт сургах ажил МАХЦ-ийн хэмжээнд өргөн далайцтай өрнөж ном давтэр, багшлах боловсон хүчин номын багшаар хангах зэрэг арга хэмжээ авсны үр дүнд бичиг үсэг мэдэх хүмүүсийн эзлэх хувь жил дараалан өсч ирэв. Үүний үр дүнд МАХЦ нь цэрэг, дарга нарыг бичиг үсэгт сургах соёлын томоохон сургууль болж, цэргээс халагдсан бичиг үсэг бүхий олон зуун хүмүүс улс орны хөгжилд дорвитой хувь нэмэр оруулж эхэлсэн юм.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ ЦЭРГИЙН ХӨГЖИЛ, БЭХЖИЛТ, ЦЭРГИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛСЭН НЬ (1932-1939 он)

§ 4.1. Алс Дорнодод дайны голомт үүссэн нь, Монгол Улсын гадаад байдал

Алс Дорнодын цэрэг-улс төрийн байдал гучаад оны эхэн үеэс улам хурцдав.

Япон улс Манжуурыг бүрэн эзэлж авснаар цэрэг-эдийн засгийн хүч чадал нь урьдхаасаа улам өсч шинэ түрэмгийлэл хийх боломж олж авчээ. Манжуурыг эзлэн авсны дараа Квантуны армийн бие бүрэлдэхүүний тоо эрс өсөв.

Япон улс 1936 онд Германтай “Коминтерний эсрэг гэрээ” байгуулсан бөгөөд энэ нь үндсэндээ ЗХУ-ын эсрэг чиглэсэн зүйл байлаа. Японы Жанжин штаб 1938 онд ЗХУ-тай томоохон дайн явуулах төлөвлөгөө боловсруулсан байна.

Тухайн цаг үед Монгол Улс нь Манж Го улстай хиллэж байсан хэдий ч үнэн хэрэгтээ тус улсаар дамжуулан Япон улстай хиллэх болсон гэж үзэж болно. Энэ байдлыг Монголын эрх баригчид тус улсын аюулгүй байдалд заналхийлж буй гол аюул гэж үзэж байв. Монгол Улсын дорнод хил хязгаарын байдал түгшүүртэй болохын зэрэгцээ баруун хилийн байдал тайвангүй болов. Гучаад оны дунд үеэр хилийн чанадаас казахууд зэвсэглэн халдаж нутгийн ард олны мал хөрөнгийг дээрэмдэх, амь насыг нь бүрэлгэх зэргээр хилийн зөрчил байнга гаргах болжээ. Тэрхүү зэвсэгт дээрэмчдийг 1934 оны 9 дүгээр сард цэргийн хүчээр дарж устгажээ.

Япон, Манжийн зүгээс хийх өдөөн хатгалгын цар хүрээ 1935 оноос улам өргөжив. БНМАУ-ын нутаг болох Халхын сүмийг 1935 оны 1 дүгээр сарын 24-ны өдөр япон, манжийн цэргүүд түрэмгийлэн эзэлсэнээр БНМАУ, Манж го улсын хооронд “хилийн будлиан” гэгч үүсэв. Эл асуудлыг шийдэхийн тулд хоёр тал чармайж, “Монгол, Манжуурын бага хурал”-ыг хэд хэдэн удаа хийсэн ч үр дүнд хүрээгүй ажээ.

Гадаад байдал ийнхүү хурцадсантай уялдаж манай Засгийн газрын хүсэлтийн дагуу 1936 оны 6-7 дугаар сард Зөвлөлтийн улаан армийн ангиуд тус улсад ирж байрлажээ. БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд 1936 оны 3 дугаар сарын 12-ны өдөр “Монгол, Зөвлөлтийн харилцан туслалцах протокол” байгуулж гарын үсэг зурав. Тус хоёр улсын хооронд ийнхүү протокол байгуулж гарын үсэг зурсан явдал Алс Дорнодын цэрэг улс төрийн байдалд чухал өөрчлөлт оруулж бүс нутгийн улс орнуудад эерэг, сөрөг нөлөө үзүүлжээ. Монгол-Зөвлөлтийн протокол нь БНМАУ-д Японы Квантуны арми цөмрөн орох тулгамдсан аюулыг зайлуулж, хамгийн гол нь БНМАУ олон улсын харилцааны эрх зүйн субъект гэдгийг харуулав.

Япон улс өөрийнхөө эсрэг эвсэл үүсч буйг үл хайхран түрэмгийлэх бодлогоо шатлан өргөжүүлж, 1937 онд Хятадын эсрэг дайн эхлүүлэв.

§ 4.2. Улс орны батлан хамгаалах хүчнийг бэхжүүлж, цэргийн шинэчлэлийг хэрэгжүүлсэн нь

МАХН-ын Төв Хорооны 1932 онд хуралдсан онц бүгд хурлаас “гадаадаас халдан орох аюул заналаас хамгаалах” явдлыг тус намын гол зорилт болгон “улс орныг батлан хамгаалах явдлыг бэхжүүлэх, ...бат бэх үндэсний цэргийг байгуулах хэрэгт”¹ намын анхаарал бодлогыг чиглүүлэхээр болсон байна. Намаас дэвшүүлсэн зорилгыг хэрэгжүүлж МАХЦ-ийн хүч чадлыг бэхжүүлэн бүтэц, зохион байгуулалтыг нь боловсронгуй болгох талаар шинэчлэлийн шинж чанартай олон арга хэмжээ авав.

1933 онд Улсыг Хамгаалах Зөвлөлийг өөрчлөн СнЗ-ийн дэргэд Улсыг Хамгаалах Комиссыг байгуулсан байна. 1934 онд хамтын удирдлагын байгууллага ХЦЗ-ийг татан буулгав. Цэргийг захирах, улсыг батлан хамгаалах ажлыг ЦЯЯ-ны сайд, Бүх цэргийн жанжнаас эрхлэн гүйцэтгэхээр болсноор МАХЦ-ийн хэмжээнд нэгэн удирдлага тогтов.

МАХЦ-ийн дарга, улс төрийн ажилчдад 1936 оноос *алдар цол* олгох болж даргалах бүрэлдэхүүний алба хаах дүрмийг батлан гаргав. МАХЦ-ийг бие бүрэлдэхүүнээр нөхөн хангахад ангиар ялгаварлах бодлого саад болж байсан бөгөөд цэргийн насны нийт эрэгтэй хүн амын 30 орчим хувийг лам нар эзэлж байсан тул тэднээс цэргийн татвар хураах болов. 1936 оноос цэрэгт нас тэнцсэн сонгуулийн эрхтэй лам нараас цэрэгт татах болсон байна.

Цэргийн төрөл бүрийн мэргэжлийн боловсон хүчнийг дотооддоо ЦЕС, түр хугацааны сургууль, курсээр бэлдэхийн зэрэгцээ ЗХУ-д цэргийн дунд сургууль, академид явуулж сургаж байв. Түүний зэрэгцээ хугацаат албаны бага дарга, цэргүүдээс дэвшүүлж, Зөвлөлтийн сургагч мэргэжилтнийг дагалдуулах зэргээр цэргийн боловсон хүчнийг хангаж байлаа.

1931-1934 онд морин цэрэг, улс төр, хүн, мал эмнэлэг, холбоо, их буу, нисэх, хуягт танкийн мэргэжлээр ЗХУ-д 244 хүн явж суралцсан бөгөөд 1932-1939 онд дээрх мэргэжлээр 482 хүн төгсөж ирсэн байна. Даргалах бүрэлдэхүүнийг сургахад ЦЕС урьдын адил гол үүрэг гүйцэтгэж байв. ЦЕС-ийн үндсэн ангийг 1931-1940 оны хооронд улс төр, сэлэмт, холбоо, их буу, пулемёт, аж ахуй, хуягт зэрэг мэргэжлээр 1176 хүн, давтан курсийг 433 хүн, бүгд 1609 хүн төгсчээ¹.

Түүнчлэн 1933 оноос эхлэн ЦЕС-ийн дэргэд академийн курс байгуулав. Академийн курст Цэргийн яамны газар, хэлтсийн дарга, корпус, дивиз, хороодын дарга, штабын дарга зэрэг албан тушаалтан, улс төр, ар талын ахлах, дээд дарга нарыг 6 сарын хугацаатай сургаж байжээ. Академийн курсийг 1933-1937 онд 384 дарга нар төгсчээ¹. 1937 он гэхэд МАХЦ нь даргалах бүрэлдэхүүнээр үндсэндээ хангагджээ. Нийт дарга нарын 40 шахам хувийг зөвхөн 1932-1937 онд бэлтгэсэн цэргийн дээд, дунд боловсролтой дарга нар эзэлж байв¹.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1937 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр хуралдсан 25 дугаар хурлын тогтоолоор МАХЦ-ийн ангиудаас хамгаалж буй дорнод хил хязгаарыг 1937 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн ДЯЯ-ны хил хязгаарыг хамгаалах цэрэгт шилжүүлэн¹ өгчээ. Энэ тогтоол гарснаар улсын хил хамгаалалтыг хязгаарын цэрэг дагнан хариуцах болов.

Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийсний дараа 1936 оны сүүлчээр МАХЦ нь дараах нэгтгэл, ангиудаас бүрдэж байв. Баянтүмэнд 2 дугаар морьт корпус (5, 6, 8 мд), Байшинтад 7 мд, Улаанбаатарт 1 мд, нисэх онгоц, хуягтын бригад, холбооны тусгай хороо, Замын-Үүдэд 34 дүгээр тусгай морьт хороо, Алтанбулагт 10 дугаар тусгай морьт суман, Ховдод нутгийн цэргийн 4 дүгээр тусгай морьт хороо, Цэцэрлэгт 31 дүгээр тусгай морьт хороо, Улиастайд 32 дугаар тусгай морьт хороо байрлаж байсан бөгөөд нийт бие бүрэлдэхүүний тоо 16,6 мянгад хүрсэн байв.

МАХЦ-ийн хөгжилт, бэхжилтэд улс төрийн хэлмэгдүүлэлт ихээхэн сөрөг нөлөө үзүүлсэн байна. МАХЦ-ийн бүрэлдэхүүнээс 1937-1940 онд улс төрийн хилс хэрэгт бүрэн бус тооцоогоор 836 хүн баригдаж хэлмэгдсэн ажээ.

§ 4.3. Монгол Улсын эсрэг Япон, Манжийн цэргийн өдөөн хатгалга, түүнийг няцаасан нь

Япон, Манжийн тал 1934 оны дунд үеэс эхлэн Монгол улсын дорнод хил дээр өдөөн хатгалга үйлдэж хилийн зөрчил гаргаж эхэлсэн бөгөөд 1935 он гараад эл үйлдэл нь өргөжив. Нэгдүгээр сарын 19, 24-нд Халхын сүмийн харуулд Япон, Манжийн цэрэг халдан довтолж, хорооны штабын дарга Дондов, цэрэг Янжив нар

амь үрэгджээ. Энэ халдлага 1936 он гарахад Буландэрсний харуулын чиглэлээр улам өргөжиж, Япон, Манжийн зүгээс 1936 оны 3 дугаар сарын 29-31-ний өдөр их хүчээр халдан довтолсныг МАХЦ-ийн ангиуд улаан армийн зарим салбарын хамт амжилттай няцаасан байна. Эл байлдаан нь Адагдулааны байлдаан гэж түүхэнд нэрлэгдэх болсон юм.

ТАВДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ ЦЭРЭГ ХАЛХЫН ГОЛЫН ДАЙНД

§ 5.1. Халхын голын дайн эхэлсэн нь

Япон, Манжийн зүгээс хийх зэвсэгт халдлага 1939 он гарангуут дахин идэвхжиж, хилийн харуулуудтай тулгаран буудалцах нь эрс нэмэгдсэн байна. Тав дугаар сар хүртэл тэд 30 гаруй удаа халдлага хийжээ. Тэдний халдлага нь жирийн нэг өдөөн хатгалга бус гэдэг нь тодорхой болсон тул МАХЦ-ийн ангиудыг болон Монголд байрлах улаан армийн ангиудаас зүүн хязгаарт татаж ирүүлэх арга хэмжээ авав.

Японы тал 5 дугаар сарын эхээр Монгол улсын хилийн дотор явуулсан ажиллагаагаа өргөтгөхийн тулд томоохон хүчийг Номун Хан, Бүрд овооны орчим хуралдуулжээ. Энэ нь японы 23 мд-ийн командлагч Комацубарагийн 1939.05.21-ний өдрийн тушаалаар байгуулсан тус дивизийн 64 ях-ны дарга хурандаа Ямагатагаар удирдуулсан нэгдсэн отряд байв. Энэ хүчний эсрэг МАХЦ-ийн 6 мд, 57 дугаар онцгой корпусаас томилогдсон А.Б.Быковын отряд, улмаар фронтод ирсэн Зөвлөлтийн ангиудын хооронд хүнд ширүүн байлдаан болсноор Халхын голын дайн эхэлжээ.

Энэ дайн улам шатлан өргөжиж МАХЦ-ийн 5, 6, 8 мд болон зөвлөлтийн 57 ОК-ын 57 мянга гаруй цэрэг байлдааны ажиллагаанд оролцжээ. Япон, Манжийн цэргийн нийт тоо 75 мянгад хүрсэн байна. Монгол, Зөвлөлтийн цэргийг Г.К.Жуков нэгтгэн удирдсан бөгөөд МАХЦ-ийг БЦЖ-ны орлогч Ж.Лхагвасүрэн тэргүүтэй МАХЦ-ийн хээрийн штаб удирджээ.

Байлдааны ажиллагаа хэд хэдэн үе шаттай явагдаж, 9 дүгээр сарын 17-оос ЗХУ, Японы хооронд Халхын голд гал зогсоох тохиролцоонд хүрч дайн зогссон юм. Монгол, Зөвлөлтийн цэрэг 8 дугаар сард Халхын голд Японы 6 дугаар армийг бүслэн устгасан давших операцийн дүнд БНМАУ-ын нутаг дэвсгэрээс дайсныг хөөн гаргаж, тус улсын хилийн шугамыг үндсэнд нь (Мана уулын районоос бусад) сэргээв.

Халхын голын дайн бол харьцангуй бага дэвсгэр нутагт хоёр талаас 130 мянган хүн, 1000 гаруй танк, хуягт машин, 800 гаруй байлдааны нисэх онгоц оролцсон буюу хамрагдаж 4 сар үргэлжилсэн, Монгол Улсын хувьд томоохон дайн байсан юм.

Халхын голын дайнд хүргэсэн шалтгаан, түүний улс төрийн үр дүнг бүхэлд нь авч үзвэл гучаад оны үед Монголын нутаг дэвсгэр Зөвлөлт, Японы улс төр, цэргийн нөлөөллийн хүрээний зөрчлийн нэг том объект болж байжээ хэмээн үзэж болно.

Харин дэлхийн хоёрдугаар дайн 1939 оны намар Европт нэгэнт эхэлснээр Монголын дорнод хил дээр болсон энэ хэрэг явдлын олон улсын харилцаанд эзлэх байр, ач холбогдол буурч Халхын голын дайныг цаашид сунжруулалгүй дуусгахад

хүргэсэн байна. БНМАУ-ын дорнод нутгийн хязгаарлагдмал хэсэгт болсон Халхын голын дайнд хэдийгээр ЗХУ, Монгол, Япон, Манж зэрэг дөрвөн улсын цэрэг оролцсон боловч Зөвлөлт, Японы цэрэг зонхилох үүрэг гүйцэтгэжээ.

Дайны хүн хүчний хохирлын хувьд Япон, Баргын цэргийн хохирол алагдсан 18115, шархадсан, сураггүй алга болсон 30534, нийт 48649 хүн, Зөвлөлтийн тал буцалтгүй хохирол 9831, эмнэлгийн хохирол 15952, нийт 25783, МАХЦ-ийн хувьд 1000 шахам хүний хохирол үзжээ. Энэ дайн нь дайтагч талуудын хувьд багагүй сургамжтай үйл явдал болсон байна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ДЭЛХИЙН ХОЁРДУГААР ДАЙНЫ ҮЕИЙН МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ ЦЭРЭГ

§ 6.1. Монгол Улсын батлан хамгаалах хүч чадлын бэхжилт

Монгол улс батлан хамгаалах хүчээ бэхжүүлэх явдлыг ЗХУ-тай тогтоосон найрамдал, хамтын ажиллагаатай нягт холбож үзэж түүний тусламж дэмжлэгэд тулгуурлаж байсан юм. ЗХУ-д Герман улс халдан довтолж, эх орны их дайн эхэлснээр Монгол улсад үзүүлэх тал бүрийн тусламж багассан нь манай орны нийгэм эдийн засгийн хөгжилд олон талын бэрхшээл учруулсан юм. Монгол улс энэ дайнд шууд ороогүй ч гэсэн Зөвлөлтийн ард түмэнд туслах явдлыг тэргүүн зэргийн зорилт болгон улс орны нийгэм эдийн засгийн амьдрал үүнд чиглэгдэж, үндсэндээ дайны байдалтай байв. Монгол, Зөвлөлтийн ард түмний нийтлэг эрх ашгийн үүднээс ЗХУ-д туслах явдлыг МАХН, төр гадаад, дотоод улс төрийн бодлогынхоо гол чиг шугам болгон тавьсан юм.

Улс орон даяар “Бүхнийг фронтод!”, “Бүхнийг ялалтын төлөө!” гэсэн уриан дор Зөвлөлтийн ард түмэн, улаан армид туслах хөдөлгөөн өрнөв. Улаан армид зориулан Монголын ард түмний хүч хөрөнгөөр “Хувьсгалт Монгол” танкийн цуваа, “Монгол ард” нисэх эскадриль байгуулж шилжүүлсэн ба дайны жилүүдэд 32 мянга гаруй агт морь бэлэглэж, хагас сая шахам агт морь худалдсан байна. Мөн энэ хугацаанд Улаан армид зориулан 8 удаа галт тэрэгний 11 цуваа бэлэг явуулсан нь нийтдээ 438 сая төгрөгийн үнэ бүхий зүйл болсон юм¹.

БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1944 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 22 дугаар хурлын тогтоолоор “МАХЦ-ийн нийт дарга нарыг офицер хэмээн нэрлэх ба МАХЦ-ийн нийт албан хаагчдын алдар цолыг шинэчлэх тухай” тогтоол гаргав¹. Ингэснээр өнөөгийн цэргийн цол бий болжээ.

МАХЦ-ийн хүч чадлыг бэхжүүлэх талаар авсан олон чухал арга хэмжээний нэг нь нэгтгэн захирах ёсыг тогтоосон явдал бөгөөд 1943 онд нэгтгэл, ангиудад даргын адил эрхтэйгээр ажиллаж байсан комиссаруудыг татан буулгажээ. ЗХУ дайны байдалтай байсан хэдий ч 1941-1945 онд МАХЦ-ийн зэвсэглэл, техникийн хангалтад болон цэргийн төрөл бүрийн боловсон хүчнийг бэлдэхэд зориулан нийтдээ 100,7 сая рублийн буюу 132,3 сая төгрөгийн¹ тусламж үзүүлсэн байна.

Дайны жилүүдэд улс орны батлан хамгаалах хүчнийг бэхжүүлэх ажилд олон түмнийг өргөнөөр татан оролцуулахад их анхаарч байв. Үүний нэг илрэл нь 1942 онд Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отрядыг аравт, тавьт, зуут, мянгат, түмтийн зохион байгуулалттай байгуулжээ.

§6.2. МАХЦ-ийн бүтэц, зохион байгуулалтад гарсан өөрчлөлт, байлдааны бэлэн байдал дээшилсэн нь

Халхын голын дайны туршлагыг харгалзан 1940 онд МАХЦ-ийн анги, нэгтгэлүүдийг өөрчлөн зохион байгуулав. Үүний дотор морьт дивизүүдийг гурван морьт хороотой болгов. Үүний хамт 1941-1942 онд төрөл, мэргэжлийн цэргийн ангиудыг шинээр байгуулсан юм. МАХЦ-т техникийн цэргийн эзлэх хувь хэмжээ 20,0 хувьд хүрсний дээр танк, хими, холбоо, инженер, автомобиль зэрэг тусгай мэргэжлийн цэрэг хөгжсөн нь морьт цэргийг өөрчлөн цаашид орчин цагийн мотомеханикжсан арми байгуулах үндэс ямар нэг хэмжээгээр тавигдсаныг харуулж байна.

Даргалах бүрэлдэхүүнийг уламжлал ёсоор гадаад, дотоодод бэлдэж байсан бөгөөд 1945 онд МАХЦ-ийн дарга нарын дотор дээд сургууль төгсөгчид 5,7 хувь, дунд сургууль төгсөгчид 45,7 хувь, курс төгсөгчид 10,8 хувь, бие даан дунд боловсрол эзэмшигчид 38,8 хувьд хүрэв¹. Дотоод, гадаадын цэргийн сургуулиар 1940-1945 онд 1441 офицер бэлтгэсэн ба МАХЦ 1943 оноос дунд дарга нарын хувьд үндсэндээ хангагдав.

Нэгтгэл, ангиудын байлдааны бэлтгэл сургалтыг эрчимжүүлж, эх орны дайны туршлагаас суралцаж байсан ч нэгтгэл, ангиудын байлдааны бэлтгэл сургуульд ноцтой дутагдал оршсоор байв. МАХЦ-ийн нэгтгэл, ангиудын 1941/42 оны сургуулийн жилийн дүнгээс үзэхэд морьт ангийн тактик, жагсаал, их буут ангийн галын бэлтгэл, холбооны ангийн бэлтгэл ерөнхийдөө үүрэгтэй шалгагдаж байсан боловч, дарга, штабуудын бэлтгэлд ихээхэн дутагдал оршиж байв

§ 6.3. МАХЦ Чөлөөлөх дайнд

Монгол цэргийн ХХ зууны түүхэнд оролцсон сүүлчийн дайн нь дэлхийн II дайны төгсгөл болох “Алс Дорнодын кампани” буюу Чөлөөлөх дайн байсан юм. ЗХУ-тай харилцан тохиролцсоноор БНМАУ эл дайнд оролцох болсон бөгөөд МАХЦ-ийн анги, нэгтгэлүүдийг зэвсэг, техник, галт хэрэгсэл, агт морьдоор хангах ажлыг 1945 оны 5 дугаар сарын эцсээр үндсэнд нь гүйцэтгэж, 7 дугаар сард анги, нэгтгэлүүийг хоёр чиглэлд Замын-Үүд, Байшинтын районд хүч хуралдуулсан байна.

Цэргийн явдлын Яамны сайд, Бүх Зэвсэгт хүчний жанжин маршал Х.Чойбалсангийн тушаалаар Монгол, Зөвлөлтийн морьт механикжуулсан бүлэг буюу МАХЦ-ийн “Өмнөд бүлэг”-ийн командлагч бөгөөд өөрийн орлогчоор дэслэгч генерал И.А.Плиевийг, Өмнөд бүлгийн командлагчийн монгол цэрэг хариуцсан орлогчоор дэслэгч генерал Ж.Лхагвасүрэнг тус тус томилон ажиллуулсан байна.

Монгол Улсын Засгийн газар милитарист Японы эсрэг дайнд оролцохдоо даян дэлхийд энх тайван байдал тогтоох бүх нийтийн үйлсэд хувь нэмрээ оруулах, Өвөр Монголын ард түмнийг Японы түрэмгийлэн эзлэгчдээс чөлөөлж, тус улсын хил хязгаарын тайван байдлыг хангах зорилтыг тавьжээ.

Монгол, Зөвлөлтийн цэргийн өмнөд бүлгийн гол үүрэг нь давшилтын баруун гарын туслах цохилтыг Долнуур, Чуулалт хаалганы чиглэлд хийж, Өвөр Байгалийн фронтын баруун жигүүрийг хангах ёстой байв. Монгол, Зөвлөлтийн цэргийн Өмнөд бүлгийн командлал байлдааны үүргээ биелүүлэхдээ хүч, хэрэгслээ хоёр хэсэг болгож, нэг хэсэг нь Дарьганга, Байшинтын районоос Долнуур, Жэхэгийн чиглэлд 950 гаруй км, нөгөө хэсэг нь Сайншандаас Чуулалт хаалга хүртэл 500 гаруй км хол зайд давшин байлдахаар төлөвлөжээ.

ЗХУ 1945 оны 8 дугаар сарын 9-нд Японд дайн зарлав. БНМАУ-ын Бага хурал, Засгийн газраас 1945 оны 8 дугаар сарын 10-нд Японд дайн зарлах тухай тунхаглах

бичиг гаргав. Наймдугаар сарын 9-нд Монгол, Зөвлөлтийн цэрэг улсын хил давж байлдааны ажиллааг эхлүүлжээ. Өмнөд бүлгийн зүүн жигүүрт давшсан МАХЦ-ийн ангиуд багагүй саад бэрхшээлийг туулж олон хот, сууринг Японы цэргээс чөлөөлж, 8 дугаар сарын 22-нд Бээжингээс 70 км орчим зайтай Миюнь хотод тулж ирсэн боловч фронт командлагчийн тушаалаар байлдаанаа зогсоожээ. Ийнхүү Долнуур-Жэхэгийн чиглэлд давшсан МАХЦ-ийн анги нэгтгэлүүд байгаль, цаг уурын хүнд нөхцөлд 1000 гаруй км-ийн хол замыг 9-10 хоногийн дотор туулж, байлдааны даалгавраа биелүүлжээ.

Морьт механикжуулсан бүлгийн давшилтын хоёр дахь томоохон давшилт нь Чуулалт хаалганы чиглэл юм. Энэ чиглэлд хурандаа Д.Нянтайсүрэн даргатай МАХЦ-ийн механикжуулсан 7 дугаар хуягт бригад, хошууч Е.Төрхүү даргатай их бууны 3 дугаар хороо Зөвлөлтийн ангийн хамт үүрэг гүйцэтгэжээ. Энэ чиглэлд дайсны хамгийн том хориглолт зохион байгуулсан түшиц газар бол Жанчхүүгийн даваа байлаа.

Жанчхүүгийн давааны бэхлэлтийг эвдэж, японы цэргийн томоохон бүлэглэлийг устгах ширүүн тулалдаан 8 дугаар сарын 19-21-нд болжээ. Жанчхүүгийн давааны бэхэлсэн районыг эзлэн авах энэ тулалдаанд хөнгөн пулемётын наводчик Д.Данзанваанчиг, түрүүч С.Дампил, ахлагч Т.Дүүдэй, түрүүч М.Жанчив, пулемётчин Л.Аюуш нарын эр зоригтнууд тодорч олон арван хүн төрийн дээд шагнал одон, медалиар шагнуулсан байна.

МАХЦ нийтийн дайсныг устгах их үйл хэрэгт Нэгдсэн үндэстний талд баттай зогсож, дэлхийн дайны голомтыг устгасан үйл явдал цэргийн төдийгүй улс төрийн хувьд түүхэн ач холбогдолтой үйл явдал байсан юм. Энэ дайны үр дүнд Монголын ард түмний тусгаар тогтнолынхоо төлөө өгсөн санал хураалтын дүнг үндэслэн ДИУ БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн билээ.

МАХЦ-ийн нэгтгэл ангиуд Өвөр Байгалийн фронтын өмнөд бүлгийн цэргийн бүрэлдэхүүнд орж дэлхийн дайны сүүлчийн голомтыг устгах шударга дайнд оролцож байлдааны үүргээ амжилттай биелүүлсэн бөгөөд байлдааны бэлэн байдал, байлдах чадвараа дээшлүүлэхэд хэрэглэвэл зохих цөөнгүй сургамж үлдээжээ.

ТӨГСГӨЛ

АЖЦ Ардын хувьсгалыг ялалтад хүргэхэд чухал нөлөөтэй Хиагтын байлдаанаас гадна эх орноо Хятадын гамин, Оросын цагаантнаас чөлөөлөх явцдаа дангаараа болон Зөвлөлт Оросын улаан цэрэгтэй хүчин хавсрах, орон нутгийн баг цэргийн ба хязгаарын монгол цэргийн хүч дэмжлэгтэйгээр 200 орчим байлдаан хийж ялалт авчирчээ.

Ардын журамт цэргээс үүсэл хөгжлийн шинэ замналаа эхлүүлсэн Зэвсэгт хүчин дэлхийн цэргийн хэргийн хөгжлийн чиг хандлагыг баримтлан байнгын цэрэг болж төлөвших үйл явц хориод онд хэрэгжжээ.

МАХЦ-ийг европын (Зөвлөлтийн) туршлагаар өөрчлөн байгуулснаар үндсэн төрлийн цэрэг болох морьт цэргийн хороо, дивиз, корпустай болж түүний бүрэлдэхүүнд хуягт танк, их буу, нисэх хүчин, холбоо зэрэг техникийн цэргийн анги шинээр бий болов. Байнгын цэргийг орон нутгийн цэрэгтэй хосолсон тогтолцоо бүрдсэн байна. Энэ нь ард олныг батлан хамгаалах үйл хэрэгт оролцуулах гол

хэлбэр байв. Нийгмийн хөгжлийн шаардлагаар МАХЦ нь эх орноо батлан хамгаалаад зогсохгүй залуучуудыг сургаж хүмүүжүүлэн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж гаргах газар болж байв.

Гучаад оны дунд үеэс эхлэн Монгол улсын хил хязгаарт удаа дараа их, бага хүчээр халдан довтолж байсан Япон, Манжийн цэргийн түрэмгийллийг МАХЦ-ийн нэгтгэл, ангиуд Зөвлөлтийн цэргийн зарим анги, салбарын дэмжлэгтэйгээр эрс шийдвэртэй няцааж эх орныхоо тусгаар тогтнол, хил хязгаарын дархан байдлыг хамгаалж чадсан юм. Япон, Манжийн зүгээс хийж буй зэвсэгт өдөөн хатгалга 1939 он гарсаар улаж идэвхжиж, улмаар Халхын голын дайнд хүргэсэн юм. Энэ дайнд Монгол, Зөвлөлтийн цэрэг дөрвөн сар гаруй хугацаанд японы цэргийн түрэмгийллийг сөрөн зогсож, Японы Квантуны армийн гол хүч болсон 6 дугаар армийг бут цохиж, эл дайн ялалтаар дууссан билээ.

Түүх бичлэгт Халхын голд болсон үйл явдлыг уг дайнд оролцогч талууд өнөөг хүртэл байлдаан, мөргөлдөөн, хэрэг явдал гэх зэргээр нэрэлж буй ч Монгол Улсын хувьд уг үйл явдал дайн байсан юм.

Халхын голын дайн нь Монгол, Зөвлөлтийн цэргийн урлаг, зэвсэглэл, байлдааны техникийн хөгжилд томоохон нөлөө үзүүлэв.

Дэлхийн II дайны сүүлчийн операцид БНМАУ-ын Зэвсэгт хүчин ЗХУ-ын холбоотон болж оролцов. Дэлхийн дайны сүүлчийн голомтыг устгах эл кампани нь холбоотон гүрнүүдийн ялалтаар төгсөж даян дэлхийд энх тайван байдал тогтов.

Зүүн хойд Хятад, Өвөр Монголын нутагт 1945 оны намар явуулсан операцид МАХЦ оролцсон нь тус улсын тусгаар тогтнолыг баталгаажуулахад эерэг нөлөө үзүүлсэн юм.

**ЕСДҮГЭЭР БОТЬ
МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧИН
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ДАЙНЫ ДАРААХ ҮЕИЙН МОНГОЛ АРДЫН
ХУВЬСГАЛТ ЦЭРЭГ (1946-1956 ОН)**

§1.1. Монгол ардын хувьсгалт цэргийг цомхотгосон нь.

Дэлхийн II дайн төгссөнтэй уялдуулан БНМАУ-ын төр, засгийн газар олон жилийн турш улс орны эдийн засгийг тамирдуулж ирсэн батлан хамгаалах зардлыг хорогдуулж, нийгэм, эдийн засгийг дайны байдлаас бүтээн байгуулалтад шилжүүлэх бодлого баримтлах болсон байна. Дайны уршгаар төмөр зам тавих, аж үйлдвэр, барилга, сургууль, соёлын зэрэг шинээр барьж байгуулах олон ажил хойшлогджээ.

1941-1945 онд батлан хамгаалах хэрэгцээнд улсын төсвийн орлогын 43,4 хувь, зарлагын 48,5 хувийг зарцуулжээ¹. Түүнчлэн 1945 оны Чөлөөлөх дайны үеэр 200 гаруй сая төгрөгийн хохирол учирсан байна. Дайны жилүүдэд мал сүргийн тоо дайн болон байгалийн бэрхшээлээс шалтгаалан 26,2 саяас 20 сая болтол хорогджээ¹.

Төр засгаас нэн түрүүнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь юуны түрүүнд байлдааны цагийн орон тоогоор дэлгэгдсэн МАХЦ болон хязгаарын цэргийг өөрчлөн зохион байгуулж цомхотгоход чиглэжээ. БНМАУ-ын зэвсэгт хүчнийг өөрчлөн байгуулах, цомхотгох үйл явц 1945 оны 9 дүгээр сараас 1956 оны дунд хүртэл арав гаруй жилийн хугацаанд үргэлжилсэн, цэрэг, улс төр, эдийн засгийн цогц арга хэмжээ байсан юм.

Дайны төгсгөлд (1945 оны 9 дүгээр сар) МАХЦ-т 42680, Хязгаарын цэрэгт 10570, нийт зэвсэгт хүчний хэмжээнд 53250 хүн алба хааж байв. МАХЦ-ийг 1956 он хүртэл 8 удаа цомхотгосон бөгөөд тайван цагийн орон тоог 1945 онтой харьцуулан үзвэл 1950 онд 3,4 дахин, 1956 онд 10,1 дахин тус тус хорогдуулж, 1945-1956 оныг дуусталх 11 жил гаруй хугацаанд МАХЦ-ийг 90 хувиар хорогдуулж, 1956 онд 4256 хүнтэй үлджээ¹.

МАХН-ын Төв Хорооны 1953 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн тогтоол, ДЯЯ-ны сайдын 1953 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 426 тоот тушаалаар Хязгаарын ба Дотоодын цэргийн удирдлага, хилийн отрядууд, хангалт, үйлчилгээний анги, байгууллагыг татан буулгасан байна. Энэ арга хэмжээний үр дүнд хилийн цэргийг татан буулгаснаар 1955 он гэхэд хилийн цэрэгт 213 хүн үлдсэн байв¹.

Энэхүү цомхотгол нь улс төр, зохион байгуулалтын томоохон арга хэмжээ байсан бөгөөд зэвсэгт хүчнээс халагдсан олон мянган дайчин материаллаг үйлдвэрлэлийн хүрээнд ажилчин, малчдыг шинэ хүчээр сэлбэхийн хамт сэхээтэн, албан хаагчдыг эгнээг өргөтгөж, улс ардын аж ахуй, соёл, боловсролын байгууллагын өмнө тулгамдсан зорилтуудыг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлсэн байна. Түүнчлэн халагдсан дайчдын дотор нам, эвлэлийн гишүүн олон байсан нь орон нутгийн нам, эвлэлийн байгууллагыг бэхжүүлэхэд сайн нөлөө үзүүлжээ.

Цэргээс халагдагсдын дотор төрөл бүрийн мэргэжил эзэмшсэн олон хүн байсан бөгөөд тухайлбал, номын багш 317, кино механик 52, хүн эмнэлгийн бага мэргэжилтэн 436, мал эмнэлгийн бага мэргэжилтэн 187, холбооны 1394, автын 2423, аж ахуйн 392, барилгын мэргэжилтэн 3390-ийг улс ардын аж ахуйд, 150 гаруй дарга нарыг хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуйн удирдах албанд шилжүүлжээ.

МАХЦ-ийг цомхотгох явцад зөвхөн бие бүрэлдэхүүнийг төдийгүй хуучирсан зэвсэг техникийг зэвсэглэлээс хасч, зарим техникийг улс ардын аж ахуйд шилжүүлсэн байна. Ардын цэргийг цомхотгон, өөрчлөн байгуулах явцад түүний бүтэц, зохион байгуулалт нэлээд өөрчлөлт орсон ажээ.

§1.2. Монгол ардын хувьсгалт цэрэг улс орны бүтээн байгуулалтад

Монгол Улсын төр, засаг, намаас дайны дараах жилүүдэд улс орныхоо эдийн засаг, нийгмийг цаашид хөгжүүлж, бүтээн байгуулалтын ажлыг өрнүүлэх зорилтын хүрээнд цэргийн зохих хэсгийг бүтээн байгуулалтын үйлсэд оролцуулах болов.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл “Иргэний нисэх онгоцны ангийг байгуулах” тухай тогтоол 1946 оны 3 дугаар сарын 7-ны өдөр гаргаж, Цэргийн яамны харьяанд Агаарын иргэний флотын нисэх онгоцны отрядыг байгуулжээ. Ийнхүү Монгол Улсад Иргэний агаарын тээвэр үүсч, Монголын нисэх хүчин цэргийн болон иргэний давхар зориулалттай болов. Улмаар 1956 оноос зарим аймагт агаарын шуудан, тээврийн тогтмол аяллыг нээсэн байна.

Улс орны бүтээн байгуулалтад МАХЦ-ийн оруулсан нэг томоохон хувь нэмэр нь барилгын цэргийн гүйцэтгэсэн үүрэг юм. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1947 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн хурлаас “Сүхбаатарын нэрэмжит офицерийн сургуулийн барилгыг бариулах тухай” тогтоол гарснаар МАХЦ-ийн бүрэлдэхүүнд барилгын ангийг дахин байгуулжээ. Энэ тогтоолоор дээрх үүргийг гүйцэтгэхэд зориулж армийн бүрэлдэхүүнд орчин цагийн барилгын иж бүрэн байгууламж барих чадалтай барилгын батальоныг барилга конторын хамт байгуулж, бие бүрэлдэхүүнийг нь барилгын төрөл бүрийн мэргэжилд ба орон нутгийн материал бэлтгэхэд сургах даалгаврыг цэрэгт өгчээ. Энэ тогтоолыг хэрэгжүүлэн ЦЯЯ-ны сайд, Бүх цэргийн жанжны орлогчийн 1947 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 0145 дугаар тушаалаар барилгын 26 дугаар батальон буюу барилгын цэргийн ууган хороо 017 дугаар ангийг байгуулжээ.

Анхдугаар таван жилд (1948-1952 он) цэргийн барилгачид улсын хөрөнгө оруулалтаар Их тэнгэрийн амны харш, Алтан өлгийд жанжин Д.Сүхбаатарын хөшөө зэрэг нийтдээ 37,5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий барилгыг ашиглалтад оруулав.

Хоёрдугаар таван жилийн (1953-1957 он) төлөвлөгөөгөөр цэргийн барилгачид 19,3 сая төгрөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэх төлөвлөгөө авч Улаанбаатарт В.И.Лениний хөшөө, Сүхбаатар, Чойбалсангийн бунхант индэр, Зайсан толгойд Зөвлөлтийн дайчдын хөшөө, Хөдөө аж ахуйн их сургуулийн иж бүрэн барилга, төв больниц, сүүний завод, архи, пивоны заводын өргөтгөл, намын дээд сургуулийн оюутны байр, цахилгаан комбинатын өргөтгөл, 5 болон 6 дугаар арван жилийн сургуулийн барилга зэрэг 29,7 сая төгрөгийн барилга барьжээ.

Бүтээн байгуулалтын ажилд зөвхөн барилгын цэрэг бус Монгол Ардын цэргийн байлдааны ангийн бие бүрэлдэхүүн тодорхой хэмжээгээр оролцож байсныг тэмдэглэх ёстой. Түүнчлэн МАХЦ-ийн дайчид энэ үеэс хөдөө аж ахуйн цаг үеийн ажилд идэвхтэй оролцох болов.

§1.3. Хязгаарын цэрэг, Монгол ардын хувьсгалт цэрэг Баруун хязгаарын аюулгүй байдлыг сахин хамгаалсан нь

1930-аад оны эхээр Шинжаан мужид оршин суугч уйгур, түрэг угсаатны угсаа гарал, шашин шүтлэг, хэл соёл, зан заншлыг Гоминданы Хятадын Засгийн газрын эрх баригчид доромжлон гутааж, эд хөрөнгийг хураан авах, татвар гувчуурын хэмжээг нэмж амар жимэр амьдрах аргагүй нөхцөл байдалд оруулжээ. Энэхүү хүнд байдлыг тэд эсэргүүцэж, тусгаар тогтнол, эрх чөлөө, шашин шүтлэгийнхээ төлөө бослого хөдөлгөөн гарган Гоминданы Хятадын эсрэг зэвсэг барин тэмцсэнээр Шинжаан муж үймээн самуун, дайн дажинд автсан юм.

Хятадын эрх баригчид Шинжаан муж дахь Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд оролцогч уйгур, түрэг угсааны иргэдийг олон мянгаар нь баривчлан хорьж, тамлан зовоож, бослогыг цус асгаруулан дарсан юм. Үүний улмаас Шинжаан дахь дайн самууны хөлөөс дүрвэн зугтсан олон зуун өрх айл, босогчдын зэвсэгт бүлэглэлүүд Монгол Улсын баруун хязгаарт орших Ховд, Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэрт хүч түрэн суурьшиж, нутгийн ард олны мал, эд хөрөнгийн дээрэмдэн тонох, амь насыг нь егүүтгэх, хилийн харуул заставыг довтлон түйвээх болжээ.

Үүний хамт Хятадын Засгийн газраас Гадаад Монгол нь тус улсын нэг муж хэмээн үзэж, манай улсын баруун хил хязгаарын дагуу цэргийн анги, салбараа татан төвлөрүүлж, БНМАУ-д халдан довтлох ажилдаа хасгийн зэвсэгт бүлэглэлүүдийг ашиглах болжээ.

Дээрх нөхцөл байдлаас үндэслэн улс орны баруун хил хязгаарын аюулгүй байдлыг хангах, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх талаар төр, засгаас улс төр-дипломатын, цэрэг-тагнуулын, хүрээнд олон чухал арга хэмжээ авсан юм.

Манай талын идэвх санаачилгын үр дүнд баруун хязгаарын байдлыг төвшитгэхэд тодорхой нааштай эхлэл тавигдаж, казахын бослогын толгойлогч Оспантай холбоо тогтоон хамтран ажиллах болжээ. Энэ мэт үйл ажиллагааны үр дүнд БНМАУ-ын баруун хил хязгаар дахь Оспаны зэвсэгт халдлага 1944-1946 оны дунд үе хүртэл буюу түүнийг Гоминданы Хятадын талд урвах хүртэл намжсан байна. Оспан 1946 оны 4 дүгээр сараас өөрийн байр суурь, зорилго, тэмцлээсээ ухарч, Гоминданы талд үйлчлэх болсноор “холбоотон” болох БНМАУ, ЗХУ-ын эсрэг дайсагнасан үйл ажиллагаа явуулж эхэлсэн нь Зөвлөлтүүд төдийгүй манай талаас ч түүний тухайд баримтлах бодлогоо эрс өөрчлөхөд хүргэжээ.

Оспан манай улстай байгуулсан найрамдал, хамтын ажиллагаанаасаа 1946 оны дундуур урван Гоминданы Хятадын талд үйлчлэх болсноор хилийн цагийн байдлыг улам хүндрүүлсэн билээ. Ингэснээр манай улсын баруун хязгаарт хоёр өөр зорилготой хоёр дайсан гарч ирсэн юм.

Гоминданы Хятадын цэргийн удирдлагууд үйл явдлын өрнөлтийг ашиглан Оспаны талынхныг БНМАУ-ын хилийг зөрчин дээрэм тонуул хийхэд нь улам бүр өөгшүүлэн турхирч зэр зэвсэг, хоол хүнсээр хангах болсон юм. Энэ нь Хятадын зүгээс Байтаг Богд уулын ойр орчмын газар нутгийг өөрийн эзэмшлийн нутаг дэвсгэр гэж үзэж байсантай холбоотой байв.

Баруун хилийн байдал улам ноцтой болсон тул тэрхүү халдан довтлогчдыг устгах байлдааны ажиллагааг хязгаарын цэрэг болон МАХЦ-ийн ангиудын хүчээр хийсэн юм. Байтаг Богд уулын районд 1947 оны 6 дугаар сарын 5-нд болсон дээрх байлдааны дүнд Гоминданы болон Оспаны тал нэлээн хохирол амсаж хилийн цаад руу ухарсан хэдий ч эл байлдаан нь тактикийн хувьд төдийгүй удирдлага, зохион байгуулалт, харилцан ажиллагаа, сахилга хариуцлагын талаар ихээхэн дутагдалтай болжээ. Үүнээс хойш хэд хэдэн байлдаан болж хязгаарын цэргээс багагүй хохирол амсчээ.

Түүхэн он цагийн үүднээс авч үзэхэд 1947-1948 он нь баруун хилийн байлдааны оргил үе гэж үзэж болохоор байна. Учир нь 1934-1949 оны хооронд нийт 62 удаагийн зэвсэгт халдлага, байлдааны ажиллагаа явагдсанаас 34 хувь буюу 21 нь 1947-1948 онд явагджээ. Байлдааны хүн хүчний хохирлын хувьд манай талаас

1934-1951 оны хооронд нийт 170 гаруй дарга, цэрэг амь үрэгдэж, 60 гаруй хүн шархадсан байна. Харин Оспан, Гоминданы талаас 1947-1948 онд болсон 21 байлдаанд 100 гаруй хүн алагдаж шархадсан байна.

Байлдаанд оролцогч талуудын хүч хэрэгслийг нэгтгэн авч үзэхэд 1934-1948 онд давхардсан тоогоор барагцаалбал манай талаас 2500 орчим цэргийн албан хаагч, сөнөөгч, бөмбөгдөгч онгоц 20 орчим, Ардын сайн дурын группийн 1000 шахам гишүүдийн хүч хэрэгсэлтэйгээр нийт 62 удаагийн байлдааны ажиллагаанд оролцсон бол Оспан, Гоминданы зэвсэгт бүлэглэл 7500 гаруй хүнтэй, хүнд хөнгөн пулемёт, миномёт зэрэг төрөл бүрийн зэвсгээр зэвсэглэсэн байжээ.

Монгол Улсын эсрэг дайсагнаж байсан Оспан эцэстээ хятадын талд баригдаж цаазлуулсан, 1949 онд Хятадад хувьсгал ялж, Гоминданы тал ялагдсан зэрэг нөхцөл байдалтай уялдаж, манай улсын баруун хилийн байдал тайван болсон юм.

Баруун хязгаарт олон жилийн турш үргэлжилсэн эл байлдаан нь хязгаарын цэрэг, МАХЦ-т багагүй сургамж үлдээсэн ажээ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

МОНГОЛЫН АРДЫН АРМИЙН ХӨГЖЛИЙН ШИНЭ ҮЕ, ЦЭРГИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛСЭН НЬ (1956-1990 он)

§2.1. Олон улсын цэрэг, улс төрийн байдлын өөрчлөлт, Монголын ардын армийг өргөтгөн зохион байгуулсан нь

Төр, засаг, эрх баригч намын батлан хамгаалах салбарт баримталсан бодлого, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнд МАА-ийн бүтэц зохион байгуулалт, дүр төрх, хүчин чадалд гарсан өөрчлөлтөөр нь 1956-1990 онд явагдсан МАА-ийг өргөтгөн зохион байгуулах үйл явц үндсэн гурван шаттайгаар хэрэгжсэн ажээ. Тавиад оны дунд үеэр буудлагын, улмаар мотобуудлагын анхны ангиудыг байгуулав. Гэсэн хэдий ч барилгын цэргийг богино хугацаанд өргөтгөн зохион байгуулах ажил үргэлжилж байсан юм.

ЗХУ болон социалист нөхөрлөлийн орнуудын тусламжтайгаар барьж байгаа Дарханы барилгын цогцолборын бүх ажлыг АЦХЭЯ-нд хариуцуулан, Дарханы барилга удирдах ерөнхий газрыг 1963 онд байгуулж, ерөнхий захиалагч нь болгосон байна. Барилгын цэрэг 1964 онд 10 ангитай болж Ардын цэргийн нийт ангиудын гуравны хоёр, бие бүрэлдэхүүний 50-иас илүү хувийг эзлэх болов.

Армийг өргөтгөн зохион байгуулах ажлын нэгдүгээр шатны үндсэн дүн гэвэл улс орныг батлан хамгаалах, бэхжүүлэх талаар нам, төрийн хэд хэдэн тогтоол шийдвэр гарсан, БНМАУ-ын АЦХЭЯ-ыг бие даалган байгуулж, орон тоог нь нэмэгдүүлэн, Ардын цэргийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөн төрөл, мэргэжлийн цэргийн анги, салбар бүхий мотобуудлагын цэрэг байгуулах чиглэлийг боловсруулсанд оршиж байв.

МАА-ийг өргөтгөн байгуулсан дараагийн шат (1964-1979 он)-ны төгсгөлд төр засаг, намаас улс орны батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлэх, армийг шинээр зохион байгуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд Монголын ардын арми төрөл, мэргэжлийн цэргийн тусгай бригад, хороо, батальон бүхий мотобуудлагын цэрэг болон өргөжиж, тухайн үеийн шинэвтэр зэвсэг, байлдааны

техник, цэргийн боловсон хүчинтэй болж, сургалт бэлтгэлийн шинэ тогтолцоог төлөвшүүлэн, нэгтгэл ангиудын байлдааны бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадварт мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан байна.

Жараад оны дунд үеэс БНМАУ-ын улсын нутаг дээр ЗХУ-ын цэргийн томоохон нэгдэл байрлаж, Монгол, Хятадын хооронд урьд өмнө тогтоосон бүхий л харилцаа, хамтын ажиллагаа хэрэг дээрээ зогсов. Хятадын удирдлага Монголын эсрэг бодлого, үйл ажиллагаагаа илэрхий идэвхжүүлж, хилийн дагуу цэргээ бүлэглэн байрлуулах, төмөр зам тавьж, нисэх онгоцны буудлууд байгуулах, хил дээр элдэв хэлбэрээр өдөөн хатгалга хийх явдал эрс нэмэгдэв.

Ийм нарийн төвөгтэй нөхцөл байдалд өргөтгөн зохион байгуулах цэргийн анги, нэгтгэлүүдэд шаардлагатай зэвсэг, байлдааны техникийг БНМАУ ба ЗСБНХУ-ын Засгийн газар хооронд 1964-1976 онд байгуулсан удаа дараагийн хэлэлцээрээр ЗХУ-аас хангасан юм.

Энэ хугацаанд анхны мотобуудлагын тусгай бригад, Улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэргийн анхны зенит пуужингийн дивизион, радио техникийн батальоныг, төрөл, мэргэжлийн ангиудыг шинээр тус тус байгуулжээ. Ингэснээр МАА 1978 он гэхэд мотобуудлагын бригад хоёр, мотобуудлагын тусгай хороо нэг, мотобуудлагын тусгай батальон хоёр, армийн артиллерийн тусгай хороо нэг, зенитийн артиллерийн тусгай хороо нэг, мэргэжлийн цэргийн тусгай батальонуудаас бүрдэж байв.

Армийг өргөтгөн зохион байгуулсан 1964-1979 онд цэрэгт нэвтэрсэн бүх төрлийн зэвсэглэл, техник нь цэргийн анги, нэгтгэлийн дүр төрх, хүчин чадлыг өөрчилж, байлдах чадварыг сайжруулах үндсэн нөхцөл болжээ.

Армийг өргөтгөх үйл явцын гуравдугаар шат (1979-1990-ээд он)-ны ажлыг МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны 1979 оны 182 дугаар тогтоолоор баталсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн юм. Бүс нутгийн цэрэг-улс төрийн байдалтай уялдаж Зөвлөлтийн цэргийн ангиуд Монголд нэмж байрлав.

Улсын хэмжээнд батлан хамгаалах арга хэмжээг удирдан зохион байгуулах тогтолцоог бий болгохын тулд 1979 онд БНМАУ-ын Батлан хамгаалах Зөвлөлийг байгуулав.

1979 онд МАА-ийн бүтцэд армийн корпусын удирдлагыг байгуулсан байна. Мөн мотобуудлагын бригадуудыг мотобуудлагын диюиз болгон өргөтгөн зохион байгуулжээ.

§2.2 Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, байлдах чадварт гарсан өөрчлөлт

Монголын Зэвсэгт хүчин бүтэц зохион байгуулалт, зэвсэг, байлдааны техник, боловсон хүчний хангалт, бие бүрэлдэхүүний тоо, цэргийн нэгтгэл, ангиудын үүрэг гүйцэтгэх чадварын өсөлтийн үндсэн үзүүлэлтээр хөгжлийнхөө дээд төвшинд 1980-аад оны дунд үе гэхэд хүрчээ. МАА-ийн бүтцэд мотобуудлагын цэрэг, улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэрэг, цэргийн нисэх хүчин, барилгын болон төрөл, тусгай мэргэжлийн цэрэг, хамгаалалт, хангалт үйлчилгээний анги, салбарууд багтаж байв. МАА-ийн нийт бүрэлдэхүүнд мотобуудлагын цэрэг 32,3, улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэрэг 2,5, нисэх хүчин 3,6, барилгын цэрэг 25.2 хувийг, бусдыг нь төрөл, тусгай мэргэжлийн болон хангалт үйлчилгээний анги, салбарууд тус тус эзэлж байжээ.

§2.3 Ар тал, улс төрийн болон бусад байгууллагууд

БХЯ-ны сайдын 1973 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн тушаалаар Арын албаныг удирдах газрыг МАА-ийн Ар талыг удирдах газар болгов. Цэргийн анги, нэгтгэлүүдийг өргөтгөх, шинээр зохион байгуулахад цэргийн алба хаагчдыг хүнс, хувцсаар хангах, эмнэлгийн үйлчилгээ үзүүлж эрүүл мэндэд нь анхаарах, цэргийн байр, гал зуух, гарааш, агуулах, клуб, соёлын ордон, спортын заал, сургалтын төв барих, офицер улирагсдыг байр орон сууцаар хангах, тэдгээрийн өвөл, зуны улирлын ашиглалтыг хэвийн нөхцөлд байлгахын тулд ар талын байгууллагууд улс орны бололцооны хүрээнд асар их ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Мөн ар талын анги, салбаруудыг шинээр болон өргөтгөн зохион байгуулжээ.

Монголын ардын армийн доторх улс төр, намын байгууллагууд 1980-аад оны эцэс хүртэл өндөр нэр хүндтэй, армийн амьдралын бүх салбарт, нөлөө бүхий байгууллага байлаа.

МАХН-ыг армийн дотор төлөөлж, түүний батлан хамгаалах салбарт явуулж байсан бодлогыг амьдралд хэрэгжүүлэхийн тулд улс төр, намын байгууллагууд МАА-ийг өргөтгөн зохион байгуулж анги, нэгтгэлүүдийн байлдах чадвар, байлдааны бэлэн байдлын төвшин, цэргийн сургалтын чанар үр ашгийг дээшлүүлэх, дайчдын ахуй хангалтыг сайжруулах, цэргийн сахилга зохион байгуулалтыг бэхжүүлэх тэмцэлд зохих хувь нэмрээ оруулжээ.

Дайчдыг эх орноо батлан хамгаалах үзлээр хүмүүжүүлэхэд соёл, гэгээрэл, хэвлэл, спортын байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Улс орныг батлан хамгаалах тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болсон улсын Иргэний хамгаалалт, Улсыг батлан хамгаалахад туслах нийгэмлэг зэрэг батлан хамгаалах системийн байгууллагын үйл ажиллагаа, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулахад төр, засаг, нам байнга анхаарч байв.

Цэргийн гадуур сургалтыг 1980-1981 оны хичээлийн жилээс дахин сэргээж бүх их, дээд сургуульд цэргийн тэнхим, БХЯ-нд цэргийн гадуур сургалтын хэлтэс байгуулан, их, дээд сургуульд 500 цагийн, ерөнхий боловсролын дунд болон тусгай мэргэжлийн дунд сургуульд 140 цагийн сургалт явуулж, эрэгтэй оюутнуудыг бэлтгэл офицероор, эмэгтэй оюутнуудыг цэргийн сувилагчаар бэлтгэдэг болов.

Төр засаг, МАХН-аас 1950-иад оны сүүлчийн хагасаас 1990-ээд оны эхэн хүртэлх хугацаанд батлан хамгаалах салбарт баримталж ирсэн бодлого, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд улс орныг батлан хамгаалах үйл хэрэг зохих төвшинд тавигдаж, батлан хамгаалах тогтолцоо бүрэлдэн төлөвшиж, батлан хамгаалах системийн нийт байгууллагын үйл ажиллагаа, нэр хүнд мэдэгдэхүйц дээшлэв. Хүн амын батлан хамгаалах ухамсар төлөвшиж, батлан хамгаалах сурталчилгаа, цэргийн сургалтанд оролцох оролцоо сайжрав.

§2.4. Монгол, Зөвлөлтийн улс төр-цэргийн холбоо, армийн гадаад харилцаа

Улс орны аюулгүй байдлыг хангах эрх ашгийн үүднээс батлан хамгаалах хүч чадлаа бэхжүүлж Зэвсэгт хүчнийг дахин сэргээж өргөтгөн зохион байгуулах, зэвсэг, байлдааны техникээр хангах, цэргийн боловсон хүчнийг бэлтгэх, бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийг дээшлүүлэх зэрэг цэргийн байгуулалтын томоохон асуудлыг БНМАУ бие даан шийдвэрлэх бололцоогүй байлаа. Иймд урьдын адил ЗХУ-ын тусламж дэмжлэгт тулгуурлахаас өөр зам байсангүй.

БНМАУ ба ЗСБНХУ-ын хооронд 1966 оны 1 дүгээр сард байгуулсан “Найрамдал, нөхөрлөл, харилцан туслалцах тухай гэрээ”-гээр үүнийг баталгаажуулсан байна. БНМАУ ба ЗСБНХУ-ын Засгийн газар хооронд “БНМАУ-д цэргийн буцалтгүй тусламж үзүүлэх тухай”, “БНМАУ-д тусгай эд хогшил нийлүүлэх тухай” зэрэг хэлэлцээр 1967, 1969, 1979, 1982, 1986 онд байгуулжээ. Эдгээр хэлэлцээрээр БНМАУ-ын Зэвсэгт хүчнийг өргөтгөн зохион байгуулахад шаардагдах бүх зэвсэг, байлдааны техник, төхөөрөмж, тусгай объектын материалыг ЗХУ үнэ төлбөргүй нийлүүлж байв.

Цэргийн нэг онол, үзэл баримтлал, нэг зэвсэг техниктэй учраас Монгол, Зөвлөлтийн цэргийн үйл ажиллагаа бүх шатанд хамтын ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө, удирдамжаар зохицуулагддаг байлаа.

Монголоос 1956-1990 онд Зөвлөлтийн цэргийн 14 академид 900 гаруй, 34 дээд, дунд сургуульд 1700 шахам хүн суралцаж төгссөн байна. 1980-аад оны эхний байдлаар МАА-ийн офицеруудын 35,3 хувь нь ЗХУ-ын цэргийн академи, дээд, дунд сургууль төгсөгчид байв.

Зөвлөлтийн цэрэг Монгол Улсын нутаг дээр байрлаж байсан хугацаанд хоёр армийн хамтарсан томоохон хээрийн сургуулийг 5 удаа зохион байгуулсан бөгөөд бусад хэлбэрийн хамтарсан сургалтыг байнга хийж иржээ. Манай улсад байрлаж байсан зөвлөлтийн дайчид тус улсад тохиолдсон байгалийн гамшиг, цаг агаарын хүнд нөхцөлд болон бүтээн байгуулалтын үйлсэд шуурхай туслалцаа үзүүлдэг байжээ.

Монгол, Зөвлөлтийн цэргийн хамтын ажиллагааны чухал хэсэг нь МАА-д ажиллаж байсан цэргийн зөвлөх мэргэжилтнүүдийн үйл ажиллагаа юм. МАА-д 1978 онд 179, 1980-аад оны эхээр 252 зөвлөх мэргэжилтэн ажиллаж байжээ.

Наяад оны дунд үеэр дэлхий дахины цэрэг-улс төрийн нөхцөл байдал өөрчлөгдсөнтэй уялдаж Монголын нутгаас 1987-1992 онд Зөвлөлтийн 82 мянган цэргийн алба хаагч (гэр бүлийн хамт 100 мянга илүү), 1866 танк, 2531 байлдааны хуягт машин, 315 байлдааны нисэх онгоц, нисдэг тэрэг, 1416 их буу, миномётыг тус тус гаргав¹.

Дэлхийн социалист систем бий болсноос хойш МАА социалист орнуудын армиудтай харилцаа холбоо тогтоож, хамтран ажиллаж иржээ. Тухайлбал, БХЯ-ны сайд нар тэргүүлсэн цэргийн төлөөлөгчдийн айлчлал хийх, армиудын ойг жил бүр харилцан тэмдэглэх, мэдээлэл, лектор, сонин сурвалжлагч, цэргийн амрагчид солилцох, цэргийн дуу бүжгийн ансамблиудыг харилцан тоглуулах, спортын төрөл бүрийн уралдаан тэмцээн зохион байгуулах, хээрийн сургуульд оролцох зэргээр хамтран ажиллаж байв.

ГУРАВДУГААР БҮЛЭГ.

НИЙГМИЙН ШИНЭ ТОГТОЛЦООНЫ ҮЕИЙН МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧИН

§3.1 Төрийн батлан хамгаалах бодлого, эрх зүйн шинэчлэл

Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн тулгуур заалтуудыг үндэслэн улс орны батлан хамгаалах тогтолцоо, Зэвсэгт хүчний байгуулалтын хууль, эрх зүйн орчинг үндсэндээ шинээр бүрдүүлэх нэн тулгамдсан зорилт дэвшигдэв. Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсаны дараа Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн

болон цэргийн алба хаагчийн эрхзүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Батлан хамгаалах тухай, Хилийн тухай хууль 1993 онд, Иргэний хамгаалалтын тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, Монгол Улсын Цэргийн номлолын үндэс баримт бичиг 1994 онд тус тус Монгол Улсын Их Хурлаар батлагдан гарчээ. Энэ үеэс эхлэн батлан хамгаалах бодлоготой холбоотой олон арван хууль, эрх зүйн баримт бичгүүдийг шинээр боловсруулан батлуулсан ажээ.

1994 оны 6 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан *“Монгол Улсын цэргийн номлолын үндэс”* нь цэргийн аюулгүй байдлыг хангах, гадаад, дотоод бодлогодоо баримтлах үндсэн чиглэлүүдийг тодорхойлж, цэргийн шинэчлэлийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэс болсон чухал ач холбогдол бүхий баримт бичиг байв. Социалист хамтын нөхөрлөлийн гэгдэж байсан орнуудын эгнээнд багтаж, тэдгээрийн дорнод хилийг хамгаалахад цэрэг, зэвсгээр оролцоход бэлэн байх агуулга бүхий цэргийн бодлогоосоо татгалзан, улс орныхоо аюулгүй байдлыг хангахдаа улс төр-дипломатын аргыг урьтал болгон хандахыг эрмэлзэх болсноо зарлан тунхагласнаар Монгол Улсын цэргийн шинэ номлолын гол ач холбогдлыг тодорхойлж болно. Энэ номлолыг шинэчлэн 1998 оны 5 дугаар сард Монгол Улсын Их Хурлаас *“Монгол улсын төрийн цэргийн бодлогын үндэс”* гэсэн баримт бичгийг баталжээ. Энэхүү баримт бичгийг УИХ-аас *“Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”* болгон өөрчилж баталжээ.

Үүний зэрэгцээ Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын түвшинд батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний шинэчлэлтэй холбогдох хөтөлбөр, үндсэн чиглэл зэрэг баримт бичгүүд гарч байв. Батлан хамгаалах бодлогын баримт бичигтэй нийцүүлэн батлан хамгаалахын хууль тогтоомжийг шинэчлэж 2016 оны 9 дүгээр сарын 1-нд УИХ-ын тогтоолоор *“Монгол улсын батлан хамгаалах тухай”*, *“Зэвсэгт хүчний тухай”*, *“Цэргийн албаны тухай”*, *“Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай”* багц хуулиудыг шинэчлэн батласан нь батлан хамгаалах салбарын эрх зүйн баримт бичгүүдийг үндсийг бүрдүүлж байна.

Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний эрх зүйн шинэчлэлийн хүрээнд БНМАУ-ын цэргийн дотоод албаны дүрэм, цэргийн сахилгын дүрэм, цэргийн хүрээний ба харуулын албаны дүрмийг шинэчлэн боловсруулжээ.

§3.2 Цэргийн удирдлагын тогтолцооны шинэчлэл

1993 онд батлагдсан *“Монгол Улсын батлан хамгаалах тухай”* хуульд батлан хамгаалах болон Зэвсэгт хүчний үйл ажиллагаа нь төр, иргэний хяналтад байх үзэл санаа тодорхой тусгагдав. Зэвсэгт хүчний тухайн үеийн байдал, хөгжлийн хэтийн төлөвт хийсэн шинжлэх ухааны дүгнэлтийг үндэслэл болгон, ардчилал хөгжсөн бусад орны жишгээр Зэвсэгт хүчний удирдлагыг ерөнхий болон цэргийн мэргэжлийн гэж байхаар зааглан салгаж, үүнтэй уялдан Батлан хамгаалах яам нь улс орны хэмжээнд төрийн батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг нэгтгэн чиглүүлж, уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байхаар тусгасан байна.

Зэвсэгт хүчин нь 2015 оноос эхлэн Хуурай замын цэрэг, Агаарын цэрэг гэсэн төрлийн цэргээс бүрдэхээр хуульд тусгасан байна.

§3.3 Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт

Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний тоог хорогдуулж, цэргийн нэгтгэл, ангиудын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт хийх, Зэвсэгт хүчнийг цаашид мэргэжлийн чиг баримжаатай болгон шинэчлэх бодлогыг ерээд оны эхнээс баримтлах болов. МАА-ийг цомхотгох, эдийн засгийн зардлыг бууруулах нэг арга нь анги, салбаруудыг хугацаат цэргийн алба хаагчгүй болгож, зөвхөн офицер, ахлагч, ажилтан, алба хаагчдаар бүрдүүлэх болсон юм. Өгүүлэн байгаа хугацаанд 20 гаруй ангийг байнгын бүрэлдэхүүнтэй болгосон нь тэдгээрийг цомхон чадварлаг болгох зорилготой байлаа.

Зэвсэгт хүчнийг мэргэжлийн цэргийн чиг баримжаатай, чадварлаг болгох талаар дэвшүүлсэн зорилтын хүрээнд Засгийн газрын 1997 оны 113 дугаар тогтоол гарч, Зэвсэгт хүчний зарим анги, салбарыг шинээр байгуулах, шилжүүлэн байрлуулах арга хэмжээг Батлан хамгаалахын сайдын баталсан хуваарийн дагуу 1997- 2000 онд багтаан явуулах ажил эхэлжээ. Түүнчлэн мотобуудлагын дивизийн бүтцээс бригадын бүтцэд шилжсэнээр мотобуудлагын 4 дивиз, 2 тусгай хороог мотобуудлагын 7 бригад болгон өөрчилж, их буу, инженер, хими, холбоо, ар тал, техникийн ангиудыг өөрчлөн зохион байгуулжээ. Мөн цэргийн удирдах байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтад томоохон өөрчлөлт хийв.

1996 оны 8 дугаар сард БХЯ-нд хийсэн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт нь Монгол цэргийн байгуулалтын түүхэнд гарсан зарчмын томоохон өөрчлөлт болов. Зохион байгуулалтын энэ өөрчлөлтөөр Монгол Улсын Батлан хамгаалахын сайдаар анх удаа энгийн хүн томилогдож, БХЯ, ЗХЕШ тус тусдаа бие даасан байгууллага болон салж, Батлан хамгаалах тухай хуулийн дагуу Зэвсэгт хүчний захиргааны болон цэргийн мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгтээ тохирсон бүтэц, зохион байгуулалттай болжээ.

Зэвсэгт хүчний шинэчлэлийн явцад нэгтгэл, ангиудын тайван цагийн бүтэц, зохион байгуулалтыг цомхон оновчтой болгох зорилтыг шийдвэрлэж Монгол Улсын Ерөнхийлөгчийн баталсан “Цэргийн байгуулалтыг 2005 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд Зэвсэгт хүчний ангиудыг хороо, батальоны цомхон бүтцэд шилжүүлж ангиудын тоог 1985 оныхоос 83,1 хувиар, 2000 оныхоос 32,6 хувиар цөөрүүлэн 9 ангийг татан буулгаж, гүйцэтгэх үүрэг, зориулалт ижил төсөөтэй байдлаар нь бусад анги, байгууллагуудтай нэгтгэн шилжүүлэн байрлуулж, офицер, ахлагч, ажилчин албан хаагчдын тоог 830 хүнээр, хугацаат цэргийн алба хаагчийн тоог 1300 хүнээр тус тус хорогдуулж, цэргийн гурван хотхоныг чөлөөлж орон нутгийн засаг захиргаанд шилжүүлсэн байна¹.

Мөн улс орны бүтээн байгуулалтын ажилд оролцох зориулалт бүхий барилга-инженерийн батальонуудыг байгуулсан байна.

§3.4 Зэвсэгт хүчний гадаад харилцаа өргөжсөн нь

Монгол Улс дэлхийн бүх улс гүрэнтэй харилцах харилцаанд найрсаг хөршийн, адил тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааны нийтлэг зарчмыг баримтлах тухайгаа бодлогын баримт бичгүүддээ тусгасан байна. Үүнтэй уялдан батлан хамгаалах салбарын гадаад харилцаа улам өргөжив.

ОХУ, БНХАУ, АНУ Монгол Улсад суугаа ЭСЯ-ныхаа дэргэд цэргийн атташегаа байнга суулган ажиллуулж байсны дээр 16 улс БНХАУ-д суугаа ЭСЯ-дын дэргэдэх цэргийн атташегаа манай улсад хавсруулан томилжээ. Өнөөгийн байдлаар батлан хамгаалах салбарт 22 улстай байгуулсан Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр болон яамд хоорондын “Харилцан ойлголцолын санамж бичиг” 60 орчмыг байгуулсан байна.

Монгол Улс 32 улстай батлан хамгаалах салбарт харилцаа тогтоон ажиллаж байна. Монгол Улсын Зэвсэгт хүчний гадаад харилцаа жил бүр өргөжин тэлж батлан хамгаалах салбарт хамтран ажиллах асуудлаар Засгийн газар хоорондын болон яамд хоорондын гэрээ, хэлэлцээрийг байгуулж, жилд дунджаар гадаадын 20 гаруй орны цэргийн 30 гаруй төлөөлөгчдийг хүлээн авч, манай салбараас жилд 20 гаруй төлөөлөгчид гадаадад албан ёсны болон ажлын айлчлал хийж, 7 улстай батлан хамгаалахын харилцааны асуудлаар жил бүр зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, дотооддоо олон улсын болон хоёр талын сургууль дадлага, уулзалт, семинар зохион байгуулж, гадаадад зохион байгуулсан адил төрлийн арга хэмжээнд манай 100 гаруй төлөөлөгчид оролцож байна.

Цэргийн мэргэжилтнүүдийг ОХУ-д сургах уламжлалт хэлбэр өргөжиж, тус улсад манай цэргийн алба хаагчид хөнгөлөлттэй нөхцөлөөр сурах болжээ.

Монгол, Оросын Зэвсэгт хүчнүүдийн хамтарсан хээрийн сургуулийг “Дархан-1,2,3” нэртэйгээр Монгол Улсын нутаг дэвсгэрт, 2011-2018 онуудад терроризм, хууль бус зэвсэгт бүлэглэлтэй тэмцэх асуудлаар хоёр талын хээрийн сургуулийг “Сэлэнгэ- 2011, 2012, 2013, 2014, 2015, 2016, 2017, 2018” нэртэйгээр жил бүр Монгол Улс, ОХУ-ын нутагт ээлжлэн явуулсан нь хоёр орны Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны нэгэн шинэлэг хэлбэр болсон байна.

2008 онд “Монгол Улсад зэвсэглэл, цэрэг-техник нийлүүлэх тухай” Монгол улсын БХЯ, ОХУ-ын БХЯ хоорондын гэрээ”-ний дагуу 82,8 сая ам.доллар буюу 115,7 тэрбум төгрөгийн өртөг бүхий зэвсэглэл, техник, материал хэрэгслийг хүлээн авсан нь нийт тусламжийн 94,4 хувь болж байжээ¹. 2010 онд ОХУ-аас манай Зэвсэгт хүчин буцалтгүй тусламжаар галын дэмжлэгийн нисдэг цэрэг Ми-24В 2 нэгж, Т-72 танк 34 нэгж, хуягт тээвэрлэгч БТР-80М 20 нэгж, хөдөлгөөнт засварын хэрэгсэл 1 иж бүрдэл, авто, хуягт техникийн болон артиллерийн сэлбэг хэрэгсэл хүлээн авчээ¹. Мөн онд ОХУ-аас “Печора 2М” загварын зенит пуужингийн цогцолбор хүлээн авсан байна.

БНХАУ-тай тогтоосон харилцаа энэ хугацаанд өргөжив. Сайдуудын түвшинд айлчлал, уулзалтуудыг тогтмол зохион байгуулж ирэв. БНХАУ-ын талаас манай Зэвсэгт хүчнийг хөгжүүлэхэд багагүй тусламж, хөнгөлөлтийг үзүүлж байна. Тухайлбал, 1993-2009 оны хооронд БНХАУ –аас Монгол Улсын Батлан хамгаалах салбарт нийтдээ 100 гаруй сая юанийн тусламж олгосон ба 2010-2014 онд нийт 40 сая юаны тусламжийг барилгын материалын хэлбэрээр олгосон байна. Энэхүү барилгын материалаар “Багабаян” дахь цэргийн амралтын газар “Энхийн төлөө” төвийг барьж ашиглалтанд оруулжээ. Монгол Улс, БНХАУ-ын БХЯ хооронд байгуулсан буцалтгүй тусламж үзүүлэх тухай протоколын дагуу 2013 оны 1 дүгээр сард Монгол Улсын Зэвсэгт хүчинд 10 сая юанийн тусламжийг /Автобус 18 нэгж, 289 архивын шүүгээ, 4 ш эмнэлгийн дадлагын хэрэгсэл/ өгчээ.

БНХАУ-ын сургалтын тусламжийн хөтөлбөрийн хүрээнд 1996-2014 онд манай 260 гаруй цэргийн алба хаагч БНХАУ-ын сургуулиудад суралцсан бөгөөд 2015-2020 онд Монгол Улсын Зэвсэгт хүчнээс 500 цэргийн алба хаагчийг Хятадын цэргийн их, дээд сургуульд суралцуулахаар шийдвэрлэсэн байна.

АНУ-тай тогтоосон харилцаа өмнөхөөсөө улам өргөжжээ. 1992-2010 онд монголын 270 гаруй цэргийн алба хаагчдыг АНУ-ын цэргийн сургууль, дамжаанд сургасан байна.

ХБНГУ-ын цэргийн удирдлагын академи, Бундесверийн их сургууль, батальон, рот, салааны захирагчийн дамжаанд манай 120 гаруй цэргийн алба хаагч суралцжээ. ХБНГУ-ын ХБХЯ-аас хүмүүнлэгийн тусламжаар “Монгол I, II, III, IV” төслүүдийг 1994-1996 онд хэрэгжүүлж, техник, эд материал, эмнэлэгийн багаж хэрэгсэл нийлүүлсэний үр дүнд нийт 18 сая 122 мянган ДМ, 50 сая төгрөг, үүнээс 17 сая 472 мянган ДМ-ын өртөг бүхий техник хэрэгсэл, хувцасыг БХЯ-нд нийлүүлсэн байна¹.

Турк, Энэтхэг, Англи, Канад, Япон, БНСУ болон бусад улстай тогтоосон харилцаа, хамтын ажиллагаа олон хэлбэрээр үргэлжилж байна.

§3.5 Монгол цэрэг энхийг дэмжих үйлсэд

Монгол Улсын зэвсэгт хүчний түүхэн дэх нэгэн цоо шинэ зүйл нь энхийг дэмжих ажиллагаа болно. НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд өөрийн цэргийн алба хаагчид, цэргийн багийг оролцуулах асуудалд 1999 оноос эхлэн Монгол Улсын Засгийн Газар санаачлан нилээд идэвхтэй бодлогыг хэрэгжүүлж иржээ.

Монгол Улсын Засгийн газар 1999 онд “Энхийг сахиулах ажиллагаанд оролцох тухай” 115 дугаар тогтоол гаргасан нь энэхүү үйл явцыг эрчимжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн маш чухал арга хэмжээ болсон юм. НҮБ-ын энхийг сахиулах байнгын хүчний тогтолцоонд хувь нэмэр оруулах талаар Монгол Улсын Засгийн газар ба НҮБ-ын хооронд 1999 оны есдүгээр сард харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан байна. Энэ нь Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багийг НҮБ-ын энхийн ажиллагаанд оролцуулах үндэс болсон бөгөөд 2002 онд хошууч Ч.Ерөөлцэнгэл, Р.Даваадорж нар Конго улсад НҮБ-ын цэргийн ажиглагчаар анх удаа явснаар манай Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид НҮБ-ын энхийн ажиллагаанд оролцож эхэлсэн билээ.

Монгол Улс 2009 онд Чад улс дахь энхийг сахиулах хүчний бүрэлдэхүүнд 264 цэргийн алба хаагч бүхий батальон илгээснээр НҮБ-ын энхийг сахиулах ажилд цэрэг илгээгч томоохон 20 улсын тоонд багтах болсон юм.

НҮБ-ын энхийг сахиулах ажилд оролцох эрх зүйн үндсийг бүрдүүлэх чиглэлээр багагүй ажлыг хийж, “Монгол Улсын цэргийн номлолын үндэс” баримт бичиг нь энхийг дэмжих ажиллагаанд оролцох эрх зүйн анхны үндсийг тавьсан байна. Шинэчлэгдэн батлагдсан “Төрийн цэргийн бодлогын үндэс” баримт бичигт Зэвсэгт түрэмгийллийн аюулаас сэрэмжлэх төрийн бодлогын үндсэн чиглэлд “НҮБ-ын үйл ажиллагаанд дэмжлэг, сайн санааны туслалцаа үзүүлэх, зуучлах, эвлэрүүлэх талаар хүлээсэн үүргээ НҮБ-ын дүрмийн дагуу биелүүлэх”¹ гэж тодорхойлсон ажээ.

Бие бүрэлдэхүүнийг энхийг дэмжих ажиллагаанд бэлтгэх ажлын хүрээнд 1999 онд ЗХЕШ-ын дэргэд энэ ажлыг гардан хариуцах үүрэгтэй Энхийг сахиулах

ажиллагааны албыг хурандаа Г.Рагчаагаар даргалуулан гурван хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан юм. Энхийг дэмжих ажиллагааны сэдвээр олон удаагийн сургалт, дадлага, семинарыг зохион байгуулж, гадаад улс дахь сургалт, дадлагад ч цөөнгүй оролцов. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох бэлтгэлийг хангах чиглэлээр нөр их ажлыг хийж гүйцэтгэжээ.

БХЯ, ЗХЖШ-аас тухайн үедээ мэргэжлийн шилмэл анги болгохоор төсөл хэрэгжүүлж байсан Зэвсэгт Хүчний 150 дугаар ангийг энхийн ажиллагаанд оролцох томилгоот анги болгон түүний сургалт, бэлтгэлийн агуулгад энхийг дэмжих ажиллагааны сургалтын элементүүдийг багтаасан өөрчлөлт оруулан мөрдүүлэв.

“Цэрэг цагдаагийн алба хаагчийг НҮБ-ын энхийг дэмжих болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай” Монгол Улсын хуулийн заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 87 дугаар тогтоол гарч, 2003 оны 8 дугаар сард “Иракийн эрх чөлөө” цэргийн ажиллагаанд анхны цэргийн багаа илгээснээр манай цэргийн багууд олон улсын энхийг дэмжих ажиллагаанд оролцох түүхэн үйл явдал эхэлсэн билээ.

Мөн Цэргийн хээрийн II шатны эмнэлгийг дэлгэн ажиллуулсан нь Монгол Улсын зэвсэгт хүчний гүйцэтгэх үүрэг өсөн нэмэгдсэний илэрхийлэл юм.

Манай цэргийн алба хаагчид цэргийн дипломат албанаас гадна НҮБ болон олон улсын бусад байгууллага, олон үндэстний цэргийн хүчний бүрэлдэхүүнд оролцон, үүргээ амжилттай гүйцэтгэж байв. Манай Зэвсэгт хүчний цэргийн баг, ажиглагчид Ирак (10 ээлжээр 1194 цэргийн алба хаагч), Сьерра-Леон (10 ээлжээр 2300 цэргийн алба хаагч), Косово (2 ээлжээр 72 цэргийн алба хаагч), Чад (1 ээлжээр 264 цэргийн алба хаагч), Этиоп-Эритрей (10 цэргийн ажиглагч), Гүрж (2 цэргийн ажиглагч), Афганистан, Конго, Баруун Сахар, Судан зэрэг орнуудад олон улсын байгууллагын мандаттай ажиллагаа болон олон үндэстний цэргийн хүчний бүрэлдэхүүнд үүргээ амжилттай гүйцэтгэж, манай Зэвсэгт хүчний төдийгүй Монгол Улсын нэр хүндийг дэлхийн тавцанд өргөхөд чухал хувь нэмэр оруулсан байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчин нь анх 2002 онд хоёр офицерыг БНАКУ дахь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд цэргийн ажиглагч офицeroор илгээснээс хойш өнгөрсөн 17 жилийн хугацаанд дэлхийн 3 тивд явагдсан НҮБ-ын 11 энхийг сахиулах, эвслийн цэргийн 4 буюу нийт 15 ажиллагаанд 16756 цэргийн алба хаагчаа оролцуулж, дэлхий нийтийн энх тайван, аюулгүй байдлыг тогтворжуулахад хувь нэмрээ оруулаад байна.

ТӨГСГӨЛ

XX зууны дунд үеэс эхлэн Зэвсэгт хүчнийг үлэмж хэмжээгээр цомхотгосон, улмаар дахин өргөтгөн байгуулсан түүхэн үйл явцыг энэ ботид дэлгэрэнгүй авч үзэв.

МАХЦ-ийг цомхотготгосон үйл явц тухайн үедээ зөв байсан байж болох ч хожмын үйл явдлуудтай харгуулан үзвэл шүүмжлэлтэй хандах зүйл цөөнгүй байх ажээ. Энэ жилүүдэд зэвсэгт хүчнийг зориулалтаар нь бэлтгэх, бэхжүүлэх бодлого алдагдаж, МАХЦ-ийг улс ардын аж ахуйн хөлсгүй хөдөлмөрлөх бэлэн хүч гэж үзэх бодлогыг хэрэгжүүлсэн явдал цэргийн бүтэц, байлдах чадварт сөрөг нөлөө үзүүлэв. Энэ он жилүүдэд МАХЦ-ийн зэвсэг, байлдааны техникийг шинэчилж чадаагүй бөгөөд энэ нь тавиад оны эцсээр уламжлалт морьт цэргийг өөрчлөн мотомеханикжуулсан арми болгон өөрчлөн байгуулахад багагүй бэрхшээл учруулсан юм.

Тавиад оны дунд хүртэлх үеийн МАХЦ-ийн түүхийн агуулга нь дэлхийн дайны дараа армийг цомхотгон өөрчлөн байгуулахын хамтаар цэргийг энхийн бүтээн байгуулах хөдөлмөрт оролцуулсан явдлаар тодорхойлогдоно.

Гэхдээ энэ он жилүүд нь МАХЦ-ийг (морьт цэргийг) орчин цагийн зэвсэгт тэмцэл явуулах чадвартай арми болгон өөрчлөн байгуулах шилжилтийн бэлтгэл үе байв.

Бидний авч үзэж буй он цагийн хүрээнд болсон нэг чухал үйл явдал нь баруун хилийн байлдаан юм. Олон жилийн турш тус улсын баруун хязгаарт Гоминдан болон Оспаны зүгээс хийж байсан дээрэм, зэвсэгт халдлагууд улам даамжирсаар байлдаан болж өргөжсөн бөгөөд түүнд хязгаарын цэргийн ангиудаас гадна МАХЦ-ийн анги, салбар оролцсон томоохон байлдаан болсон билээ.

Баруун хилд 1930-1940-өөд онд болсон үйл явдлыг Монгол Улсын түүх бичлэгт “зэвсэгт тулгаралт”, “Оспан, Гоминданы өдөөн хатгалга”, “баруун хилийн тулгаралт” хэмээн томъёолж нэрлэх болсон нь уг үйл явдлын цар хүрээ, ач холбогдол, үр дүн, сургамжийг үгүйсгэсэн хэрэг гэж үзэж болно. Иймээс баруун хилд олон жил үргэлжилсэн тэрхүү зэвсэгт халдлага, түрэмгийллийн эсрэг Монголын ард түмэн, төр засаг, цэрэг дайчдын явуулсан зэвсэгт тэмцлийг “Байлдааны ажиллагаа” гэж томъёолж нэрлэх нь зүйд нийцнэ.

Өнгөрсөн зууны тавиад оны дунд үеэс дэлхийн цэрэг-улс төрийн нөхцөл байдалтай уялдаж, дэлхий нийтийн цэргийн хэргийн чиг хандлагыг харгалзсан буудлагын улмаар мотобуудлагын цэрэг болгон өөрчлөх нөр их ажлыг эхлүүлсэн бөгөөд энэ нь хэд хэдэн үе шаттай үргэлжилж өнөөгийн Зэвсэгт хүчний дүр төрхийг бий болгосон ажээ.

БНМАУ-д 1990-ээд оныг хүртэл төр, засгийн үндэсний аюулгүй байдлыг хангах үзэл баримтлал, цэргийн номлол, батлан хамгаалах хууль гэж албан ёсны баримт бичиг байгаагүй юм. Монголын төр засаг, МАХН дайны шинж чанар, түүнийг явуулах арга, Зэвсэгт хүчний байгуулалтын зарчмын үндсэн асуудлаар ЗХУ-ын цэргийн бодлого, шинжлэх ухаан, номлолыг баримталж байв.

Төр засаг, МАХН-аас 1950-иад оны сүүлчийн хагасаас 1990-ээд оны эхэн хүртэлх хугацаанд батлан хамгаалах салбарт баримталж ирсэн бодлого, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд улс орныг батлан хамгаалах үйл хэрэг зохих төвшинд тавигдаж, батлан хамгаалах тогтолцоо бүрэлдэн төлөвшиж, батлан хамгаалах системийн нийт байгууллагын үйл ажиллагаа, нэр хүнд мэдэгдэхүйц дээшлэв. Хүн амын батлан хамгаалах ухамсар төлөвшиж, батлан хамгаалах сурталчилгаа, цэргийн сургалтанд оролцох оролцоо сайжрав.

МАА-ийн 1956-1990-ээд оны түүх нь улс орны батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх, армийг өргөтгөн зохион байгуулах талаар МАХН, төр, засгийн цэргийн бодлогыг амьдралд хэрэгжүүлэхийн төлөө явуулсан цэргийн дээд командлал, бүх шатны дарга, захирагч, штаб, улс төр, нам, олон нийт, ар талын байгууллага, нийт дайчдын хамтын хөдөлмөр зүтгэлийн түүх юм. Армийн дайчдын нөр их хөдөлмөр, зүтгэлээр бүтээсэн МАА-ийн энэ хугацааны түүх нь Монгол цэрэг, МАА-ийн түүхийн тодорхой зурвас үеийн бие даасан томоохон үе шат мөн.

Энэ бүлгийн сүүлчийн шатан дахь Зэвсэгт хүчний үйл ажиллагаатай холбогдсон нэлээд асуудлууд цаг хугацааны хувьд түүхчлэн бичих болоогүй тул зарим баримт, үнэлэлт дүгнэлт дутуу дулимаг мэт санагдаж болохыг уншигчид ойлгоно байх.

Монгол Улсын Зэвсэгт хүчин Үндсэн хууль, Батлан хамгаалах болон бусад цогц хууль, үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын үзэл баримтлал, цэргийн номлолынхоо дагуу бүтэц, зохион байгуулалт, сургалт хүмүүжлийн ажлын агуулга,

арга хэлбэрээ шинэчлэх, эх орноо батлан хамгаалах үүргээ шинэ цаг үе, нөхцөл байдалд хэрэгжүүлэх түүхийн шинэ үедээ орлоо.

Монгол Улс олон улсын энхийн үйл явцад хувь нэмрээ оруулж ирсэн өнгөрсөн 10 гаруй жилийн түүх нь улс төрийн онцгой ач холбогдолтой, алсыг харсан зөв алхам болсон төдийгүй “жигжиг орны том бодлого” болсныг гэрчлэн харуулж байна.

Манай энхийг сахиулагчид аливаа сорилт, бэрхшээлийг үл огоорон, эх орныхоо даалгасан үүргийг нэр төртэйгээр гүйцэтгэсээр ирсэн нь тэднийг дэлхийд данслагдсан “цэнхэр дуулгатан” хэмээх алдрын зэрэгт хүргээд зогсохгүй, тэд маань өнөөдөр нэгэнт эх орныхоо “нэрийн хуудас” болж байгааг бахархахгүй байхын аргагүй билээ.

ДҮГНЭЛТ

Эртний улсууд нь цөм төрийн байгууламжийн хувьд нэгдмэл төвлөрсөн хэлбэрийн улсууд байсан бөгөөд цэрэг-захиргааны аравтын тогтолцоонд тулгуурласан төр, цэргийн нэгдмэл зохион байгуулалт, улсыг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваариар баруун, зүүн гар, төв хэмээн хуваасан “гурван гарын тогтолцоо” нь Монголын нутаг дэвсгэр, төр улсыг байгуулан оршин тогтнож байсан монгол угсаат дараагийн улсуудад уламжлагдан хэрэглэгдэж байжээ. Тийнхүү эртний Хиан улсын үеэс үүдэлтэй төрт ёс, цэргийн байгууламжийн тогтолцоо Хүннү, Сүмбэ, Нирун, Хятаны зэрэг улсын үед улам нарийн, боловсронгуй болсоор Их Монгол улсын үетэй золгожээ. Тухайлбал, эртний төрт улсууд болох Хүннү, Сяньби /буюу Сүмбэ/, Жужан /буюу Нирун/, Тоба Вэй, Муюн, Хятан /буюу Кидан/ нар нь дорно дахинаас үүдэлтэй цэрэг – захиргааны аравтын тогтолцоог уламжлан авч төгөлдөржүүлэн сайжруулсан нь хожимоо Их Монгол Улсад мянгатын тогтолцоог буй болгох үндэс суурь болж өгчээ.

Хүннү, Сүмбэ, Нирун, Хятан зэрэг монгол нутагт тогтож байсан эртний улсуудын гол дайсан нь ямагт Хятадын нутагт ээлж дараалан тогтож байсан нангиад удмын улсууд байсан бөгөөд нүүдэлчид цэрэг, зэвсгийн хүчээр хятад болон хөрш зэргэлдээх улс орнуудаас огтхон ч дутаж байгаагүйгээр барахгүй зарим талаар илүү гарч байсны баталгаа нь тэдгээр улсуудад ноёрхлоо тогтоож байсан явдал юм. Гэвч түүхийн тодорхой тодорхой үе цагт нүүдэлчин монголчуудыг бусдын өмнө хүчин мөхөсдөхөд хүргэж байсан гол шалтгаан нь гагцхүү дотоодын хямрал буюу баяжин хүчирхэгжсэн ноёд, язгууртнуудын эрх мэдэл, алдар нэр, эд баялгийн төлөөх тэмцлээс үүдсэн эв нэгдэлгүй байдалтай холбоотой байсныг бидний энэ судалгаа ч нотлон харуулж байна.

Мөн монгол угсаатныг нэгтгэж ирсэн эртний төрт улсуудын уламжлал нь хожим хойно нэгэн хэл, нэгэн зан заншил, хэв болон бичгийн хууль цааз, цэрэг-захиргааны нэгэн тогтолцоотой үндэстэн улс буй болгох урьдач нөхцөл болсон байна.

Тэдгээр улсуудын цэргийн бүтэц, зохион байгуулалт, зэр зэвсгийн хүчин чадал, байлдааны арга технологи нь тухайн цагтаа бусад ямар ч улс орноос

дутахгүйгээр барахгүй, зарим зэвсэг, ялангуяа харвуул зэвсгээр тэргүүлэх хэмжээнд байсан нь тэдгээрийн дайн байлдааны ажиллагаа, ялалт амжилтаас тодорхой байна. Монголчууд түүхэндээ хоёр удаа “дэлхийг донсолгож” асаны эхнийх нь хүннүтэй холбоотой нь тэр үед цэрэг зэвсгийн хүчээр тэргүүлж байсны хөдөлшгүй нотолгоо бөгөөд бидний судалгаанд дурдагдсан хүннүгийн зэвсгийн төрөл хэлбэр, бүтэц хийц ч үүнийг илтгэн харуулж байна. Тиймээс Л.Н.Гумилевын өгүүлснээр чухамдаа “Хүннүчүүд л хятадын түрэмгийллээс тухайн үедээ дэлхий дахиныг авран хамгаалсан” агаад улмаар урт удаан хугацааны амь хайргүй тэмцлийнхээ үр дүнд гол дайсан болох хятадын Хан улсыг бутцохин мөхөөсөн байна. Түүгээр барахгүй хятадууд хүннү цэргийг дууриан “Хүннү маягийн морьт цэргийг үүсгэн, хүннүгийн гутал, хувцсыг хэрэглэж, нум сумаар харвах хийгээд байлдааны бусад арга тактикийг нь хуулбарлан дуурайж байсан” болон эмээл, дөрөө хэрэглэхээс эхлээд агт морио хуяглахыг хүртэл олон улс даяар таниулсан нь дэлхий дахины цэргийн хэрэгт өвөг дээдсийн маань оруулсан үнэтэй хувь нэмэр юм.

Монголын эртний төрт улсуудын цэрэг-захиргааны байгуулалт хийгээд төрийн тогтолцоо, дайн байлдаан, зэр зэвсгийн түүх нь тус бүрдээ биеэ даасан судалгааны асуудлууд бөгөөд энэ чиглэлээр түүх, археологи, угсаатны зүй, төр эрх зүйн түүх, цэргийн эрх зүй, цэргийн байгуулалт, антропологийн талаас нь нарийвчлан судлах шаардлага зүй ёсоор урган гарч буй нь судалгааны явцад харагдаж байна.

-Хамаг Монгол, Их Монгол Улс байгуулагдсан нь монголын төдийгүй дэлхийн түүхийн онцгой нэгэн үзэгдэл байсан бөгөөд эдгээр улсыг байгуулахад тухайн үеийн монгол цэрэг тэргүүн зэргийн үүрэг гүйцэтгэжээ.

-Их Монгол Улс байгуулагдмагц хөрш орнуудын аюул занал идэвхжиж, үүний улмаас монголчуудын аян дайн эхэлжээ. 1205-1260 оны хооронд 55 жил буюу монгол тооллоор бараг нэгэн жарны турш харьд хийсэн их аян дайны шалтгаан нь Их Монгол Улсынхаа тусгаар тогтнолыг аюулаас хамгаалахын төлөө тэмцэл байсан учраас өөрийгөө хамгаалах шударга дайн хийжээ.

- Дайны зорилгоо хэрэгжүүлэх арга нь маневрын болон сэтгэл зүйн дайны шинжийг агуулж байна.

-Өөрөөсөө хэдэн зуу дахин илүү цэрэг, хүн амтай улс орнуудыг Их Монгол Улсын цэрэг ялан дийлж байсан нууц нь нүүдэлч соёл иргэншлийн давуу чанарт шүтэлцсэн цэргийн байгуулалт, цэргийн урлагийн зарчмуудыг яв цав баримталсан, бүтэц, зохион байгуулалт төгөлдөр, хурд, маневрын чадвараар тухайн үедээ хэтийдсэн монголын хөнгөн морьт цэргийн гайхамшигт оршин байжээ.

- Орчин үед дайн, байлдаан энэрэнгүй /хүмүүнлиг/ байх тухай ярьж, олон улсын хууль ч үйлчлэх болжээ. Тэгвэл энэ үзэл санааг Их Монгол Улсын хаад, жанжид дундад зуунд баримтлан хэрэгжүүлж байсныг түүхийн баримтууд өгүүлж байна.

-Хамаг Монгол, Их Монгол Улсыг байгуулан төвхнүүлэх тэмцлийн явцад монгол цэргийн жанждын хэдэн үе өсөн торниж, монгол цэргийн урлагийг төгс төгөлдөрийн туйлд хүргэж өгчээ.

-Тэдний үлдээсэн цэргийн соёл,цэргийн байгуулалт, цэргийн урлагийн зарчмуудын үзэл санаа, өнөөдөр ч ач холбогдлоо алдаагүй, сургамжтай хэвээр байна.

Хубилай хаан Сүн улсыг мөхөөж Хятадын умард, өмнөд хоёр хэсгийг нь нэгтгэж Монгол төрийн нэгэн жолоонд оруулсан нь одоогийн бидний “Хятад” хэмээн нэрлэх болсон хан үндэстний олон зуун жилийн хагарал тэмцлийг зогсоож, хожим нь “Дундад улс” хэмээн өөрснийгөө нэрлэх болсон их гүрэн байгуулагдахын үндэс суурь болсон түүхэн их ач холбогдолтой үйл явдал байсан билээ.

Монгол цэрэгт сайн дураар элссэн, дагаар орсон, олзлогдон ирсэн олон улс орны цэргийн мэргэжилтэн, урчууд дархчууд Монголын эзэнт гүрний аж үйлдвэрийн салбарт ажиллаж өөр, өөрийн өвөрмөц арга технологийг нэвтрүүлэн бие биенээс харилцан суралцах боломж нээгдсэн байв. Тиймээс Монгол цэргийн хэрэглэж байсан зэр зэвсэг нь хүртэл тухайн үедээ өвөрмөц агаад шинэлэг зүйл олонтой байжээ. Монгол нум сум л гэхэд хамгийн хүчтэй, төгс төгөлдөр, хатангу хатууд тооцогдож байсан бөгөөд дарийг хятадад нээсэн хэдий ч дэлхий дахинд түгээн дэлгэрүүлэгч нь монголчууд бөгөөд бүр Хятаны үеэс галт буу үйлдэх болж, XIII зуунд усан онгоцон дээр гол төмөрт их буу суурилуулан тулалдаж байснаараа анхдагч нь байв. Хятад хэдийгээр галт, дарьт зэвсэг, гал чулуу урвуур, хүчит харвуур зэрэг олон төрлийн зэвсэг, техникээр тухайн үедээ тэргүүлэгч улс орны хэмжээнд байсан боловч монгол цэрэг тэднээс дутуугүй хүчтэй зэр зэвсэгтэй байсныг Юань улсын цэргийн их ялалт амжилт, Азид хийсэн аян дайных нь түүх харуулж байна. Зөвхөн "Хотон буу"-г хэрэглэсэн түүхийг аваад үзэхэд л монгол зэвсэг хятадынхаас юугаараа давуу байсныг харуулах бодит баримт болно. Энэ нь дээр өгүүлсэнчлэн монголын үйлдвэрлэхүй хүчин, түүний дотор зэр зэвсгийн технологи нь ялангуяа араб, перс хийгээд бусад улс орны болон монголчуудын өөрсдийнх нь эрдэм ухаанаар бүтсэн техник, технологийн огтлолцол дээр бүтсэн цоо шинэ зүйл байсны тод томруун жишээ юм.

Түүний зэрэгцээ Хятад зэрэг дорнын улс орны цэргийн хэргийн хөгжил монгол цэргийн зэр зэвсэг, цэргийн хэргийн хөгжилд ч бас ихээхэн түлхэц өгсөн билээ.

Энэ нь Чингис хаанаас эхлэн түүний үе залгамжлагч монголын их хаад, түүний дотор Хубилай сэцэн хаан болон түүнийг залгамжлагчид үйлдвэрлэл, шинжлэх ухааныг хөгжүүлж, цэрэг армия хамгийн сүүлийн үеийн шилдэг зэвсэг техникээр хангахад онцгой анхаарч байсны үр дүн. Монголчууд олон улсын цэргийн байлдах, дайлах эрдэм ухааны хөгжилд ч шинэ эргэлт гаргажээ. Дундад эртний монгол жанжнууд дан морьт цэргийн хувьсах хөдөлгөөнд тулгуурласан өвөрмөц стратеги, тактикийг боловсруулан хэрэгжүүлж байсан нь зөвхөн тэр үедээ, дорно дахинд төдийгүй, дэлхий дахины хэмжээнд аваад үзсэн ч цоо шинэ зүйл байсан төдийгүй орчин үеийн цэргийн стратеги, тактикийн үндэс суурь болсон “Маневрийн дайн”-ы эх хувилбар болж өгсөн билээ.

Ийнхүү Юань улсын цэргийн жанжнууд, дундад эртний бусад монголчуудынхаа нэгэн адил дэлхий дахины цэргийн хэргийг хөгжүүлэхэд ихээхэн түлхэц өгснийг тэдний түүх харуулж байна.

Нэг. Алтан ордны улс, Цагадайн улс, Ил хант улс нь эртний уламжлалт “Гурван түмний” буюу “Гурван гарын тогтолцоо” бүхий цэрэг-захиргааны нэгдмэл шинжтэй байгуулалттай байжээ.

Энэхүү “Гурван түмний тогтолцоо” нь наанадаж Хүннүгийн үеэс уламжлалтай бөгөөд орчин үеийн ойлголтоор бол “Орон нутгийн хамгаалалт”-ын өвөрмөц нэг хэлбэр ч гэж тодорхойлж болно. Учир нь тэр үед нийт улсыг төвийн түмэн, баруун, зүүн түмэн гэсэн үндсэн 3 хэсэгт хуваадаг байсан ба аливаа байлдаанд цэргээ мөн л их гол, баруун, зүүн гар гэж хуваан тулалддаг, бас тийнхүү гурван гарлахыгаа “Гурван түмэн болж” гэж нэрлэсэн байдаг. Тэр үеийн энэхүү цэрэг-захиргааны “Түмэн” гэдэг ухагдахуун нь яг таг 10000 гэсэн тоон утгыг илэрхийлдэггүй, харин одоогийн “Ард түмэн” гэдэгчлэн олныг заасан нэр томъёо байв.

Алтан ордны улс, Цагадайн улс нь мөн л тэр ёсоор төв, баруун, зүүн түмэн (гар, оросууд жигүүр ч гэсэн байдаг) гэсэн үндсэн гурван хэсэгт хуваагдаж байв. Энэ бүтэц нь цаашид ч олон жил уламжлагдан явсан юм.

Хоёр. Алтан ордны улс, Цагадайн улс, Ил хант улсын цэрэг нь эртний уламжлалт аравтын тогтолцоонд тулгуурласан мянгатын байгуулалттай байжээ. Өөрөөр хэлбэл цэргийн байгуулалтын хамгийн бага нэгж нь аравт бөгөөд бие даан харьцангуй томоохон хэмжээний байлдаан явуулах чадвартай тактикийн дээд нэгж нь мянгат, оперативын хэмжээний нэгж нь түмт байсан байна.

Алс аялан дайлах үед мянгат, түмтүүдийг ихэвчлэн гол, баруун, зүүн гар гэж хуваарилан гурав гурваар нь илгээдэг. Мөн одоогийн “түргэн байрлуулах хүч” маягийн үүрэг бүхий “Тамачин” хэмээх цэргийг томилон байлдааны үүрэг гүйцэтгүүлдэг байжээ.

Гурав. Улсын цэрэг нь хуурай замын болон усан замын буюу усч цэрэг гэсэн үндсэн хоёр том “ай”-д хуваагддаг ба хуурай замын цэрэг нь морьт, явган болон одоогийн томъёоллоор тусгай мэргэжлийн цэргийн түмт, мянгатуудаас бүрдэл болдог байжээ. Энэхүү тусгай мэргэжлийн цэрэгт их бууны (галт буу, чөдөр оньс, урвуур харвуураар зэвсэглэсэн), инженерийн (цайз, бэхлэлтийг эвдэх түншүүр, тэсэлж дэлбэлэх, гал, утаан хөшиг тавих, суваг шуудуу ухах юм уу бөглөж таглах, хүрээ хороо байгуулах гэх мэт үүрэг гүйцэтгэх), ар тал хангалтын (зэр зэвсэг үйлдвэрлэх дархчууд, эмч домч, хөтөч гэх мэт хүмүүсээс бүрдсэн, мөн өртөө зам хариуцсан нэгжүүд) гэх мэт нэгжүүд хамаарна.

Түүнээс гадна олзны цэрэг, иргэдээс бүрдүүлдэг “Хашал” (Хашар ч гэсэн байдаг) түр зуурын тусгай багуудыг байгуулж хот, цайзыг дайлах байлдаанд манлай цэргийн өмнө илгээж хотыг тойруулсан хамгаалалтын гуу жалгыг бөглүүлж таглуулах, хотыг тойруулан шөрөг хүрээ босгуулах гэх мэт үүрэг байлдааны үүрэг гүйцэтгүүлдэг байжээ.

Дөрөв. Алтан ордны улсын цэрэг нь бүрэлдэхүүний хувьд анх улс байгуулах үед Зүчид хувь болгон өгсөн харьяат иргэн болох 9000 албат иргэн, 4000 цэрэг, мөн Их Монгол Улсыг байгуулах үед нутгаасаа дүрвэн гарч кибчагтай нийлсэн байсан найман, хэрэйд, мэргэдийн үлдэгдэл болох монголжин овог аймгийнхнаас гадна кибчаг, булгар, огуз, орос, алан, черкес, армян, мордов зэрэг олон үндэстэн угсаатнаас бүрдэл болж байснаараа онцлог байв. Харин Цагадайн улсын цэрэг нь 1206 онд Чингис хаан эх, хөвүүд, дүү нартаа улс иргэнийг хувааж өгөхөд Цагадайд оногдсон 8 мянган иргэний ихэнх нь *Жалайр, Барлас, Каучин [Хуучид]* болон *Арлуад*

аймгийн харьяат байв. Дараа нь Чингис хаан тэнгэрт халихын өмнө хөвгүүддээ их цэргээ хувааж өгөхөд Цагадайд 4 түмэн цэрэг мөн оногджээ.

Харин тэднийг ихэвчлэн аравтын тогтолцоогоор зохион байгуулж байсан нь тэдгээр улсуудын хувьд шинэлэг агаад удирдлагыг тодорхой, шуурхай болгож өгсөн, зохион байгуулалтын дэвшилтэт арга хэлбэр байжээ. Цэргийн гол хүч нь монгол цэрэг, ханы дэргэдэх гол тулгуур болсон шадар хишигтэн нь цэргийн зонхилох нь ч дээр дурдсан монголжин овог аймгийн цэрэг байжээ.

Харин нийт цэргийн тооны хувьд авч үзвэл дийлэнх олонхийг нь исламын шашинт түрэг гаралтай хүмүүс бүрдүүлж байсан ба Алтан ордны улсын хувьд үнэн алдартны болон католик шашинт слав гаралтай болон кавказын уулынхан ч алба хашиж байжээ. Харин Цагадайн улсын цэрэгт ислам шашинт ард иргэд түлхүү зонхилж байжээ. Гэхдээ үе үеийн хангуудын цэргийн бүрэлдэхүүн, хүн хүчний тоо харилцан адилгүй байсан байна. Тухайлбал: Алтан ордны улсын Бат, Бэрх, Мөнх-Төмөр, Тохта нарын үед 250 мянга, Узбек, Жанибег, Тохтамыш хангуудын үед 170 мянга орчимд тус тус хэлбэлзэж байжээ.

Тав. Монгол цэргийн жанжнууд дайн, байлдаанд тоог бус чанарыг эрхэмлэх зарчмыг тууштай нэвтрүүлж, ямагт цөөнөөр олныг ялан дийлэх ухааныг сийлж, маневрын дайны стратеги, тактикийн өвөрмөц аргуудыг хэрэглэж байсан нь тэр үеийн дэлхий дахины цэргийн урлагт цоо шинэ зүйл байв.

Монголчууд стратегийн төвшинд:

-Эн түрүүнд стратегийн тагнуулыг сайтар зохион байгуулж, дайсны талаар шаардлагатай бүхий л зүйлийг тагнан судалдаг. Тэгэхдээ цэргийн тагнуулын албыг дэлхийн түүхэнд анх удаа байгуулан ашиглаж байсан бол Европын армиудад бүр хожим, тухайлбал XIX зуун хүрч байж л сая Жанжин штабын мэдлийн тусгай албад бий болгосон бөгөөд тэр үеэс л болзошгүй дайснаа урьдчилан тагнах ажиллагааг байнга явуулах болсон ажээ.

Мөн монгол цэрэг гадагш дайлах болсон цагаас эхэлж дагнан стратегийн тагнуул хийх, дайсан этгээдийн гэнэтийн ажиллагаанаас гол хүчээ сэргийлэн халхлах, дайлан өнгөрсөн газар нутагт гарч болзошгүй бослого, үймээнийг дарах үүрэгтэй “Тамачин цэрэг” хэмээх гавшгай цэргийн ангиудыг тусгайлан томилох болжээ.

Тийнхүү стратеги, тактикийн тагнуулыг маш нарийн зохион байгуулдаг байсан нь дайны талбарт амжилт олохынх нь нэг үндэс болдог байв;

- Тагнуул, судалгааныхаа үндсэн дээр дайны ажиллагааны театр буюу байлдаан явуулах газар орныг урьдчилан бэлтгэж төхөөрөмжлөх арга хэмжээг авдаг.Энэ нь одоогийн цэрэгт шинэ юм биш боловч тэртээ XIII зуунд бол шинэлэг зүйлийн нэг байв ;

-Дайсан улсаа бусад улс оронтой эвсэн нэгдэхээс урьдчилан сэргийлж, ганцаардуулах ажиллагааг цэргийн хийгээд улс төр, дипломатын бүхий л шугамаар явуулдаг.

-Дайн, байлдааны ажиллагааг тодорхой тодорхой үе шаттайгаар нарийвчлан тооцоолж гаргадаг;

-дайныг эхлэхдээ дайсныхаа хүчийг тарамдуулж, хэсэглэн хувааж цохих зорилгоор гол чиглэлд үндсэн хүчээ төвлөрүүлэхийн зэрэгцээ дайсныхаа нутаг дэвсгэрт аль болох олон чиглэлээр зэрэг довтолдог.

Монгол цэрэг хэдий олон салж, хэдий олон чиглэлээр аялан явавч шийдвэрлэх тулалдаан хийх газарт нэгэн зэрэг тал талаасаа хуралдан ирж чаддаг, тэгэхдээ хожимдох нь бүү хэл урьтаж түрүүлэлгүйгээр, яг тогтсон цагтаа ирдэг байсан ба аялан дайлах ийм зарчмыг Германы цэргийн нэрт онолч Мольтке “Саланги явж, хамтдаа тулалдах” хэмээн томъёолсон нь одоогийн цэргийн урлагийн хэвшмэл нэгэн нэр томъёо болжээ;

-монголчууд ямар нэгэн улстай дайтахдаа хүчээ ерөнхийд нь манлай, их гол, баруун, зүүн гар хэмээн хуваахаас гадна онцлог чухал чиглэлүүдэд стратегийн зориулалтаар тусгай замын түмтүүдийг томилон, туулан өнгөрсөн газруудын орчимд “Тамачин” цэрэг суулгадаг байжээ

-“Стратегийн гэнэдүүлэлт”-ийг чадамгай гүйцэтгэж, одоогийн хэллэгээр “Маневрын дайны стратеги”-ийг дэлхийн түүхэнд анх удаа хэрэгжүүлсэн;

-дайсагнагч улсынхаа цэрэг, хүн амын сэтгэл санаанд нөлөөлөх зорилгоор цэрэг дайны хөлөөс урьд сэтгэл зүйн хүчтэй довтолгоон хийдэг;

-Чингис хааны үеэс эхлэн монголчууд аль ч шашныг үл гадуурхах бодлогыг стратегийн төвшинд ч хүртэл хэрэгжүүлж байв

-монголчууд дайснаа бутран сарнисан ч гэлээ бүрэн устгаж сөнөөх хүртлээ мөрдөн хөөдөг байсан ба тэр нь тухайн үед Европынхон дайснаа зөвхөн бутраагаад орхидог байснаас онцлог байв

-цэрэг арми нь хангалтын нүсэр том бааз буюу “Ар тал” хэмээн одоогийн цэргийн нэрлэдэг зүйлээс огт хамааралгүй, Эрэнжен Хара-Даваны өгүүлсэнчлэн “хувь хувьдаа өөрийн “Бааз”-ыг авч явдаг” байсанд, мөн зүйрлэн хэлбэл ар талдаа биш, харин урд талдаа хангалтын “Бааз”-тай байсанд цэргийн хангалтын онцлог оршиж байв. Өөрөөр хэлбэл “Дайн дайнаа тэжээх ёстой” хэмээн Юлий Цезарийн өгүүлсэн хэмээх зарчмыг монголчууд жинхэнэ бодитойгоор хэрэгжүүлж байжээ.

Монгол цэрэг аянд явахдаа суурин харуул, алгинч, манлай, гол хүч, гээглүүр, ар цагдуул, хажуугийн харуул хэмээн хуваагдаж дайсны гэнэтийн довтолгооноос сэргийлэн хамгаалах бүхий л талын бололцоог бүрдүүлж явдаг байсан нь тэр үед өөр хаана ч байгаагүй нарийн зохион байгуулалт бөгөөд энэ нь харин ерөнхий бүрдэл хэсэг, зохион байгуулалтын зарчмын хувьд одоогийн цэргийн нэгтгэл, ангиудын аяны журамтай таарч байгаа юм.

Хээрийн байлдааны журам нь фронтын дагууд их гол ба зүүн, баруун гар гэдэг үндсэн гурван хэсгээс бүрдэх ба гүн тийшээ манлай, их гол, хөтөд хэмээх цувраануудаас бүрддэг байжээ.

Тактикийн түвшинд “Нуман түлхүүр байр хийх”, “Бух сэжүүр”, оросын түүх бичлэгт “Хоровод” хэмээн нэрийдсэн тасралтгүй суман мөндөр буулган довтолох өвөрмөц арга, “Алгинчлах” буюу байлдан тагнах арга, эртний уламжлалт “Өдөж хөдөлгөх”, “Нуур байрт байлдах”, “Бух сэжүүр байр хийх”, “Өлөмлөх”, “Дэрэлгэх”, “Тойрох”, “Бүслэх”, “Бүчих”, “Нүүр дээрээс нь асгах”, “Нохой хэрэл хэрэх”, “Харгана зорчил зорчих”, “Сундаргах”, “Гэнэтгэж, жич харин татах”, “Огторгуй эрвээлжлүүлэх”, хожим нь “Монголын Ла’ва” гэж нэрлэгдэж ХХ зууны морьт цэрэгт хүртэл уламжлагдан хэрэглэгдэж байсан арга тактик, мөн өрнөдийнхөн “Тулугама (Tulughama)” хэмээн нэрийдэх болсон тулгам байлдааны арга зэрэг олон аргыг хэрэглэж, цэргийн ов мэхийг дээд зэргээр ашигладаг байсан нь монгол цэргийн

эрдэм ухааны нэгэн онцлог байв. Эдгээр арга нь тэр үедээ өөр хаана ч хэрэглэж байгаагүй маневрын тактикийн арга хэлбэрүүд байв.

Зургаа. Алтан ордны улс, Ил хант улс, Цагадайн улсын цэрэг олон улс, үндэстний цэргээс бүрдэж байсан нь зэвсэглэл, хүн нэг бүрийн агсамжид нь ч тусгалаа олсон байв.

Тухайлбал Алтан ордны улсын цэргийн “Гол хүч” нь болж байсан монгол цэрэг нь дан морьт цэрэг болон одоогийнхоор бол их буу, инженерийн мэргэжлийн мянгат, зуутуудаас бүрдэж байсан бол булгар, кибчаг зэрэг бусад бүрэлдэхүүн улс аймгийн хийгээд орос, асуд мэт түшмэг улсын цэрэг нь морьт, явган, усч цэрэг зэрэг холимог бүтэцтэй байснаар үл барам тэдгээрийн ихэс ноёдынх нь шадар цэрэг, байнгын цэргийн шинжтэй “Дружинник”-үүд болон тариачид, эгэл ардаас бүрдүүлдэг дайчилгааны журамт цэрэг, Ижил орчим, Крым, Кавказ, бусад газраас гаралтай хөлсний цэргийн хэлбэрээр алба хашиж байсан цэрэг гэх мэт цэргийн зэвсэглэл нь өөр өөр байсан онцлогтой. Цагадайн улсын цэрэг нь ихэвчлэн Түрэг гаралтай ард түмнээс бүрдэж байсан бол Ил хант улсын цэрэг араб персүүдээс бүрдэж байжээ. Төв Азийн өнөөгийн ихэнх улс үндэстэн Цагадайн улсын цэрэгт алба хааж байжээ. Тэгвэл ойрх дорнодын ихэнх улс Ил хант улсын цэрэгт алба хааж байсан юм.

Гэхдээ монгол цэргийн гол зэвсэг нь нум сум хэвээр байсан ба цэрэг бүр байлдаанд наанадаж 2-3, түүнээс ч олон нумтай явдаг байжээ. Монгол цэргийн ердийн нум доод тал нь 30-32 кг-ын таталттай, 20-30 алхмын зайд тэр үеийн бараг бүх хуягийг нэвт харвадаг, сумны ашигтай тусгал нь 200-300 метр байсан бол хамгийн хүчит “Төмөр буюу болд ширхэгт нум” нь 70-80 кг-ынтаталт бүхий бөгөөд ашигтай тусгал нь 500-600 метр хүрдэг байжээ.

Монгол нум тухайн үедээ хамгийн хүчтэй, ончтой бөгөөд бараг ижил бүтэцтэй гэж одоо судлаачдын үзэж буй бусад нүүдэлчин улс аймгийн болон хятад, орос нумаас хүчин чадал, найдвараар илүү байсан тул Алтан ордны улсын бүрэлдэхүүнд багтаж байсан улс аймгийнхны нумын технологид шууд нөлөө тусгалаа олж, шинэчлэл өөрчлөлт хийхэд хүргэснийг эртний судлалын баримтууд нотолж байна.

Алтан ордны улсын болон Цагадайн улсын цэргийн бүрэлдэхүүнд багтаж байсан улс үндэстнүүд илд, жадны уламжлал сайтай бөгөөд мөн араб дахины дам нөлөөгөөр Их Монгол Улсын үетэй харьцуулахад монгол цэргийн хэрэглэж байсан илд, жад, бялуу шийдэм, байлдааны сүх зэрэг ойрын байлдааны зэвсгийн төрөл хэлбэр олшрон төгөлдөржиж, тэр үед Евроазид хэрэглэж байсан бараг бүх төрлийн цавчих, зүсэх, дэлдэх, занчих зэвсгээр өвч хангагдсан байжээ.

Гэхдээ Алтан ордны улс, Цагадайн улсын морьт цэрэгт хотгор илд харьцангуй их дэлгэрсэн байсан бөгөөд тэр нь морьт цэргийн цавчилдаанд бусад төрлийн илднээс илүү зохицолдолгоотой байсантай нь холбоотой байжээ. Харин Ил хант улсын цэрэгт араб даманск илд голлох байр суурьтай байжээ.

Мөн байлдаанд бие хамгаалах хэрэгсэл буюу хуяг, дуулга, халх бамбайны технологид ч хувьсал дэвшил гарч төрөл, хэлбэр нь олширсон онцлогтой байна. Гэхдээ XIII зуунаас хойш Алтан ордны бүрэлдэхүүн улсууд болон европын суурин улс орнууд “Хатангу дээл” мэт монгол хуягуудаас үлгэр авч жижиг тушим хэлхэн хийсэн уян хатан хуяг ихээр хэрэглэх болсон нь мөн л хэрэглээний зохицолдолгоо илүүтэй байсантай холбоотой байна. Тийм хийцийн хуягаа европынхон “Бригантина” (гер. Brigantine) гэдэг байсан ба оросууд монгол нэрээр нь “Куяк”

хэмээн нэрлэх болжээ. Монголчууд мөн төмөр цагираг хэлхэн үйлддэг байсан хөө хуяг (хөө дээл, цагираг хуяг, гархин хуяг, төмөр хуяг ч гэдэг байсан)-ийг ч хэрэглэдэг байсан ба ийм төрлийн хуяг орос, болгар, кибчагт ч ихэд дэлгэрчээ. Цагадайн улсын цэргүүд ч XIII зууны монголчуудын нэгэн адил ижил төрлийн хуяг хэрэглэж байжээ.

Бас монголчууд тушим ба гархийг хослон үйлдсэн хуягуудыг ч өргөн дэлгэр хэрэглэдэг байсан ба "Бэхтэр" хэмээх богино, дэглэй маягийн нэгэн төрөл хуягийг үйлдэхдээ цээж, суга, ташааны зарим газарт төмөр цагариган хэсгийг оруулж өгсөн байдаг байжээ.

Монголчууд хот суурин, цайз бэхлэлтийг дайлах эртний уламжлалтай бөгөөд XIII зууны Алтан ордны улсын, Ил хант улсын, Цагадайн улсын цэрэг ч тэр үедээ тэргүүлэх хэмжээнд байсан техник, технологийг эзэмшсэн, одоогийнхоор бол инженерийн тусгай мэргэжлийн мянгат, зуутуудтай, үүлэн шат, хуягт цамхаг, хуяг халхат тэрэг, урвуур, харвуур, чөдөр оньс зэрэг техник хэрэгсэлтэй байсан нь ялалт, амжилт байгуулахад нь шийдвэрлэх нөлөө үзүүлж байв. Ялангуяа Чингис хаан Хорезмын хаант улсыг байлдан дагуулах үед хот хэрэм эвдэх төрөл бүрийн зэвсгүүд уламжлагдан үлджээ.

Монголчууд Хятан (907-1125 он)-ы үед анх галт зэвсэг бүтээж, Их Монгол Улсын үеэс галт, дарьт зэвсгийг дайн байлдаанд өргөнөөр хэрэглэж эхэлсэн уламжлал Алтан ордны улсын үед улам хөгжиж иржээ. Монгол цэрэг кибчагуудыг мөшгин тулалдсаар өрнө зүгт цөмөрсөн их аян дайны үеэр Батын баруун гарын цэрэг Легницагийн дэргэд Польш, герман, чех зэрэг улсуудын нэгдсэн цэрэгтэй тулгарахдаа аймшигт их дуу чимээ, утаагаргадаг нэгэн шинэ төрлийн зэвсэг хэрэглэж ялсан гэж түүхэнд тэмдэглэжээ. Ямар боловч тэр үеэс монгол цэрэг галт, дарьт зэвсэг хэрэглэх болсон байсан нь баримттай байна.

Ийнхүү галт зэвсэг монголчуудаар дамжин Орос, Европ, төв Азийн бусад улсад нэвтэрсэн бөгөөд галт, дарьт зэвсэг нь XIII зууны үеийн Монгол цэргийн төдийгүй дэлхийн цэргийн хэрэгт шинэ үеийг авчирсан түүхтэй.

Долоо. Алтан ордны улс, Ил хант улс, Цагадайн улсууд оршин тогтносон хугацаандаа өөр хоорондоо болон бусад улс орнуудтай байлдан дагуулалтыг олонтоо хийж байжээ. Европ, ойрх дорнод, төв Ази гээд бүс нутгууд бүгд Алтан орд, Цагадайн улс, Ил хант улсын эрхшээлд байжээ. Дайн байлдаанд амжилт олж байсан учир шалтгаан нь ердөө Монгол цэргийн байлдах арга ухаан, зэр зэвсэг, стратеги тактик байжээ.

Аливаа улс орны албан ёсны нэрийдэл нь үндэсний тусгаар тогтнол, бие даасан байдал хийгээд гадаад, дотоод харилцааны үндэс суурь болж, олон улсын хэмжээнд зүй ёсоор хүлээн зөвшөөрөгдөхийн баталгаа, нэр төрийн хэрэг цэрэг, түүхийн судалгаанд чухал ач холбогдолтой юм. Гадаад, дотоодын түүхийн сурвалж, судалгааны зохиол бүтээлүүдэд XIV-XVII зууны үеийн Монгол улсын нэрийг "Мин улсын үеийн Монгол", Юань улс мөхсөний дараах Монгол, "Юаний үлдэгдэл", "Юаний хойчис", "Хуучин Юаний хүчин доройтсон ба Мин улсаас ван өргөмжлөл зассан үе", "Самуурлын үе", "Татар, Ойрад, Урианхайн аймаг", "Монголын хаант улс", "Бэйлу", "Нан Вэй", "Дөчин түмэн их Монгол улс", "Монгол, Ойрадын улс", "Улс төрийн бутралын үеийн Монгол", "Ар Юань улс", "Умард Өн улс", "Бага хаадын үе" хэмээн янз бүрээр бичиж тэмдэглэжээ. Харин монголын албан ёсны түүх судлалд өгүүлэн буй үе [XIV зууны II хагас -XVII зууны II хагас]-ийн улс орны нэрийн тухайд

1954 оноос “феодализм”, “феодалын бутрал”, 1966 оноос “ХIY-ХYII зууны үеийн Монгол орон”, 1968 оноос “ХIY-ХIХ зууны үеийн Монгол орон”, 1984 оноос “ХIY-ХYII зууны үеийн Монгол орон [Феодлын бутрал]” гэх зэргээр тэмдэглэсэн буй. Эдгээр нэр томъёо нь монголын түүх бичлэгт марксист онол, арга зүйн нөлөө хүчтэй дэлгэрч байсантай холбоотой юм. Өдгөө Монгол улсын албан түүхийн бүтээлд хууль цааз болон сурвалж бичгийн мэдээ баримтанд үндэслэн “Дөчин, Дөрвөн хоёрын үе”, “Монгол улсын үе” хэмээн авч үзэх болсон байна. Гэвч эдгээр нэрийдэл нь нийгэм, улс төр болон цэрэг, түүхийн асуудлыг хараахан бүрэн хэмжээнд тусган илэрхийлэх боломжгүй юм. Иймд сүүлийн үеийн судалгааны ажлын үр дүнд улс орны нэрийдэл болон тухайн цаг үеийн онцлогийг харгалзан “Эзэнт гүрний дараах үеийн Монгол цэрэг (ХIY зууны II хагас-ХYII зууны II хагас)” хэмээн нэрийдэх саналыг анхлан дэвшүүлсэн;

Монгол цэргийн цаазны шинж чанар, цэрэг-улс төрийн түүхэн ач холбогдлыг цэргийн түүх судлалын үүднээс тусгайлан судалж, үнэлэн дүгнэсэн;

Монгол цэргийн гадаад, дотоодод явуулсан дайн, байлдааны тоо баримтыг ойролцоогоор тооцон гаргаж, түүний ялалт, ялагдлын хувь хэмжээ, учир шалтгааныг тоон график аргаар судлан дүгнэх оролдлого хийсэн;

Монгол цэргийн зэр зэвсгийн хөгжлийн түүхийн асуудлыг тусгайлан авч үзэхдээ сүүлийн үеийн түүх, археологийн олдвор, баримт материалаар баяжуулан, цэргийн түүх судлалын үүднээс судлан шинжилж, судалгааны эргэлтэнд оруулсан зэрэг болно.

XVI зууны сүүлчээс XX зууны эхэн хүртэлх монгол цэргийн түүх бол бүхэлдээ харийн түрэмгийллийг эсэргүүцсэн, дотоодын эв нэгдлээ бэхжүүлэхийг оролдсон, улмаар Манжийн эрхшээлээс гарахыг эрмэлзсэн тэмцлийн түүх мөн.

1590-ээд оноос эхлэн Монголын зүүн хөрш Зүрчидийн Нурхачи баатар зүрчид аймгуудыг нэгтгэж, улмаар хөрш зэргэлдээ улс орнуудын талаар түрэмгий бодлого явуулж эхэлжээ. Манж нар Монголыг эзлэхийн тулд дан ганц эргийн хүч хэрэглэсэнгүй, хооронд нь хагалан бутаргаж хүчийг нь сулруулах, шан хишиг, хэргэм зэргээр урхихах гэх мэт олон аргыг хэрэглэж байв.

Лигдэн хаан тэргүүтэй Монголын эрх баригчид Манжийн түрэмгийллийн эсрэг тууштай тэмцсэн боловч бүтэлгүйтлээр төгсөж, 1636 онд Өмнөд Монгол Манжийн эрхшээлд орсон юм. Өмнөд Монголыг эзлэн авсны дараа манж нар Халх Монгол, Ойрадыг эрхэндээ оруулах бодлогыг тууштай явуулахдаа мөн л дээр дурдсан аргуудыг хэрэглэж байв.

Чин улс 1691 онд Халхыг, 1758 онд Зүүнгар улсыг тус тус эрхэндээ оруулав. Ийнхүү манж нар бүх Монголыг эзлэхэд 120 гаруй жилийн хугацааг зарцуулсан юм. Харийн эрхшээлд орсон үндсэн шалтгаан нь дотоодын хямрал, эрх мэдлийн төлөөх тэмцэлтэй холбоотой агаад хэрэв эе эвээ нэгтгэж чадсан бол манж нар цэргийн хүчээр тийм ч амархан эзлэх боломжгүй байсан билээ.

Монголчууд харийн эрхшээлд ямар ч эсэргүүцэлгүйгээр орсонгүй, эцсээ хүртэл эсэргүүцэн тэмцсээр байсан агаад Манжийн дарлалд орсны дараа ч түрэмгийлэгчдийн эсрэг бослого хөдөлгөөн тасраагүй билээ. Сүнидийн Тэнгис вангийн бослого хийгээд түүнийг дэмжсэн Халхын хаадын цэргийн үйл ажиллагаа,

Цахарын Бүрнн вангийн бослого, Хөхнуурын Лувсанданзан, Хойдын Амарсанаа, Хотогойдын Чингүнжав нарын бослого нь түүний тод томруун жишээ мөн.

Нөгөө талаар, өгүүлэн буй үед монголчууд зөвхөн Чин улстай байлдаад зогсохгүй, эхэн үедээ Хятадын Мин улс, бас Хаант Орос, Дорнод Туркестан, Хасаг, Киргиз, Узбек, Түвэд зэрэг улстай зэвсэг зөрүүлэн байлдаж байв. Тухайлбал, умар зүгээс хүч түрж газар нутгийг түрэмгийлсэн Хаант Оростой зэвсэг зөрүүлэн тулалдсаны жишээ бол Түшээт хан Чихундорж, Зүүнгарын Галданцэрэн нарын явуулсан тулалдаан юм.

Харин Дорнод Туркестан, Хасаг, Киргиз, Узбек, Түвэд зэрэг улстай Ойрад, Зүүнгар улс дайн тулалдаан хийж байсан нь улс орноо хүчирхэг болгох, үүний үндсэн дээр харийн түрэмгийллийг сөрөн зогсох гэсэн зорилготой холбоотой боловч заримдаа үүний эсрэг үр дүнд хүрэх тохиолдол байсныг үгүйсгэж болохгүй. Тухайлбал, Цэвээравдангийн Түвэдэд хийсэн аян дайн нь Түвэд, Хөхнуурыг Манжийн дарлалд бүрэн орох явдлыг улам түргэтгэж өгсөн гэж үзүүштэй.

Түүнээс гадна дотооддоо самууран байлдсан тохиолдол цөөнгүй бөгөөд эв эеэ нэгтгэхийн оронд ийнхүү харилцан эвдрэлцсэн нь харийн эрхшээлд орох суурь нөхцөл болсныг дурдах нь зүйтэй. Гэвч эдгээр дотоодын дайн тулааныг харийн түрэмгийлэгчдийн эсрэг хүчээ нэгтгэх гэсэн зорилготой дайн тулалдаан, бас зөвхөн эрх мэдэл, эд баялгийн төлөөх дайн байлдаан гэх мэтээр ялгаж үзэх боломжтой. Тэр дундаа Халх-Ойрадын олон жилийн тэмцлийг эцэс болгож 1640 онд Монгол-Ойрадын их цаазыг баталсан нь харийн эсрэг эв эеэ нэгтгэх гэсэн манай өвөг дээдсийн мэргэн бодлогын жишээ мөн.

Өгүүлэн буй үед дэлхийн цэрэг дайны түүхэнд эргэлт болсон галт зэвсгийн эрин үе нэгэнт эхлээд байсан учир урьдын хүлэг морь, хүчит нумаар гайхуулдаг монголчуудад ихээхэн халгаатай болж иржээ. Энэ үеийг “галт буу нум сумтай харшилдсан үе” гэж томьёолдог. Гэвч монголчууд тухайн үеийн технологийн том дэвшил болсон галт зэвсгийг хэрэглэж сураад зогсохгүй үхэр буу ч хэрэглэж байжээ. Гэхдээ цэрэг зэвсгээ бүрэн шинэчилж, галт зэвсгээр орлуулах боломж байгаагүй тул ихэнхи тохиолдолд урьдын адил нум сум, илд жад гол зэвсэг нь байж, галт зэвсэг бүхий харийн түрэмгийлэгчдийн өмнө хүчин мөхөсдөхөд хүрч байсныг Монголын ард түмний 1755-1758 оны зэвсэгт тэмцэл харуулдаг. Харийн эрхшээлд орсноос хойш ч зэр зэвсгийг бүрэн шинэчилсэнгүй, урьдын адил хоцрогдсон зэр зэвсэг ихэнх хувийг эзэлж байжээ.

Монголын цэргийн түүхэнд тод ул мөрөө үлдээсэн улс бол Зүүнгар улс агаад тэд өрнө зүгт байлдан дагуулал явуулж Монголын хамгийн сүүлчийн эзэнт улсыг байгуулсан юм. Галдан бошогтын Зүүнгар улсад тусгаар тогтнол, ард иргэнээ батлан хамгаалах чадвартай хүчирхэг армийг байгуулжээ. Цэргийн урлагийн хувьд, Эрдэнэ баатар хунтайж, Галдан бошогт нар улс орондоо галт зэвсэг анх нэвтрүүлж, цэргийн урлагийг энэхүү шинэ зэвсэгтэй уялдуулан цаашид хөгжүүлэхийг зорьж байжээ. Мөн ойрадууд “нуман түлхүүр”, “задын арга” зэрэг монгол цэргийн тактик, стратегийн зарчмуудыг уламжлан хэрэглэж байжээ. Зүүнгар улс өөртөө цэргийн төрөл бүрийн зэвсгийн үйлдвэрлэлийг бий болгож, өргөжүүлэхийг оролдож байсан нь цэрэг арми хүчирхэг байх үндсийг бэхжүүлсэн ажээ.

Цэргийн байгуулалтын хувьд, манж нар монголчуудыг эрхэндээ оруулсны дараа цэрэг-засаг захиргааны үндсэн нэгж болох хошуу болгон зохион байгуулаад,

хошууг дотор нь сум хэмээх цэрэг-захиргааны нэгжид хуваадаг байв. Гэвч энэ нь шинэ зүйл огт бус, харин Монголд хуучин байсан цэрэг маягийн зохион байгуулалтыг нь хэвээр үлдээж, зарим нэгэн өөрчлөлт оруулсан хэрэг болно. Монгол эрчүүдийг цэргийн албанд бүрэн дайчлахын тулд Манжийн төр хатуу чанд хууль дүрэм зохион мөрдүүлж байв. Манжийн ноёрхогчид монголчуудыг өөрсдийн цэрэг дайны хэрэгт ашиглахын тулд байнгын цэрэг дайны бэлтгэлтэй байлгахын төлөө хичээж байлаа.

Манж нар эрхшээлдээ оруулсан монголчуудын цэргийн хүчийг бусад улс орныг эзлэн түрэмгийлэх, бослого хөдөлгөөнийг дарангуйлахад ашиглахыг зорьж байжээ. Тухайлбал, Солонгосын Чосөн улсыг 2 удаа дайлахад Өмнөд Монголын цэрэг оролцсон, Хар тамхины дайн, Цагаан малгайтны буюу Дунганы бослогыг дарахад монгол цэргийг дайчлан оролцуулж байжээ.

Бас манж нар Зүүнгарыг байлдан эзлэх зорилгоор Халх, Өвөр Монголоос цэрэг дайчилж байсан агаад үүнд халхчууд илт дургүйцэж, байлдааны газраас цэргээ авч буцах зэргээр эсэргүүцэл үзүүлж байв. Мөн 1755-1758 онд Зүүнгарыг эзлэхэд Өвөр Монгол, Халх, Ойрад цэргийг дайчилсан боловч тэрхүү цэрэгт дайчлагдсан монголчууд, тэр дундаа халхчууд цэргийн албыг хаяж эсэргүүцэж байв. Ийнхүү монгол нь монголынхоо эсрэг дайтахад хүрч байсан нь монголчуудын өөрсдийн хүслээр болсон бус, харийнхны дарамт шахалтын доор болсон юм.

XVIII зууны дунд үед Зүүнгарыг байлдан дагуулах дайн дууссантай холбогдуулан, 1760 оны орчимд манжийн их цэргийг Ар Монголоос хойш татаж, оронд нь Халх, Солон, Захчин, Дөрвөд, Урианхайн 3 мянга шахам цэргийг зах хязгаарт хуваан суулгаснаас гадна Халхын дөрвөн аймгийн 4 мянган цэргийг Улиастайн орчим жил бүр лавлан боловсруулж байжээ. Гэвч үүнээс хойш 100 гаруй жил Ар Монголд дайн дажин гаралгүй, энх амгалан цаг байсан тул Хүрээний сайд, Улиастайн жанжин нар цэргийн бүртгэл буюу “эр төөлөх” ажлыг явуулахдаа нарийн чанд шалган үзэхээ үндсэндээ больж, тогтмол нэгэн тоо хэмжээгээр өргөн мэдүүлж, хээл хахуулиар энэ асуудлыг шийддэг болжээ. Түүнчлэн “авлан боловсруулах” гэх мэт цэргийн сургуулилт нь яваандаа ор нэрийн төдий, цэрэг эрийг боловсруулахад ямар ч тус нэмэргүй зүйл болон хувирчээ.

Ийнхүү манж нар нэг талаас монголчуудын цэргийн хүчийг ашиглах, нөгөө талаас тэднийг хүчирхэг цэрэгтэй байлгахад болгоомжилж байсан нь хоорондоо зөрчилдөж байжээ. Чин улсын төр улам бүр сулран доройтохын хэрээр дайн тулалдаанд анхаарал хандуулах нь багасаж, дээр өгүүлсэнчлэн орон нутгийн эрх баригчид ч цэргийн сургуулилалт, зэр зэвсгийн бэлэн байдлыг нарийн чанд шалгаж, шаардахаа больж, хээл хахууль аван худал мэдүүлдэг болсон нь монгол цэргийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлсэн нь тодорхой.

Тиймээс XVIII зууны эцсээс хойшхи Манжийн эрхшээлийн үе нь монгол цэргийн хөгжлийг зогсонги байдалд ороход хүргэсэн ажээ. Дэлхий нийтэд галт зэвсэг, өрнийн маягийн цэргийн боловсрол, тактик дэлгэрээд байхад харийн дарлалд байсан монголчууд урьдын адил хоцрогдсон зэр зэвсэг, бэлтгэл сургуулилалттай байсан нь монголчуудын цэрэг дайны амжилтад сөрөг үр дагаврыг авчирсан гэж үзэж болно. Ялангуяа 1860-аад онд Чин улсад өрнөсөн дайн тулаанууд нь хуучин маягийн монгол цэрэг нэгэнт үеэ өнгөрөөснийг харуулсан гэж үздэг.

Гэсэн хэдий ч монгол хүний төрөлхийн цэрэг зан чанар нь бүрмөсөн үгүй бололгүй, далд хэлбэрээр оршсоор байсныг 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, Өвөр Монголыг чөлөөлөх байлдаан, 1921 оны Ардын хувьсгал зэрэг тод харуулдаг агаад 1911 онд үүсэн буй болсон тусгаар Монголын цэрэг 10 хүрэхгүй жилийн дотор хүчирхэг арми болж чадсаныг монгол эр хүний төрөлх чанартай холбон тайлбарлахаас өөр аргагүй. Ийнхүү монголчууд тусгаар тогтнолоо сэргээснээр монгол цэргийн түүхийн нэгэн балар үе дуусаж, хөгжил дэвшлийн шинэ эрин эхэлсэн билээ.

Аливаа улс орон тусгаар тогтнолоо хамгаалахын тулд цэрэг зэвсэгт хүчнээ байгуулдаг жамтай. Монгол улс тусгаар тогтнолоо сэргээх явцад Хиагтын зүүн, баруун харуул болон Сэцэн хаан аймгаас тодорхой тооны цэрэг дайчлан татсан нь Монгол улсын цэргийн үндэс суурь болжээ. Улмаар 1912 оноос аймаг, хошуудаас олон мянган цэрэг удаа дараа дайчлан татаж, сурган бэлтгэснээр Монгол улсын цэргийн хүч нэмэгдэж, 1913 оны байдлаар цэргийн тоо арван мянгад хүрч байв. Энэ үеийн цэргийн гол онцлог нь нэгд: монгол цэргийн уламжлалд тулгуурласан морьт цэрэг байсан, хоёр: Европ болон Хаант Оросын цэргийн туршлага, ололтыг ашиглаж, Хаант Оросын тусламжтайгаар цэргийн сургууль байгуулж, орчин үеийн галт зэвсгээр цэргээ зэвсэглэж байсан, гуравт: эрх чөлөө, тусгаар тогтнолоо хамгаалсан зэвсэгт тэмцлийг эрчимтэй явуулж байсан зэрэгт оршино.

Монгол улсын засгийн газар анх удаа цэргийн сургууль байгуулсан, цэргийн дүрэм, хууль цаазыг батлан мөрдүүлсэн, Хаант Оросоос орчин үеийн галт зэвсэг авч морьт цэргийг зэвсэглэсэн зэрэг олон шинэ зүйл энэ үед цэргийн хэрэгт нэвтэрсэн байна. Энэ нь монгол цэргийн түүхэнд онцгой нөлөө үзүүлсэн юм.

Судалгааны үр дүнд дараах санал, дүгнэлтийг дэвшүүлж байна.

Нэгд: Өнөөгийн зэвсэгт хүчний үүсэл хөгжлийн түүхийг 1921 оноос эхлэлтэй хэмээн үзэх хандлага урьдын адил байсаар байна. Гэтэл 1911-1912 онд байгуулагдсан Монгол улсын цэрэг нь Монголд орчин үеийн цэрэг зэвсэгт хүчин байгуулагдах үндэс суурь болсон бөгөөд энэ үйл явц 1921 оны хувьсгалын дараа улам эрчимтэй явагдсан байна.

Хоёрт: Судалгааны бүтээлүүдэд Монгол улсын цэргийн түүхийг 1911-1919, 1911-1921 он хэмээн хоёр янзаар үечлэн авч үзсэн байна. Монголын автономитыг 1919 онд устгасан боловч 1921 оны цагаан сард автономитыг сэргээн Богдыг хаан ширээнд залж, таван яам бүхий засгийн газрыг байгуулж, Монгол улсын засгийн газар аймаг, хошуудаас цэрэг дайчлан татаж, гамин болон цагаантнаас эх орноо чөлөөлөх зэвсэгт тэмцлийг удирдан явуулж байгаад 1921 оны долдугаар сард засгийн эрхийг Ардын засгийн газарт тайван замаар шилжүүлсэн билээ. Ийм учраас Монгол Улсын цэргийн түүхийг 1919 оноор таслан авч үзэх нь үндэслэл муутай байна. Тийм учраас цаашид Монгол Улсын цэргийн түүхийг 1911-1921 он хэмээн үечилж хэвших нь чухал байна.

АЖЦ Ардын хувьсгалыг ялалтад хүргэхэд чухал нөлөөтэй Хиагтын байлдаанаас гадна эх орноо Хятадын гамин, Оросын цагаантнаас чөлөөлөх явцдаа дангаараа болон Зөвлөлт Оросын улаан цэрэгтэй хүчин хавсрах, орон нутгийн баг цэргийн ба хязгаарын монгол цэргийн хүч дэмжлэгтэйгээр 200 орчим байлдаан хийж ялалт авчирчээ.

Ардын журамт цэргээс үүсэл хөгжлийн шинэ замналаа эхлүүлсэн Зэвсэгт хүчин дэлхийн цэргийн хэргийн хөгжлийн чиг хандлагыг баримтлан байнгын цэрэг болж төлөвших үйл явц хориод онд хэрэгжжээ.

МАХЦ-ийг европын (Зөвлөлтийн) туршлагаар өөрчлөн байгуулснаар үндсэн төрлийн цэрэг болох морьт цэргийн хороо, дивиз, корпустай болж түүний бүрэлдэхүүнд хуягт танк, их буу, нисэх хүчин, холбоо зэрэг техникийн цэргийн анги шинээр бий болов. Байнгын цэргийг орон нутгийн цэрэгтэй хосолсон тогтолцоо бүрдсэн байна. Энэ нь ард олныг батлан хамгаалах үйл хэрэгт оролцуулах гол хэлбэр байв. Нийгмийн хөгжлийн шаардлагаар МАХЦ нь эх орноо батлан хамгаалаад зогсохгүй залуучуудыг сургаж хүмүүжүүлэн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж гаргах газар болж байв.

Гучаад оны дунд үеэс эхлэн Монгол улсын хил хязгаарт удаа дараа их, бага хүчээр халдан довтолж байсан Япон, Манжийн цэргийн түрэмгийллийг МАХЦ-ийн нэгтгэл, ангиуд Зөвлөлтийн цэргийн зарим анги, салбарын дэмжлэгтэйгээр эрс шийдвэртэй няцааж эх орныхоо тусгаар тогтнол, хил хязгаарын дархан байдлыг хамгаалж чадсан юм. Япон, Манжийн зүгээс хийж буй зэвсэгт өдөөн хатгалга 1939 он гарсаар улаж идэвхжиж, улмаар Халхын голын дайнд хүргэсэн юм. Энэ дайнд Монгол, Зөвлөлтийн цэрэг дөрвөн сар гаруй хугацаанд японы цэргийн түрэмгийллийг сөрөн зогсож, Японы Квантуны армийн гол хүч болсон 6 дугаар армийг бут цохиж, эл дайн ялалтаар дууссан билээ.

Түүх бичлэгт Халхын голд болсон үйл явдлыг уг дайнд оролцогч талууд өнөөг хүртэл байлдаан, мөргөлдөөн, хэрэг явдал гэх зэргээр нэрэлж буй ч Монгол Улсын хувьд уг үйл явдал дайн байсан юм.

Халхын голын дайн нь Монгол, Зөвлөлтийн цэргийн урлаг, зэвсэглэл, байлдааны техникийн хөгжилд томоохон нөлөө үзүүлэв.

Дэлхийн II дайны сүүлчийн операцид БНМАУ-ын Зэвсэгт хүчин ЗХУ-ын холбоотон болж оролцов. Дэлхийн дайны сүүлчийн голомтыг устгах эл кампани нь холбоотон гүрнүүдийн ялалтаар төгсөж даян дэлхийд энх тайван байдал тогтов.

Зүүн хойд Хятад, Өвөр Монголын нутагт 1945 оны намар явуулсан операцид МАХЦ оролцсон нь тус улсын тусгаар тогтнолыг баталгаажуулахад эерэг нөлөө үзүүлсэн юм.

XX зууны дунд үеэс эхлэн Зэвсэгт хүчнийг үлэмж хэмжээгээр цомхотгосон, улмаар дахин өргөтгөн байгуулсан түүхэн үйл явцыг энэ ботид дэлгэрэнгүй авч үзэв.

МАХЦ-ийг цомхотготгосон үйл явц тухайн үедээ зөв байсан байж болох ч хожмын үйл явдлуудтай харгуулан үзвэл шүүмжлэлтэй хандах зүйл цөөнгүй байх ажээ. Энэ жилүүдэд зэвсэгт хүчнийг зориулалтаар нь бэлтгэх, бэхжүүлэх бодлого алдагдаж, МАХЦ-ийг улс ардын аж ахуйн хөлсгүй хөдөлмөрлөх бэлэн хүч гэж үзэх бодлогыг хэрэгжүүлсэн явдал цэргийн бүтэц, байлдах чадварт сөрөг нөлөө үзүүлэв. Энэ он жилүүдэд МАХЦ-ийн зэвсэг, байлдааны техникийг шинэчилж чадаагүй бөгөөд энэ нь тавиад оны эцсээр уламжлалт морьт цэргийг өөрчлөн мотомеханикжуулсан арми болгон өөрчлөн байгуулахад багагүй бэрхшээл учруулсан юм.

Тавиад оны дунд хүртэлх үеийн МАХЦ-ийн түүхийн агуулга нь дэлхийн дайны дараа армийг цомхотгон өөрчлөн байгуулахын хамтаар цэргийг энхийн бүтээн байгуулах хөдөлмөрт оролцуулсан явдлаар тодорхойлогдоно.

Гэхдээ энэ он жилүүд нь МАХЦ-ийг (морьт цэргийг) орчин цагийн зэвсэгт тэмцэл явуулах чадвартай арми болгон өөрчлөн байгуулах шилжилтийн бэлтгэл үе байв.

Бидний авч үзэж буй он цагийн хүрээнд болсон нэг чухал үйл явдал нь баруун хилийн байлдаан юм. Олон жилийн турш тус улсын баруун хязгаарт Гоминдан болон Оспаны зүгээс хийж байсан дээрэм, зэвсэгт халдлагууд улам даамжирсаар байлдаан болж өргөжсөн бөгөөд түүнд хязгаарын цэргийн ангиудаас гадна МАХЦ-ийн анги, салбар оролцсон томоохон байлдаан болсон билээ.

Баруун хилд 1930-1940-өөд онд болсон үйл явдлыг Монгол Улсын түүх бичлэгт “зэвсэгт тулгаралт”, “Оспан, Гоминданы өдөөн хатгалга”, “баруун хилийн тулгаралт” хэмээн томъёолж нэрлэх болсон нь уг үйл явдлын цар хүрээ, ач холбогдол, үр дүн, сургамжийг үгүйсгэсэн хэрэг гэж үзэж болно. Иймээс баруун хилд олон жил үргэлжилсэн тэрхүү зэвсэгт халдлага, түрэмгийллийн эсрэг Монголын ард түмэн, төр засаг, цэрэг дайчдын явуулсан зэвсэгт тэмцлийг “Байлдааны ажиллагаа” гэж томъёолж нэрлэх нь зүйд нийцнэ.

Өнгөрсөн зууны тавиад оны дунд үеэс дэлхийн цэрэг-улс төрийн нөхцөл байдалтай уялдаж, дэлхий нийтийн цэргийн хэргийн чиг хандлагыг харгалзсан буудлагын улмаар мотобуудлагын цэрэг болгон өөрчлөх нөр их ажлыг эхлүүлсэн бөгөөд энэ нь хэд хэдэн үе шаттай үргэлжилж өнөөгийн Зэвсэгт хүчний дүр төрхийг бий болгосон ажээ.

БНМАУ-д 1990-ээд оныг хүртэл төр, засгийн үндэсний аюулгүй байдлыг хангах үзэл баримтлал, цэргийн номлол, батлан хамгаалах хууль гэж албан ёсны баримт бичиг байгаагүй юм. Монголын төр засаг, МАХН дайны шинж чанар, түүнийг явуулах арга, Зэвсэгт хүчний байгуулалтын зарчмын үндсэн асуудлаар ЗХУ-ын цэргийн бодлого, шинжлэх ухаан, номлолыг баримталж байв.

Төр засаг, МАХН-аас 1950-иад оны сүүлчийн хагасаас 1990-ээд оны эхэн хүртэлх хугацаанд батлан хамгаалах салбарт баримталж ирсэн бодлого, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд улс орныг батлан хамгаалах үйл хэрэг зохих төвшинд тавигдаж, батлан хамгаалах тогтолцоо бүрэлдэн төлөвшиж, батлан хамгаалах системийн нийт байгууллагын үйл ажиллагаа, нэр хүнд мэдэгдэхүйц дээшлэв. Хүн амын батлан хамгаалах ухамсар төлөвшиж, батлан хамгаалах сурталчилгаа, цэргийн сургалтанд оролцох оролцоо сайжрав.

МАА-ийн 1956-1990-ээд оны түүх нь улс орны батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх, армийг өргөтгөн зохион байгуулах талаар МАХН, төр, засгийн цэргийн бодлогыг амьдралд хэрэгжүүлэхийн төлөө явуулсан цэргийн дээд командлал, бүх шатны дарга, захирагч, штаб, улс төр, нам, олон нийт, ар талын байгууллага, нийт дайчдын хамтын хөдөлмөр зүтгэлийн түүх юм. Армийн дайчдын нөр их хөдөлмөр, зүтгэлээр бүтээсэн МАА-ийн энэ хугацааны түүх нь Монгол цэрэг, МАА-ийн түүхийн тодорхой зурвас үеийн бие даасан томоохон үе шат мөн.

Энэ бүлгийн сүүлчийн шатан дахь Зэвсэгт хүчний үйл ажиллагаатай холбогдсон нэлээд асуудлууд цаг хугацааны хувьд түүхчлэн бичих болоогүй тул зарим баримт, үнэлэлт дүгнэлт дутуу дулимаг мэт санагдаж болохыг уншигчид ойлгоно байх.

Монгол Улсын Зэвсэгт хүчин Үндсэн хууль, Батлан хамгаалах болон бусад цогц хууль, үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын үзэл баримтлал, цэргийн

номлолынхоо дагуу бүтэц, зохион байгуулалт, сургалт хүмүүжлийн ажлын агуулга, арга хэлбэрээ шинэчлэх, эх орноо батлан хамгаалах үүргээ шинэ цаг үе, нөхцөл байдалд хэрэгжүүлэх түүхийн шинэ үедээ орлоо.

Монгол Улс олон улсын энхийн үйл явцад хувь нэмрээ оруулж ирсэн өнгөрсөн 10 гаруй жилийн түүх нь улс төрийн онцгой ач холбогдолтой, алсыг харсан зөв алхам болсон төдийгүй “жигжиг орны том бодлого” болсныг гэрчлэн харуулж байна.

Манай энхийг сахиулагчид аливаа сорилт, бэрхшээлийг үл огоорон, эх орныхоо даалгасан үүргийг нэр төртэйгээр гүйцэтгэсээр ирсэн нь тэднийг дэлхийд данслагдсан “цэнхэр дуулгатан” хэмээх алдрын зэрэгт хүргээд зогсохгүй, тэд маань өнөөдөр нэгэнт эх орныхоо “нэрийн хуудас” болж байгааг бахархахгүй байхын аргагүй билээ.

ЭШ ТАТСАН СУРВАЛЖ, СУДАЛГААНЫ ЗОХИОЛ

1. Монголын эртний түүх. Тэргүүн боть. Хүннү. УБ., 2017.
2. Батсүрэн Б. Ухуань (Авар) ба Сяньби (Сэрби). УБ., 2016.
3. 史記(shi ji)。卷(juan)110, 匈奴(xiongnu), 第2893頁
4. Дэлгэржаргал П. Сяньби . Монголын эртний түүх дэд боть. УБ, 2017.
5. Материалы по истории древних кочевых народов группы дунху. Введение, перевод и комментарии В.С.Таскина. М., 1984.
6. Крадин Н.Н. Общественный строй Жужаньского каганата // История и археология Дальнего Востока: к 70 летию Э.В.Шавкунова. Владивосток, 2000.
7. Материалы по истории древних кочевых народов группы дунху. Введение, перевод и комментарии В.С.Таскина. М., 1984.
8. Хандсүрэн Ц. Жужаны хаант улстай холбогдох түүхийн сурвалж бичгүүд // Жужаны хаант улс ба түүхийн зарим судалгаа. УБ., 2005.
9. Сүхбаатар Г. Монгол Нирун улс (330-555) УБ., 1992.
10. 송기호, 「발해 멸망기의 대외관계 –거란-후삼국과의 관계를 중심으로–」, “한국사론” 17권, 서울대학교 국사학과, 1987, 83쪽.
11. Юү Дыггон, Пархэгийн шинжлэл, орчуулсан Ц.Цэрэндорж, УБ., 2014.

12. Корйөса, 13:35a6-b2, 14:3b4-9, 6a6
13. Мансан. Монгол үндэстний бүрэн түүх. Дөрөвдүгээр дэвтэр. ӨМӨЗО. 2004 он.
14. БНМАУ-ын түүх. УБ., 1966
15. Иванин. М.Н. Тэмүжин, Төмөрийн цэрэг хэрэглэх арга. Хөх хот., 1987.
16. Полководцы. X- XVI вв. М., 1989.
17. Военный энциклопедический словарь. М., 1986.
18. Цэргийн нэр томъёоны тайлбар толь. УБ., 2014.
19. Савкин. В.Е. Основные принципы оперативного искусства и тактики. М., 1972.
20. Воровьев. И.Н. О тактике. - "Военная мысль. №1,3,5. М., 2002.
21. Клаузевиц. К.О войне. М., 1998.
22. Балжинням Б. Дэлхийн монголчуудын түүх. Дөтгөөр дэвтэр. УБ. 2012
23. БНМАУ-ын түүх. 3 боть, Тэргүүн дэвтэр. УБ., 1966.
24. Далай Ч. Монголын түүх /1260-1388/. УБ., 1992.
25. 高锐, 射国良, 李维民. 中国军事史略. 中册. 北京., 1992. 第292页
26. 中国军事通史第十四卷-元代军事史. 军事科学出版社. 1998. 第188页
27. Монгол цэргийн түүхийн товчоо. Тэргүүн дэвтэр., УБ. 1996.
28. 中国战典. 上卷. 北京. 2008. , 第836页, 周良霄. 顾菊英. 元史. 上海., 2008. 第350页
29. Монголын эзэнт гүрний гадаад харилцаа. УБ., 1995.
30. 元史. 卷二百一十
31. Пунсаг А. Тэнгэрийн их Юань улсын түүхэн тэмдэглэл. Улаанбаатар. 2010.
32. Храпачевский Р.П. Военная держава Чингисхана. Москва. 2005 г.

ХАВСРАЛТ

Олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл

1. С.Ганболд. “Уроки войны на реке Халхин гол и железная дорога”. Өвөр Байгалийн муж байгуулагдсаны 165 жил, Монгол-Оросын хооронд дипломат харилцаа тогтоосны 95 жилийн ойд зориулж ОХУ-ын Чита хотод 2016 оны 9 дүгээр сард болсон “Хил орчмын орон зай дахь бүс нутаг” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал.
2. С.Ганболд. “Улс төрийн хэлмэгдүүлэлтэд МАХЦ-ийн бие бүрэлдэхүүн өртсөн нь”. Улс төрийн хэлмэгдүүлэлт: шалтгаан, үр дагавар, сургамж сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал. 2017.09.07. Улаанбаатар.
3. Х.Шагдар, Ж.Базарсүрэн. “Дальневосточная операция: Заключительный этап Второй мировой войны”. Улаан Үд хотод болсон “Мир Центральной Азии”-IV” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал. 2017.10.04-07. Улаан Үд.
4. Х.Шагдар. “Халхин-гол главная стажировка Советских военных журналистов” (Г.Нямдоржийн хамт). Өвөр Байгалийн муж байгуулагдсаны 165 жил, Монгол-Оросын хооронд дипломат харилцаа тогтоосны 95 жилийн ойд зориулж ОХУ-ын Чита хотод 2016 оны 9 дүгээр сард болсон “Хил орчмын орон зай дахь бүс нутаг” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал.

5. С.Ганболд. “Роль СССР в подготовке военных кадров Монголии (1939-1945)”. “Мир Центральной Азии”-IV” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал. 2017.10.04-07. Улаан Үд.
6. Т.Эрдэнэхишиг, Ц.Нарангэрэл. “Наваандоржийн Жадамбын намтар түүхийн зарим асуудал”. Даяаршил ба монгол судлал-2017 сэдэвт олон улсын хурал. 2017.05.19.
7. С.Ганболд. “Улс төрийн хэлмэгдүүлэлтэд МАХЦ-ийн бие бүрэлдэхүүн өртсөн нь”. “Улс төрийн хэлмэгдүүлэлт: шалтгаан, үр дагавар, сургамж” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал. 2017.09.07. Улаанбаатар.
8. Д.Ундрах. “Хятад ордны тайганы түүх, нийгэм соёлд үзүүлсэн нөлөө” /Хамтарсан/, “Ази судлал” ОУЭШ хурал 2016. 05.14
9. Д.Ундрах. “Монгол дахь хятад судлал-Өнөөгийн байдал цаашдын зорилт” /Хамтарсан/ “Ази судлал” ОУЭШ хурал 2017. 04.14
10. Д.Ундрах. “Монголын эзэнт гүрний дараах үед холбогдох монгол хятадын харилцаа”, “Ази судлал” ОУЭШ хурал 2017. 04.14
11. Д.Ундрах. “XIV-XVI зууны үеийн Монголын түүхэнд холбогдох нанхиад хэлээрх сурвалжийн тухайд” “Сурвалжийн өв” Олон улсын Монголч эрдэмтдийн эрдэм шинжилгээний хурал.2018.08.18
12. Д.Ундрах. “БНХАУ-ын шашны талаар авч явуулж буй бодлого” “Буддист эмэгтэйчүүд-Тогтвортой хөгжид” ОУЭШ 4 дүгээр бага хурал. 2018.11.1
13. Н.Хишигт. “Чөлөөлөх дайны үед БНМАУ-ын засгийн газраас Өвөр Монголын тухайд баримталсан бодлого, үйл ажиллагаа”-//Дэлхийн хоёрдугаар дайны өмнөх ба дараах Япон, Монголын харилцаа”. Эрдэм шинжилгээний хурал. Япон улсын Шига Их сургууль. 2016.03.26.
14. Н.Хишигт. “Великая Российская революция и национально -освободительное движение монголов“. Сибирь в годы Великой Российской революции (К 100 летию революционных событий в России и периоду Гражданской войны и иностранной интервенции). Материалы Всероссийской научно-практической конференции с международным участием. Улан-Удэ., 2017. С.14-23.
15. Н.Хишигт. “1921 оны хувьсгалын түүх бичлэгийн асуудалд”. ”Монголын түүх бичлэг шинэ зууны эхэнд: Асуудал, чиг хандлага” олон улсын эрдэм шинжилгээний хурал.Улаанбаатар. 2017.09.21-22.
16. Н.Хишигт. “1921 оны хувьсгалын түүхэнд Хиагт хотын эзлэх байр суурь”. “Хиагт ба Хүрээг Евроазийн нүдээр тольдохуй” олон улсын эрдэм шинжилгээний хурал. Улаанбаатар. 2018.08.31.

Улсын болон салбарын хэмжээний эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл

1. С.Ганболд. “Цэргийн хөгжмийн удирдаач Г.Бирваа” (хошууч Н.Хүдэрбатын хамт). 2016.
2. С.Ганболд. “Улс орны батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх зорилт ба маршал Ю.Цэдэнбал” (Ц.Бямба-Эрдэнийн хамт). 2016.
3. С.Ганболд. “Монгол Улс, АНУ-ын батлан хамгаалах салбарын харилцаа”. “АНУ-ын Зүүн хойт Ази дахь бодлого ба Монгол-Америкийн харилцаа” сэдэвт

- эрдэм шинжилгэний хуралд тавьсан илтгэл. (Ц.Бямба-Эрдэнийн хамт). 2017.01.18.
4. С.Ганболд. “Цэргийн эрдэм шинжилгээний байгууллагыг хөгжүүлж, бэхжүүлэхэд Д.Гомбосүрэнгийн оруулсан хувь нэмэр”. Д.Гомбосүрэнгийн мэндэлсний 80 жилийн ойд зориулсан “Монголын төр, цэргийн түүхийн тулгамдсан асуудлууд” сэдэвт эрдэм шинжилгээний хурал. 2017.05.15.
 5. Х.Шагдар. “Д.Гомбосүрэн: 22 дугаар морьт хорооны мөрөөр...”. Д.Гомбосүрэнгийн мэндэлсний 80 жилийн ойд зориулсан “Монголын төр, цэргийн түүхийн тулгамдсан асуудлууд” сэдэвт эрдэм шинжилгээний хурал. 2017.05.15.
 6. С.Ганболд. “Залуу жанжин Ж.Лхагвасүрэн Халхын голын дайнд”. Жанжин Ж.Лхагвасүрэнгийн мэндэлсний 105 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал. Булган. 2017.11.09.
 7. С.Ганболд. “Ш.Найдансүрэнгийн цэргийн үйл ажиллагаа”. Төрийн зүтгэлтэн Шаравын Найдансүрэн” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал. 2017.11.24.
 8. Ж.Базарсүрэн (доктор Л.Баярын хамт). “Монгол Улсын цэргийн удирдлагын тогтолцооны уламжлал, сургамж”. 2017.03.10.
 9. Ж.Базарсүрэн. “БНМАУ-ын БХЯ-ны сайд Ж.Лхагвасүрэн”. Жанжин Ж.Лхагвасүрэнгийн мэндэлсний 105 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал. Булган. 2017.11.09.
 10. Х.Шагдар. “Жанжин Ж.Лхагвасүрэн 1945 оны Чөлөөлөх дайнд”. Жанжин Ж.Лхагвасүрэнгийн мэндэлсний 105 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал. Булган. 2017.11.09.
 11. Ж.Базарсүрэн, С.Ганболд, Ж.Бадамбазар. “ЗХЖШ-ын цэргийн мэргэжлийн удирдлагын байгууллага болон төлөвших үйл явц-20 жил (Түүхэн замнал, сургамж, дүгнэлт)”. 2017.11.30.
 12. С.Ганболд, И.Чинбат. “Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний ёс суртахууны төлөвшилд соёл, хүмүүжлийн ажлын гүйцэтгэсэн үүрэг (уламжлал, шинэчлэлийн асуудал)”. ҮБХИС-ийн Нийгмийн ухааны тэнхим байгуулагдсаны 50 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал. 2017.12.01.
 13. С.Ганболд. “Зэвсэгт хүчнийг үндэслэн байгуулагч, цэргийн гарамгай жанжин Д.Сүхбаатар”. Д.Сүхбаатарын мэндэлсний 125 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал. 2018.02.02. Баруун-Урт.
 14. Ж.Базарсүрэн. “Ардын журамт цэргийн 1921 оны байлдааны ажиллагаануудыг цэргийн урлагийн үүднээс дүгнэх нь”. Д.Сүхбаатарын мэндэлсний 125 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал. 2018.02.02. Баруун-Урт.
 15. Х.Шагдар, Ц.Бямба-Эрдэнэ. “Зэлтэрийн гацаа”. Д.Сүхбаатарын мэндэлсний 125 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал. 2018.02.02. Баруун-Урт.
 16. Т.Эрдэнэхишиг “Монгол улс, БНХАУ-ын батлан хамгаалах салбарын харилцаа (XX-XXI зуун)”.
 17. Д.Ундрах. “Дэлхийн хятад судлалын чиг хандлага”. /Хамтарсан/ МУ-д хятад хэлтэй боловсон хүчин бэлтгэгдэж эхэлсний 60 жилийн ойн эрдэм шинжилгээний хурал, 2017.11.24
 18. Н.Хишигт. “Хөвсгөлийн хязгаарт байгуулагдсан МАЖЦ-ийн анхны хороо”. Хөвсгөлийн хязгаарын түүх, соёлын зарим асуудал” эрдэм шинжилгээний бага хурал. Улаанбаатар. 2016.04.29.
 19. Н.Хишигт. “1921 оны хувьсгалын түүхэн дэх Сэлэнгэ нутаг”. 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын 95 жилийн ойд зориулсан “Үндэсний

- хувьсгалын түүхэн дэх Сэлэнгэ нутаг” сэдэвт эрдэм шинжилгээний хурал. Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум. 2016.09.19-20.
20. Н.Хишигт. Ж.Гантулга. “Түүхийн сурвалж, архивын баримтын судалгаанд доктор Д. Гомбосүрэнгийн оруулсан хувь нэмэр”. Цэргийн нэрт түүхч доктор /Sc.D/, профессор Д.Гомбосүрэн агсны мэндэлсний 80 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал. Улаанбаатар. 2017.05.15.
 21. Н.Хишигт. “1920-иод оны Монголын хэрэг явдал ба Манзушир хутагт Цэрэндорж”. Монгол улсын төр, шашны нэрт зүтгэлтэн, ерөнхий сайд Манзушир хутагт С.Цэрэндоржийн мэндэлсний 145 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал. Улаанбаатар. 2017.10.30.
 22. Н.Хишигт. Ж.Гантулга. “1921 оны Монгол дахь цэрэг дайны ажиллагаа ба Сундуй гүн”. “XX зууны эхэн үеийн Монголын түүхийн судалгаа, Бишрэлт гүн Сундуй” эрдэм шинжилгээний хурал. 2017.12.08

Гадаад хэлээр хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл

1. Н.Хишигт. “Монголия-Россия: политическое и военное сотрудничество в годы второй мировой войны”. “Россия-Монголия: история, вызовы XXI века, перспективы”. Сборник научных статей. Улан-Батор., 2017. С.197-209
2. С.Ганболд. “Mongolia made an important contribution to international peace by taking part in the War of Liberation”. “The Mongolian observer” сэтгүүл. 2017.03.29. №3.

Дотоодод хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл

1. Ж.Базарсүрэн. “Кибчагчин аян хийгээд Легница-гийн тулалдааны учир холбогдлын тухайд”. Сургалт, судалгаа, арга зүйн улирал тутмын “Цац” сэтгүүл. БХИС. УБ., 2016 он. №4 (27). т.110-117.
2. Ж.Базарсүрэн. “Цэрэг гэдэг үгийн гарал буюу “Сэргэ”-ийн тухай”. Соёмбо-БХИС. 2016.III. №5 (70) буюу “Соёмбо” сонин. 2016.III.8-18. №10,11 (10480,10481).
3. Ж.Базарсүрэн. “Хубилай сэцэн хааны цэрэг: уламжлал, шинэчлэл (XIII зууны хоёрдугаар хагас)”. “Хубилай сэцэн хаан ба Монголын Юань улс” эмхэтгэл. УБ., 2016. 404-415 дахь тал.
4. Ж.Базарсүрэн. “Монголын Зэвсэгт Хүчин 5000 жилийн түүхтэй”. “Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал” сэтгүүл. 2016. №22 (32). 86-90 дэх тал.
5. Х.Шагдар. “Хаан ширээнд Хубилай суусан нь”. “Хубилай сэцэн хаан ба Монголын Юань улс” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2016
6. Т.Эрдэнэхишиг. “Сяньнянь, Фаньчэнь хотыг эзлэн авахад Юань улсын их бууч цэргийн гүйцэтгэсэн үүрэг”. “Хубилай сэцэн хаан ба Монголын Юань улс” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2016
7. Т.Эрдэнэхишиг. “Юань улс байгуулагдсан нь”. “Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал” сэтгүүл. №22 (32). 91-100 дахь тал. УБ., 2016
8. Т.Эрдэнэхишиг, М.Тунгалаг. “Юань улсын цэргийн алба”. “Цац” сэтгүүл. 2017 он №07/30/.

9. Т.Эрдэнэхишиг, Ц.Нарангэрэл. “Наваандоржийн Жадамбын намтар түүхийн зарим асуудал”. Даяаршил ба монгол судлал-2017 сэдэвт олон улсын хурал. 2017.05.19.
10. Ж.Базарсүрэн. “Цэрэг гэдэг үгийн гарал хийгээд Монголын Зэвсэгт хүчний үүслийн тухайд”. “Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал” сэтгүүл. 2017. № 23.
11. Ж.Базарсүрэн. “Хоровод буюу монголчуудын байлдааны тойрон бүжиг”. “Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал” сэтгүүл. 2017. № 24.
12. Т.Эрдэнэхишиг. “Цин (НТӨ 221-206), Хан (НТӨ 206-НТ 220) улсын цэргийн бүтэц, зохион байгуулалт”. “Аюулгүй байдал, Батлан хамгаалах судлал” сэтгүүл. 2017. № 23.
13. С.Ганболд: “Цэргийн удирдах дээд байгууллагуудын анхны дарга Д.Сүхбаатар”. “Соёмбо-ҮБХИС” сонин. 2018.02.
14. Ц.Цэрэндорж. Солонгосын түүхийн сурвалж дахь XIV-XVIII зууны үеийн Монголтой холбоотой мэдээ баримт // “Солонгос судлал” сэтгүүл, 1 (5), 2018, 10-26-р тал
15. Ц.Цэрэндорж. Сайн ноён аймгийг хэнд зориулж байгуулсан бэ? - Сайн ноён хан аймгийн Сэцэн чин вангийн хошууны түүх, соёлын судалгаа, УБ., 2018, 71-78-р тал.
16. Д.Ундрах. “Монгол-Хятадын харилцааны түүхэнд холбогдох “Умрыг төвшитгөсөн тэмдэглэл” хэмээх нанхиад сурвалжийн тухай” Солонгосын монгол судлал сэтгүүл 2016 он дугаар №1.
17. Д.Ундрах. “Мин улсын судрын бүрэн орчуулга” “Гадаад хэл соёл судлал сэтгүүл” 2017 №1.
18. Д.Ундрах. “Умарш дайлсан хожуу тэмдэглэл” хэмээх сурвалжийн тухайд” “Оюуны хэлхээ ” сэтгүүл 2018.
19. Д.Ундрах. “XIV-XVI зууны үеийн Монголын түүхэнд холбогдох нанхиад хэлээрх сурвалжийн тухайд” “Акта хисторика” сэтгүүл 2018 №2.
20. Д.Ундрах. “Юунлө хааны монголд дайлсан 5 удаагийн дайны тухайд” “Гадаад хэл соёл судлал сэтгүүл” 2019 №1.
21. Т.Сүхбаатар. “Бат хааны цэргийн тагнуулын үйл ажиллагаа”. “Тусгаар тогтнол” сэтгүүл. УБ., 2017. №2 /38/
22. Т.Сүхбаатар. “Бат хааны цэргийн тооны асуудалд”. УБ.,2017.12. ҮБХИС-ийн Нийгэм хүмүүнлэгийн тэнхмийн 50 жилийн ойд зориулсан эрдэмтэдийн бүтээлийн “Дээжис” эмхэтгэл.
23. Т.Сүхбаатар. “Зүчийн улс соёл иргэншил”. “Аюулгүй байдал батлан хамгаалах бодлого судлал” сэтгүүл. УБ.,2018. №25 /35/
24. Т.Сүхбаатар. “Сайн хаан Бат”. “Аюулгүй байдал батлан хамгаалах бодлого судлал” УБ.,2018. №26 /36/
25. Т.Сүхбаатар. “Барон Унгерны 1921 оны хувьсгалд үзүүлсэн нөлөө”. “Цэргийн шинэчлэл” сэтгүүл. 2018 он № 4 (72)

Удирдаж хамгаалуулсан доктор

1. Даваадорж Н. “Монгол Улсын баруун хилийн хамгаалалтын судалгаа”. Цэргийн түүхийн ухаанаар доктор (Ph.D)-ын зэрэг горилсон диссертаци. УБ., 2016. Эрдэм шинжилгээний удирдагч доктор, профессор С.Ганболд.
2. Пак Вон Кю. “Сүнзийн дайны онол, Чингис хааны практикийн харьцуулсан судалгаа”. Цэргийн түүхийн ухаанаар докторын зэрэг горилсон диссертаци. УБ., 2017. Удирдагч шинжлэх ухааны доктор, профессор Х.Шагдар.

3. Нарангэрэл Ц. “Наваандоржийн Жадамбын цэрэг, улс төрийн үйл ажиллагаа”. Цэргийн түүхийн ухаанаар докторын зэрэг горилсон диссертаци. УБ., 2018. Удирдагч доктор, профессор С.Ганболд.
4. Бүрнээбаатар А. “Улс орныг батлан хамгаалахад орон нутгийн гүйцэтгэсэн үүргийн судалгаа”. Цэргийн түүхийн ухаанаар докторын зэрэг горилсон диссертаци. УБ., 2018. Удирдагч доктор, профессор Г.Мягмарсамбуу.